ULAANBAATAR SECURITIES EXCHANGE
TAVAN BOGD CAPITAL
2026 . 2
БУРТГЭВ

OCHUN FINANCE

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч:
Үүсгэн байгуулагч:
Очир Ундраа ОМЗ ББСБ ХХК

2026 .06. 11
БУРТГЭВ

Үндсэн андеррайтер:
Таван Богд Капитал ҮЦК ХХК

Дэд андеррайтер:
Ти Ди Би Секьюритис ҮЦК ХХК


Зээлийн шинжилгээ гаргагч:
Си Пи Ти Эй Аудит ХХК

Хуулийн фирм:
Өмгөөллийн Эм Жэй Эл Атторнэйс ХХК

Хөрөнгө итгэмжлэн удирдагч:
Юү Эй Эф Ассет Менежмент ХХК

Ochir Undraa ABS

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны танилцуулга



TDB SECURITIES
CDTA AUDIT LLC
MJI
UAF

ULAANBAATAR SECURITIES EXCHANGE
2026 . 2
БҮРТГЭВ

СЗХ
2026 . 06 . 11
БҮРТГЭВ

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр Баталгаажсан Үнэт Цаасны тухай хууль болон Санхүүгийн Зохицуулах Хороо, Улаанбаатар Үнэт Цаасны Биржийн холбогдох дүрэм, журмын дагуу Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргаж байгаа болно.

Энэхүү Үнэт цаасны танилцуулга нь Хөрөнгө оруулагч таны хараат бус үнэлгээ гаргах, шинжилгээ хийхийг орлохгүй бөгөөд тэдгээрт тооцогдохгүй. Хөрөнгө оруулагч та Үнэт цаас гаргагч болоод түүний гаргаж буй үнэт цаас, холбогдох мэдээллийн талаар өөрийн хөндлөнгийн судалгаа шинжилгээг хийсний үндсэн дээр хөрөнгө оруулалт хийж буй бөгөөд өөрийн мэргэжлийн санхүүгийн, хуулийн болон бусад зохих мэргэжлийн зөвлөхүүдтэйгээ зөвлөлдөхийг зөвлөж байна.

Энэхүү Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан зарим ирээдүйн болон зөвхөн одоогоор цаг хугацааны шинж чанартай гаргасан мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөлөл нь Андеррайтерийн холбогдох эх сурвалжаас цуглуулсан мэдээлэл, итгэл үнэмшил дээр тулгуурласан бөгөөд санаатайгаар ямар нэгэн мэдээллийг орхигдуулаагүй болно. Андеррайтер нь эдгээр мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөллийг гаргахдаа аль болох үнэн зөв мэдээллийг ашиглан бодит байдалд нийцүүлэхийг зорьсон боловч цуглуулсан мэдээллийн үнэн зөв байдалд хариуцлага хүлээхгүй бөгөөд тооцоолол, ирээдүйн төсөөллийн биелэлтэд баталгаа өгөөгүй болно.

ЭНЭХҮҮ ТАНИЛЦУУЛГАД ТУСГАСАН ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН БАТАЛГААТ ҮНЭТ ЦААСЫГ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО БОЛОН УЛААНБААТАР ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ БҮРТГЭСЭН НЬ УГ БАТАЛГААТ ҮНЭТ ЦААСАНД ГАРГАСАН БАТАЛГАА БИШ БӨГӨӨД ТҮҮНИЙ АГУУЛСАН МЭДЭЭЛЛИЙН ҮНЭН ЗӨВ, БҮРЭН БҮТЭН БАЙДАЛ БОЛОН АЛИВАА ЭРСДЭЛИЙГ СЗХ БОЛОН БОЛОН УБҮЦБ ХАРИУЦАХГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ.

ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, БАТАЛГААТ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, БАТАЛГААТ ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.

Энэхүү үнэт цаасны танилцуулгад хөрөнгө оруулагч танд тус үнэт цаасыг худалдан авах шийдвэр гаргахад туслах шаардлагатай бүхий л мэдээллийг агуулахыг зорьсон болно. Хөрөнгө оруулагч таны шийдвэр гаргалтад танилцуулгад тусгагдсан мэдээллээс илүү дэлгэрэнгүй, нэмэлт мэдээлэл шаардлагатай болох буюу лавлаж тодруулах зүйл байвал Үнэт цаас гаргагч болон Андеррайтер **"ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК"** ХХК-д хандаж тодруулна уу.





2026 .06. 11

2026 № 2
БҮРТГЭВ

ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч Үүсгэн байгуулагч	"Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК
	Улаанбаатар, Сүхбаатар, 3-р хороо, Сөүлийн, 20/1, Сөүл плаза 4 давхар 401 тоот +976 7575-1818 info@omz.mn
Үндсэн андеррайтер	"Таван Богд Капитал ҮЦК" ХХК
	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай-16, "Галлериа-Улаанбаатар" барилгын 1 давхар +976 7272-7282 cr@tavanbogdcapital.com
Дэд андеррайтер	"Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК
	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө- 19 +976 7010-0261 info@tdbsecurities.mn
Зээлийн шинжилгээ гаргагч	"Си Пи Ти Эй аудит" ХХК
	Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 3-р хороо, 45/А барилга Оршил төв, 501 тоот +976 7723-3030 info@cptaaudit.mn
Хуулийн фирм	"Өмгөөллийн Эм Жэй Эл атторнейс" ХХН
	Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Самбуугийн 13/2 байр, Глобал бизнес центр, 503 тоот +976 7012 9556 info@mjlattorneys.mn
Хөрөнгө итгэмжлэн удирдагч	"Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК
	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Соёл амралтын хүрээлэн /14240/, Олимпын гудамж, 7/2 байр 803 тоот +976 7012 2346 info@uaf.mn

ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ ТЗК ХХК

ҮЦТХ ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ
ҮЦТХ-ЫН ХК SECURITIES EXCHANGE
2026 2
БҮРТГЭВ

СЗХ
2026 сар 11 өдөр
БҮРТГЭВ
№ 01

ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУХАЙ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

"ОЧУН АКТИВ НЭГ ТЗК" ХХК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ
Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, Сөүлийн гудамж 13-А барилгын 12-р давхар

2026 оны 04 сарын 20 Дугаар 2026/09 Улаанбаатар хот

ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.5 дах заалт, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дах хэсэг, "Очун Актив Нэг ТЗК" ХХК-ийн дүрмийн 4.4 дэх заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

Нэг. "Очун Актив Нэг ТЗК" ХХК нь 40,000,000,000 (дөчин тэрбум) төгрөгийн нийт дүнтэй, нэг бүр нь 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 400,000 (дөрвөн зуун мянга) ширхэг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Улаанбаатар Үнэт Цаасны Бирж дээр нийтэд санал болгон **гаргасугай.**

Хоёр. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны ерөнхий нөхцөлийг энэ тогтоолын Хавсралт 1-р, Зээлийн хөрөнгөд тавих хуулийн шаардууры энэ тогтоолын Хавсралт 2-р, Зээлийн хөрөнгийн багцад тавих санхүүгийн шаардууры Хавсралт 3-р тус тус **баталсугай.**

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Г.Цогтгэрэл)-д **даалгасугай.**

ТОГТООЛЫГ БАТАЛСАН

ДАРГА Г.ЦОГТГЭРЭЛ

ГИШҮҮД Г.БАЯНТУЯА

Б.БААСАНДОРЖ

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947
7239888 Л. ХНТ10470

УЛААНБААТАР ХОТ
ТАВАН ТОГОЛОГ КАПИТАЛ ҮЦК ХХК
ШТК0128 5469112 9021061377

2026 2
БҮРТГЭВ
СЗХ
2026 .06. 11 өдөр
БҮРТГЭВ

ҮНЭТ ЦААСНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Санхүүгийн Зохицуулах Хороо, Улаанбаатар үнэт цаасны биржийн холбогдох журмын дагуу Очун Актив Нэг ТЗК ХХК нь нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 400,000 ширхэг, 40,000,000,000 төгрөгийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг нийтэд санал болгож байна.

Үнэт цаас гаргагч Анхны үүрэг гүйцэтгүүлэгч	"Очун Актив Нэг ТЗК" ХХК "Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК
Үнэт цаасны төрөл	Зээлийн багцын хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас
Үнэт цаасны нэгжийн нэрлэсэн үнэ	100,000 төгрөг
Үнэт цаасны тоо ширхэг	400,000 ширхэг
Үнэт цаасны нийт үнийн дүн	40,000,000,000 төгрөг
Үнэт цаасны хугацаа	24 сар
Үнэт цаасны хүү	18.5 хувь (жилийн)
Үнэт цаасны хүү төлөлт	Улирал тутам
Үнэт цаасны үндсэн төлбөрийн төлөлт	Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш хагас жил тутам тэнцүү дүнгээр буюу 6 дахь сард 25%, 12 дахь сард 25%, 18 дахь сард 25%, 24 дэх сард 25%.
Үнэт цаасны төлбөр төлөгдөх эх үүсвэр	Хөрөнгийн багц дахь зээлийн үндсэн төлбөр болон хүүний орлого
Үнэт цаасны хүүд ногдох татвар	Хүүний орлогын 5.0 хувь
Үнэт цаасны хадгалалт	Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв
Анхдагч зах зээлийн захиалга	Андеррайтер төвтэй
Арилжаа эрхлэх байгууллага	Улаанбаатар Үнэт Цаасны Бирж
Арилжааны хэлбэр	Нээлттэй зах зээлд
Зээлийн багцын дүн	44,006,588,238
Зээлийн тоо	1,919
Зээлдэгчдийн тоо	1,885
Барьцаа	Барьцаат зээлийн багц, зээлийн эргэн төлөлтийн данс
Зээлийн чанар	100% хэвийн
Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт	Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс зээлийн багц худалдан авахад зарцуулна. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь зээлийн багц худалдсанаас хүлээн авах мөнгийг зээлийн багцыг нэмэгдүүлэхэд зарцуулна.

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947
7239689 ... ХНТ10470

УЛААНБААТАР ХОТ
ТАВАН БОГД КАПИТАЛ УДК ХХК

УЛААНБААТАР ХОТ ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ ULAANBAATAR SECURITIES EXCHANGE 2026 -06- 12 БҮРТГЭВ
СЗХ он сар өдөр 2026 06 11 БҮРТГЭВ №

АГУУЛГА

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР 9
ХҮСНЭГТ 11
ГРАФИК 12
ЗУРАГ 12
1. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН 14
1.1. Макро эдийн засгийн төлөв байдал 14
1.2. Хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдал 18
1.3. Банк бус санхүүгийн байгууллагын салбар 18
1.4. ХБҮЦ-ны тухай, давуу болон сул талууд 21
2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ 26
2.1. Үнэт цаас гаргагчийн ерөнхий мэдээлэл 26
2.2. Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт 26
2.3. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн хурал 27
2.4. Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн мэдээлэл 27
2.5. Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журам 28
2.6. Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүдийн эрх, үүрэг 28
2.7. Үнэт цаас гаргагчийн эхлэлтийн тайлан баланс 29
2.8. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн төсөөлөл 29
3. ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/ АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ 34
3.1. Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчийн товч танилцуулга 34
3.2. Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчийн хуулийн этгээдийн бүртгэл хаяг 34
3.3. Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчийн хувьцаа эзэмшигч 35
3.4. Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчийн бүтэц зохион байгуулалт, компанийн засаглал 35
3.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн танилцуулга 36
3.6. Гүйцэтгэх удирдлагын баг 37
3.7. Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчийн үйл ажиллагаа 39
3.8. Үүсгэн байгуулагчийн эзэмшиж буй тусгай зөвшөөрөл 40
3.9. Үүсгэн байгуулагчийн бүтээгдэхүүн үйлчилгээний танилцуулга 40
3.10. Дотоод орчны эрсдэл 42
3.11. Үйл ажиллагаандаа хэрэгжүүлж буй эрсдэлийн удирдлага 43
3.12. Үүсгэн байгуулагчийн хүний нөөц, программ хангамжийн тухай 45
3.13. Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчийн санхүүгийн тайлан, шинжилгээ 45
3.14. Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчийн бизнес төлөвлөгөө 53
3.15. Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчийн санхүүгийн төсөөлөл 53
3.16. Үйлчилгээ үзүүлэгчийн тухай мэдээлэл, үүрэг 57

УЛААНБААТАР ХОТ ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ ОЧУН АКТИВ НЭГ ТӨК ХХК

2026 06 12
БҮРТГЭВ

СЗХ
2026 05 11 өдөр
БҮРТГЭВ
№ 01

3.17. Үйлчилгээ үзүүлэгчийн байгуулсан гэрээ 58
3.18. Үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан гэрээг цуцлах нөхцөл 58
4. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ 60
4.1. Үнэт цаасжуулах хэлцлийн зураглал 60
4.2. Үнэт цаасны хүү тогтоосон үндэслэл 62
4.3. Үнэт цаастай холбоотой оролцогч талуудтай хийсэн гэрээнүүд 62
4.4. Үнэт цаасны төлбөрийн хуваарь 65
4.5. Хөрөнгийн багц, түүнд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтүүд 65
4.6. Хөрөнгийн багцын мэдээлэл 67
4.7. Хөндлөнгийн шинжилгээний дүгнэлт 68
4.8. Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах тухай 69
4.9. Үнэт цаасыг хөрөнгө оруулагчдад олгохоос өмнө төлөгдөх төлбөр, зардлын мэдээлэл 70
4.10. Үнэт цаасны төлбөрийг төлөх төлбөрийн зохицуулалт 70
4.11. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг буцаан худалдан авах нөхцөл 72
4.12. Үнэт цаасны төлбөр хугацаандаа төлөгдөхгүй нөхцөлд авах арга хэмжээ 73
4.13. Эрсдэлийн удирдлага 73
5. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН 82
5.1. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн орчин 82
5.2. Үнэт цаастай холбоотой журмууд 83
5.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон хөрөнгийн багцтай холбоотой хууль эрх зүйн орчин 84
6. ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА 87
6.1. Үнэт цаасны анхдагч зах зээлийн захиалга хүлээн авах заавар 87
6.2. Үнэт цаас худалдан авах, захиалга өгөх заавар 88
6.3. Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа 88
6.4. Албан татварын тухай 88
6.5. Үнэт цаас эзэмшигчийн эрх 89
6.6. Үнэт цаас гаргагчийн үүрэг 89
7. ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД 91
7.1. Үндсэн андеррайтерийн компани 91
7.2. Дэд андеррайтерийн компани 92
7.3. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тухай 94
7.4. Зээлийн шинжилгээ гаргагч бөгөөд хөндлөнгийн аудитын үйлчилгээ үзүүлэгч 98
7.5. Хуулийн дүгнэлт гаргагчийн тухай 100
7.6. Оролцогч байгууллагууд нь нэгдмэл сонирхол, бизнесийн холбоо хамааралтай эсэх талаарх мэдээлэл 103
7.7. Үнэт цаас гаргах үйл ажиллагааг хариуцсан ажилтнуудын мэдээлэл 104

ТАВАН БОГД КАПИТАЛ ХХК
9026040847
7239689 .\. ХНТ10470

ТАВАН БОГД КАПИТАЛ УЦК ХХК
9021061377

2026 ... 2
СЗХ
2026 ... 11
ҮНЭТГЭВ

8. ХАВСРАЛТ 107
8.1. Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэлийн гэрчилгээ 107
8.2. Үнэт цаас гаргагчийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээ 109
8.3. Үнэт цаас гаргагчийн дүрэм 114
8.4. Үнэт цаас гаргагчийн эхлэлтийн баланс 119
8.5. Үнэт цаас гаргагчийн дүрмийн сан 120
8.6. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээ 122
8.7. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээ 124
8.8. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн дүрэм 129
8.9. Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ 134
8.10. Зээлийн багцын жагсаалт 147
8.11. Мэргэжлийн байгууллагуудыг сонгох тухай ТУЗ-ийн тогтоол 167
8.12. Зээлийн шинжилгээ гаргагчийн улсын бүртгэлийн гэрчилгээ 169
8.13. Зээлийн шинжилгээ гаргагчийн тусгай зөвшөөрөл 171
8.14. Санхүүгийн дүн шинжилгээний тайлан 172
8.15. Хуулийн дүгнэлт гаргагчийн улсын бүртгэлийн гэрчилгээ 183
8.16. Хуулийн дүгнэлт гаргагчийн тусгай зөвшөөрөл 185
8.17. Хуулийн дүн шинжилгээний тайлан 186
8.18. Хуулийн дүгнэлт 208
8.19. Үндсэн андеррайтерийн улсын бүртгэлийн гэрчилгээ 226
8.20. Үндсэн андеррайтерийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээ 228
8.21. Дэд андеррайтерийн улсын бүртгэлийн гэрчилгээ 233
8.22. Дэд андеррайтерийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээ 235
8.23. Андеррайтерийн тодорхойлох захидал 237
8.24. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн улсын бүртгэлийн гэрчилгээ 241
8.25. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээ 243
8.26. Аудитын компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ 248
8.27. Аудитын компанийн тусгай зөвшөөрөл 250
8.28. Нэгдмэл ашиг сонирхолгүй баталгаа СЗХ-нд 251
8.29. Нэгдмэл ашиг сонирхолгүй баталгаа УБҮЦБ-д 258

УЛААНБААТАР ХОТ
ОЧИН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947
7239689 Л. ХНТ10470

УЛААНБААТАР ХОТ
ГАВАН БОГД КАПИТАЛ
ГАВАН БОГД ҮЦК ХХК

2026 ... 12
БҮРТГЭВ

СЭХ
2026.06.11 өдөр
БҮРТГЭВ

НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

Үнэт цаас гаргагч	Үнэт цаасны зах зээлд арилжихаар санал болгож Санхүүгийн зохицуулах хороо болон Биржид үнэт цаасаа бүртгүүлсэн этгээд.
Үүсгэн байгуулагч	Компанийг үүсгэн байгуулсан Монгол улсын иргэн, хуулийн этгээд, хуульд заасан бол гадаад улсын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн, ТЗК-ийн үүсгэн байгуулагчийн хувьд хуульд заасан банк, банк бус санхүүгийн байгууллага, орон сууцны санхүүжилтийн компани болон Хорооноос зөвшөөрсөн санхүүгийн бусад байгууллага.
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасан хөрөнгөөр баталгааждаг, хөрөнгө оруулагч нь уг хөрөнгийн орлогоос тэргүүн ээлжид төлбөрөө гаргуулах эрхийг баталгаажуулсан үнэт цаас буюу энэхүү танилцуулгад заасан ирээдүйд олох зээлийн орлогоор хөрөнгийн багц бүрдүүлэн тусгай зориулалтын компанид шилжүүлэх замаар үнэт цаасжуулсан санхүүгийн хэрэгсэл.
Андеррайтер	Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний үндсэн дээр түүний үнэт цаасыг нийтэд санал болгон гаргахад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч.
Тусгай зориулалтын компани	Хорооноос хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авсан хязгаарлагдмал хариуцлагатай компани.
Анхны үүрэг гүйцэтгүүлэгч	Өөрийн санхүүгийн тайлан, тэнцэлд туссан хөрөнгийг тусгай зориулалтын компанид шилжүүлсэн, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд.
Үйлчилгээ үзүүлэгч	Үүрэг гүйцэтгэгчтэй харилцаж, хөрөнгөтэй холбоотой төлбөрийг цуглуулан тусгай зориулалтын компанид шилжүүлэх, бүртгэх, тайлагнах болон Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөлтэй хуулийн этгээд.
Зээлийн шинжилгээ гаргагч	Хөрөнгийн багц дахь зээлийн данснуудад тавигдах санхүүгийн шалгүүр үзүүлэлт хангагдсан эсэхэд дүгнэлт гаргагч, үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөлтэй хуулийн этгээд.
Хөрөнгө итгэмжлэн удирдагч	Тусгай зориулалтын компанитай гэрээ байгуулсан, хөрөнгө оруулагчид барьцаалуулсан хөрөнгийг түүний эрх ашигт нийцүүлэн эзэмшиж, удирдах болон Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан үүрэг бүхий хөрөнгө итгэмжлэн удирдах тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд.

УЛААНБААТАР ХОТ
ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК

2026 06 12
БҮРТГЭВ
СЗХ
2026.06.11
БҮРТГЭВ

Хууль зүйн дүгнэлт гаргагч	Хөрөнгийн багц дахь зээлийн данснуудад тавигдах хуулийн шалгуур үзүүлэлт хангагдсан эсэх тухайн хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээний тайлан болон Хорооны журмаар тогтоосон агуулгын хүрээнд хууль зүйн дүгнэлт гаргагч үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий, СЗХ-нд бүртгэлтэй хуулийн этгээд.
Хөрөнгийн багц	Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны нэг удаагийн гаргалтыг баталгаажуулж байгаа хөрөнгийн нийлбэр.
Анхдагч зах зээлийн арилжаа	Үнэт цаас гаргагч хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасаа нийтэд санал болгох замаар анхдагч зах зээлд байршуулах, хуваарилалт хийх, арилжих үйл ажиллагаа.

ААН	Аж ахуй нэгж
АҮГ	Анхны үүрэг гүйцэтгүүлэгч
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЖДХ	Жигнэсэн дундаж хүү
ЗЗҮ	Зах зээлийн үнэлгээ
ЗҮХ	Зээл үнэлгээний харьцаа
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
СЗХ	Санхүүгийн Зохицуулах Хороо
ТЗК	Тусгай зориулалтын компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УБЕГ	Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар
УБҮЦБ	Улаанбаатар Үнэт Цаасны Бирж
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ҮЦК	Үнэт цаасны компани
ҮЦТХТ	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
ӨОХ	Өр орлогын харьцаа
ХБҮЦ	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас
ХЭХ	Хувьцаа эзэмшигчдийн хурал
ХИУ	Хөрөнгө итгэмжлэн удирдагч

УЛААНБААТАР ХОТ
ТАВАН БОГД КАПИТАЛ
ТАВАН БОГД
ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ
ТЗК ХХК

2026 -06- 12
ХҮСНЭГТ
БҮРТГЭВ

СЗХ
2026 оны 06 сар 11 өдөр
БҮРТГЭВ

Хүснэгт 1: Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаа 19
Хүснэгт 2: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн танилцуулга 27
Хүснэгт 3: Үнэт цаас гаргагчийн орлогын тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр 29
Хүснэгт 4: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр 30
Хүснэгт 5: Үнэт цаас гаргагчийн мөнгөн гүйлгээний тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр 31
Хүснэгт 6: Ерөнхий ба удирдлагын зардал 32
Хүснэгт 7: Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчийн хуулийн этгээдийн бүртгэл, мэдээлэл 34
Хүснэгт 8: Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчийн хувь эзэмшлийн бүтэц 35
Хүснэгт 9: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн танилцуулга 36
Хүснэгт 10: Гүйцэтгэх удирдлагын багийн танилцуулга 37
Хүснэгт 11: Үүсгэн байгуулагчийн эзэмшиж буй тусгай зөвшөөрлүүд 40
Хүснэгт 12: Эрсдэлийн удирдлагын бодлого, журмууд 44
Хүснэгт 13: Орлого үр дүнгийн тайлан хураангуй, сая төгрөгөөр 46
Хүснэгт 14: Орлого үр дүнгийн тайлангийн босоо шинжилгээ 47
Хүснэгт 15: Санхүүгийн байдлын тайлан хураангуй, сая төгрөгөөр 48
Хүснэгт 16: Санхүүгийн байдлын тайлангийн босоо шинжилгээ 49
Хүснэгт 17: Санхүүгийн тайлангийн харьцааны шинжилгээ 50
Хүснэгт 18: Чанаргүй зээлийн хэмжээ, сая төгрөгөөр 50
Хүснэгт 19: Зохистой харьцааны үзүүлэлт 51
Хүснэгт 20: Үүсгэн байгуулагчийн балансын төсөөлөл, сая төгрөгөөр 53
Хүснэгт 21: Үүсгэн байгуулагчийн орлогын тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр 55
Хүснэгт 22: Голлох харьцаа үзүүлэлтүүд төсөөлөл 56
Хүснэгт 23: Үнэт цаасжуулах үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлүүд 74

УЛААНБААТАР ХОТ
ТАВАН БОГД КАПИТАЛ
ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947

2026 -06- 12
БҮРТГЭВ
2026 .06. 11 өдөр
БҮРТГЭВ
№ 01

ГРАФИК

График 1: Эдийн засгийн өсөлт 14
График 2: ДНБ ба Эдийн засгийн өсөлт, их наяд төгрөг 15
График 3: МУ-ын гадаад валютын нөөц 17
График 4: Банкны салбар зээлийн чанар 19
График 5: ББСБ салбарын зээлийн ангилал 19
График 6: ББСБ-уудын тоо, харилцагчдийн тоо мянгаар 20
График 7: ББСБ-уудын нийт хөрөнгө, Нийт зээлийн хэмжээ, төрбум төгрөг 20
График 8: Салбарын орлогын тайлангийн голлох үзүүлэлтүүд, төрбум төгрөг 21
График 9: Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх үе шат 44
График 10: Нийт хөрөнгө бө өөрийн хөрөнгө, төрбум төгрөгөөр 47
График 11: 12 сарын хугацаатай хүүгийн харьцуулалт 62

ЗУРАГ

Зураг 1: ХБҮЦ-ны зураглал 21
Зураг 2: Очир Үндраа ОМЗ ББСБ-ийн лого 34
Зураг 3: Үүсгэн байгуулагчийн бүтэц зохион байгуулалт 35
Зураг 4: Зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ 40
Зураг 5: ОРАУ аппликэйшн 42
Зураг 6: Эрсдэлийн матриц 43
Зураг 7: Хэлцлийн зураглал 60
Зураг 8: ХБҮЦ-ыг анхдагч зах зээлд санал болгох үйл явц 87

УЛААНБААТАР ХОТ
ТАВАН БОГД КАПИТАЛ
ТАВАН БОГД КАПИТАЛ ХХК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК


ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН
ОРЧИН

2026 -ны 2
БҮРТГЭВ

СЭХ
2026 .06. 11
БҮРТГЭВ

1. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧИН


1.1. Макро эдийн засгийн төлөв байдал

Эдийн засгийн өсөлт

Монгол улсын хувьд 2017 оноос улсын төсвийн гүйцэтгэлд эерэг өөрчлөлтүүд гарч, макро эдийн засгийн бодлогын уялдаа сайжирч, түүхий эдийн үнэ харьцангуй өсөлттэй байсан нь 2020 оныг хүртэл үргэлжилж эдийн засаг таатай байх нөхцөлийг бүрдүүлээд байсан. Гэвч 2020 онд Ковид-19 цар тахал гарсны нөлөөгөөр дэлхий дахинд түүхий эдийн эрэлт огцом буурч, БНХАУ-тай хиллэх хилээ хаасан нь эдийн засгийн өсөлт -4.6%-тай гарахад нөлөөлсөн. Харин 2022 оноос уул уурхайн олборлолт болон экспортын хэмжээ нэмэгдсэнээр эдийн засаг буцаж сэргэсэн.

2024 оны эцсээр Монгол улсын эдийн засгийн өсөлт 4.9 хувьтай гарсан нь өмнөх онтой харьцуулахад бага зэрэг саарсан ч ашигт малтмалын олборлолт болон үйлчилгээний салбарын нөлөөгөөр эрчимтэй өссөн. Уул уурхайн салбарын өсөлт, тэр дундаа зэсийн баяжмалын үйлдвэрлэлээ нэмэгдүүлж буй Оюу толгойн уурхай 2026 оны эдийн засгийн өсөлтөд гол түлхэц үзүүлнэ. Харин өнгөрсөн онуудад малын хорогдлын томоохон хохирол амссан хөдөө аж ахуйн салбар энэ онд сэргэх төлөвтэй байна.

График 1: Эдийн засгийн өсөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2026 оны 1-р сарын байдлаар эдийн засгийн өсөлт 8.6% орчим байна. Уул уурхайн салбарын өсөлт саарсан ч дотоодын хэрэглээ, үйлчилгээ, хөдөө аж ахуйн салбарын сэргэлтээр нөхөгдөж байгаа дүр зурагтай баина.


2024 оны турш эдийн засгийн идэвхжил өндөр түвшинд хадгалагдаж, Хятадын эдийн засгийн сэргэх хандлага, нүүрсний экспорт, гадаад худалдааны эерэг орчин зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр ДНБ-ийн өсөлт 6.8% хүрсэн бол 2025 оны жилийн эцсээр 4.9% болсон байна. Энэ нь төсвийн тэлэлттэй бодлого, хэрэглээний өсөлт, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт нэмэгдсэнтэй холбоотой.

УЛААНБААТАР ХОТ
ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947
7239689 ХНТ10470

2026 -06- 12 БҮРТГЭВ
СЗХ 2026 .06. 11 ӨДӨР БҮРТГЭВ

График 2: ДНБ ба Эдийн засгийн өсөлт, их наяд төгрөг



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Төсөв, төлөвлөлт

Төсвийн орлогын хэмжээ ДНБ-д эзлэх хувиар тогтвортой буюу 35.7%-ийн орчимд байна гэж таамаглаж байгаа ч уул уурхайн орлого 2026 онд ДНБ-ий 16.7%-ийг эзэлж байсан бол 2028 он гэхэд 14.5% болж буурах төлөвтэй байна. Харин төсвийн зарлагын хэмжээ өндөр хэвээр, ДНБ-д эзлэх хувь нь 36.8%-аас 37.7% хүртэл өсөх хандлагатай байна. Энэ нь төсвийн алдагдлыг нэмэгдүүлэх эрсдэлийг дагуулж байгаа тул төсвийн сахилга батыг баримтлан зарлагаа хянахыг зөвлөж байна.

Засгийн газрын нийт өрийн түвшин 2026 онд ДНБ-ий 37.5%, 2028 онд 36.3% болж аажмаар буурахаар байна. Гэсэн хэдий ч өндөр өрийн түвшин төсөвт дарамт учруулах эрсдэлтэй тул анхааралтай хандах шаардлагатай.

Төсвийн орлогын өсөлт нь уул уурхайн салбарын сэргэлт, экспортын гол нэрийн бүтээгдэхүүний үнийн таатай төлөв, дотоодын татварын орлогын нэмэгдэл зэрэг хүчин зүйлсэд үндэслэгдсэн. Тухайлбал, зэс, нүүрсний экспортын хэмжээ болон үнэ өсөх хандлагатай байгаа нь төсвийн орлогыг нэмэгдүүлэхэд эергээр нөлөөлөхөөр байна.

Зарлагын талд, нийгмийн халамж, боловсрол, эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, дэд бүтцийн төслүүдийг үргэлжлүүлэх зэрэг бодлогын чиглэлүүдийг тусгасан. Төсвийн зарлагын өсөлт нь эдийн засгийн өсөлтийг дэмжих, иргэдийн амьжиргааг сайжруулахад чиглэж байгаа боловч төсвийн алдагдлыг нэмэгдүүлэх эрсдэлтэй тул Засгийн газар санхүүгийн сахилга батыг чанд хадгалах бодлого баримталж байна.

Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх хүрээнд Засгийн газар дотоодын үнэт цаасны зах зээлийг идэвхжүүлэх, гадаад зээл, тусламжийн эх үүсвэрийг оновчтой ашиглах зэрэг арга хэмжээг төлөвлөж байна. Энэ нь хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэнэ.

Энэхүү төсвийн төлөвлөлт нь Монгол Улсын эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах, санхүүгийн сахилга батыг бэхжүүлэх зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэж байгаа бөгөөд хөрөнгө оруулагчдын хувьд Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал, санхүүгийн бодлогын чиг хандлагыг биллгоход чухал мэдээлэл болно.

Инфляц, хүү ба Мөнгөний бодлого

УЛААНБААТАР ХОТ ТАВАН БОГД КАПИТАЛ ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК ХХК
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК

2026 -12
БҮРТГЭВ
СЭХ
2026 .09. 11 өдөр
БҮРТГЭВ

Жил дараалсан цалингийн өндөр өсөлт болон цахилгаан, нийтийн тээвэр зэрэг төрийн зохицуулалттай үйлчилгээний үнэ нэмэгдсэнээс инфляц 2025 оны эхний саруудад эрчимжиж зорилтоос даваад байв. Мөнгө, санхүүгийн бодлогын төлөвийг шат дараатайгаар хатууруулсан, өвөлжилт өнтэй байсан зэргээс сүүлийн саруудад инфляц аажим буурч байна. Цаашид эдийн засагт томоохон шок бий болохгүй, төрийн зохицуулалттай үйлчилгээний үнэ огцом өсөхгүй тохиолдолд инфляцын буурах хандлага үргэлжилж зорилтот түвшинд хүрч тогтворжихоор байна.

2026 онд Монгол Улсын эдийн засаг тогтвортой өсөлттэй байх төлөвтэй байгаа ч инфляцын түвшин өндөр хэвээр хадгалагдах хандлагатай байна. Азийн хөгжлийн банкны таамаглалаар энэ онд инфляцын жилийн дундаж түвшин 7-8 хувьд хүрэхээр байна. Инфляцын өсөлтөд нөлөөлөх гол хүчин зүйлсэд өрхийн хэрэглээний өсөлт, эрчим хүчний үнэ нэмэгдэлт, ханшийн савлагаа, махны нийлүүлэлтийн бууралт зэрэг багтаж байна.

Монголбанк инфляцын өсөлтийг хязгаарлах зорилгоор мөнгөний бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. 2026 оны гуравдугаар сард бодлогын хүүг 12 хувьд хэвээр хадгалсан нь зээлийн өсөлтийг сааруулах, инфляцын дарамтыг бууруулахад чиглэсэн алхам байв. Мөн 2025 онд хэрэглээний зээлд тавигдах шаардлагыг чангаруулж, өр, орлогын харьцааны дээд хязгаарыг 50 хувьд тогтоосон.

Төв банкны зорилт нь инфляцыг 6 ±2 нэгж хувийн интервалд тогтворжуулах бөгөөд дунд хугацаанд буюу 2027 оноос 5 хувьд хүргэхээр төлөвлөж байна. Энэ хүрээнд мөнгөний бодлогын хатуу хяналтыг үргэлжлүүлж, банкны салбарын тогтвортой байдлыг хангах, гадаад валютын ханшийн уян хатан байдлыг хадгалах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Эдийн засгийн өсөлт, инфляцын дарамт зэрэг хүчин зүйлсийг харгалзан үзвэл, Монгол Улсын мөнгөний бодлого 2026 онд инфляцын өсөлтийг хязгаарлах, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах чиглэлд төвлөрч байна. Хөрөнгө оруулагчдын хувьд энэ нь эдийн засгийн төлөв байдлыг ойлгоход чухал мэдээлэл болох юм.

Гадаад сектор

“Уул уурхай болон үйлчилгээний салбарын эрчимтэй өсөлт хөдөө аж ахуйн салбарын огцом агшилтыг нөхсөнөөр Монгол Улсын эдийн засаг 2024 онд тэсвэртэй байдлаа хадгалж чадлаа” гэж АХБ-ны Орон хариуцсан ахлах эдийн засагч Эдуард Фэйбер хэлээд "2025 болон 2026 онд уул уурхайн салбар эдийн засгийн өсөлтийн гол хөдөлгүүр хэвээр байх бөгөөд дотоодын эрэлт өсч, дэд бүтцийн хөрөнгө оруулалт нэмэгдэж, хөдөө аж ахуйн салбар аажмаар сэргэж буй нь өсөлтөд түлхэц үзүүлнэ. Гэсэн хэдий ч Монгол Улс түүхий эдийн экспорт, тэр дундаа нүүрсний экспортоос хамааралтай байгаа тул эрсдэл байсаар байна" хэмээн тодотгов.

Уул уурхайн үйлдвэрлэл нэмэгдсэнээр экспорт өсөх төлөвтэй байна. Харин хөрөнгө оруулалтын төслүүдэд шаардагдах үндсэн тоног төхөөрөмж, бараа материал зэрэг импортын өсөлт буурахгүй хэвээр байх хүлээлттэй байна. Барааны худалдааны тэнцэл ашигтай хэвээр байх боловч үйлчилгээний худалдааны алдагдал, орлогын гадагшлах урсгалын улмаас урсгал данс алдагдалтай хэвээр байх төлөвтэй байна.

Төсөөллийг бууруулж болзошгүй эрсдэлүүд нь түүхий эдийн үнэ унах, нүүрсний эрэлт буурах, хөдөө аж ахуйн салбарт сөргөөр нөлөөлж болзошгүй байгаль цаг уурын эрсдэл, инфляц тооцоолсноос илүү нэмэгдсэнээр мөнгөний хатуу бодлого баримталж эхлэх зэрэг болно. Харин уул уурхайн салбарын үйлдвэрлэл, тэр дундаа зэсийн

ГАВАН БОГД ХАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК


2026 01 12
БҮРТГЭВ
2026 06 11
БҮРТГЭВ

олборлолт төсөөлж байснаас хурдан нэмэгдэх нь эдийн засгийг төсөөллийг өсгөх магадлалтай.

Бодит эдийн засгийн нөхцөл байдал эерэг хэвээр байгаа ч худалдааны гол түншүүдийн эрэлтийн өөрчлөлт нь өсөлтийн төсөөлөлд саад учруулж болзошгүй. Бодит эдийн засаг дахь хөдөлмөр эрхлэлт, өрхийн орлого, амьжиргааны түвшин тогтвортой өсөх, өрхийн орлого, цалин өнөөгийн болон ирээдүйн үнэ цэнээ алдахгүй байх, нийт хөдөлмөр эрхэлж буй хүн амын оролцооны түвшин өндөр байх нь эсэхээс шалтгаалан зээлийн чанар, зээл эргэн төлөгдөх магадлал хамаарна. МУ-ын хэмжээнд өрхийн орлого нэмэгдэж буй. ББСБ-ын зүгээс зээлдэгчийг санхүүгийн дарамтад оруулахаас урьдчилан сэргийлэх, зээлдэгчийн орлогоос хамааруулан тухайлсан бүтээгдэхүүн үйлчилгээ санал болгох замаар эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Валютын ханш

График 3: МУ-ын гадаад валютын нөөц



Эх сурвалж: Монголбанк

2019 оноос эхлэн Монгол банкны зүгээс валютын зах зээлд оролцох оролцоо үлэмж хэмжээгээр нэмэгдэж, экспортын үйл ажиллагаа эрхэлдэг томоохон уул уурхайн ААН-үүдээс шууд валют худалдан авч түүнийгээ зах зээлд интервенц хийх замаар ам.доллар төгрөгийн ханшийг тогтвортой байлгах арга хэмжээ авч байна. 2026 оны 2-р сарын байдлаар Монгол улсын гадаад валютын нөөц 6.8 тэрбум доллартой тэнцэж байна. Гэсэн хэдий ч ам.доллартай харьцах төгрөгийн ханш суларсаар байгаа нь төлбөрийн тэнцэл алдагдалтай гарах, худалдан авах чадвар буурч эдийн засгийн өсөлт саарах зэрэг эрсдэлийг үүсгэж байна.

Зээлийн хүү ба инфляц

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2026 оны 3 дугаар сарын 18, 20-ны одруудийн эсэжит журлаар бодлогын хүүг 12 хувьд хэвээр хадгалах шийдвэр гаргалаа. Инфляц 2026 оны II сарын байдлаар 6.5%-д хүрч буурсан хэдий ч мах, хүнсний ногоо болон шатахууны үнэ нэмэгдэх хандлагатай байгаа нь инфляцыг цаашид өсгөж болзошгүй байна. Эдийн засгийн өсөлт 2025 онд 6.8%-д хүрч эрчимжихэд хөдөө аж ахуй, уул уурхай болон аж үйлдвэрийн салбар гол хувь нэмэр оруулаа. Энэ онд уул уурхайн салбар, томоохон төслүүдийн бүтээн байгуулалт эдийн засгийн өсөлтийг тэтгэхээр байна. Цаашид эдийн засгийн өсөлт потенциал түвшнийхээ орчимд тогтворжих хүлээлттэй байна. Мөн олон улсад өрнөж буй геополитикийн хурцадмал байдал, гэнэтийн өөрчлөлтүүд нь тодорхой бус байдлыг нэмэгдүүлж байгаа нь

ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК ХХК
5469112 9021061377
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК

2026 БҮРТГЭВ
СЗХ БҮРТГЭВ

цаашлаад инфляцыг өсгөх эрсдэл дагуулж байгаа юм. Энэхүү шийдвэр нь инфляцыг 2027 оноос +/-2 нэгж хувийн интервалд 5 хувьд тогтворжуулах Төв банкны зорилттой нийцтэй бөгөөд дунд хугацаанд макро эдийн засгийн тогтвортой байдлыг дэмжихэд чиглэж байна.

1.2. Хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдал

Өнгөрөгч онуудад Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал хүндхэн байсан ч хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2025 онд 6.6 хувиар өсөж 13.9 их наяд төгрөгт хүрлээ. Хөрөнгийн зах зээлд нийт 634 зохицуулалттай этгээд, хувьцаат компани үйл ажиллагаа эрхэлж байна.

Үнэт цаасны зах зээлийн арилжаа

2025 онд 1.3 их наяд төгрөгийн үнэт цаас зах зээлд арилжигдсан нь өмнөх оноос 16.7 хувиар, 2021 оноос 7.0 хувиар буурсан үзүүлэлт юм. Тайлант онд хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны хөрвөх чадвар 2.1 хувь байна.

Нийт хувьцааны арилжаа 287.2 тэрбум төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 19.9 хувиар, 2021 онтой харьцуулахад 5.8 хувиар тус тус буурчээ. Компанийн бондын арилжаа 323.6 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх онтой харьцуулахад 64.6 хувиар, 2021 онтой харьцуулахад 69.1 хувиар тус тус буурчээ. ХОС-ийн арилжаа 188.0 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх онтой харьцуулахад 83.6 хувиар, 2021 онтой харьцуулахад 3.3 дахин өсжээ. Засгийн газрын дотоод үнэт цаас (ЗГДҮЦ)-ны арилжаа 144.6 тэрбум төгрөгт хүрсэн.

Нийт арилжааны 28.3 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (ХБҮЦ)-ны, 24.6 хувийг компанийн бондын, 21.8 хувийг хувьцааны, 14.3 хувийг хөрөнгө оруулалтын сан (ХОС)-гийн нэгж эрхийн, 11.0 хувийг Засгийн газрын дотоод үнэт цаас (ЗГДҮЦ)-ны арилжаа тус тус эзэлж байна. ХБҮЦ-ны арилжаа 372.1 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх онтой харьцуулахад 80.6 хувиар, 2021 онтой харьцуулахад 88.0 дахин өсжээ. 2025 онд шинээр гаргасан компанийн өрийн хэрэгслийн арилжаанд "Бэрс Эй Би Эс про ТЗК" ХХК, "Си И Си Ая ассет ван ТЗК" ХХК болон "Жи Эс Би актив хоёр ТЗК" багтаж байна.

Харин 2026 оны 2-р сард "Монголын хөрөнгийн бирж", "Улаанбаатар үнэт цаасны бирж", "Чингисхаан хөрөнгийн бирж"-ээр нийт 133.7 тэрбум төгрөгийн арилжаа явагдсан байна. Нийт арилжааны 16.0 хувийг хувьцааны, 15.9 хувийг Засгийн газрын дотоод үнэт цаасны, 12.7 хувийг компанийн бондын, 0.1 хувийг хөрөнгө оруулалтын сангийн, 55.3 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа тус тус эзэлж байна.

1.3. Банк бус санхүүгийн байгууллагын салбар


Санхүүгийн салбар

Монгол улсын санхүүгийн салбарт банк, хөрөнгийн зах зээл, Банк бус санхүүгийн байгууллага, даатгал, хадгаламж зээлийн хоршоо, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч, зээлийн батлан даалтын сан, үл хөдлөх хөрөнгө зуучлал, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид багтана. Монголын санхүүгийн зах зээлийн дийлэнх хэсгийг банкны салбар бүрдүүлсэн хэвээр байгаа бөгөөд 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт актив 85.4 их наяд төгрөг, нийт пассив 77.0 их наяд төгрөг, өөрийн хөрөнгө 8.5 их наяд төгрөг байна.

УЛААНБААТАР ХОТ
ТАВАН БОГД КАПИТАЛ
ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК ХХК
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947
7239689 ХНТ10470

2026 ... 2
БҮРТГЭВ
СЗХ
2026 он, 06, сар 11 өдөр
БҮРТГЭВ

График 4: Банкны салбар зээлийн чанар



Эх сурвалж: Монголбанк

2026 оны 2-р сарын 28-ны байдлаар нийт зээлийн 91.3 хувь хэвийн ангилалд, 5.3 хувь буюу 2.3 их наяд төгрөгийн зээл чанаргүй ангилалд тус тус ангилагдаж байна.

Банк бус санхүүгийн салбарын үзүүлэлт

2025 оны жилийн эцсийн байдлаар Санхүүгийн зохицуулах хорооноос банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 575 ББСБ байгаа нь өмнөх оноос 20 ББСБ буюу 0.3 хувиар өссөн үзүүлэлт юм. Эдгээр ББСБ-уудын 4.5 хувь нь гадаадын, 95.5 хувь нь үндэсний хөрөнгө оруулалттай байна. ББСБ-ын харилцагчдын тоо давхардсан тоогоор 4.1 саяд хүрчээ.

Хүснэгт 1: Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаа


Тусгай зөвшөөрөл	ББСБ-ын тоо
Нийт	575
Зээл	512
Итгэлцэл	91
Факторинг	60
Төлбөрийн баталгаа	29
Төлбөр тооцоо	7
Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	56
Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	55
Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлал	1
Гадаад валютын арилжаа	165

Эх сурвалж: СЗХ-ны ББСБ-уудын 2025 оны тайлангийн нэгтгэл

ББСБ-ын зээлийн багцын чанар

Зээлийн багцын 87.2 хувийг хэвийн зээл, 4.4 хувийг анхаарал хандуулах зээл, 8.4 хувийг чанаргүй зээл бүрдүүлж байна. Салбарын нийт зээлийн хэмжээ өмнөх оноос 25.5 хувиар буюу 1.5 их наяд төгрөгөөр, 2021 оноос 3.6 дахин буюу 5.2 их наяд төгрөгөөр өсжээ.

График 5: ББСБ салбарын зээлийн ангилал




УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947
7239689 ... ХНТ10470
УЛААНБААТАР ХОТ
КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
2026 БҮРТГЭВ
СЗХ
БҮРТГЭВ
№ 01

Эх сурвалж: СЗХ-ны ББСБ-уудын 2025 оны тайлангийн нэгтгэл

Нийт харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 23.9 хувиар буурч давхардсан тоогоор 4,102,801-д, нийт зээлдэгчдийн тоо өмнөх оны мөн үеэс 36.6 хувиар өсөж 3,153,503-д хүрээд байна. ББСБ-ын салбарын нийт харилцагчдын 89.8 хувь нийт зээлдэгчдийн 90.1 хувь нь финтек үйлчилгээнд хамрагджээ. Санхүүгийн үйлчилгээнд технологийн дэвшил ашиглаж буй ББСБ-уудын зээлийн үлдэгдлийн 83.8 хувь нь хэвийн, 6.7 хувь нь хугацаа хэтэрсэн, 9.4 хувь нь чанаргүй зээлийн ангилалд байна. Зөвхөн технологид суурилж зээл олгодог 6 ББСБ нь салбарын зээлдэгчдийн 40.6 хувийг, нийт зээлийн үлдэгдлийн 9.1 хувийг, олгосон зээлийн 27.3 хувийг, төлөгдсөн зээлийн 28.3 хувийг тус тус эзэлж байгаа нь эдгээр ББСБ-уудын зээлийн эргэлт сайн байгааг илтгэж байна.

График 6: ББСБ-уудын тоо, харилцагчдийн тоо мянгаар



Эрхэлж буй үйл ажиллагаагаар авч үзвэл зээлийн үйл ажиллагааг эрхэлж буй 512 ББСБ, гадаад валютын арилжааны үйл ажиллагааг дагнан эрхэлж буй 165 ББСБ байгаа юм. Мөн факторингийн үйлчилгээ эрхлэх 60, итгэлцлийн үйлчилгээ эрхлэх 91, цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулгын 55 ББСБ тус тус байна.

Эх сурвалж: СЗХ-ны ББСБ-уудын 2025 оны тайлангийн нэгтгэл

Зээлийн бүтэц

Нийт хөрөнгийн хэмжээ 2025 оны жилийн эцсийн байдлаар 9.1 их наяд төгрөг, нийт зээлийн хэмжээ 7.1 их наяд төгрөгт тус тус хүрээд байна. ББСБ-ын салбарын нийт хөрөнгө 9.1 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх онтой харьцуулахад 27.4 хувиар буюу 2.0 их наяд төгрөгөөр өсжээ. Үүнд зээлийн 75.2 хувийн өсөлт нөлөөлжээ. Салбарын эх үүсвэрийн бүтцийн 45.5 хувь нь өр төлбөр, 54.6 хувь нь өөрийн хөрөнгө болно. Үүний 62.3 хувь нь өр төлбөрийн өсөлт, 37.7 хувь нь өөрийн хөрөнгийн өсөлт болно.

График 7: ББСБ-уудын нийт хөрөнгө, Нийт зээлийн хэмжээ, тэрбум төгрөг



Эх сурвалж: СЗХ-ны ББСБ-уудын 2025 оны тайлангийн нэгтгэл

Салбарын нийт орлого 2,718.0 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 48.7 хувиар өсөлттэй, нийт зардал 1,771.9 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 56.8 хувь өссөн, цэвэр ашиг 946.1 тэрбум төгрөг болсон нь өмнөх онтой харьцуулахад 35.6 хувь нэмэгдсэн бөгөөд энэ өсөлт нь зах зээлийн идэвхжил, хүүгийн орлогын огцом өсөлт болсон байгууллагуудын

ТАВАН БОГД КАПИТАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ
ӨЧҮҮ АКТИВ ПЭЙ
ТӨХК ХХК
9026040947
7239689 ХНТ10

2026 2
БҮРТГЭВ
СЗХ
2026 .08. 11 өдөр
БҮРТГЭВ
№ 01

санхүүгийн стратеги оновчтой хэрэгжсэнтэй шууд холбоотой байгааг харуулж байна. 508 ББСБ нь нийт 952.6 тэрбум төгрөгийн ашигтай, 9 ББСБ нь тайлант хугацаанд ашиг, алдагдалгүй, 58 ББСБ нь нийт 6.5 тэрбум төгрөгийн алдагдалтай.

График 8: Салбарын орлогын тайлангийн голлох үзүүлэлтүүд, тэрбум төгрөг



Эх сурвалж: СЗХ-ны ББСБ-уудын 2025 оны тайлангийн нэгтгэл


Цар тахлын улмаас 2020-2021 онуудад ББСБ салбарын өсөлт харьцангуй удаашралтай байсан бол 2022 оноос эхлэн идэвхжиж, үндсэн үйл ажиллагаа болох зээл олголтын хэмжээ нэмэгдсэн. Үүнийгээ дагаад хүүгийн орлого болон түүнээс олох цэвэр ашгийн хэмжээ ч мөн нэмэгдсэн ба 2025 оны жилийн эцсийн байдлаар орлогын хэмжээ 2.7 их наяд, цэвэр ашгийн хэмжээ 946.1 тэрбум төгрөгт тус тус хүрсэн байна.

1.4. ХБҮЦ-ны тухай, давуу болон сул талууд

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зураглал

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь Монгол улсын "Хөрөнгөөр Баталгаажсан Үнэт Цаасны тухай" хуульд зааснаар санхүүгийн мөнгөн урсгал бий болгох хөрөнгөөр баталгааждаг ба хөрөнгө оруулагч нь уг хөрөнгийн орлогоос тэргүүн ээлжид төлбөрөө гаргуулах эрхийг баталгаажуулсан үнэт цаас юм. Тухайлбал, олон улсад хамгийн түгээмэл танигдсан бүтээгдэхүүн бол АНУ-ын моргейжийн гэрээг багцалсан хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас юм. Энгийнээр тайлбарлавал тухайн компанийн ирээдүйд орж ирэх гэрээгээр баталгаажсан мөнгөн урсгалыг багцлан, бүтээгдэхүүн болгож ирээдүйн төлбөрийг тухайн гэрээгээр баталгаажсан мөнгөн урсгалаар төлөх үйл явц юм.

Зураг 1: ХБҮЦ-ны зураглал



2026 . 2 БҮРТГЭВ
СЭХ 2026 он 01 сар 11 өдөр БҮРТГЭВ №01

ХБҮЦ гаргах болон үйл ажиллагаа хэвийн явагдахад оролцогч талууд

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч – Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т заасанчлан анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь өөрийн санхүүгийн тайлан, тэнцэлд түссан хөрөнгийг түсгай зориулалтын компанид шилжүүлсэн, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд байна.

Тусгай Зориулалтын компани – Тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т заасанчлан Тусгай Зориулалтын Компани нь Компанийн тухай хууль болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу байгуулагдсан, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл авсан хязгаарлагдмал хариуцлагатай компани байна.

Хөрөнгө Итгэмжлэн удирдагч – Тус хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т заасанчлан Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь тусгай зориулалтын компанитай гэрээ байгуулсан, хөрөнгө оруулагчид барьцаалуулсан хөрөнгийг түүний эрх ашигт нийцүүлэн эзэмшиж, удирдах эрх үүрэг бүхий этгээд байна.

Үйлчилгээ үзүүлэгч – Тус хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-т заасанчлан Үйлчилгээ үзүүлэгч нь Үнэт цаас гаргагчтай байгуулсан Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээний хүрээнд Хөрөнгөтэй холбоотой төлбөр цуглуулан ТЗК-д шилжүүлэх, бүртгэх, тайлагнах болон үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасан хөрөнгөтэй холбоотой бусад үйлчилгээ, үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд байна.

Хуулийн фирм – ТЗК-иас тогтоосон хууль зүйн шалгуур үзүүлэлтийн дагуу санамсаргүй түүврийн сонгосон хөрөнгийн багцад багтсан зээлийн дансдад дүн шинжилгээ хийж, хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах ажиллагаанд хөндлөнгийн хууль зүйн үйлчилгээ үзүүлж, хууль зүйн дүгнэлт гаргах, үнэт цаас гаргагчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх эрх бүхий хуулийн этгээд;

Аудитын байгууллага – Үнэт цаас гаргагчийн зээлийн багцад болон санхүү аудитын дүгнэлт гаргах, ТЗК-тай холбоотой аудитын дүгнэлт гаргах этгээд.

Зээлийн шинжилгээ гаргагч – Хөрөнгийн багц дахь зээлүүд нь ТЗК-иас тогтоосон санхүүгийн шалгуур үзүүлэлтэд нийцэж буй эсэхэд санхүүгийн дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх эрх бүхий аудитын компани.

Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны онцлог

Тодорхой байдал

Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас нь Зээлийн багцын ирээдүйн мөнгөн урсгалаар баталгаажсан байдаг. Цаашлаад зээлийн үндсэн хүү, төлөгдөх хугацаа, үе шатлал зэрэг нь хуваарийн дагуу явагддаг учир мөнгөн хөрөнгө эргэн төлөгдөх баталгаат урсгалтай.

Найдвартай байдал

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн тайлан балансаас зээлийн багцыг хасаж ТЗК-д шилжүүлснээр тусдаа хяналтын бүтцэд оруулдаг.

Эрсдэлийг бууруулна

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн тайлан балансаас зээлийн багцыг хасаж бүртгэсний хүрээнд компанийн аливаа эрсдэл, мөнгөн хөрөнгө тасалдал, дампуурал зэрэг нь хөрөнгөөр баталгаажсан зээлийн багцад нөлөө үзүүлэхгүй.

Өндөр өгөөж

ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК

2026 К 2 БҮРТГЭВ
СЗХ 2026 .06. 11 БҮРТГЭВ № 01

ХБҮЦ-ны өгөөжийн түвшин өндөр тогтох боломжтой байдаг ба эрсдэлээр жигнэсэн өгөөжийн хувьд харьцангуй өндөр.

Менежмент

Зээлийн багцыг шаардах эрхийг Тусгай Зориулалтын Компанид шилжүүлэхээс гадна хөрөнгө итгэмжлэн удирдагч нь зээлийн багцад хяналт тавьснаар олон талт менежментийн системийг бий болгоно.

Үнэт цаасжуулалт

Тусгай зориулалтын компани нь ирээдүйн орлогоо барьцаалан шинээр санхүүжилт татах боломжтой байдаг. ХБҮЦ гаргаж татан төвлөрүүлэх дүн нь зээлийн багцад суурилж тодорхойлогддог.

Эрсдэл

Компанийн зээлийн багцыг салгаж дампуурах эрсдэлийг хязгаарлаж өгдөг хэдий ч багц зээл нь тасалдах эрсдэлтэй. Мөн харилцаанд орж буй талуудын уялдаа холбоог нарийн тодорхойлж өгөөгүйгээс үүдэн үүргийн гүйцэтгэл хангагдахгүй байх, ХБҮЦ-ны эргэн төлөлтийн үйл ажиллагаа тасалдах магадлалтай. Түүнчлэн ТЗК-ийн баталсан журмуудыг баримталж ажиллахгүй байх эрсдэл гарах магадлалтай.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас нь дараах хоёр төрлөөс бүрдэнэ. 1) Баталгаат үнэт цаас, 2) Барьцаат үнэт цаас.

	1) Баталгаат үнэт цаас	2) Барьцаат үнэт цаас
Үнэт цаас гаргагч	Тусгай зориулалтын компани	Орон сууцны санхүүжилтийн компани, Банк

1) Баталгаат үнэт цаас нь

Хөрөнгийг анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үнэт цаас гаргагчийг үүсгэн байгуулагч, худалдагчийн санхүүгийн тайлан, тэнцлээс хасаж, хөрөнгөтэй холбоотой шаардах эрх болон олох орлогыг тусгай зориулалтын компанийн санхүүгийн тайлан, тэнцэлд шилжүүлэн анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагчийг хөрөнгөтэй холбоотой үүргээс бүрэн чөлөөлснийг гэрчилсэн үнэт цаас байна.

2) Барьцаат үнэт цаас нь

Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан, тэнцэлд тусгаарлан бүртгэгдсэн, орон сууцны зээлийн болон хуулиар зөвшөөрсөн бусад үл хөдлөх эд хөрөнгийн барьцаатай холбоотой шаардах эрхээр баталгаажсан, үнэт цаасны танилцуулгад заасан хугацаанд үндсэн төлбөр, түүний хүүг хөрөнгө оруулагчид төлөх үүргийг гэрчилсэн үнэт цаас байна.

Үнэт цаас худалдан авагчид үүсэх давуу тал

Давуу тал	Сул тал
▸ Аюулгүй байдал/ Компанийн эрсдэлийг хааж өгсөн/ ▸ Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үйл ажиллагаа тасалдах, дампуурсан тохиолдолд ч ХБҮЦ хэвийн төлөгдөнө.	▸ Эргэн дуудах нөхцөл Зээлийн багцын төлөлт хугацаанаас өмнө орж ирсэн тохиолдолд ХБҮЦ-ыг эргэн дуудах нөхцөлтэй гаргадаг. Ингэснээр худалдан авсан хөрөнгө оруулагчид хугацаанаас өмнө эргэн


ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ ОЧУП ХӨРӨНГӨ ТЗК ХХК

2026 ... 2
Б ҮРТГЭВ
СЭХ
2026 .06. 11 . өдөр
БҮРТГЭВ
№ 01

- Хугацаанаас өмнө төлөлт хийгдэх эрсдэл
- Хугацаанаас өмнө төлөлт хийгдэх эрсдэлийг бууруулах арга хэмжээ
- Хугацаанаас өмнө төлөлт хийгдэх эрсдэлийн үр дагавар
- Худалдан авагчдын мөнгөн урсгал орж ирэх хугацаа, төлбөр төлөх дараалал тодорхой
- Гэрээлэгдсэн учир эргэн төлөлтийн мөнгөн урсгал орж ирэх эх үүсвэр тодорхой
- Биржээр дамжуулж хугацааны өмнө борлуулах боломжтой өндөр

төлөлтөө авах магадлалтай. "Очун Актив Нэг ТЗК" ХХК-ийн гаргаж буй ХБҮЦ-ны хувьд ХБҮЦ-ны тухай хуульд зааснаас бусад тохиолдолд эргэн дуудаж төлөлт хийх нөхцөлгүй тул энэхүү эрсдэлийг хаасан байна.

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
УЛААНБААТАР ХОТ



ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

2026 -06- 12

СЗХ
2026 . 06 . 11 . өдөр
БҮРТГЭВ
№ 01

2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

2.1. Үнэт цаас гаргагчийн ерөнхий мэдээлэл

Үнэт цаас гаргагч "Очун Актив Нэг ТЗК" ХХК нь анх 2026 оны 01 сарын 23-ны өдөр бизнесийн зөвлөгөө өгөх үйл ажиллагааны чиглэлээр үүсгэн байгуулагдаж, СЗХ-ны 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 84 тоот тогтоолоор хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авч, 2026 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн улсын бүртгэлд бүртгүүлж ТЗК болсон.

Үнэт цаас гаргагч	Очун Актив Нэг ТЗК ХХК
Улсын бүртгэлд бүртгүүлсэн огноо	2026 оны 01 сарын 23
Регистрийн дугаар	7239689
Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ	1,000,000 (нэг сая) төгрөг
Гаргасан болон зарласан хувьцааны тоо	Нэг бүр нь 1,000 төгрөгийн үнэ бүхий 1,000 хувьцаа
Хувьцаа эзэмшигчийн оноосон нэр	"Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК
Хувьцаа эзэмшигчийн хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь	100%
Улсын бүртгэлийн дугаар	9011888355
Үйл ажиллагааны үндсэн чиглэл	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах
Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл авсан огноо	2026 оны 03 сарын 26
Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар	ТЗ 315/84
Хаяг	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, 5-р хороолол, Сөүлийн 13/а барилга, 12 давхар
Утас	+976 9910 1389

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэлийн гэрчилгээ

"Тусгай зориулалтын компани" нь зөвхөн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилготой байх бөгөөд Хорооны зөвшөөрөлгүйгээр хувьцаагаа худалдах, арилжих, барьцаалах болон бусад хэлбэрээр шилжүүлэх эрхгүй болно.

Түүнчлэн хуульд зааснаас оор үйл ажиллагаа эрхлэх, Хорооны зөвшөөролгүйгээр компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулахыг хориглодог.

2.2. Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.12.5 дугаар заалтад тусгасны дагуу ТЗК нь хөдлөмөрийн гэрээ болон бусад гэрээний үндсэн дээр ажилтан авч ажиллуулах хориотой тул үндсэн ажилтангүй болно.

ТЗК нь хөрөнгө худалдаж авах, баталгаат үнэт цаас гаргах, хөрөнгө өмчлөх, хөрөнгө оруулагчийн эрх ашигт нийцүүлэн хөрөнгийг удирдах болон бусад эрхийн хүрээнд хийж гүйцэтгэх ажил, үйлчилгээг гуравдагч этгээдээр гүйцэтгүүлнэ. Компанийн бүтэц,

ТАВАН БОГД ЛИЗИНГ ТӨҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ТЗК ХХК
9026040947
7239689 . ХНТ10470

2026 БҮРТГЭВ
СЭХ 2026 БҮРТГЭВ

зохион байгуулалт, удирдлага, тэдгээрийн эдлэх эрх, үүрэг нь Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль болон Компанийн дүрэм журмаар зохицуулагдана.

2.3. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн хурал

Компанийн дүрэмд тусгасны дагуу үнэт цаас гаргагчийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байх ба хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хувьцаа эзэмшигчийн ТУЗ хэрэгжүүлнэ. Хувьцаа эзэмшигчдийн хурлын эрх хэмжээ болон бусад асууллыг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу зохицуулна.

2.4. Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн мэдээлэл

Үнэт цаас гаргагчийн дүрмийн 4.3-т "Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөө цагт компанийн эрх барих дээд байгууллагын бүрэн эрхийг Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл хэрэгжүүлнэ" гэж заасан.

Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагч/ анхны үүрэг гүйцэтгэгчийн 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн Хувьцаа эзэмшигчийн 2025/99 тоот шийдвэрээр Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийг 3 гишүүнтэй байхаар шийдвэрлэсэн бөгөөд ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна.

***Хүснэгт 2:* Төлөөлөн Удирдах Зөвлөлийн танилцуулга**

ТУЗ-ийн дарга Г. Цогтгэрэл



Боловсрол:

- 1994-2004 онд Ганзам 20-р сургууль, ЕБС
- 2004-2008 онд МУИС, Бизнесийн удирдлага
- 2022-2025 онд МУИС, Эрх зүйч

Ажлын туршлага:

- 2008-2014 онд Хаан банк, Ахлах эдийн засагч
- 2014-одоо, Очир Ундраа ОМЗ ББСБ, Гүйцэтгэх захирал

ТУЗ-ийн хараат бус гишүүн Г. Баянтуяа



Боловсрол:

- 1972-1982 онд, ЕБС
- 1982-1986 онд МУИС, Зээлийн эдийн засагч

Ажлын туршлага:

- 1986-1989 онд Говь-алтай аймаг, Улсын банкны ерөнхий хороо, Нягтлан бодогч, Эдийн засагч
- 1989-2000 онд УБ, ХОТШ банк, Нягтлан бодогч, Ерөнхий нягтлан бодогч, Зээлийн эдийн засагч
- 2001-2013 онд УБ, ХХБ, Эдийн засагч, Данс хариуцсан ажилтан, ахлах данс хариуцсан ажилтан
- 2013-Одоо Түмэнменежмент ББСБ ХХК, Түмэнменежмент ХХК, Гүйцэтгэх захирал

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК

2026 -ны 12
БҮРТГЭВ
ТУЗ-ийн хараат бус гишүүн Б. Баасандорж

СЭЗХ
2026.06.11 өдөр
БҮРТГЭВ



Боловсрол:

- 2005-2010 онд МУИС, Олон улсын эрх зүйч, эрх зүйн бакалавр
- 2012-2015 онд Төв Хятадын шинжлэх ухаан, технологийн их сургууль, Харьцуулсан эрх зүйн магистр
- 2017-2019 онд СЭЗИС, Санхүү менежмент

Ажлын туршлага:

- 2016- Одоо Баасандорж консалтинг ХХК, Үүсгэн байгуулагч
- 2019- Одоо МУИС- ХЗС, Нийтийн эрх зүйн тэнхим, багш

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

2.5. Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журам

Очун Актив Нэг ТЗК ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн 2025 оны 12 сарын 18-ны өдрийн 99 тоот шийдвэрээр "Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ыг баталсан ба тус журмаар ТУЗ-ийн бүтэц бүрэлдэхүүн, бүрэн эрх, зохион байгуулалттай холбоотой харилцааг нарийвчлан зохицуулсан байна.

Тус журамд Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүд нь Компанийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Хорооноос баталсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-д заасан шаардлага болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан нэмэлт шаардлагыг хангасан байхаар заажээ.

2.6. Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүдийн эрх, үүрэг

ТУЗ-ийн гишүүний эрх, үүргийг Үнэт цаас гаргагчийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам болон холбогдох хууль тогтоомжид зааснаар тодорхойлно. Тухайлбал, Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь дараах эрх, үүргийг хүлээж байна.

1. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээллийн үнэн зөвийг хариуцах;

2. Улиралд 1-ээс доошгүй удаа хуралдах;

3. Хувьцаа эзэмшигчийн хурлыг зарлан хуралдуулах, хурлаар хэлэлцэх асуудлыг батлах;

4. Үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагч, аудитор болон хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийг томилох, солих;

5. Үнэт цаас гаргахтай холбоотой мэргэжлийн оролцогч, үйлчилгээ үзүүлж буй хуулийн этгээдтэй гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

6. Хөрөнгийн багцыг сонгох шалгуур үзүүлэлтийг батлах;

7. Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн бүртгэлийг хянаж, хөрөнгө оруулагч, харилцагчдын эрх ашгийг хамгаалж ажиллах;

8. Үнэт цаасны танилцуулгын хүрээнд татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих;

9. Үнэт цаас гаргагчийн нэр дээр данс нээх, аудит, тайлан бүртгэлийг хянах, хөрөнгө оруулагчдад төлөх төлбөр болон бусад төлбөр, зардлын төсвийг батлах;

ХАВАН БОГД ХЭЗАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК

10. ТУЗ-ийн хараат бус гишүүн нь ТЗК-ийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, хөрөнгө оруулагчид хүргэх тогтоосон болон тухай бүр мэдээлэх мэдээллийн үнэн зөв, баталгаат байдалд хяналт тавьж ажиллах;

11. Хөрөнгийг бүртгэлээс хасах, нэмэх;

12. ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд тусгасан Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд хамаарах журам батлах, гэрээ байгуулах;

13. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгийн ашиглалт, нөөц хөрөнгийн талаар зөрчил гаргасан тохиолдолд шаардлагатай холбогдох арга хэмжээг авах үүнтэй холбоотой шийдвэр гаргах;

14. Хөрөнгө оруулагчдаас болон эрх бүхий зохицуулах төрийн байгууллагаас хүсэлт ирүүлсэн даруйд холбогдох мэдээллийг тэдгээрт цаг тухайд нь хүргэх.

ТЗК-ийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд хурлын чөлөөт цагт ТУЗ нь үйл ажиллагааг удирдаж, хяналт тавьж ажиллана. Мөн ТУЗ-ийг төлөөлж аливаа бичиг баримтад ТУЗ-ийн дарга төлөөлж гарын үсэг зурна хэмээн үнэт цаас гаргагчийн дүрэмд тусгасан байна.

ТУЗ болон түүний гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь Үнэт цаас гаргагчийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл авсан үеэс эхлэн ТЗК татан буугдах буюу ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан үндэслэлээр бүрэн эрхиг дуусгавар болгох хүртэл хугацаанд үргэлжилнэ.

СЗХ-ны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсэгт заасны дагуу Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдах бөгөөд нийт гишүүдийн дийлэнх олонхи оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.

Энэхүү үнэт цаасны танилцуулгын үнэн зөвийг Үнэт цаас гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөл бүрэн хариуцна.

2.7. Үнэт цаас гаргагчийн эхлэлтийн тайлан баланс

Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагч "Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК нь нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,000 ширхэг энгийн хувьцаа буюу 1,000,000 төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр "Очун Актив Нэг ТЗК" ХХК-г үүсгэн байгуулсан бөгөөд эхлэлтийн тайлан баланс дараах байдалтай байна.

№	Үзүүлэлт	Актив	Пассив
1	Мөнгөн хөрөнгө	1,000,000	-
2	Хувь нийлүүлсэн хөрөнгө	-	1,000,000
	Тэнцэл	**1,000,000**	**1,000,000**

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн мэдээлэл

2.8. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн төсөөлөл

Үнэт цаас гаргагчийн орлогын тайлангийн төсөөллийг "Хөрөнгө хуваалдах, хуваалдан авах гэрээ"-ний дагуу анхны үүрэг гүйцэтгүүлэгч "Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК-аас шилжүүлэх зээлийн хөрөнгийн багцаас орж ирэх мөнгөн урсгал болон үйл ажиллагааны төсөвлөсөн зардалд үндэслэн тооцоолсон.

Хүснэгт 3: Үнэт цаас гаргагчийн орлогын тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр

Үзүүлэлт	У1	У2	У3	У4	У5	У6	У7	У8	НИЙТ
Хүүний орлого	3,348	3,374	3,058	2,686	1,774	1,431	1,108	831	**17,610**

2026 .. 2
БҮРТГЭВ
СЗХ 2026 .06. 11 БҮРТГЭВ

ХБҮЦ-ийн хүүний төлбөр	(1,850)	(1,850)	(1,388)	(1,388)	(925)	(925)	(463)	(463)	**(9,250)**
Цэвэр хүүний орлого	**1,498**	**1,524**	**1,670**	**1,298**	**849**	**506**	**646**	**369**	**8,360**
Эрсдэлийн сангийн зардал									
Эрсдэлийн сангийн дараах ашиг	**1,498**	**1,524**	**1,670**	**1,298**	**849**	**506**	**646**	**369**	**8,360**
Үйл ажиллагааны зардал	(1,263)	(423)	(414)	(403)	(346)	(290)	(256)	(226)	**(3,621)**
Татварын өмнөх ашиг	**235**	**1,101**	**1,257**	**895**	**503**	**215**	**389**	**143**	**4,739**
Татвар	(24)	(110)	(126)	(90)	(50)	(22)	(39)	(14)	**(474)**
Татварын дараах цэвэр ашиг	**212**	**991**	**1,131**	**806**	**453**	**194**	**350**	**128**	**4,265**

Үнэт цаас гаргагчийн санхүүгийн төсөөллийг ХБҮЦ-ны нөхцөл, зээлийн багцын болон бусад мөнгөн урсгалын төсөөллийг ашиглан тооцоолсон. Үнэт цаас гаргагч нь ХБҮЦ-ыг олон нийтэд санал болгон арилжаалж, хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэх үед Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс 44.0 тэрбум төгрөгийн зээлийн багцыг худалдан авах бөгөөд ХБҮЦ-ны хугацаа дуусах үед үнэт цаас гаргагч нь ойролцоогоор 8.3 тэрбум төгрөгийн цэвэр хөрөнгөтэй үлдэх ба тус хөрөнгө нь ТЗК татан буугдах үед Анхны үүрэг гүйцэтгэгчид шилжинэ.

Хүснэгт 4: Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр

Үзүүлэлт	У0	У1	У2	У3	У4	У5	У6	У7	У8
Бэлэн мөнгө	1	5,731	1,649	8,601	5,540	12,147	7,768	12,759	6,998
Нийт зээл	44,007	38,489	33,561	27,740	21,607	15,453	10,026	5,386	1,275
Авлага									
Эрсдэлийн сан									
Нийт хөрөнгө	**44,008**	**44,219**	**35,210**	**36,341**	**27,147**	**27,600**	**17,794**	**18,144**	**8,273**
ХБҮЦ-ны өглөг	40,000	40,000	30,000	30,000	20,000	20,000	10,000	10,000	-
Бусад өглөг	4,007	4,007	4,007	4,007	4,007	4,007	4,007	4,007	4,007
Өр төлбөрийн дүн	**44,007**	**44,007**	**34,007**	**34,007**	**24,007**	**24,007**	**14,007**	**14,007**	**4,007**
Хувьцаат капитал	1	1	1	1	1	1	1	1	1
Хуримтлагдсан ашиг	-	-	212	1,202	2,333	3,139	3,592	3,786	4,137
Татварын дараах ашиг	-	212	991	1,131	806	453	194	350	128
Нийт өөрийн хөрөнгө	**1**	**213**	**1,203**	**2,334**	**3,140**	**3,593**	**3,787**	**4,138**	**4,266**
Өр төлбөр ба эзний өмч	**44,008**	**44,219**	**35,210**	**36,341**	**27,147**	**27,600**	**17,794**	**18,144**	**8,273**

Үнэт цаас гаргагч нь VI болон VIII улирлуудад ХБҮЦ-ны үндсэн төлбөр төлөхтэй холбоотой үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ -2.4 тэрбум төгрөг болон -5.7 тэрбум төгрөг тус тус байх хүлээлттэй байна. Харин бусад улирлуудад үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ эерэг 0.7-11.8 тэрбум төгрөгийн хооронд хэлбэлзэх бөгөөд эдгээр мөнгөн хөрөнгийг банкны харилцах данс, ТЗК-ийн дүрэм болон журамд нийцсэн санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийн / богино хугацаат хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд хуримтлуулан ХБҮЦ-ны үндсэн болон хүүгийн төлбөрийг хуваарийн дагуу төлнө. ХБҮЦ-ны өглөг нь 6 дахь сарын эцэст 10.0 тэрбум төгрөг, 12 дахь сарын эцэст 10.0 тэрбум төгрөг, 18 дахь сарын эцэст 10.0 тэрбум төгрөг, 24 дэх сарын эцэст 10.0 тэрбум төгрөг тухай бүр төлөгдөнө. ХБҮЦ-ны хугацааны эцэст 7.0 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгө үлдэх ба үүсгэн байгуулагч Очир Ундраа ОМЗ ББСБ ХХК руу шилжинэ.

ТАВАН БОГД КАПИТАЛ ХХК
ОЧИР АКТИВ ТЗК ХХК
9026040947
7239689 ХХТ10470

2026 -06- 12
БҮРТГЭВ
2026 он 06 сар 11 өдөр
БҮРТГЭВ
№ 31

Хүснэгт 5: Үнэт цаас гаргагчийн мөнгөн гүйлгээний тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр

Үзүүлэлт	У1	У2	У3	У4	У5	У6	У7	У8	НИЙТ
Хүүний орох мөнгөн урсгал	3,278	3,169	2,698	2,163	1,595	1,095	641	259	**14,899**
Зээлийн үндсэн төлбөрийн орох мөнгөн урсгал	9,860	10,931	11,029	10,384	9,420	7,702	6,041	4,770	**70,138**
ХБҮЦ-ны үндсэн төлбөр	-	-10,000	-	-10,000	-	-10,000	-	-10,000	**-40,000**
ХБҮЦ-ны хүүний төлбөр	-1,850	-1,850	-1,388	-1,388	-925	-925	-463	-463	**-9,250**
Үйл ажиллагааны зардал	-1,263	-423	-414	-403	-346	-290	-256	-226	**-3,621**
Татварын зардалд төлсөн төлбөр	-24	-110	-126	-90	-50	-22	-39	-14	**-474**
Үйл ажиллагааны мөнгөн урсгал	**10,002**	**1,717**	**11,801**	**667**	**9,694**	**-2,440**	**5,924**	**-5,674**	**31,691**
Хадгаламж, хөрөнгө оруулалтын хүүний орлого	70	205	360	523	179	336	467	572	**2,712**
Банкны хадгаламж	70	205	360	523	179	336	467	572	**2,712**
Мөнгөн хөрөнгөөрх зээл худалдан авалт	-4,342	-6,004	-5,208	-4,251	-3,266	-2,275	-1,400	-659	**-27,406**
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал	**-4,272**	**-5,799**	**-4,848**	**-3,728**	**-3,087**	**-1,939**	**-934**	**-87**	**-24,694**
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	**1**	**5,731**	**1,649**	**8,601**	**5,540**	**12,147**	**7,768**	**12,759**	
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	**5,731**	**1,649**	**8,601**	**5,540**	**12,147**	**7,768**	**12,759**	**6,998**	

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2026 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 2026/07 тоот тогтоолын Хавсралт 9-өөр баталсан "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам"-ын дагуу Үнэт цаас гаргагч нь хүүгийн болон үндсэн төлбөрийг үнэт цаас эзэмшигчид олгохоос гадна ТЗК-ийн үйл ажиллагаатай холбоотой ерөнхий ба удирдлагын зардалд төсвийг зарцуулна. Ерөнхий ба удирдлагын зарал дараах зардлууд багтана. Үүнд:

- Татвар;
- Төрийн болон бусад эрх бүхий байгууллагад төлөгдөх зардал;
- ХБҮЦ гаргах, хадгалалттай холбоотой зардал;
- Банкны гүйлгээ, үйлчилгээний шимтгэлтэй холбоотой зардал;
- Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн төлбөр;
- Үйлчилгээ үзүүлэгчийн төлбөр;
- Хөндлөнгийн аудит болон бусад мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн төлбөр;
- ТЗК-ийн үйл ажиллагаатай холбоотой ерөнхий болон удирдлагын цалин урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, татвар, үйл ажиллагааны зардал (вэб хуудастай холбоотой зардал, санхүүгийн программтай холбоотой зардал, мэдээлэл хүргэхтэй холбоотой зардал, бичиг хэргийн зардал).

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040847
7239689 .\. ХНТ10470

2026 -06- 12
БҮРТГЭВ

СЗХ
2026 он 06 сар 11 өдөр
БҮРТГЭВ

Эрх бүхий байгууллагын шийдвэр, давагдашгүй хүчин зүйлийн нөлөө болон ХБҮЦ-ны төлбөрийг төлөхөд зайлшгүй зардал гаргах шаардлага үүсвэл ТУЗ-ийн хурлаар уг асуудлыг хэлэлцэж, зөвшөөрсөн тохиолдолд ТУЗ-ийн тогтоолд заасан хэмжээгээр уг зардлыг нэмж гаргана.

Хүснэгт 6: Ерөнхий ба удирдлагын зардал

№	Зардлын зориулалт	Дүн	Давтамж
1	Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйлчилгээний төлбөр	Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний дагуу	Сар бүр
2	Үйлчилгээ үзүүлэгчийн үйлчилгээний төлбөр	Цуглуулсан төлбөрийн 2.5 хувь	Сар бүр
3	Хөндлөнгийн аудитын үйлчилгээний төлбөр	Жилд 18.7 сая төгрөг	Жил бүр
4	ТУЗ-ийн гишүүдийн цалингийн зардал	Жилд 12 сая төгрөг	Улирал бүр
5	Захиргааны зардал	Сард 1.5 сая төгрөг	Сар бүр

УЛААНБААТАР ХОТ
ЭРДЭНЭБОГД КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК

TAVAN BOGD CAPITAL

ОСНИП FINANCE

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/ АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ

ОЧУН АКТИВ НЭГ ТӨК ХХК

2026 . 2
СЗХ 2026 .06. 11 өдөр БҮРТГЭВ

3. ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ/ АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧИЙН ТУХАЙ

3.1. Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчийн товч танилцуулга

"Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК нь нь 2007 онд үүсгэн байгуулагдаж, 2008 онд Санхүүгийн зохицуулах хорооноос Банк бус санхүүгийн байгууллагын (ББСБ)-н үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авсан. Улмаар 2009 онд гадаад валютын арилжаа болон итгэлцлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, 2020 онд цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын тусгай зөвшөөрөл, 2021 онд факторинг болон богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх тусгай зөвшөөрлийг тус тус авснаар өдгөө ББСБ-ын зах зээлд идэвхтэй ажиллаж байна.

Зураг 2: Очир Ундраа ОМЗ ББСБ-ийн лого

3.2. Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчийн хуулийн этгээдийн бүртгэл хаяг

***Хүснэгт 7:* Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчийн хуулийн этгээдийн бүртгэл, мэдээлэл**

Хуулийн этгээдийн нэр	"Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК
Хариуцлагын хэлбэр	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
Улсын бүртгэлд бүртгэгдсэн огноо	2007.11.13
Улсын бүртгэлийн дугаар	9015001102
Регистрийн дугаар	2734745
Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар	ТЗ 101/128
Гүйцэтгэх захирал	Ганбаатар Цогтгэрэл
Үйл ажиллагааны төрөл	▸ Зээлийн үйл ажиллагаа ▸ Гадаад валютын арилжаа ▸ Итгэлцлийн үйлчилгээ ▸ Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга ▸ Факторинг ▸ Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх
Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ	5.0 тэрбум төгрөг
Хаяг	Улаанбаатар, Сүхбаатар, 3-р хороо, Сөүлийн, 20/1, Сөүл плаза 4 давхар 401 тоот
Утас	(+976) 7575-1818
Цахим шуудан	info@omz.mn
Цахим хаяг	www.omz.mn

Эх сурвалж: Үүсгэн байгуулагчийн мэдээлэл

УЛААНБААТАР ХОТ ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК 9020040947 7239600 ХНТ10470

2026 № 2 БҮРТГЭВ
БҮРТГЭВ № 01

3.3. Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчийн хувьцаа эзэмшигч

Үүсгэн байгуулагч нэг бүр нь 1,000,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 5,000 ширхэг хувьцаатай бөгөөд компанийн дүрэмд зааснаар хувьцаа эзэмшигч нь Т. Гантөмөр болон "Очир Ундраа Холдинг" ХХК байна. Хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй энгийн хувьцаа нь хуваагдахгүй бөгөөд хувьцаа тус бүр нь нэг саналын эрхтэй байна.

***Хүснэгт 8:* Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчийн хувь эзэмшлийн бүтэц**


№	Хувьцаа эзэмшигч иргэний овог, нэр	Гаргасан хувьцааны тоо ширхэг	Нэг бүрийн нэрлэсэн үнэ	Гаргасан хувьцааны нийт нэрлэсэн үнэ	Хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь
1	Т. Гантөмөр	2,500	1,000,000	2,500,000,000	50%
2	"Очир Ундраа Холдинг" ХХК	2,500	1,000,000	2,500,000,000	50%
	Нийт	**5,000**	**1,000,000**	**5,000,000,000**	**100%**

Эх сурвалж: Үүсгэн байгуулагчийн мэдээлэл

3.4. Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчийн бүтэц зохион байгуулалт, компанийн засаглал

Үүсгэн байгуулагчийн гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд хувьцаа эзэмшигчид, төлөөлөн удирдах зөвлөл, дотоод хяналт нь хяналт тавьж ажилладаг. ТУЗ нь эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулах зорилгын хүрээнд Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тодорхойлсон, тодорхой чиг үүрэг, байгуулагаа бүхий Эрсдэлийн удирдлагын хороо, Аудитын хороо, Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороод үйл ажиллагаа явуулж байна. Харин гүйцэтгэх захирал нь 3 салбар, 5 төрлийн хэлтсийн хүрээнд компанийн үйл ажиллагааг хянан явуулж байна.

Зураг 3: Үүсгэн байгуулагчийн бүтэц зохион байгуулалт



УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЭК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ХАВАН БОГД КАПИТАЛ
ШТК0128 0469112 9021061377

Эх сурвалж: Үүсгэн байгуулагчийн мэдээлэл

2026 1 2
БҮРТГЭВ
СЗХ
он сар өдөр
2026 06 11
БҮРТГЭВ
№ 01

3.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн танилцуулга

Очир Ундраа ОМЗ ББСБ ХХК-ын Төлөөлөн удирдах зөвлөл нь нийт таван гишүүнтэй үйл ажиллагаа явуулдаг ба ба үүнээс хоёр гишүүн нь хараат бус гишүүн байна.

Хүснэгт 9: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн танилцуулга

ТУЗ-ийн дарга Б. Билигүүн



Боловсрол

- 1993-1997 онд МУИС, Электроникийн инженер, Бакалавр
- 1998-2000 онд Texas Wesleyam University, Бизнесийн удирдлага, Магистр

Ажлын туршлага

- 2000-2003 онд S&D Inc USA, Financial Analyst
- 2003-2006 онд MCS Электроникс ХХК, Бизнес менежер
- 2006-2007 онд Юнител ХХК, Дэд захирал
- 2007-2008 онд IBA Molecular USA, Sr. Financial Analyst
- 2008-2012 онд Юнител ХХК, Гүйцэтгэх захирал
- 2012-2014 онд MCS групп, Дэд ерөнхийлөгч
- 2014-2017 онд Анунгоо ХХК, Гүйцэтгэх захирал
- 2017-2025 онд MCS групп, Дэд ерөнхийлөгч
- 2025-Одоо Очир Ундраа Холдинг ХХК, Гүйцэтгэх захирал

ТУЗ-ийн хараат бус гишүүн гишүүн Ш. Батжаргал



Боловсрол:

- 1992-1997 онд МОХС, ЕБС
- 1993-1997 онд МУИС, ОУХ Маркетинг, Бакалавр

Ажлын туршлага:

- 2004-2008 онд Анунгоо ХХК, Маркетингийн албаны дарга
- 2008-2010 онд MCS холдинг ХХК, Сургалт хөгжлийн албаны дарга
- 2010-2011 онд Гоёо ХХК, Маркетинг хариуцсан захирал
- 2011-2012 онд Юнител ХХК, Төслийн удирдагч
- 2012-2013 онд Юнивишн ХХК, Дэд захирал
- 2017-2018 онд Макс групп, Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал
- 2019-2022 онд АПУ ХК, Байгууллагын харилцаа эрхэлсэн захирал

ТУЗ-ийн хараат бус гишүүн гишүүн Б. Даринчулуун



Боловсрол:

- 1986-1992 онд ОХУ-ын Удирдлагын Их Сургууль, Инженер эдийн засаг
- 2000-2001 онд Колумбын их сургууль, Олон улсын эдийн засаг

Ажлын туршлага:

- 2017-2019 онд Ачит Ихт ХХК, Санхүү эрхэлсэн захирал
- 2019-2022 онд Dale Carnegie Mongolia, Сургалт хариуцсан захирал

ТУЗ-ийн гишүүн Б. Эрдэнэ-Очир



Боловсрол

- 1985-1995, 11-р дунд сургуул, ЕБС
- 1995-1999 онд Мандах бүртгэл, НББ-ээр мэргэжсэн Бизнесийн удирдлага, Бакалавр
- 2011-2013 онд Удирдлагын академи, Бизнесийн удирдлага



2026 : 2
БҮРТГЭВ
СЭХ
2026 .06. 11 . өдөр
БҮРТГЭВ
№ 21



Ажлын туршлага
- 1999-2001 онд Мандах бүртгэл, Багш
- 2002-2005 онд Хас банк ХК, Дотоод аудитор
- 2005-2008 онд Худалдаа хөгжлийн банк ХК, Данс хариуцсан ажилтан
- 2009-2016 онд Балхан аудит ХХК, Гүйцэтгэх захирал, аудитор
- 2016-2018 онд Шонхор үнэлгээ аудит ХХК, Гүйцэтгэх захирал, аудитор
- 2018-2019 онд Авера аудит ХХК, Аудитор
- 2019-2021 онд WSC ОУБ, Санхүүч
- 2019-2022 онд Очун ҮЦК ХОМК, Дотоод аудитор
- 2022-Одоо Очир Ундраа Холдинг ХХК, Санхүүгийн удирдлага хариуцсан захирал

ТУЗ-ийн гишүүн Г. Оргил



Боловсрол:
- 1996-2006 онд Сант сургууль, ЕБС
- 2006-2010 онд МУИС, Бизнесийн удирдлага
- 2019-2020 онд Queen Mary university of london, Санхүү, хөрөнгө оруулалт

Ажлын туршлага:
- 2010-2011 онд Голомт банк, ХҮА
- 2011-2017 онд Голомт банк, Дилер
- 2017-2018 онд Голомт банк, Ахлах дилер
- 2020-2020 онд Ард Менежмент ҮЦК, Сангийн менежер
- 2022-2022 Смарт Мони, Дэд захирал
- 2022-Одоо Очун ҮЦК, Гүйцэтгэх захирал

Эх сурвалж: Үүсгэн байгуулагчийн мэдээлэл

3.6. Гүйцэтгэх удирдлагын баг

Хүснэгт 10: Гүйцэтгэх удирдлагын багийн танилцуулга

Гүйцэтгэх захирал Г. Цогтгэрэл



Боловсрол:
- 1994-2004 онд Од цогцолбор, ЕБС
- 2004-2008 онд МУИС, Бизнесийн удирдлага
- 2022 онд МУИС, Эрх зүйч

Ажлын туршлага:
- 2008-2014 онд Хаан банк, Ахлах эдийн засагч
- 2014-Одоо, Очир Ундраа ОМЗ ББСБ, Гүйцэтгэх захирал

Дэд захирал Л. Болор-Эрдэнэ



Боловсрол:
- 2001-2005 онд ШУТИС, Санхүүгийн удирдлага

Ажлын туршлага:
- 2005-2010 онд Хас Банк ХК, Жижиг дунд бизнесийн мэргэжилтэн, Эрсдэлийн менежер
- 2010-2018 онд Хас Банк ХК, Салбарын захирал
- 2018-2021 онд Хаан Банк ХК, Бизнес төвийн захирал
- 2021-2025 онд М Банк ХК, Бизнесийн зээлийн хэлтсийн захирал
- 2025 Одоо, Очир Ундраа ОМЗ ББСБ ХХК, Дэд захирал

УЛААНБААТАР ХОТ
ТАВАН БОГД ХАРИУЦАА
ТӨВ САНГИЙН ҮЦК ХХК
ШТК0128 9112 9021061377

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026030947
7239689 ХНТ10470

2026 01 12
БҮРТГЭВ

2026 оны 06 дугаар сарын 11 өдөр
БҮРТГЭВ

Дижитал инновацын газрын захирал Ч. Болорчимэг



Боловсрол:

- 1994-2004 онд ГСА, 1-р 10 жил, ЕБС
- 2004-2008 онд СЭЗДС, Санхүүгийн менежмент

Ажлын туршлага:

- 2008-2011 онд Хаан банк, Эдийн засагч
- 2011-2013 онд Хадгаламж банк, Ахлах эдийн засагч, эрсдэлийн мэргэжилтэн
- 2013-2019 онд Төрийн банк, Шинжээч, хөрөнгийн үнэлгээчин
- 2020-Одоо, Очир Ундраа ОМЗ ББСБ, Зээлийн газрын захирал

Санхүү, хөрөнгө удирдлагын газрын захирал Т. Долгорсүрэн



Боловсрол:

- 1995-2005 онд Өверхангай, ЕБС
- 2005-2009 онд МУИС, Эдийн засаг, Математик загварчлал
- 2022- CFA Level-1 passed

Ажлын туршлага:

- 2009-2010 онд Монмасло, Нягтлан бодогч
- 2010-2011 онд Хаан банк, Теллер, Ахлах теллер
- 2011-2013 онд Чингис Хаан банк, Хөрвөх чадварын эрсдэлийн шинжээч
- 2013-2017 онд Очир Ундраа ОМЗ ББСБ, Зээлийн мэргэжилтэн
- 2017-2022 онд Очир Ундраа ОМЗ ББСБ, Салбарын захирал
- 2022-Одоо, Очир Ундраа ОМЗ ББСБ, Санхүү хөрөнгө удирдлагын газрын захирал

Программ хөгжүүлэлтийн газрын захирал Н. Гэрэлчулуун



Боловсрол:

- 1995-2005 онд Баян-Өлгий, 2-р сургууль
- 2005-2009 онд МУИС- МТС, Программ хангамжийн инженер

Ажлын туршлага:

- 2025-2026 онд Номин Холдинг ХХК, Төслийн удирдлага, программ-н хэлтэс- дарга
- 2026-Одоо, Очир Ундраа ОМЗ ББСБ, Программ хөгжүүлэлтийн газрын захирал

Мэдээлэл технологи хариуцсан захирал О. Төгөлдөр



Боловсрол:

- 2003-2006 онд Орчлон сургууль, Бүрэн дунд
- 2008-2012 онд SFSU, Эдийн засагч

Ажлын туршлага:

- 2012-2016 онд Энержи Ресурс, Санхүүгийн шинжээч
- 2023-2026 онд Инвескор, ЦХ хариуцсан
- 2026-Одоо, Очир Ундраа ОМЗ ББСБ, МТ хариуцсан захирал

УЛААНБААТАР ХОТ
ТӨВ БӨГД КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
7239689 ХТ10470

Эрсдэл, комплайнс хариуцсан захирал Ц. Алтаннавч



Боловсрол:

- 2005-2009 онд Парисын их сургууль, Бизнесийн удирдлага, эдийн засаг
- 2013-2015 онд Рояал ОУДС, Бизнесийн удирдлагын магистр

Ажлын туршлага:

- 2009-2020 онд Хасьанк, Харилцааны менежер, Эрсдэлийн ахлах менежер
- 2020-2025 онд Инвескор ББСБ ХК, Үйл ажиллагаа хариуцсан захирал
- 2025-Одоо, Очир Ундраа ОМЗ ББСБ, Эрсдэл, комплайнс хариуцсан захирал

Хүний нөөц, үйл ажиллагааны газрын захирал Б. Ундрах



Боловсрол:

- 1990-2000 онд 24-р дунд сургууль, Бүрэн дунд
- 2000-2004 онд Шихихутуг ХЗДС, Эрх зүйч

Ажлын туршлага:

- 2011-2015 онд MCS Гоёо ХХК, Хүний нөөцийн мэргэжилтэн, ахлах
- 2015-2017 онд MCS Гламур ХХК, Хүний нөөцийн менежер
- 2017-2018 онд MCS Юнител ХХК, Хүний нөөцийн менежер
- 2018-2019 онд Алтан Жолоо Импекс, ЗХНА-ны дарга
- 2020-2023 онд Скай Профешнл Групп, Хүний нөөцийн газрын захирал
- 2021-2023 онд 4-р эмнэлэг, Хүний нөөцийн газрын захирал
- 2023-2025 онд Жижиг, дунд бизнесүүдэд Хүний нөөцийн аутсорс, зөвлөх үйлчилгээ
- 2025-Одоо, Очир Ундраа ОМЗ ББСБ, Хүний нөөц, үйл ажиллагааны газрын захирал

Эх сурвалж: Үүсгэн байгуулагчийн мэдээлэл

3.7. Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчийн үйл ажиллагаа

"Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК нь нь 2007 онд үүсгэн байгуулагдаж, 2008 онд Санхүүгийн зохицуулах хорооноос Банк бус санхүүгийн байгууллагын (ББСБ)-н үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авсан. Улмаар 2009 онд гадаад валютын арилжаа болон итгэлцлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, 2020 онд цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын тусгай зөвшөөрөл, 2021 онд факторинг болон богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх тусгай зөвшөөрлийг тус тус авснаар өдгөө ББСБ-ын зах зээлд идэвхтэй ажиллаж байна.

АЛСЫН ХАРАА

Хамгийн үр өгөөжтэй санхүүгийн байгууллага болно.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Мэдрэмж, шинэчлэлийг хослуулж, үнэ цэн, бүтээмжээ тасралтгүй нэмэгдүүлэн, тогтвортой байдлыг эрхэмлэж, харилцагчдынхаа талархлыг хүлээсэн ёс зүйтэй байгууллага байна.

ҮНЭТ ЗҮЙЛС

- Үнэнч, шударга байдал
- Бүтээлч байдал
- Хариуцлагатай байдал
- Эрсдэлдэх чадвартай байдал
- Хүндэтгэлтэй байдал

2026 2
БҮРТГЭВ
СЗХ
БҮРТГЭВ

Санхүүгийн салбарт 18 жилийн туршлагатай "Очир Ундраа ОМЗ ББСБ" нь уламжлалт болон финтек (Opay.mn app), 8 салбараараа дамжуулан 95 мянга гаруй харилцагчдадаа бизнес, хэрэглээний зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэхээс гадна итгэлцэл, валют арилжаа, факторингийн үйлчилгээнүүдийг үзүүлж байна.

3.8. Үүсгэн байгуулагчийн эзэмшиж буй тусгай зөвшөөрөл

"Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК нь Монгол Улсын "Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль", "Аж ахуйн нэгжийн зөвшөөрлийн тухай хууль", болон бусад холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаснаар СЗХ-ны 2015 оны 04-р сарын 22-ний өдрийн 209-р тогтоолоор Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан.

***Хүснэгт 11:* Үүсгэн байгуулагчийн эзэмшиж буй тусгай зөвшөөрлүүд**

№	Тусгай зөвшөөрөл	Олгосон огноо
1	Зээл	2008.03.13
2	Гадаад валютын арилжаа	2009.07.28
3	Итгэлцлийн үйлчилгээ	2009.07.28
4	Банк бус санхүүгийн цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	2020.11.11
5	Факторинг	2021.07.07
6	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт	2021.07.07


Эх сурвалж: Үүсгэн байгуулагчийн мэдээлэл

3.9. Үүсгэн байгуулагчийн бүтээгдэхүүн үйлчилгээний танилцуулга

"Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК нь Бизнес, хэрэглээ, автомашин, төсөл болон финтек зээлийн үйлчилгээг нэвтрүүлэн харилцагч нартаа хялбар зээлийн үйлчилгээг түргэн шуурхай авах боломжийг нээж өгөн ажиллаж байна.

Түүнчлэн Финтек зээлийг СЗХ-ны 160 тоот "Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам"-д заасны дагуу "OPAY" аппликейшныг холбогдох хууль, журмыг хангасан гэж дүгнэж финтек зээлийн бүтээгдэхүүнийг албан ёсоор бүртгэсэн байна.

Зураг 4: Зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ



2026 . 2
БҮРТГЭВ

СЗХ
2026 .06. 11
БҮРТГЭВ

Мэдээллийн аюулгүй байдал

"Очир Ундраа ОМЗ ББСБ" нь хувийн мэдээллийн нууцыг өндөр хамгаалалттай хадгалдаг ба мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх болон хувь хүний нууцын тухай хуулийг чанд мөрдөн ажилладаг. Мөн ISO/IEC 27001:2013 - Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог 2023 онд өөрийн байгууллагад нэвтрүүлсэн ба 2024 онд магадлан аудит хийж баталгаажуулсан байна.

OPAY.mn аппликейшн

Opay.mn бол Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг санхүүгийн технологийн (финтек) шийдэл бүхий гар утасны аппликэйшн бөгөөд хэрэглэгчдэд цахим зээл, төлбөр тооцоо, мөнгөн шилжүүлэг зэрэг олон төрлийн санхүүгийн үйлчилгээг хялбар, хурдан, аюулгүй байдлаар ашиглах боломжийг олгодог.

Харилцагчид OPAY.mn аппликейшнийг ашигласнаар дараах бүтээгдэхүүн үйлчилгээг түргэн шуурхай, найдвартай авах боломжтой юм.

Цахим зээл

- Барьцаагүй онлайн зээл: 50,000₮–1,000,000₮ хүртэлх хэмжээтэй, 12 сарын хугацаатай, хүүгүй, үйлчилгээний шимтгэл 1–2.99%.
- Кредит картын зээл: 5,000,000₮ хүртэлх хэмжээтэй, 24 сарын хугацаатай, сарын 3% хүүтэй. Зөвхөн ашигласан хоногоор хүү тооцогддог тул хэрэглэхгүй үед хүү бодогдохгүй.

BNPL (Buy Now, Pay Later) буюу Тэгэх үү? зээл

- 3,000,000₮ хүртэлх бараа, үйлчилгээний үнийг 60 хоногийн дотор 5 хуваарь, хүүгүйгээр төлөх боломжтой.

Төлбөр тооцоо, шилжүүлэг

- Банк хооронд болон хэрэглэгч хооронд мөнгөн шилжүүлэг хийх, хэрэглээний төлбөрүүдийг төлөх, орлого хүлээн авах зэрэг үйлдлүүдийг хялбар гүйцэтгэх боломжтой.

Итгэлцлийн үйлчилгээ

- Харилцагч хугацаанаас хамаарсан итгэлцэл нээх, хянах, сунгах, үр шимээ тооцох боломжтой.

Бонус оноо

- Аппликэйшн дээр хийсэн үйлдэл бүрт бонус оноо цуглуулах, түүнийг ашиглах боломжтой.

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК

2026 -06- 12
БҮРТГЭВ
2026 .06. 11
БҮРТГЭВ

Зураг 5: OPAY аппликэйшн



3.10. Дотоод орчны эрсдэл

Эрсдэлийн удирдлагын тогтолцоог Монгол улсын хууль тогтоомж, эрх бүхий зохицуулагч байгууллагын шаардлага, шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн, компанийн стратеги, суурь бодлого, зорилго, зорилтыг хэрэгжүүлэхтэй холбоотой эрсдэлийн удирдлагын нэгдсэн бодлого, стандартыг тодорхойлж, компанийн үйл ажиллагааны процесс бүрд эрсдэлийн соёлыг хэвшүүлэх, хөгжүүлэх зорилгоор 2024 оны 12 сард компанийн "Эрсдэлийн удирдлагын бодлого"-ыг шинэчлэн баталсан.

Тус бодлогын хүрээнд компанийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, арга хэмжээ авах, эрсдэлийн удирдлагын тогтолцооны оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг тодорхойлж, гурван шатлалт хамгаалалтын тогтолцоог бүрдүүлж, Олон улсын эрсдэлийн удирдлагын ISO31000:2022 стандартын шаардлагыг хэрэгжүүлэн ажилладаг.

Үнэт цаасжуулах үйл ажиллагаанаас үүдэлтэй гадаад болон дотоод хүчин зүйлсээс шалтгаалсан эрсдэл үүсч болзошгүй. Иймд Үнэт цаас гаргагч нь тус эрсдэлийг бууруулах зорилгоор "Эрсдэлд суурилсан дотоод хяналтын бодлого, журам"-ыг баталж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус журамд ХБҮЦ гаргах, үнэт цаасны төлбөрийг хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчдэд төлөхтэй холбоотой эрсдэлийг удирдах, түүнтэй холбогдох дотоод хяналтыг хэрэгжүүлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авахтай холбоотой холбогдох хууль журмын хүрээнд зохицуулагч байгууллагууд болон оролцогч талуудтай харилцах харилцааг нарийвчлан зохицуулсан.


"Очир Үндраа ОМЗ ББСБ" ХХК (цаашид үүсгэн байгуулагч/ анхны үүрэг гүйцэтгүүлэгч гэх)-ийн үйл ажиллагаанд зээлийн эрсдэл, мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл, үйл ажиллагааны эрсдэл, зах зээлийн эрсдэл болон хөрвөх чадварын эрсдэл учирч болзошгүй байна. Тус эрсдэлийн хүчин зүйлсийг тохиолдох магадлал болон үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөхийг эрсдэлийн матрицаар ангилан авч үзсэн болно.

Үнэт цаас гаргагчийн хувьд компанийн үндсэн үйл ажиллагаа болох зээлийн үйл ажиллагаанд тохиох эрсдэл буюу зээлийн эргэн төлөлт буурах, чанаргүй зээл нэмэгдэх магадлал өндөр байна.

УЛААНБААТАР ХОТ
ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК

2026 -ны 12
БҮРТГЭВ
2026.06.11
БҮРТГЭВ

Зураг 6: Эрсдэлийн матриц



3.11. Үйл ажиллагаандаа хэрэгжүүлж буй эрсдэлийн удирдлага

Хууль тогтоомж, дотоод болон гадаад дүрэм журмыг даган мөрдөж, тэдгээрийн нийцэл, санхүүгийн үнэн зөв тайлагнал, үндсэн үйл ажиллагааны үр дүнтэй байдал болон үр ашгийг нэмэгдүүлж урт болон богино хугацааны стратегийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулахад байгууллагын ажилтан нэг бүрийн оролцоотойгоор хэрэгжүүлэх, тасралтгүй хөгжих системийг бий болгон ажиллаж байна. Эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь хамгаалалтын гурван бүсийн зарчимд тулгуурлан ажилладаг ба хамгаалалтын гурван бүс гэдэг нь эрсдэлийг илрүүлэх, бууруулах, хянах, хүлээн зөвшөөрөх чиг үүрэг бүхий эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг илтгэдэг.

Эрсдэлийн удирдлагын тогтолцооны зорилт

Компани өөрийн үйл ажиллагааны эрсдэл, өгөөжийн харьцааг хамгийн оновчтой түвшинд байлгаж, хүлээж болзошгүй алдагдлын хэмжээг тухайн нөхцөл байдалд тохируулан боломжит бага түвшинд бууруулах зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллана.

- Эрсдэлийн эрсдэлийн соёлыг бий болгох;
- Эрсдэлийн удирдлагын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх;
- Компанийн онцгой нөхцөл буюу хүндрэлийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх;
- Эрсдэлд суурилсан шийдвэр гаргалт, арга хэмжээ нь ТУЗ-өөс баталсан бизнес стратеги болон зорилготой уялдаж байх.

Эрсдэлийн удирдлагын тогтолцооны зарчим

- Хараат бус бие даасан үнэлгээ хийх;
- Тогтмол хяналт, тайлагналын тогтолцоог бүрдүүлэх;
- Хэмжигдэхүйц, ил тод, баримтжуулсан байх;
- Эдийн засгийн үр ашигтай байх;
- Санхүүгийн эх үүсвэрийн тогтвортой байдлыг хангах, зохистой удирдах;

ГАВАН БОГД КАПИТАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9021061377

2026 -ны 2
БҮРТГЭВ
СЭХ
2026 .08. 11. өдөр
БҮРТГЭВ
№ 01

Хамгаалалтын гурван бүсийн чиг, үүргүүд

Хамгаалалтын I шугам	**Гүйцэтгэх удирдлага**

- Удирдлагын хяналт дор дотоод хяналтын арга замуудыг хэрэгжүүлж гүйцэтгэх удирдлагад тайлагнах замаар

Хамгаалалтын II шугам	**Гүйцэтгэх удирдлага**

- Санхүүгийн хяналт, аюулгүй байдал,эрсдэлийн удирдлага, чанар, үзлэг шалгалт, нийцлийг тодорхойлж гүйцэтгэх удирдлагад тайлагнах замаар

Хамгаалалтын III шугам	**Гүйцэтгэх удирдлага, ТУЗ, Эрсдэл аудитын хороо**

- Дотоод аудит нь гүйцэтгэх удирдлага болон ТУЗ, эрсдэл аудитын хороонд тайлагнах замаар

3.12. Үүсгэн байгуулагчийн хүний нөөц, программ хангамжийн тухай

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Грэйпсити Монгол ХХК-ийн нэвтрүүлсэн ПОЛАРИС суурь систем, Кредит данс систем, СОТ интерфэйс систем, мөн гэрээгээр нийлүүлсэн Мэдэгдлийн менежмент систем, ТЕГ-ын НӨАТУС рүү и-баримт илгээх модуль, Нэмэлт 25 хэрэглэгчийн эрх, 104 төрлийн OpenAPI гүйлгээ, Private cloud дэд бүтэц, Титан Си Ар Эй ЗМС ХХК руу холбогдох модулийг тус тус түрээсээр ашигладаг.

ПОЛАРИС ERP системийн танилцуулга

Үндсэн хөрөнгө систем- Байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэл хөтөлж, стандартын дагуу элэгдэл тооцож, түүн дээр үндэслэн лавлагаа мэдээ шуурхай авах, байгууллагын дотоод хэрэгцээнд зориулсан хангамжийн бараа материал, үнэ бүхий зүйлсийн орлого, зарлага хөтөлж, бараа материалын захиалга хийж, лавлагаа авах зориулалттай, Үндсэн хөрөнгө систем нь нягтлан бодогч, эд хариуцагчийн үйл ажиллагааг автоматжуулсан ашиглахад хялбар, энгийн интерфэйстэй.

Хүний нөөцийн систем- Байгууллагын боловсон хүчний бүртгэл мэдээллийг хөтөлж, түүнд үндэслэн оновчтой шийдвэр гаргах, хүний нөөцийг зөв зохистой төлөвлөх, цэгцтэй бодлого явуулахад шаардлагатай бүх талын судалгаа шинжилгээний тайлан мэдээ боловсруулах зориулалттай.

Цалин систем- ААН байгууллагын ажилчдын хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлогыг тооцоолох, холбоотой бүртгэл болон гүйлгээг автоматжуулах, тооцооны үр дүнг хадгалах, тайлан гаргах зориулалттай. Цалингийн нэмэгдэл, суутгал, урьдчилгаа тооцох дүрмийг байгууллагын онцлогт тохируулан өөрчлөх боломжтойгоос гадна салбар нэгж, албан тушаал, ажилтан тус бүрийн цалин бодолтыг уян хатан болгож, олон хэлбэр, дүрмээр нэгэн зэрэг тооцоолох боломжтой.

3.13. Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчийн санхүүгийн тайлан, шинжилгээ

Үүсгэн байгуулагчийн 2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайланд "Мүүрь Аудит" ХХК хөндлөнгийн аудит хийсэн.

Хөндлөнгийн аудитын компанийн дүгнэлтээр "Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК нь 2025 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн тусдаа санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналыг Олон Улсын Стандартын зөвлөлөөс баталсан СТОУС-ын Стандартуудын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Орлогын тайлангийн шинжилгээ

ГАВАН БОГЦ КАПИТАЛ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
УЛААНБААТАР ХОТ

Үүсгэн байгуулагчийн 2022-2025 оны аудитлагдсан санхүүгийн тайланд үндэслэн санхүүгийн шинжилгээ хийсэн болно.

Хүснэгт 13: Орлого үр дүнгийн тайлан хураангуй, сая төгрөгөөр

ҮЗҮҮЛЭЛТ	2022	2023	2024	2025	2024 2025	
Хүүгийн орлого	**12,785.0**	**16,210.9**	**24,231.5**	**34,890.1**	**10,658.6**	**44%**
Банканд байршуулсан хөрөнгө	191.5	452.4	135.9	748.8	612.9	451%
Үнэт цаасны	132.4	11.2	-	-	-	-
Зээлийн	12,461.0	15,747.3	24,095.6	33,140.0	9,053.4	38%
Бусад хүүгийн орлого	-	-	-	992.4	992.4	-
Хүүгийн зардал	**1,657.5**	**2,584.3**	**4,299.7**	**8,523.3**	**4,223.6**	**98%**
Итгэлцлийн үйлчилгээний үр шим	1,575.9	2,474.8	4,070.8	5,767.7	1,696.9	42%
Зээлийн хүүгийн зардал	81.6	109.5	228.9	289.9	61.0	27%
Бондын хүүгийн зардал	-	-	-	2,064.4	2,064.4	-
Бусад хүүгийн зардал	-	-	-	401.3	401.3	-
ХҮҮГИЙН ЦЭВЭР ОРЛОГО	**11,127.5**	**13,626.5**	**19,931.8**	**26,366.8**	**6,435.0**	**32%**
Эрсдэлийн сангийн зардал	2,524.9	2,227.6	2,364.0	2,596.8	232.8	10%
ЭРСДЭЛИЙН САНГИЙН ДАРААХ ЦЭВЭР ОРЛОГО	**8,602.5**	**11,398.9**	**17,567.8**	**23,770.1**	**6,202.3**	**35%**
Хүүгийн бус орлого	**171.4**	**388.7**	**1,140.9**	**2,774.2**	**1,633.3**	**143%**
Хүүгийн бус зардал	**2,595.7**	**3,947.7**	**4,748.8**	**7,755.3**	**3,006.8**	**63%**
ТАТВАРЫН ӨМНӨХ АШИГ, АЛДАГДАЛ	6,214.3	7,759.0	13,959.8	18,788.9	4,829.1	35%
Орлогын албан татварын зардал	948.4	991.3	2,497.1	3,315.5	818.4	33%
Цэвэр ашиг	5,266.0	6,767.7	11,462.8	15,473.4	4,010.6	35%
НИЙТ ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ДҮН	5,266.0	6,767.7	11,462.8	15,473.4	4,010.6	35%

Эх сурвалж: Үүсгэн байгуулагчийн аудитлагдсан тайлангийн мэдээлэл

Үүсгэн байгуулагчийн нийт хүүгийн орлого 2022 оны 12.8 тэрбум төгрөгөөс 2025 онд 34.9 тэрбум төгрөгт хүрч, 3 жилийн хугацаанд 2.7 дахин өссөн байна. 2024-2025 оны хооронд өсөлт 44% байгаа нь үйл ажиллагаа эрчимжиж, зээлийн багц өргөжсөнтэй холбоотой. Хүүгийн орлогын дийлэнх нь зээлийн хүүгээс бүрдэж, 2025 онд 33.1 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Хүүгийн зардал 2022 оны 1.7 тэрбум төгрөгөөс 2025 онд 8.5 тэрбум төгрөг болж 5 дахин нэмэгдсэн бөгөөд үүнд итгэлцлийн үйлчилгээний үр шим 1.6 тэрбум төгрөгөөс 5.8 тэрбум төгрөг болон өссөн нь голлон нөлөөлжээ. Үүний үр дүнд хүүгийн цэвэр орлого 2025 онд 26.4 тэрбум төгрөг болж сэргэлттэй үзүүлэлттэй гарсан байна.

Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого 2022 онд 8.6 тэрбум байсан бол 2025 онд 23.8 тэрбум төгрөг болж 277%-иар өссөн нь үндсэн үйл ажиллагаа илүү үр ашигтай явагдаж байгааг харуулж байна.

Бүх зардлыг тооцсоны дараах татварын өмнөх ашиг 2022 онд 6.2 тэрбум төгрөг байсан бол 2025 онд 18.8 тэрбум төгрөгт хүрч 3 дахин өссөн байна. Үүнтэй уялдаатайгаар цэвэр ашиг 2022 онд 5.3 тэрбум байсан бол 2025 онд 15.5 тэрбум болж өссөн бөгөөд энэ нь компанийн тогтвортой өсөлт, бизнесийн загварын үр ашигтай байдлыг баталгаажуулж байна.

2026 БҮРТГЭВ

Хүснэгт 14: Орлого үр дүнгийн тайлангийн босоо шинжилгээ

ҮЗҮҮЛЭЛТ	2022	2023	2024	2025
Хүүгийн орлого	**98%**	**97%**	**95%**	**91%**
Банканд байршуулсан хөрөнгө	1%	3%	1%	2%
Үнэт цаасны	1%	0%	0%	0%
Зээлийн	96%	95%	95%	87%
Бусад хүүгийн орлого	0%	0%	0%	3%
Хүүгийн зардал	**21%**	**26%**	**31%**	**44%**
Итгэлцлийн үйлчилгээний үр шим	20%	25%	29%	30%
Зээлийн хүүгийн зардал	1%	1%	2%	1%
Бондын хүүгийн зардал	0%	0%	0%	11%
Бусад хүүгийн зардал (түрээсийн хүү)	0%	0%	0%	2%
ХҮҮГИЙН ЦЭВЭР ОРЛОГО	**85%**	**82%**	**79%**	**69%**
Эрсдэлийн сангийн зардал	33%	23%	17%	13%
ЭРСДЭЛИЙН САНГИЙН ДАРААХ ЦЭВЭР ОРЛОГО	**66%**	**68%**	**69%**	**62%**
Хүүгийн бус орлого	**1%**	**2%**	**4%**	**7%**
Хүүгийн бус зардал	**33%**	**40%**	**34%**	**40%**
ТАТВАРЫН ӨМНӨХ АШИГ, АЛДАГДАЛ	48%	47%	55%	49%
Орлогын албан татварын зардал	12%	10%	18%	17%
ТАЙЛАНТ ХУГАЦААНЫ НИЙТ ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ДҮН	40%	41%	45%	41%


Эх сурвалж: Үүсгэн байгуулагчийн аудитлагдсан тайлангийн мэдээлэл

Үүсгэн байгуулагчийн 2022 оноос 2025 он хүртэлх хугацаанд хүүгийн орлого нийт орлогын 91–98 хувийг бүрдүүлдэг бөгөөд үүний дийлэнх буюу 87–96 хувь нь зээлийн хүүгийн орлогоос бүрдэж байна. Хүүгийн зардал 2022 онд 21 хувь байсан бол 2025 онд 43 хувь болж өссөн нь зээлийн зардал нэмэгдсэнтэй холбоотой бөгөөд итгэлцлийн үйлчилгээний зардал мөн өссөн хандлагатай байна. Хэдий хүүгийн орлого өндөр түвшинд хадгалагдаж байгаа боловч зардлын өсөлт ашигт ажиллагаанд тодорхой дарамт үзүүлж эхэлж буйг илтгэнэ.

Эрсдэлийн сангийн зардал 2022 онд 33 хувьтай байсан бол 2025 онд 13 хувь хүртэл буурсан байна. Иймд компанийн зээлийн чанарт хяналт тавих, эрсдэлийн удирдлагын бодлогоо үргэлжлүүлэн оновчтой хэрэгжүүлэх шаардлагатай.

Татварын өмнөх ашиг 2022 онд 48 хувь байсан бол 2025 онд 49 хувь болсон нь байгууллага үйл ажиллагааны орлогоос хангалттай ашигтай ажиллаж байгааг харуулна. Орлогын албан татварын зардал харьцангуй тогтмол, 10–18 хувийн хооронд хэлбэлзэж байна. Үүний үр дүнд, тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн 2022-2025 онд 40-45 хувь, цэвэр ашигт ажиллагаа тогтвортой байна.

График 10: Нийт хөрөнгө бө өөрийн хөрөнгө, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: Үүсгэн байгуулагчийн аудитлагдсан тайлангийн мэдээлэл

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК

Санхүү байдлын тайлангийн шинжилгээ

Үүсгэн байгуулагчийн 2022-2025 оны аудитлагдсан санхүүгийн тайланд үндэслэн санхүүгийн шинжилгээ хийсэн болно.

Хүснэгт 15: Санхүүгийн байдлын тайлан хураангуй, сая төгрөгөөр

ҮЗҮҮЛЭЛТ	2022	2023	2024	2025	2024-2025	
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3,498.1	4,203.5	3,248.2	6,696.1	3,447.9	106%
Хөрөнгө оруулалт	99.9	24.3	33.3	35.7	2.4	7%
Зээл /цэврээр/	43,508.3	58,326.5	81,559.0	118,747.3	37,188.3	46%
Бусад санхүүгийн хөрөнгө	17.5	52.6	1,190.1	1,878.5	688.4	58%
Санхүүгийн хөрөнгийн дүн	**47,123.8**	**62,606.9**	**86,030.7**	**127,357.7**	**41,327.0**	**48%**
Бусад	67.4	618.5	2,929.1	1,668.3	(1,260.8)	-
Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, түрээсийн хөрөнгө, биет бус хөрөнгө	2,902.2	2,819.1	1,847.5	5,071.7	3,224.2	175%
Санхүүгийн бус хөрөнгийн дүн	**3,460.9**	**3,886.9**	**4,776.5**	**6,740.0**	**1,963.5**	**41%**
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	**50,584.7**	**66,493.8**	**90,807.2**	**134,097.7**	**43,290.5**	**48%**
Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр	14,488.2	23,208.3	28,616.2	40,144.4	11,528.2	40%
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	-	-	4,989.2	-	-	-
Бусад эх үүсвэр	-	-	-	17,767.7	17,767.7	-
Бусад санхүүгийн өр төлбөр	-	-	237.7	3,036.1	-	-
Санхүүгийн өр төлбөрийн дүн	**14,488.2**	**23,208.3**	**33,843.2**	**60,948.1**	**27,104.9**	**80%**
Санхүүгийн бус өр төлбөрийн дүн	**404.0**	**849.6**	**603.1**	**1,332.4**	**729.3**	**121%**
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	**14,892.2**	**24,057.9**	**34,446.3**	**62,280.5**	**27,834.2**	**81%**
Хувь нийлүүлсэн хөрөнгө	2,500.0	2,500.0	5,000.0	5,000.0	-	-
Хуримтлагдсан ашиг, алдагдал	32,507.8	39,235.0	50,875.7	65,812.0	14,936.3	29%
Бусад хяналт	684.7	700.9	985.2	1,205.2	220.0	78%
ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	**35,692.5**	**42,435.9**	**56,360.9**	**71,817.2**	**15,456.3**	**27%**
ӨР ТӨЛБӨР ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	**50,584.7**	**66,493.8**	**90,807.2**	**134,097.7**	**43,290.5**	**48%**

Эх сурвалж: Үүсгэн байгуулагчийн аудитлагдсан тайлангийн мэдээлэл

2022 оноос 2025 он хүртэлх хугацаанд компанийн санхүүгийн үзүүлэлтүүд тогтвортой өсөлт үзүүлж, найдвартай байдал, ашигт ажиллагаа нэмэгдэж зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлж байгааг харуулж байна. Нийт хөрөнгийн хэмжээ 2024 онд 90.8 тэрбум төгрөг байсан бол 2025 онд 134.1 тэрбум төгрөгт хүрч 47.7 хувийн өсөлттэй гарсан. Энэхүү өсөлтийн гол шалтгаан нь зээл болон лизингийн үлдэгдэл нэмэгдсэн явдал юм.

Өрийн бүтцийн хувьд, компанийн нийт өр төлбөр 2024 онд 34.4 тэрбум төгрөг байсан бол 2025 онд 62.3 тэрбум төгрөг болж 80.8 хувиар өссөн ч энэхүү өсөлт нь санхүүгийн өр төлбөрт төвлөрсөн байна. Өөрийн хөрөнгө ч мөн адил тогтвортой өсөлттэй байсан ба 2024 оны эцэст 56.4 тэрбум төгрөг байсан бол 2025 онд 71.8 тэрбум төгрөг болж 27.4 хувиар нэмэгдсэн байна. Тус өсөлт нь голчлон хуримтлагдсан ашгийн өсөлтөөр

2026 2 БҮРТГЭВ
СЗХ 2026 он 06 сар 11 өдөр БҮРТГЭВ

бүрдсэн бөгөөд 2024 онд 50.7 тэрбум төгрөг байсан ашиг 2025 онд 65.6 тэрбум төгрөгт хүрсэн байна. Энэ нь компанийн ашигт ажиллагаа сайжирч, дотоод нөөцөөр хөрөнгөжилт хийх чадамж нэмэгдэж буйг харуулж байна.

Дээрх үзүүлэлтүүд нь компанийн хөрөнгийн суурь тогтвортой өсөж, санхүүгийн эрсдэл зохистой удирдагдаж байгааг илтгэж байна. Тиймээс энэхүү үнэт цаас нь өндөр өгөөж хүлээхээс гадна санхүүгийн хувьд найдвартай, итгэлтэй хөрөнгө оруулалт болох бүх нөхцөлийг бүрдүүлж байна.

Хүснэгт 16: Санхүүгийн байдлын тайлангийн босоо шинжилгээ

ҮЗҮҮЛЭЛТ	2022	2023	2024	2025
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	7%	6%	4%	5%
Хөрөнгө оруулалт	0%	0%	0%	0%
Зээл /цэврээр/	86%	88%	90%	89%
Бусад санхүүгийн хөрөнгө	0%	0%	1%	1%
Санхүүгийн хөрөнгийн дүн	**93%**	**94%**	**95%**	**95%**
Бусад	0%	1%	3%	1%
Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, түрээсийн хөрөнгө, биет бус хөрөнгө	6%	4%	2%	4%
Санхүүгийн бус хөрөнгийн дүн	7%	6%	5%	5%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	100%	100%	100%	100%
Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр	29%	35%	32%	30%
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр	0%	0%	5%	0%
Бусад эх үүсвэр	0%	0%	0%	13%
Бусад санхүүгийн өр төлбөр	0%	0%	0%	2%
Санхүүгийн өр төлбөрийн дүн	29%	35%	37%	45%
Санхүүгийн бус өр төлбөрийн дүн	**1%**	**1%**	**1%**	**1%**
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	**29%**	**36%**	**38%**	**46%**
Хувь нийлүүлсэн хөрөнгө	**5%**	**4%**	**6%**	**4%**
Хуримтлагдсан ашиг, алдагдал	64%	59%	56%	49%
Бусад өмч	1%	1%	1%	1%
ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	**71%**	**64%**	**62%**	**54%**
ӨР ТӨЛБӨР ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	**100%**	**100%**	**100%**	**100%**

Эх сурвалж: Үүсгэн байгуулагчийн аудитлагдсан тайлангийн мэдээлэл

Компанийн 2022 оноос 2025 он хүртэлх хугацааны санхүүгийн бүтэц, хөрөнгийн эх үүсвэр, цэвэр хөрөнгийн харьцааг харахад үнэт цаас гаргагч нь үйл ажиллагаагаа тогтвортой тэлж, хөрөнгийн зохистой менежментийг хэрэгжүүлж ирсэн нь харагдаж байна.

Хөрөнгийн зориулалттай хэсгээс авч үзвэл үндсэн хөрөнгө, урт хугацаат хөрөнгө оруулалтын эзлэх хувь 2022 онд 6 хувь байсан бол дараагийн жилүүдэд буурч, 2025 онд 4 хувьд хүрсэн нь компанийн хөрөнгө оруулалтын бүтцэд өөрчлөлт орж, богино хугацааны актив руу төвлөрөх хандлага ажиглагдаж байгааг харуулна. Хөрөнгийн эх үүсвэр талаас авч үзвэл итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр нь нийт хөрөнгийн 29–35 хувийг тогтвортой эзэлсээр байгаа нь компанийн бизнесийн үндсэн чиглэл, орлогын

УЛААНБААТАР ХОТ ӨЧҮҮН АКТИВ ҮЗЭХ 9026040947 7239889 ХНҮ10470

тогтвортой эх үүсвэр хадгалагдаж байгааг илэрхийлж байна. Үүсгэн байгуулагчийн хувьд ийнхүү өрийн хэрэгсэл гаргаж байгаа нь эх үүсвэрийг төрөлжүүлж компанийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэхэд гол түлхэц болох юм.

Компанийн өр төлбөрийн бүтэц нь тогтвортой бөгөөд цалингийн өглөг, татварын өглөг зэрэг богино хугацааны үүргүүд 0–1 хувийн түвшинд хадгалагдаж байгаа нь компанийн үйл ажиллагааны зардлын хяналт, төлбөрийн сахилга бат сайн байгааг илтгэж байна. Цэвэр хөрөнгийн бүтцэд хуримтлагдсан ашиг нь 2022 онд 64 хувь байсан бол 2025 онд 49 хувьтай байгаа нь байгууллага тогтвортой ашигтай ажиллаж ирсэн, өөрийн хөрөнгийн суурь хангалттай түвшинд хадгалагдаж байгааг илэрхийлж байна.

Үүсгэн байгуулагчийн нийт хөрөнгийн бүтэц 2022–2025 онуудад тогтвортой, оновчтой байгаа ба зээлийн багц нийт хөрөнгийн бүтцийн голлох хэсгийг бүрдүүлж байгаа. Энэ өсөлт нь эргэлтийн хөрөнгийн дийлэнхийг зээлд төвлөрүүлснээр, компанийн орлогын чадавхи өндөр хэвээр байгааг илтгэнэ. Үүний зэрэгцээ бэлэн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь 2022-2025 онд 4-7 хувийн хооронд хэлбэлзэж байгаа ч компанийн хөрвөх чадвар, мөнгөн урсгалын зохицуулалт хангалттай байгааг харуулж байна. Энэхүү үзүүлэлт нь компанийн урсгал үйл ажиллагаа, эргэлтийн хөрөнгийн удирдлага нь үр ашигтай явагдаж байгааг илэрхийлдэг.

Хүснэгт 17: Санхүүгийн тайлангийн харьцааны шинжилгээ

ҮЗҮҮЛЭЛТ	2022	2023	2024	2025
Нийт ашгийн маржин	87.0%	84.1%	82.3%	76.1%
Цэвэр ашгийн маржин	41.2%	41.7%	47.3%	44.1%
Эргэлтийн харьцаа	3.3	2.7	2.5	2.1
Өрийн харьцаа	29.4%	36.2%	37.9%	46.1%
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн харьцаа (cash ratio)	24.1%	18.1%	9.7%	11.9%
ROA	10.4%	10.2%	12.6%	11.6%
ROE	14.8%	15.9%	20.3%	21.4%

Эх сурвалж: Үүсгэн байгуулагчийн аудитлагдсан тайлангийн мэдээлэл

Үүсгэн байгуулагч нь өмнө нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргаж байгаагүй богоод уг хөшүүргийг ашиглан, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж эх үүсвэр татан төвлөрүүлж, үйл ажиллагаагаа улам тэлж, өсөлт үзүүлэх боломжтой юм.

Хүснэгт 18: Чанаргүй зээлийн хэмжээ, сая төгрөгөөр

Үзүүлэлт		2024		2025
Нийт зээл	**88,758.3**	**100.0%**	**125,297.7**	**100.0%**
Хэвийн	75,333.4	84.8%	108,404.9	86.5%
Анхаарал хандуулах	2,989.5	3.4%	5,562.6	4.4%
Чанаргүй:	**10,435.5**	**11.8%**	**11,330.1**	**9.1%**
Хэвийн бус	990.7	1.2%	2,089.8	1.7%
Эргэлзээтэй	2,344.3	2.6%	4,060.1	3.3%
Муу	7,100.5	8.0%	5,180.2	4.1%

Эх сурвалж: Үүсгэн байгуулагчийн аудитлагдсан тайлангийн мэдээлэл

Үүсгэн байгуулагчийн 2024 оны байдлаарх нийт зээлийн хэмжээ 88.8 тэрбум төгрөг байсан бол 2025 онд 125.3 тэрбум төгрөг болж, 29.1 хувиар өссөн байна. Энэ өсөлт нь компанийн зээл олголт нэмэгдэж, зах зээлийн оролцоо идэвхжсэнийг илтгэж байна.

Чанаргүй зээлийн нийт хэмжээ 2024 онд 10.4 тэрбум төгрөг (11.8%) байсан бол 2025 онд 11.3 тэрбум төгрөг (9.1%) болж, нийт зээлд эзлэх хувь харьцангуй буурсан нь нэг талаараа эерэг өөрчлөлт болж байна.

Чанаргүй зээлд хамгийн өндөр хувийн жин үзүүлж буй зээл нь "муу" ангиллын зээл юм. Энэ төрлийн зээл 2024 онд 7.1 тэрбум төгрөг (8.0%) байсан бол 2025 онд 5.2 тэрбум төгрөг (4.1%) болж дүнгээр болон эзлэх хувиар буурсан байна. Харин "эргэлзээтэй" зээлийн хэмжээ 2024 онд 2.3 тэрбум төгрөг (2.6%) байсан бол 2025 онд 4.0 тэрбум төгрөг (3.0%) болж өссөн үзүүлэлттэй. Гэхдээ "хэвийн бус" зээлийн хэмжээ 2024 онд 1.0 тэрбум төгрөг (1.2%) байснаас 2025 онд 2.1 тэрбум төгрөг (1.7%) болж өссөн нь эргэлзээтэй зээл төлөгдөж ангилал шилжсэнтэй холбоотой.

Нөгөө талаас, анхаарал хандуулах зээлийн хэмжээ 2024 онд 3.4% байсан бол 2025 онд 4.4% болж компанийн зээлдэгчдийн эрсдэлийн түвшин 1.0 нэгжээр нэмэгдсэн байна.

Чанаргүй зээлд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

Үүсгэн байгуулагч нь чанаргүй зээлийг бууруулах зорилгоор зээлийн бүтээгдэхүүн бүрээр ангилсан чанаргүй зээл төлүүлэлтийн процессын зураглал боловсруулж, батлан хэрэгжүүлж байна. Тухайлбал зээлийн хугацаа хэтэрсэн хоногоос хамааруулан төлөлтийг сануулсан мессеж илгээх, зээлдэгч болон холбоо хамаарал бүхий этгээдрүү дуудлага хийх, уулзалт хийх, гэрийн хаяг руу албан мэдэгдэл хүргэх, тусгай актив болон хуулийн хэлтэсрүү шилжүүлэн ажиллах зэрэг ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна. Түүнчлэн Монголбанкны актив ангилах журмын дагуу зээлийн мэдээллийн санд ангилал бууруулж байна.

Үүсгэн байгуулагчийн Тусгай активын алба нь 5 хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг ба тухайн салбарт мэргэшсэн, эрх зүйч мэргэжилтэй мэргэжилтнүүдээр багаа бүрдүүлсэн. Түүнээс гадна Хэруга Партнэрс хуулийн фирм, Цогц өмгөөлөл хуулийн фирм зэрэг байгууллагуудтай гэрээ байгуулан чанаргүй зээлийг бууруулахаар идэвхтэй ажиллаж байна.

Зохистой харьцаа

Үүсгэн байгуулагчийн зохистой харьцаа нь Санхүүгийн зохицуулах хорооны ББСБ-д тавигдах зохистой харьцааны шаардлагыг бүрэн хангаж байгаа бөгөөд үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгийн 50.9% нь нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөөс бүрдэж байна. Мөн төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт харгалзтай буюу 13.0% (>8%) гарсан байна.

Хүснэгт 19: Зохистой харьцааны үзүүлэлт

Д/д				
А.	**ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ**			
1	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-аас доошгүй	50.9%	Хангасан
2	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, ЭРСДЭЛЭЭР ЖИГНЭСЭН НИЙТ АКТИВЫН ХАРЬЦАА	20%-аас доошгүй	51.4%	Хангасан
3	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, НИЙТ АКТИВЫН ХАРЬЦАА:	30%-аас доошгүй	53.4%	Хангасан
Б.	**ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА**			
4	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ХАРЬЦАА	8%-аас дээш	13.0%	Хангасан
В.	**АКТИВ ХӨРӨНГИЙН ТӨВЛӨРЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ**			

2026 К. 2
БҮРТГЭВ
Сэхэ
БҮРТГЭВ
№ 01

5	ХӨРӨНГӨ /АКТИВ/-ИЙН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭ (+илүү, - дутуу)	8,687,683,103.9	9,593,615,356.9	905,932,253.0
6	НЭГ ЗЭЭЛДЭГЧ БОЛОН ХОЛБОГДОХ ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛ, ЗЭЭЛТЭЙ АДИЛТГАН ТООЦОХ БУСАД АКТИВ ХӨРӨНГӨ, ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	30%-аас хэтрэхгүй	13.2%	Хангасан
7	ББСБ-ААС ГАРГАСАН ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	70%-аас хэтрэхгүй	0.0%	-
8	ББСБ-ЫН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ АЖИЛТАН ХОЛБОГДОХ ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛ, ЗЭЭЛТЭЙ АДИЛТГАН ТООЦОХ БУСАД АКТИВ ХӨРӨНГӨ, ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ НИЙЛБЭР ДҮНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	25%-аас хэтрэхгүй	0.2%	Хангасан
9	ББСБ-ЫН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ, ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ АЖИЛТАН, ХОЛБОГДОХ НЭГ ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛ, ЗЭЭЛТЭЙ АДИЛТГАН ТООЦОХ БУСАД АКТИВ ХӨРӨНГӨ, ТӨЛБӨРИЙН БАТАЛГААНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	10%-аас хэтрэхгүй	0.0%	Хангасан
	ҮНЭТ ЦААСНЫ ЭЗЭМШИЛ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	50%-аас хэтрэхгүй	0.0%	Хангасан
	КОМПАНИЙН ХУВЬЦАА, ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	20%-аас хэтрэхгүй	0.0%	-
10	МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН "I", "II" АНГИЛАЛЫН НЭГ КОМПАНИЙН ГАРГАСАН ХУВЬЦААНААС ХУДАЛДАЖ АВАХ ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	20%-аас хэтрэхгүй	0.0%	Хангасан
	КОМПАНИЙН ӨРИЙН БИЧИГ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	20%-аас хэтрэхгүй	0.0%	-
	БУСАД ҮНЭТ ЦААС, ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	10%-аас хэтрэхгүй	0.0%	Хангасан
Г.	**ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ЭРСДЭЛ**			
11	ГАДААД АКТИВ, ПАССИВЫН ЗӨРҮҮ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	(+/-40%)	0.1%	Хангасан
Д.	**БУСДААС ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**			
12	ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨГЛӨГ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	60%-аас хэтрэхгүй	52.2%	Хангасан
13	ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ЭХ ҮҮСВЭРИЙН НӨӨЦ САН	461,577,460.9	461,577,460.9	Хангасан
18	ӨРИЙН БИЧГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	3,741,634,544.8 30%-аас хэтрэхгүй	24.8%	Хангасан
Е.	**ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ**			
17	ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	15%-аас хэтрэхгүй	2.0%	Хангасан

Эх сурвалж: Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчийн мэдээлэл (2025 оны 12-р сарын 31-ний байдлаар)

ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК ХХК
ШТК0128 5469112 9021061377
ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947
7239689 ХМТ104752

2026 он 12 БҮРТГЭВ
ҮЦХ 2026 оны 06 сар 11 өдөр БҮРТГЭВ

3.14. Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчийн бизнес төлөвлөгөө

Бүтээгдэхүүн хөгжүүлэлт

- Бизнесийн болон хэрэглээний зээлийн бизнес моделийг шинэчилж, харилцагчийн хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгодог болно.
- Бүтээгдэхүүний функциональ байдал, үйлчилгээний чанарыг сайжруулах, брэндээр дамжуулан шинэчлэл хийнэ.
- Цахим бүтээгдэхүүн, үйлчилгээ болон тогтвортой үйл ажиллагааны шилжилтийг дэмжиж ажиллана.
- Харилцагчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх
- Ногоон зээлийн багцыг 2027 онд 5 болон түүнээс дээш хувьд хүргэх.

Байгууллагын хөгжил

- Үндсэн үйл ажиллагааны процессыг автоматжуулж, үйл ажиллагааг хөнгөвчилнө.
- Ажилтны туршлага, ажлын таатай орчин, ажилтны сэтгэл ханамжид анхаарч, чадамжтай ажилтныг тогтвортой ажиллуулахад хүний нөөцийн бодлогыг чиглүүлнэ.
- Бизнес процессын реинженеринг хийж, тасралтгүй сайжруулна.
- Санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд СТОУС-ыг нэвтрүүлнэ.
- Компанийн танигдалтыг нэмэгдүүлж, зах зээл дээрхи мэргэжлийн нэр хүндийг өсгөх.

Эрсдэлийн удирдлага, хяналт

- Зээлийн эрсдэл хяналтын тогтолцоог сайжруулна.
- Үйл ажиллагааны эрсдэлийг эрт илрүүлэх, үнэлэх, удирдах үйл явцыг тогтмолжуулах.
- Кибер аюулгүй байдал, Технологийн эрсдэлийн арга аргачлалыг нэвтрүүлж, хэрэгжүүлэх.
- Байгууллагын засаглал (эрсдэл дотоод хяналт) индексээр 90% дээш байна.

3.15. Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагчийн санхүүгийн төсөөлөл

Үүсгэн байгуулагчийн орлого үр дүн, санхүүгийн байдлын төсөөллийг доор үзүүлэв. Үүнд ирэх 3 жилийн үзүүлэлтийг таамагласан байна.

Хүснэгт 20: Үүсгэн байгуулагчийн балансын төсөөлөл, сая төгрөгөөр

Үзүүлэлт хөрөнгө	2026	2027	2028
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	10,632.9	15,417.7	21,584.7
Хөрөнгө оруулалт	28.3	28.3	28.3
Зээл (цэврээр)	171,001.1	240,598.8	332,084.5
Зээлийн багц	181,283.0	253,796.2	348,462.2
Зээлийн эрсдэлийн сан	-13,545.1	-17,765.7	-22,650.0
Зээлд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	3,263.1	4,568.3	6,272.3
Факторинг	10,259.7	12,311.6	14,774.0
Факторингийн авлагад хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	164.2	197.0	236.4
Бусад санхүүгийн хөрөнгө	280.0	364.0	473.2
САНХҮҮГИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	192,366.1	268,917.5	369,181.2
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	2,609.4	3,131.3	3,757.6
Өмчлөх бусад хөрөнгө (цэврээр)	1,065.0	1,278.0	1,533.6

ТАВАН БОГД КАПИТАЛ ХХК
ТАВАН БОГД КАПИТАЛ ХХК
ШТК0128 5469 9021061377
УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ ХХК
ТЗК ХХК
9026040941
7239689 ХЦ 10470

ҮЦХҲБ ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ ULAANBAATAR SECURITIES EXCHANGE
2026 -06- 12
БҮРТГЭВ
СЗХ
2026 .06. 11 өдөр
БҮРТГЭВ

Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	0.0	0.0	0.0
Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө	1,006.2	1,006.2	1,006.2
Бусад санхүүгийн бус хөрөнгө	368.6	442.4	530.8
Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, түрээсийн хөрөнгө, биет бус хөрөнгө	4,291.7	4,799.1	5,397.5
Үндсэн хөрөнгө (цэврээр)	2,227.3	2,672.8	3,207.4
Биет бус хөрөнгө (цэврээр)	2,064.4	2,126.3	2,190.1
Ашиглах эрхтэй хөрөнгө	673.0	450.9	222.1
САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	10,014.1	11,108.0	12,447.9
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	**202,380.2**	**280,025.5**	**381,629.0**
ӨР ТӨЛБӨР			
Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр (+хур.хүү)	51,420.1	67,617.4	97,369.0
Итгэлцлээр татсан хөрөнгө	48,281.7	63,490.5	91,426.3
Итгэлцлээр татсан хөрөнгөнд хуримтлуулж тооцсон үр шим	3,138.3	4,126.9	5,942.7
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр (2026 оноос гадаадын зээл)	0.0	21,000.0	34,000.0
Бондоор татсан эх үүсвэрийн өглөг	25,583.0	30,000.0	40,000.0
Бондын өглөгт хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	530.0	772.5	1,030.0
ХБҮЦ-аар татсан эх үүсвэрийн өглөг	30,000.0	40,000.0	50,000.0
ХБҮЦ-д хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	1,968.8	2,250.0	2,812.5
Бусад эх үүсвэр	476.6	373.6	226.1
Бусад санхүүгийн өр төлбөр	120.0	144.0	172.8
САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	110,098.4	162,157.5	225,610.4
САНХҮҮГИЙН БУС ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	1,562.2	2,445.8	3,143.1
ААНОАТ-ын өглөг	1,457.5	1,755.3	2,620.0
Бусад санхүүгийн бус өр төлбөр	104.7	690.5	523.1
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	111,660.6	164,603.3	228,753.5
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ			
Хувь нийлүүлсэн хөрөнгө	5,000.0	5,000.0	10,000.0
Хуримтлагдсан ашиг, алдагдал	66,036.0	85,037.6	109,672.0
Тухайн үеийн ашиг/алдагдал	19,001.6	24,634.4	32,378.3
Бусад өмч	682.0	750.2	825.2
ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	90,719.6	115,422.2	152,875.5
ӨР ТӨЛБӨР ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	**202,380.2**	**280,025.5**	**381,629.0**

Эх сурвалж: Үүсгэн байгуулагчийн мэдээлэл

Үүсгэн байгуулагчийн 2026-2028 оны санхүүгийн төлөв байдлын тооцооллоос харахад компанийн хөрөнгийн хэмжээ тогтвортой өсөлттэй, санхүүгийн бүтэц нь аажмаар бэхжиж байгааг харуулж байна. 2026 онд компанийн нийт хөрөнгө 202.4 тэрбум төгрөг байх бол 2027 он гэхэд 280.0 тэрбум төгрөгт хүрэхээр төлөвлөгдсөн нь 28 орчим хувийн өсөлтийг харуулж байгаа юм. Энэ өсөлтөд голлон нөлөөлсөн үзүүлэлт бол зээлийн эх үүсвэр юм.

Өр төлбөрийн талаарх төлөвөөс харвал 2026 онд 111.7 тэрбум төгрөг байх нийт өр төлбөр 2028 онд 225.6 тэрбум төгрөг болж, хөөр дахин нэмэгдэх хандлагатай байна. Үүнд санхүүгийн өр төлбөр буюу итгэмжлэгдсэн үйлчилгээнээс авсан хөрөнгө, банк санхүүгийн байгууллагуудаас татсан зээл, бусад санхүүгийн өр төлбөрийн өсөлт голлон нөлөөлжээ. Энэ нь компанийн үйл ажиллагаа өсөн тэлж, илүү их эх үүсвэр шаардлагатай болж байгааг илтгэнэ.

Харин өөрийн хөрөнгийн хэмжээ ч мөн адил тогтвортой өсөлттэй байж, 2026 оны 90.7 тэрбум төгрөгөөс 2028 онд 152.9 тэрбум төгрөгт хүрэхээр байна. Өөрийн хөрөнгийн өсөлтөд голлон нөлөөлж буй хүчин зүйл бол хуримтлагдсан ашиг юм. 2026 онд 66.0 тэрбум төгрөг байсан хуримтлагдсан ашиг 2028 онд 109.7 тэрбум төгрөгт хүрнэ гэж

ТАВАН БОГД КАПИТАЛ ХХК
ТАВАН БОГД КАПИТАЛ ХХК
УПАДАНГАЙН ХОТ
ОЧУН ЭКТИВ НЭГ ТЭК ХХК
7230689 т. ХНТ10470

2026 БҮРТГЭВ
СЭХ 2026 БҮРТГЭВ

тооцоологджээ. Энэ нь компанийн үндсэн үйл ажиллагаанаас ашиг хүртэж, урт хугацаанд ашигт ажиллагааг хадгалах боломжтой байгааг харуулна.

Хүснэгт 21: Үүсгэн байгуулагчийн орлогын тайлангийн төсөөлөл, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2026	2027	2028
Хүүгийн орлого	52,852.5	74,254.4	100,876.1
Банканд байршуулсан хөрөнгө	600.0	750.0	937.5
Зээлийн хүүгийн орлого (Нийт зээлийн хүүгийн орлого)	49,866.6	70,118.7	95,875.7
Зээлийн хүүгийн орлого (90-с бага хоногийн хэтрэлттэй болон хэвийн зээлийн хүүгийн орлого)	46,876.6	68,525.0	94,855.7
Зээлийн хүүгийн орлого (90+ хоногийн хэтрэлттэй буюу тэнцлийн гадуурх хүүнээс төлүүлэх)	2,990.0	1,593.8	1,020.0
Бусад хүүгийн орлого (Факторингийн хүүгийн орлого)	2,385.9	3,385.7	4,062.8
Хүүгийн зардал	16,864.7	26,984.3	38,803.1
Итгэлцлийн үйлчилгээний үр шим	7,734.8	10,618.4	14,717.1
Зээлийн хүүгийн зардал (Гадаадын банкнаас авсан зээл)	0.0	2,467.5	6,462.5
Бондын хүүгийн зардал	3,474.3	5,210.0	7,210.0
ХБҮЦ-ны хүүгийн зардал	5,437.5	8,437.5	10,125.0
Бусад хүүгийн зардал (түрээсийн хүү)	218.1	250.9	288.5
ХҮҮГИЙН ЦЭВЭР ОРЛОГО	35,987.9	47,270.2	62,073.0
Эрсдэлийн сангийн зардал	3,185.1	4,220.7	4,884.3
Зээлийн эрсдэлийн сангийн зардал	3,185.1	4,220.7	4,884.3
ЭРСДЭЛИЙН САНГИЙН ДАРААХ ЦЭВЭР ОРЛОГО	32,802.8	43,049.5	57,188.7
Хүүгийн бус орлого	1,915.1	2,598.9	3,530.7
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	1,915.1	2,598.9	3,530.7
Бусад хүүгийн бус орлого			
Бусад орлого, олз	21.0	250.0	250.0
Хүүгийн бус зардал	11,248.5	15,834.8	20,529.3
Хураамж, шимтгэлийн зардал	55.7	445.5	504.4
Үйл ажиллагааны бусад зардал	11,192.8	15,389.2	20,024.9
Ажилтнуудын цалинтай холбоотой зардал (Цалин хөлс+НДШ, ЭМДШ)	6,046.6	8,186.6	11,121.6
Бусад зардал, гарз	116.1	163.4	201.8
ТАТВАРЫН ӨМНӨХ АШИГ, АЛДАГДАЛ	23,374.2	29,900.3	40,238.3
Орлогын албан татварын зардал	4,372.6	5,265.9	7,860.0
Тайлант үеийн орлогын татварын зардал	4,372.6	5,265.9	7,860.0
Цэвэр ашиг	19,001.6	24,634.4	32,378.3

Эх сурвалж: Үүсгэн байгуулагчийн мэдээлэл

Компанийн үйл ажиллагааны үр ашиг, цэвэр ашиг, ашгийн маржин зэргээс харахад 2026-2028 оны хооронд орлого ба ашигт ажиллагаа тогтвортой өсөлттэй, санхүүгийн чадавхи бэхжиж байгааг илэрхийлж байна. 2026 онд компанийн нийт хүүгийн орлого 52.9 тэрбум төгрөг байсан бол 2027 он гэхэд энэ тоо 74.3 тэрбум төгрөгт хүрэхээр төлөвлөгдсөн байна. Үүний дийлэнхийг зээлийн үйл ажиллагаанаас олсон хүүгийн орлого бүрдүүлж байгаа нь компанийн үндсэн орлого бүрдүүлэгч гол эх үүсвэр байгаа харуулж байна.

Хүүгийн зардал ч мөн адил өсөх боловч орлогоосоо харьцангуй бага хурдаар өсч байгаа нь ашигт ажиллагаанд эерэгээр нөлөөлж байна. Жишээлбэл, 2026 онд 16.9 тэрбум төгрөг байсан хүүгийн зардал 2027 онд 27.0 тэрбум төгрөг болж байгаа ч, жил хугацаанд хүүгийн цэвэр орлого 36.0 тэрбум төгрөгөөс 47.3 тэрбум төгрөг хүртэл өсөж

УЛААНБААТАР ХОТ ТЭЭВЭР БОГД КАПИТАЛ ХХК ШТК0128 5469112 9021061377
УЛААНБААТАР ХОТ ТЭЭВЭР БОГД КАПИТАЛ ХХК

2026 : 2 БҮРТГЭВ
СЭХ 2026 .05. 11 ӨДӨР БҮРТГЭВ

байна. Энэ нь компанийн цэвэр хүүгийн маржин хадгалагдаж, хөрөнгийн өгөөжийг оновчтой удирдаж байгааг харуулж байна.

Эрсдэлийн сангийн зарлага харьцангуй тогтвортой бөгөөд 2027 онд 4.2 тэрбум төгрөг, 2028 онд 4.9 тэрбум болохоор байна. Үүний дараа тооцоолсон эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого 2026 онд 32.8 тэрбум төгрөг байсан бол 2028 онд 57.2 тэрбум төгрөг болж 57.3%-иар өсөх нь онцлох үзүүлэлт юм.

Үйлчилгээний шимтгэл, хураамжийн орлого мөн өсөлттэй байгаа бөгөөд 2026 оны 1.9 тэрбум төгрөгөөс 2028 онд 3.5 тэрбум төгрөг хүрч нэмэгдэнэ. Энэ төрлийн орлого нэмэгдэх нь компанийн үйлчилгээний цар хүрээ, төрөлжилт тэлж байгааг илтгэнэ. Харин үйл ажиллагааны зардлууд, тухайлбал бусад зардал, шимтгэлийн зардлууд ч мөн нэмэгдэж байгаа ч нийт ашгийн өсөлттэй харьцуулбал зохистой түвшинд байна.

Эцсийн дүндээ, компанийн татварын өмнөх ашиг 2026 онд 23.4 тэрбум төгрөг байсан бол 2028 онд 40.2 тэрбум төгрөг болж өснө. Татвар төлсний дараах цэвэр ашиг 19.0 тэрбум төгрөгөөс 32.4 тэрбум төгрөг хүртэл өсөж байгаа нь хөрөнгө оруулагчдын хувьд хамгийн чухал үзүүлэлт юм. Энэ нь компанийн тогтвортой өсөлт, өгөөж бий болгох чадварыг бататгаж, урт хугацааны хөрөнгө оруулалтын үнэ цэнийг бүрдүүлэх баталгаа болно.

Хүснэгт 22: Голлох харьцаа үзүүлэлтүүд төсөөлөл

ҮЗҮҮЛЭЛТ	2026	2027	2028
Нийт ашгийн маржин	68.1%	63.7%	61.5%
Цэвэр ашгийн маржин	36.0%	33.2%	32.1%
Эргэлтийн харьцаа	1.7	1.7	1.6
Өрийн харьцаа	55.2%	58.8%	59.9%
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн харьцаа (cash ratio)	9.7%	9.5%	9.6%
ROA	9.4%	8.8%	8.5%
ROE	20.9%	21.3%	21.2%

Эх сурвалж: Үүсгэн байгуулагчийн мэдээлэл

Төсөөллөөр Компанийн үйл ажиллагааны үр ашиг, санхүүгийн бүтцийн зохистой байдал, хөрөнгө оруулагчдын өгөөжийн хүлээлтийг үнэлэхэд энэхүү харьцааны үзүүлэлтүүд чухал үндэслэл болж байна. Net Interest Margin буюу цэвэр хүүгийн маржин 2025 онд 77.1% байснаа 2027 онд 70.9% болж бага зэрэг буурч байгаа ч харьцангуй өндөр түвшинд хадгалагдаж байна. Энэ нь компанийн үндсэн орлого болох зээлийн үйл ажиллагаа хүүгийн зардлын дараах ашигтай байдал хадгалагдаж байгааг илтгэнэ.

Хүүгийн зардлын хэмжээ нийт үйл ажиллагааны орлоготой харьцуулахад 2025 онд 22.3% байсан бол 2026, 2027 онуудад 28.2–28.4%-д хүрч өссөн нь өрийн санхүүжилтийн зардал өсч байгааг харуулж байгаа хэдий ч компанийн нийт ашигт байдалд сөргөөр нөлөөлөх хэмжээнд биш байна. Үүнийг УА ашгийн маржин буюу үйл ажиллагааны ашигт байдлын хэмжээ 2026 онд 50.8%, 2027 онд 51.6%-д хадгалагдаж буйгаар нотолж болох юм.

Мөн үйл ажиллагааны бус зардлын үр ашиг нэмэгдэж, тухайн зардлуудын УА орлогод эзлэх хувь 2025 оны 22.4%-иас 2027 онд 19.3% болж буурч буй нь компанийн дотоод зардлын удирдлага сайжирч байгааг харуулж байна. Эрсдэлийн сангийн зарлага ч

ТАВАН БОГД КАПИТАЛ ХХК ШТК0128 5469 9021061377
ӨЧҮҮН АКТИВ НЭГ ТӨК ХХК УЛААНБААТАР ХОТ

мөн адил хэлбэлзэлтэй боловч 2026 онд 1.3% болж буурсан нь зээлийн чанар сайжирч, хохирлын магадлал багассан байж болохыг илтгэнэ.

Хөрөнгө оруулагчдын хамгийн их анхаардаг үзүүлэлт болох Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) 2025 онд 23.9% байсан бол 2027 онд 25.3%-д хүрч өссөн нь компанийн өөрийн хөрөнгөнд ногдох ашиг нэмэгдэж буйг илэрхийлнэ. Энэ үзүүлэлт нь олон улсын жишигтэй харьцуулахад өндөрт тооцогдох үзүүлэлт юм. Үүнтэй адилаар нийт хөрөнгийн өгөөж (ROA) 2025 онд 13.5% байсан нь 2026 онд бага зэрэг буурсан ч 2027 онд 12.7%-д тогтворжиж, хөрөнгийн үр ашиг өндөр хэвээр байгааг баталж байна.

3.16. Үйлчилгээ үзүүлэгчийн тухай мэдээлэл, үүрэг

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэгт зааснаар үйлчилгээ үзүүлэгч нь үүрэг гүйцэтгэгчтэй харилцаж хөрөнгөтэй холбоотой төлбөрийг цуглуулан тусгай зориулалтын компанид шилжүүлэх, бүртгэх, тайлагнах болон үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасан хөрөнгөтэй холбоотой бусад үйлчилгээ, үйл ажиллагаа эрхлэхээр үнэт цаас гаргагчтай гэрээ байгуулсан хуулийн этгээд байна.

Үнэт цаас гарагчийн Үйлчилгээ үзүүлэгч буюу Анхны үүрэг гүйцэтгүүлэгч "Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК нь хүний нөөцийн болон нягтлан бодох бүртгэл, тайлан тооцоо гаргах, программ, техник хангамжийн нөхцөлөөр бүрэн хангагдсан бөгөөд компанийн засаглалын өөрийн үнэлгээ хийж Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодекст заасан зарчмуудыг хэрэгжүүлэх хөтөлбөр батлан ажиллаж байна.

Үйлчилгээ үзүүлэгчийн хэрэгжүүлэх арга хэмжээ, үүрэг:

- Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээний нөхцөл болон Үнэт цаас гаргагч эсхүл түүний төлөөлөгчөөс бичгээр ирүүлсэн зааварчилгаанд дурдсан нөхцөлийн дагуу үйл ажиллагаа явуулна.
- Хөрөнгийн багцад багтсан зээлийн Зээлдэгч, үүрэг гүйцэтгэгч нартай харилцах, төлбөр цуглуулах, зээл төлүүлэх арга хэмжээг өөрийн холбогдох Зээлийн эрсдэлийг удирдах журамд заасны дагуу хэрэгжүүлэх, зээлдэгчийн өмнө ТЗК- г төлөөлж, зээлийн эргэн төлөлтийг гэрээнд заасан хугацаанд ТЗК-д шилжүүлэх, бүртгэх, тайлагнах;
- Зээлдэгчийн хүсэлтийн дагуу Зээлийн гэрээнд өөрчлөлт оруулж, төлбөрийн хуваарьт өөрчлөлт оруулсан бол Үйлчилгээ үзүүлэгч нь энэ талаарх мэдээллийг Хөрөнгө итгэмжлэн удирдагчид Зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан сард багтааж мэдэгдэнэ;
- Хөрөнгийн багцад багтсан зээлийн мэдээллийг хадгалах, ТЗК, Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн хууль ёсны шаардлагаар ТЗК-тай холбоотой аливаа дүгнэлт гаргахад шаардагдах мэдээлэл, баримт бичгийг хүргүүлэх, мэдээллээр хангах, өөрийн гаргасан дүгнэлтийг холбогдох баримтыг бүрэн судалж, зохих стандартын дагуу үйл ажиллагаа явуулж, гаргасан дүгнэлтийн хариуцлагыг бие даан хариуцна;
- Үилчилгээ үзүүлэгч нь өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас ТЗК болон Үнэт цаас эзэмшигчдэд хохирол учруулсан тохиолдолд өөрийн хөрөнгөөр тэдний өмнө хариуцлага хүлээнэ;
- ТЗК-ийн нэрийн өмнөөс зээлийн хүүгийн төлбөрийн нэмэгдсэн өртгийн албан татварын баримтыг зээлдэгчид хүргүүлнэ;
- Үйлчилгээ үзүүлэгч нь хөрөнгөөс олох орлогыг баталгаат үнэт цаасны хөрөнгийн багц тус бүрээр, багцын тодорхой хэсгээр тусдаа дансанд хуримтлуулна.

2026 ... 2
БҮРТГЭВ

2026.05.11
БҮРТГЭВ

3.17. Үйлчилгээ үзүүлэгчийн байгуулсан гэрээ

Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээ

Компанийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргахтай холбоотой "Очун Актив Нэг ТЗК" ХХК, "Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК, "Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК нарын хооронд 2026 оны 04-р сарын 21-ний өдөр ОАН-2026-02 тоот "Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г байгуулсан байна. Тус гэрээ нь нийт 9 бүлгээс бүрдсэн бөгөөд тус гэрээний дагуу Үйлчилгээ үзүүлэгч нь Үнэт цаас гаргагчаас гаргах хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны төлбөрийг цаг хугацаанд нь цуглуулан, шилжүүлэх, бүртгэлийг хөтлөх, тайлагнах, Зээлийн эрсдэлийг удирдах журмын дагуу зээлийн хяналт тавьж, зээл төлүүлэх ажиллагаа явуулах, Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас төлбөр цуглуулах үйл ажиллагаанд хяналт тавих, Үнэт цаас гаргагч нь үйлчилгээний төлбөрийг төлөхтэй холбогдох харилцааг зохицуулсан байна.

Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ

Компанийн ХЭХ, ТУЗ-ийн хурлын бэлтгэлийг хангах, албан бичиг хэргийн ажил гүйцэтгэх, Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай хамтран нягтлан бодох бүртгэл хөтлөх, ТЗК-ийн мөнгөн хөрөнгөөс шаардлагатай мөнгөн гүйлгээг ХИУ-ийн хяналт доор хамтран гүйцэтгэх, хүүгийн орлогын албан татвар төлөх, компанийн цахим хуудас хөтлөх зэрэг Үнэт цаас гаргагчийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотойгоор ОАН-2026-06 тоот "Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г Үнэт цаас гаргагч нь "Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК-тай 2026 оны 04-р сарын 21-ний өдөр байгуулсан байна. Гэрээ нь нийтлэг үндэслэл, үзүүлэх үйлчилгээ, үйлчилгээний хөлс, баталгаа, мэдэгдэл, гэрээ дуусгавар болох, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, нууц мэдээлэл, маргаан шийдвэрлэх, бусад зүйл гэсэн 9 бүлэг бүхий зохицуулалттай байна.

3.18. Үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан гэрээг цуцлах нөхцөл

Үйлчилгээ үзүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд ТЗК нь гэрээг цуцалж, шинэ үйлчилгээ үзүүлэгчийг томилно.

Гэрээг цуцалсан тохиолдолд түүнээс хойш 5 хоногийн дотор дараагийн үйлчилгээ үзүүлэгчийг сонгоно. Шинэ үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулсан гэрээ хүчин төгөлдөр болох хүртэл хугацаанд Үйлчилгээ үзүүлэгч Төлбөр цуглуулах үйлчилгээг үргэлжлүүлэн үзүүлэх үүрэгтэй ба ТЗК-аас нэмэлт төлбөр шаардах эрхгүй байна.


УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК

TAVAN BOGD CAPITAL

ОСНИН FINANCE

БУРТГЭВ

БУРТГЭВ



ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК

2026 06 12
БҮРТГЭВ

СЭХ
2026 06 11 өдөр
БҮРТГЭВ
№ 01

4. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

4.1. Үнэт цаасжуулах хэлцлийн зураглал

Зураг 7: Хэлцлийн зураглал



Тусгай зориулалтын компани үүсгэн байгуулах

ТЗК нь СЗХ-ноос зөвшөөрөл авсны үндсэн дээр, баталгаат үнэт цаас гаргах бүрд байгуулагддаг тусгай зориулалттай хуулийн этгээд юм. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.4-т заасны дагуу Очир Ундраа ОМЗ ББСБ ХХК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгоор хууль журмын дагуу Очун Актив Нэг ТЗК ХХК-ийг үүсгэн байгуулсан.

Хууль, журмын хүрээнд шаардлага хангаж буй зээлийг багцлан бүрдүүлэх

Шинээр байгуулагдсан "Очун Актив Нэг ТЗК" ХХК-ийн ТУЗ-өөс үйл ажиллагаа, санхүү, хөрөнгийн удирдлага зэрэг үйл ажиллагаа явуулахтай холбоотой дотоод журмууд батлан гаргасан бөгөөд эдгээр журамд үндэслэн "Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК-аас шаардлага хангаж буй зээлийн багцыг тодорхойлно. 2026 оны 02 сарын 12-ны өдрөөр тасалбар болгосон зээлийн багцын үнийн дүн 44,006,588,238 /дөчин дөрвөн тэрбум зургаан сая таван зуун наян найман мянга хоёр зуун гучин найм/ төгрөг байна.

Зээлийн багцын хөндлөнгийн дүгнэлт

Тодорхойлогдсон зээлийн багцад үндэслэн Үнэт цаас гаргагчаас тогтоосон хуулийн болон санхүүгийн шалгуурыг хангаж буй эсэхэд хөндлөнгийн хуулийн дүгнэлтийг Өмгөөллийн Эм Жэй Эл атторнейс ХХН, зээлийн шинжилгээг Си Пи Ти Эй аудит ХХК боловсруулсан. Ингэхдээ ХБҮЦ-н тухай хууль, СЗХ, Улаанбаатар Үнэт Цаасны Биржийн журмуудад тусгасан асуудлаар дүн шинжилгээ хийсэн.

Шинээр байгуулагдсан ТЗК-д зээлийн багцыг шилжүүлэх

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшилд буй зээлийн багцыг "Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК-тай 2026 оны 04-р сарын 21-ний өдөр байгуулсан ОАН-2026-01 тоот "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-ний дагуу "Очун Актив Нэг ТЗК" ХХК-д шилжүүлнэ. Тус гэрээ нь нийт 14 бүлгээс бүрдсэн бөгөөд тус гэрээний дагуу Үнэт цаас гаргагч нь

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК

2026 оны 2 БҮРТГЭВ

СЗХ 2026.06.11 БҮРТГЭВ

зээлийн багц хөрөнгө болон түүнд холбогдох эрхийг худалдан авч, гэрээнд заасан үнийг төлөх, анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгийн багцыг худалдах, зээлийн хөрөнгийг солихтой холбоотой харилцааг зохицуулж байна.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч Юү Эй Эф Ассет Менежмент ХХК нь ТЗК-тай байгуулсан гэрээний үндсэн дээр хөрөнгө оруулагчид барьцаалуулсан тус хөрөнгийг түүний эрх ашигт нийцүүлэн эзэмшиж удирдана. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ үнэт цаасны хугацааны эцэст дуусгавар болно.

Эрх бүхий байгууллагуудад бүртгүүлэх

Андеррайтер нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хууль, СЗХ-ны "Хөрөнгөөр Баталгаажсан Үнэт Цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам", УБҮЦБ-ийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам"-ын дагуу үнэт цаасны танилцуулга, хүсэлтийг боловсруулж, үнэт цаасыг бүртгүүлнэ. Үнэт цаас гаргагч нь ҮЦТХТ-өөр дамжуулж Үнэт цаасыг бүртгүүлж хадгалуулах, хүүгийн төлбөр тооцоо, эрхийг шилжүүлэх зэрэг үүргийг гүйцэтгүүлнэ.

УБҮЦБ-ээр дамжуулан олон нийтэд анх удаа санал болгох

УБҮЦБ болон СЗХ-оос зөвшөөрөл авсны үндсэн дээр Андеррайтер нь эрх бүхий байгууллагуудаас гаргасан үнэт цаасыг танилцуулах хууль, дүрэм журмын хүрээнд тогтоосон хугацаанд анхдагч зах зээлд олон нийтэд сурталчилж, санал болгон арилжаалж, захиалгыг хүлээн авна. Худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагчид УБҮЦБ -ээр дамжуулж Үнэт цаас олон нийтэд санал болгох анхдагч зах зээлийн арилжааны хугацаанд өөрийн ҮЦТХТ-д бүртгэлтэй дансанд захиалгын мөнгийг шилжүүлж, арилжаанд оролцоно. Арилжаа амжилттай явагдсаны дараа Үнэт цаасыг хөрөнгө оруулагчдын дансанд байршуулна. Ингэснээр ХБҮЦ-ны үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг үнэт цаасны танилцуулгад заасан хугацаанд авах эрх үүснэ. Үнэт цаас гарган татан төвлөрүүлсэн хөрөнгийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид шилжүүлнэ.

Хөрөнгө Итгэмжлэн удирдах

"Очун Актив Нэг ТЗК" ХХК-с гаргасан Хөрөнгө итгэмжлэн удирдах журам, Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний хүрээнд тогтоосон бүрэн эрхийн дагуу Юү Эй Эф Ассет Менежмент ХХК-аар дамжуулж хөрөнгийг итгэмжлэн удирдуулна. Ингэхдээ ХБҮЦ-ны багцтай холбоотой хөрөнгийг бүртгэх, тайлагнах зэрэг үйлчилгээг Хөрөнгө итгэмжлэн удирдах журам, СЗХ, УБҮЦБ -н баталсан журамд заасан хугацаанд гүйцэтгэнэ.

Тусгай зориулалтын компанийг татан буулгах

Тусгай зориулалтын компанийг дараах нөхцөлүүдэд татан буулгана. Үүнд:

1. Үнэт цаасны танилцуулга, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай шийдвэр, хууль тогтоомж болон холбогдох журамд заасан баталгаат үнэт цаасаар хүлээсэн үүрэг нь бүрэн гүйцэтгэсэн,

2. Баталгаат үнэт цаасны Хөрөнгийн багцыг анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагчтай тохиролцон багцыг буцаан худалдсан,

3. Баталгаат үнэт цаасны төлбөр төлөх болон үнэт цаасны танилцуулгад заасан үүргээ биелүүлээгүйн улмаас нийт үнэт цаасыг эзэмшиж байгаа хөрөнгө оруулагчдын гуравны хоёроос дээш хувь нь татан буулгахыг шаардсан, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан нөхцөлүүдийн дагуу.

Тусгай зориулалтын компанийг өөрчлөн байгуулах, дахин үүсгэн байгуулах үйл ажиллагаа хийгдэхгүй.

УЛААНБААТАР ХОТ ... КАПИТАЛ ТҮЦК ХХК ... 9021061377

ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК 9028040947 ХНТ10470

БҮРТГЭВ

2026 .06. 11 БҮРТГЭВ

Татан буугдсан тусгай зориулалтын компанийн хөрөнгийг хуваарилах

Татан буугдсан тусгай зориулалтын компанийн хөрөнгийг хуваарилахад дараах дарааллыг баримтална:


- Татан буулгах ажиллагааны зардал;
- Хөрөнгө оруулагчид олгох үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөр;
- ХБҮЦ-ны хүүгийн орлогын татвар;
- Тусгай зориулалтын компаниас авлагатай анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс бусад бүх этгээдийн шаардлага;
- Авлагатай анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн шаардлага;
- ТЗК-ийн ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулалтай холбоотой зардал;
- Бусад ТЗК-ийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой ТУЗ-өөс баталсан төсвийн дагуу гарах зардал;
- Үлдсэн хөрөнгийг оруулсан хөрөнгийн хэмжээтэй нь хувь тэнцүүлэн хувь нийлүүлэгчдэд олгоно.

4.2. Үнэт цаасны хүү тогтоосон үндэслэл

Үнэт цаас гаргагч нь "Очун Актив" ХБҮЦ-ны хүүгийн түвшинг тогтоохдоо хадгаламжийн хүүг харгалзан үзэж тогтоосон. 2026 оны 3 дугаар сарын байдлаар банкнуудын шинээр татсан 12 сарын хугацаатай төгрөгийн хугацаатай хадгаламжийн хүү 11.0%-12.2% байна. Харин хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны купон 18.5% байгаа бөгөөд энэхүү өгөөж нь хугацаатай хадгаламжийн дундаж хүүгээс 7.3%-8.5% нэгжээр өндөр хүүг хөрөнгө оруулагчдад санал болгож байна.

Мөн ХБҮЦ-ны хүүгийн төлбөрийг улирал тутам, үндсэн төлбөрийг хагас жил тутамд тэнцүү дүнгээр хүлээн авснаар дахин хөрөнгө оруулалт хийж, бодит өгөөжийн түвшнийг нэмэгдүүлэх боломжтой. Үнэт цаасыг нээлттэй хүрээнд санал болгож байгаагийн хувьд биржийн бус зах зээлд гаргасан хаалттай бонд болон банкны хадгаламжийн хүүгийн орлоготой харьцуулахад татварын давуу талыг эдлэх юм.

График 11: 12 сарын хугацаатай хүүгийн харьцуулалт



Эх сурвалж: Арилжааны банкны вебсайт

4.3. Үнэт цаастай холбоотой оролцогч талуудтай хийсэн гэрээнүүд

№	Гэрээний нэр, огноо	Оролцогч талууд	Гэрээний агуулга
1	Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ 2026.04.21 "ОАН-2026-01"	-Очун Актив Нэг ТЗК ХХК -Очир Ундраа ОМЗ ББСБ	Зээлийн багц болон холбогдох эрхийг худалдан авч, гэрээний үнийг анхны үүрэг гүйцэтгүүлэгчид төлөх, анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгийн багцыг худалдах, зээлийн хөрөнгийг солих, нэмэх, буцаан худалдах үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулсан байна.
2	Фидуцийн барьцааны гэрээ	-Очун Актив Нэг ТЗК ХХК	Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс үнэт цаас хариуцуулж

УЛААНБААТАР ХОТ ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК

ТАВАН БОГД КАПИТАЛ УЦК ХХК

	2026.04.21 "ОАН-2026-05"	-Очир Ундраа ОМЗ ББСБ	худалдсан хөрөнгийн багцад ногдох Фидуцийн гэрээний дагуу анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжсэн автотээврийн хэрэгслүүд, барьцааны гэрээний дагуу анхны үүрэг гүйцэтгүүлэгчид барьцаалуулсан үл хөдлөх хөрөнгө, газрын эрхийг энэхүү ХБҮЦ-ны үүргийн гүйцэтгэлд барьцаалуулахтай холбоотой харилцааг уг гэрээгээр зохицуулсан байна.
3	Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ 2026.04.21 "ОАН-2026-03"	-Очун Актив Нэг ТЗК ХХК -Юү Эй Эф Ассет Менежмент ХХК	Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас үзүүлэх үйлчилгээ, үйлчилгээний хөлс төлөх болон гэрээний дагуу хамтран ажиллах зарчим, хөрөнгө итгэмжлэн удирдагчийн үйл ажиллагаанд баримтлах журам, талуудын эрх үүргийг тодорхойлсон.
4	Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээ 2026.04.21 "ОАН-2026-02"	-Очун Актив Нэг ТЗК ХХК -Очир Ундраа ОМЗ ББСБ -Юү Эй Эф Ассет Менежмент ХХК	Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь зээлийн багцын эргэн төлөлтөөс орж ирэх мөнгийг зээлийн эргэн төлөлтийн дансанд төвлөрүүлэх, уг төлбөрийг ТЗК-ийн төлбөр цуглуулах дансанд шилжүүлэх, хяналт тавих ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулсан байна.
5	Зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээ 2026.04.21 "ОАН-2026-04"	-Очун Актив Нэг ТЗК ХХК -Очир Ундраа ОМЗ ББСБ -Юү Эй Эф Ассет Менежмент ХХК	Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээнд тусгасан зээлийн эргэн төлөлтийн данс, уг дансанд цугларах зээлийн төлбөрийн орлогыг барьцаалах, ТЗК-ийн ХБҮЦ-ны төлбөрийг төлөх зорилгоор зээлийн эргэн төлөлтийн данснаас ТЗК-ийн төлбөр цуглуулах дансанп гэрээ болон журмаар тогтоосон хугацаанд үл маргах журмаар шилжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.
6	Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ 2026.04.21 "ОАН-2026-06"	-Очун Актив Нэг ТЗК ХХК -Очир Ундраа ОМЗ ББСБ	Компанийн ХЭХ, ТУЗ ийн хурлын бэлгэлийг хангах, ТУЗ-ийн нарийн бичгийн чиг үүргийг гүйцэтгэх, мөнгөн хөрөнгөөс шаардлагатай мөнгөн гүйлгээг хийж гүйцэтгэх болон нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, холбогдох тайлан мэдээг хуульд нийцсэн хугацаанд тайлагнахтай холбогдуулан ХИУ-д хяналт тавих, шаардлагатай тохиолдолд хамтран ажиллах, хүүгийн орлогын албан татвар тайлагнах, компанийн цахим хуудас хөтлөх, жилийн үйл ажиллагааны тайлангийн аудитад бэлтгэх, дүгнэлтийг хүлээн авч ТУЗ болон ХИУ-д хүргүүлэх, ХБҮЦ-ны хэлцлийн гэрээ, журамд өөрчлөлт оруулах тохиолдолд төслийг боловсруулан баталгаажуулж ХИУ-д хүргүүлэх ХБҮЦ-ны зээлийн багц дахь хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу эрх бүхий

2026 06 2
БҮРТГЭВ
СЭХ
2026 06 11
БҮРТГЭВ

			байгууллагад бүртгүүлэх зэрэг үнэт цаас гаргагчийн өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулсан байна. ТЗК-ийн байгууллагын тэмдэг, улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм, тусгай зөвшөөрөл, санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан зэрэг баримт бичгийг Захиргааны үйлчилгээ үзүүлэгч өөрийн ажлын байранд хадгалах бөгөөд аюулгүй байдал, мэдээллийн нууцлалыг хадгалах үүргийг хүлээж, баталгаа гаргасан байна.
7	Андеррайтерийн үйлчилгээний гэрээ /ХБҮЦ/ 2025.12.05 "43/AY-25-021"	-Таван Богд Капитал ҮЦК ХХК -Очир Ундраа ОМЗ ББСБ ХХК	Андеррайтер нь үнэт цаас гаргах төслийн бэлтгэл ажлыг хангах, Үнэт цаас гаргагчаас шаардлагатай баримт бичгүүд, төсөв төлөвлөгөө, мэдээ мэдээллийн талаар зөвлөгөө өгөх, ирүүлсэн баримт бичиг, мэдээлэл болон хөндлөнгийн зөвлөх байгууллагуудын боловсруулсан дүгнэлт тайланд үндэслэн Үнэт цаас гаргахад шаардлагатай судалгаа, шинжилгээ хийж, Үнэт цаасны танилцуулга, Андеррайтерийн мэдэгдэл, дүгнэлт болон Үнэт цаасны багц баримт бичгүүдийг боловсруулах андеррайтер, зуучлалын үйлчилгээг үзүүлэхээр тусгасан байна.
8	Хамтын ажиллагааны гэрээ 2026.04.13 "43/AY-26-09"	-Таван Богд Капитал ҮЦК ХХК -Ти Ди Би Секьюритис ҮЦК ХХК	Үнэт цаас гаргагчийн эрх бүхий этгээдийн шийдвэрт заасан нөхцөлөөр ХБҮЦ гаргах, Биржээр дамжуулан олон нийтэд санал болгох, худалдах ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Үндсэн андеррайтер болон Дэд андеррайтерийн хамтын ажиллагаа, эрх, үүрэг, хариуцлага, төлбөрийн нөхцөлийг зохицуулахаар хөрөнгө оруулагч нарт компанийг танилцуулах, санал болгох, санхүүжилт татаж өгөх үйлчилгээ үзүүлэхээр тусгасан байна.
9	ХБҮЦ зээлийн багцад санхүүгийн шинжилгээ хийх гэрээ 2026.02.02 "26/14"	-Си Пи Ти Эй Аудит ХХК -Очир Ундраа ОМЗ ББСБ ХХК	Гэрээт ажлын цар хүрээ буюу сонгогдсон зээлийн хувийн хэргийг харилцан тохиролцсон ажил үйлчилгээний гүйцэтгэл болон илрүүлсэн асуудлуудыг цэгцэлж тайлагнах асуудлыг зохицуулжээ.
10	Хуулийн хөндлөнгийн шинжилгээ, хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ 2026.02.03 "MJL-25359-C1"	-Очир Ундраа ОМЗ ББСБ ХХК -Өмгөөллийн Эм Жэй Эл Атторнейс ХХН	Үнэт цаас гаргагчийн ХБҮЦ-ыг бүрдүүлэх, олон нийтэд санал болгон арилжаалах ажлын хүрээнд, төслийн бүтэц, оролцогч талууд, тэдгээрийн хооронд үүсэх харилцаа, байгууллсан гэрээ, гэрээний төслүүд нь хүчин төгөлдөр, хууль ёсны үндэслэлтэй эсэх талаар хууль зүйн дүгнэлт гаргаж, үнэт цаасны холбогдох зөвшөөрөл авах асуудлаар хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх,

УЛААНБААТАР ХОТ
ТАВАН БОГД КАПИТАЛ
ТАВАН БОГД КАПИТАЛ ХХК
ШТК012 9021061377
ОЧУН АКТИВ ПЭГ
ТЗК ХХК
9026040947
7239689 Х ХК 0470

БҮРТГЭВ

			бацгцын хөрөнгөд тавигдах шаардлага зэргийг тодорхойлж, хөрөнгийн багцад шинжилгээ хийж, тайлан гаргуулахаар тохиролцож гэрээ байгуулсан байна.
11	Програм хангамж түрээсээр ашиглах гэрээ 2023.12.04 "ЛА-23/74"	-Очир Ундраа ОМЗ ББСБ ХХК -Грэйпсити Монгол ХХК	Системийг түрээсээр ашиглуулах, түүнтэй холбогдон гарах нэвтрүүлэлтийн ажил, дагалдах засвар үйлчилгээг хүргэх болон мэдээллийн нууцлал, төлбөр тооцоотой холбогдсон харилцааг гэрээгээр тохирсон байна.

4.4. Үнэт цаасны төлбөрийн хуваарь

Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны төлбөрийн үндсэн төлбөр болон хүүний төлбөрийг 44,006,588,238 төгрөгийн дүн бүхий зээлийн багцын эргэн төлөлтийн мөнгөн урсгалаар төлнө. Тус багц нь одоогоор зээлүүдийн гэрээгээр хүлээсэн үүргийг харуулах боловч хугацааны дундуур зээл урьдчилан төлөгдөх, хугацаа дууссан тохиолдолд анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шалгуур хангахгүй болсон зээлүүдийг хасаж шалгуур хангасан зээлээр солих, худалдан авах зэргээр мөнгөн урсгалын тооцоололд өөрчлөлт орох боломжтой. Хэрэв зээлийн багцын мөнгөн урсгалаас тухайн улиралд төлөх боломжгүй болсон тохиолдолд үүссэн төлөлтийн мөнгөн урсгалын эрсдэлийн сангийн эх үүсвэрээр төлбөрийг төлж барагдуулна.

ТЗК-ийн санал болгож буй үнэт цаас нь жилийн 18.5 хувийн хүүтэй, улирал тутам хүү төлөх, үндсэн төлбөрийг хагас жил тутам тэнцүү дүнгээр төлөх нөхцөлтэй бөгөөд ХБҮЦ-ны эргэн төлөгдөх төлөвлөгөөний задаргааг доор хүснэгтээр харууллаа:

ХБҮЦ төлбөрийн хуваарь, сая.төг (хүүгийн тооцоолол хийсэн жилийн суурь хоног 365/A)

	Q1	Q2	Q3	Q4	Q5	Q6	Q7	Q8
ХБҮЦ	40,000	40,000	30,000	30,000	20,000	20,000	10,000	10,000
Төлөгдөх үндсэн дүн	-	-10,000	-	10,000	-	-10,000	-	10,000
ХБҮЦ үлдэгдэл	40,000	30,000	30,000	20,000	20,000	10,000	10,000	-
Хүү	1,850	1,850	1,388	1,388	925	925	463	463
Татварын дараах	1,758	1,758	1,318	1,318	879	879	439	439
Төлөгдөх нийт дүн	1,758	11,758	1,318	11,318	879	10,879	439	10,439

Эх сурвалж: Андеррайтерийн тооцоолол

Анхаарах: Хөрөнгө оруулагчийн эргэн төлөлтөөс авах үндсэн болон хүүгийн төлбөрийг түүний эзэмшиж буй үнэт цаасны тоо ширхэг, дүнгээс тооцно.

4.5. Хөрөнгийн багц, түүнд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтүүд

"Очун Актив Нэг ТЗК" ХХК-ийн зээлийн хөрөнгөд тавигдах санхүүгийн шалгуур үзүүлэлтүүд:

1. Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэх хөрөнгийн мэдээлэл нь зээлийн хувийн хэрэг дэх үндсэн баримттай нийцэж байх;

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947
7239689 ДХТ10470

2026 .06. 11
БҮРТГЭВ

2. Зээл нь Монгол төгрөгөөр олгогдсон бөгөөд Монгол төгрөгөөр эргэн төлөгдөх зээл байх;

3. Зээлийн эргэн төлөлтийн хуваарьт зээлдэгчийн сар бүрийн төлөх дүнг (төлж дуусгах хугацаа) тусгасан байх, зээлийн хугацааны эцэст бүрэн төлөгдөж дуусахаар байх;

4. Фидуцийн гэрээний зүйл нь даатгалд даатгагдсан байх, даатгал нь хүчин төгөлдөр байх (тээврийн хэрэгслийн хувьд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд даатгагдсан байх, хүчин төгөлдөр байх), харгалзан үзэх;

5. Тасалбар болгосон өдрийн байдлаар зээл нь хэвийн төлөлттэй байх;

6. Зээлийг холбогдох журмын дагуу үүсгэсэн байх бөгөөд зээлийн стандарт нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн дотооддоо хэрэгжүүлдэг ерөнхий стандартаас дутуугүй шалгуур хангасан байх:

6.1. Тасалбар болгосон өдрийн байдлаар зээлдэгчийн өр орлогын харьцаа (ӨОХ) нь татварын өмнөх орлогын 55%-с илүүгүй байх; ӨОХ = зээлийн сарын төлбөр / (Өрхийн сарын орлого (татвараас өмнөх))

6.2. Тасалбар болгосон өдрөөрх зээл үнэлгээний харьцаа (ЗҮХ) 75%-с хэтрэхгүй байх. ЗҮХ = (Тасалбар болгох өдрийн байдлаарх үндсэн зээлийн өрийн үлдэгдэл) / (Үндсэн барьцаа хөрөнгийн үнэлгээ + Нэмэлт барьцаа хөрөнгийн үнэлгээ)

6.3. Фидуцийн зүйлийн ашиглах/ашигласан хугацааны талаар анхны үүрэг гүйцэтгүүлэгч/үнэт цаас гаргагчийн тогтоосон шалгуур хангасан байх;

6.4. Үндсэн болон хамтран зээлдэгчид нь 12 сараас багагүй хугацаанд тус тус хөдөлмөрийн гэрээний дагуу ажиллаж байгаа, эсхүл төрийн алба хааж байгаа, хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд сүүлийн дараалсан 6 сарын баталгаажсан орлогоо Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зөвшөөрөхүйц хэлбэрээр гарган өгсөн байх;

"Очун Актив Нэг ТЗК" ХХК-ийн зээлийн хөрөнгөд тавигдах хуулийн шалгуур үзүүлэлтүүд:

1. Зээлийн хөрөнгө нь хууль зүйн хувьд анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүрэн өмчлөлд байх бөгөөд анхны зээлдүүлэгчээс бусад этгээдийн хувьд аливаа байдлаар үүргээс ангид байх;

2. Зээлийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд уг зээлийг барьцаа хөрөнгөөс гаргуулан төлүүлэх боломжтой байх;

3. Зээлтэй холбоотойгоор анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон зээлдэгчийн хооронд байгуулсан фидуцийн гэрээ нь зээлдэгч (Үүрэг гүйцэтгэгч)-ийн хувьд хуульд нийцсэн, хүчин төгөлдөр, заавал биелэгдэх үүрэг үүсгэсэн зээлдэгч үүргээ биелүүлээгүй тохиолдолд анхны үүрэг гүйцэтгүүлэгч өмчлөгчийн эрхээ хэрэгжүүлж, худалдан борлуулж зээл, үүнтэй холбоотой бүх төлбөрийг гаргуулах боломжтой байх;

4. Зээл нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хувьд хууль, гэрээ эсхүл бусад байдлаар аливаа үүргээс ангид, фидуцийн гэрээний зүйлийн хамтаар гуравдагч этгээдэд шилжихэд хориглогдоогүй эсхүл хязгаарлагдаагүй байх;

ГАВАН БОГД ХАЛТИРААА
КАПИТАЛ ГРУПП ХХК
ШТК0128 5469112 9021061377

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9036040947
5239688 ХНТ10470

2026 № 2
БҮРТГЭВ
2026.06.11

5. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид байгаа мэдээллээр, тасалбар болгох өдрийн байдлаар зээлийн гэрээ нь Үүрэг гүйцэтгэгчийн хувьд үүргээ хугацаанаас өмнө дуусгавар болгох/урьдчилан төлөх нөхцөл, хэлцлээс татгалзах, харилцан суутгал хийх замаар үүргийг дуусгавар болгох, сөрөг нэхэмжлэл гаргах, эсхүл үүргээс татгалзах (илт хохиролтой хэлцлийн улмаас үүргээс татгалзах нөхцөлийг хамаарууллан) эрх үүсээгүй, эсхүл эрхээ хэрэгжүүлэх хүсэл зориг илэрхийлээгүй байх;

6. Фидуцийн гэрээ хүчин төгөлдөр болгоход Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ердийн практикт мөрддөг бүх дүрэм журмыг дагаж мөрдсөн, тухайн үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг нотолж буй бүх баримт бичиг нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшил, хадгалалт хамгаалалтад байх.

4.6. Хөрөнгийн багцын мэдээлэл

Үнэт цаас гаргагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс санал болгосон авто тээврийн хэрэгсэл болон үл хөдлөх хөрөнгө барьцаалсан 2026 оны 2-р сарын 12-ны өдрөөр тасалбар болгосон нийт 1,919 зээлийн гэрээнээс бүрдсэн 44,006,588,238 (дөчин дөрвөн тэрбум зургаан сая таван зуун наян найман мянга хоёр зуун гучин найм) төгрөгийн үнийн дүн бүхий хөрөнгийн багцыг бүрдүүлсэн.

Хөрөнгийн багцын үндсэн үзүүлэлт

Зээлийн төрөл	Дүн /төгрөгөөр/
Нийт зээлийн багцын дүн	**44,006,588,238**
Зээлийн хөрөнгийн барьцааны дүн	97,592,344,905
Зээлийн гэрээний тоо	1,919
Зээлийн дундаж үлдэгдэл	22,932,042
Барьцааны дундаж дүн	50,855,834
Жигнэсэн дундаж хүү /сар/	2.9%
Жигнэсэн дундаж хугацаа /сар/	46.1
Жигнэсэн дундаж LTV%	56.8%
Багцын зээлийн чанар	**100% хэвийн зээл**

Хөрөнгийн багцын 68.4 хувийг авто тээврийн хэрэгсэл барьцаалсан зээл бүрдүүлж байгаа ба зээлдүүлэгч нь авто тээврийн хэрэгслийн өмчлөлийг шилжүүлэн авч, зээлдэгч зээлийн төлбөрийг төлөхгүй нөхцөлд тус автомашиныг худалдан борлуулах замаар зээлийн үүргийн гүйцэтгэл хангуулах нөхцөлтэй зээл юм. Хөрөнгийн багцын үлдсэн хэсгийг буюу 31.6 хувийг үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээл бүрдүүлсэн бөгөөд анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь үл хөдлөх хөрөнгийг барьцаалж, барьцааны эрхийг холбогдох улсын бүртгэлд бүртгүүлсэн байна.

Зээлийн дүн: Авто тээврийн хэрэгсэл болон үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлийн багц нь анх олгосон дүнгээр 55.5 тэрбум төгрөгийн 1,919 ширхэг зээлээс бүрдэх ба хуваарийн дагуу эргэн төлөлт хийгдсээр 2026 оны 02 сарын 12-ны өдрийн байдлаар 44.0 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Хөрөнгийн багц дахь зээлүүдийг үлдэгдэл дүнгээр нь задалж үзвэл 10-40 сая хүртэлх үлдэгдэл бүхий зээл нь нийт зээлийн багцын 56.2 хувийг бүрдүүлж байна. Хөрөнгийн багц дахь зээлүүдийн дундаж үлдэгдэл 22.9 сая төгрөг байна.

УЛААНБААТАР ХОТ
ТАВАН ТОЛГОЙ КАПИТАЛ ХХК
ШТК0138 5466 9021061377
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040587 7239689 XHT10470

2026 - 2
БҮРТГЭВ
СЗХ
2026 оны 06 сар 11 өдөр
БҮРТГЭВ

Зээлийн дүн	Тоо	Үнийн дүн /сая төгрөг/	Багцад эзлэх хувь
10 сая хүртэлх	453	3,298.5	7.5%
10-40 сая хүртэлх	1,311	24,748.1	56.2%
40-100 сая хүртэлх	135	7,971.3	18.1%
100-200 сая хүртэлх	10	1,513.1	3.4%
200 саяас дээш	10	6,475.6	14.7%
Нийт	**1,919**	**44,006.6**	**100.0%**

Зээлийн хугацаа: Хөрөнгийн багцад багтах зээлүүдийн анх олгосон дундаж хугацаа нь 47 сар байгаа бол зээлийн үлдэгдэлд жинлэсэн дундаж хугацаа 46.1 сар байна. Түүнчлэн нийт зээлийн багцын 41.2 хувийг 48 сараас дээш хугацаатай зээлүүд эзэлж байна. Зээлийн багцад шинээр зээл худалдаж авах, солих, зээл урьдчилан төлөгдөх зэргээр багцын дундаж хугацаа ХБҮЦ-ны явцад өөрчлөгдөж болох ба эдгээр зохицуулалт нь ХБҮЦ-ны хүү болон үндсэн төлбөрийн эргэн төлөлттэй мөнгөн урсгалыг нийцүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Анх олгосон хугацаа	Тоо	Үнийн дүн /сая төгрөг/	Багцад эзлэх хувь
0-12 сар	43	2,094.3	4.8%
12-24 сар	144	5,650.9	12.8%
24-36 сар	475	8,716.3	19.8%
36-48 сар	513	9,426.2	21.4%
48 сараас дээш	744	18,118.8	41.2%
Нийт	**1,919**	**44,006.6**	**100.0%**

Зээлийн багцыг хугацаагаар харвал үнэт цаас гаргагч нь багцад хэт богино хугацаат зээл оруулахгүй байх зарчмыг баримталсан байна. Учир нь хэт богино хугацаат зээлүүд нь ХБҮЦ-ны зөвшөөрөл авах үе шат болон ХБҮЦ-ны эхэн үед хуваариас өмнө төлөгдөх магадлал өндөртэй байдаг.

Зээлдэгч: Нийт 1,919 зээл байгаагаас 33 зээлдэгчийн авсан 67 зээл буюу нийт 4.9 тэрбум төгрөгийн зээл давхардсан байна. Мөн хамгийн өндөр дүнтэй зээл буюу 2.8 тэрбум төгрөгийн нэг зээл байгаа нь багцын хувьд тооцоход эргэн төлөлт, мөнгөн урсгалд материаллаг нөлөө байхгүй, багцын 6.4%-тай тэнцэж байна.

Барьцаа хөрөнгө: Хөрөнгийн багц дахь барьцаа хөрөнгийн үнэлгээ нь 2026 оны 02 сарын 12-ны өдрөөр тасалбар болгосон зээлийн үлдэгдэл дүнгээс 2.2 дахин их байгаа бөгөөд нийт зээлийн багцын жигнэсэн дундаж LTV харьцаа 56.8% байна.

УЛААНБААТАР ХОТ
ӨЧҮҮН АКТИВ НЭГ ТӨК ХХК
9026040947

Багцын зээлүүдийн үлдэгдэл дүнг барьцаа хөрөнгийн үнэлгээтэй зээл тус бүрээр харьцуулан LTV тооцож харвал дараах байдлаар ангилагдаж байна.

Зээлийн хүү	Тоо	Үнийн дүн /сая төгрөг/	Багцад эзлэх хувь
2%-20%	102	1,542.5	3.5%
21%-40%	403	6,613.8	15.0%
41%-60%	949	18,678.8	42.5%

ТАВАН БОГД КАПИТАЛ ХХК

2026 1 2 БҮРТГЭВ

СЗХ 2026 09 11 БҮРТГЭВ

61%-80%	431	12,024.5	27.3%
81%-100%	34	5,147.0	11.7%
Нийт	**1,919**	**44,006.6**	**100.0%**

Багцад байгаа зээлүүдийн үлдсэн хугацаа: Тус зээлийн багцад байгаа 1,919 зээлүүдийн үлдсэн дундаж хугацаа 17 сар байгаа ба үлдэгдэлд жинлэсэн дундаж хугацаа нь 15 сар байна. Мөн хөрөнгийн багцын 84.2% нь 0-24 сарын хугацаатай зээлүүдээс бүрдэж байна.

Үлдсэн хугацаа	Тоо	Үнийн дүн /сая төгрөг/	Багцад эзлэх хувь
0-12 сар	607	19,140.1	43.4%
12-24 сар	853	17,934.1	40.8%
24-36 сар	442	6,702.2	15.2%
36-48 сар	16	156.1	0.4%
48 сараас дээш	1	74.1	0.2%
Нийт	**1,919**	**44,006.6**	**100.0%**

Зээлийн хүү: Хөрөнгийн багц дахь зээлүүдийг хүүгээр нь задалж үзвэл 2.5%-2.8% хүртэлх хүүтэй зээл нь нийт зээлийн багцын 51.1 хувийг бүрдүүлж байна. Хөрөнгийн багц дахь зээлүүдийн дундаж хүү 2.9% байна.

Зээлийн хүү	Тоо	Үнийн дүн /сая төгрөг/	Багцад эзлэх хувь
2.5%-2.8%	948	22,493.8	51.1%
2.9%-3.1%	402	9,732.6	22.1%
3.2%-3.4%	506	10,191.2	23.2%
3.5%-3.8%	63	1,589.0	3.6%
Нийт	**1,919**	**44,006.6**	**100.0%**

ТОП зээлдэгчдийн багцад эзлэх хувь: Үнийн дүнгээр ТОП 50 зээлийг авч үзэхэд тус зээлүүдийн үлдсэн дундаж хугацаа 10 сар байгаа ба багцын 24.1%-ийг эзэлж байна. Үүний 6.4% нь ТОП 1 зээлээс бүрджээ.

Зээл	Үлдсэн дундаж хугацаа	Үнийн дүн /сая төгрөг/	Багцад эзлэх хувь
ТОП-1	10 сар	2,800.0	6.4%
ТОП-10	7 сар	6,475.6	14.7%
ТОП-50	10 сар	10,624.0	24.1%

УЛААНБААТАР ХОТ ОЧУН АКТИВ ПЭЙ ТЗК ХХК 9026040947 7239689 ХНТ10470

УЛААНБААТАР ХОТ ТӨРИЙН БОГД КОМПАНИ ҮЦК ХХК

2026 -04- 2
БҮРТГЭВ
СЗХ
2026 он 06 сар 11 өдөр
БҮРТГЭВ

4.7. Хөндлөнгийн шинжилгээний дүгнэлт

Зээлийн багцын шинжилгээ гаргагчийн гэрээт ажлын тайлан

Зээлийн шинжилгээ гаргагч буюу "Си Пи Ти Эй Аудит" ХХК нь үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний дагуу хөрөнгийн багц дахь зээлүүд нь санхүүгийн шалгуур үзүүлэлтүүдийг хангасан эсэхэд шинжилгээ хийж үр дүнг тайлагнасан байна. Тус ажил үйлчилгээ нь тохиролцсон горимоор гүйцэтгэсэн гэрээт ажил бөгөөд "холбогдох үйлчилгээний Олон Улсын Стандарт 4400"-ын дагуу гүйцэтгэсэн байна.

Зээлийн багцын эх олонлог болох 1,919 зээлээс итгэлцлийн түвшин 95%, байж болох хамгийн их алдаа 10% (ББХИА), хүлээгдэж буй алдаа 5% гэсэн үзүүлэлтүүдийг харгалзан өндөр дүнтэй болон урт хугацаат зээлүүдээс нийт 9.3 тэрбум төгрөгийн үлдэгдэл 110 зээлийг сонгон шалгасан. Түүвэрлэлт хийхдээ ЗҮХ болон ӨОХ өндөр зээлийн дансыг аль болох ихээр хамруулах, салбар бүрээс багадаа 2 зээл хамрагдсан байх, Улаанбаатар болон орон нутагт олгогдсон зээлийн тоо нь нийт багцын бүтэцтэй ойролцоо байх гэдэг зарчмуудыг баримталсан байна.

Зээлийн багцын шинжилгээний дагуу түүвэрт сонгогдсон 110 зээл нь шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан гэж дүгнэсэн байна. Тус харилцан тохиролцсон горимоор гүйцэтгэсэн ажлын тайланг үнэт цаасны танилцуулгын хавсралтаас харна уу.

Зээлийн багцын хууль зүйн шинжилгээний тайлан

Очун Актив ХБҮЦ-ны хөрөнгийн багц дахь зээлүүд нь хуулийн шалгуур үзүүлэлтүүдийг хангасан эсэхэд "Өмгөөллийн Эм Жэй Эл Атторнейс" ХХН дүн шинжилгээ хийсэн бөгөөд зээлийн хөрөнгийн багцаас 95% итгэлцлийн түвшин, 9%-ийн хүлээгдэж буй алдааны дээд хязгаартай байхаар тооцоолж санамсаргүй түүврийн аргаар 108 зээлийг сонгосон байна.

Шинжилгээг хийхдээ зээлийн дансны зээлийн хувийн хэрэг, түүнд агуулагдсан ББСБ-ын дотоод мэдээлэл, дүгнэлт, шийдвэр, бусад нотлох баримт, үйл баримтыг хуулийн 12 шалгуур үзүүлэлт болон хуулийн хөндлөнгийн шинжилгээний хүрээнд шалгах 37 асуудал буюу асуултуудын дагуу шалгах, үнэлэх замаар гүйцэтгэсэн.

Хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээний тайлангийн дагуу түүвэрт сонгогдсон зээлийн дансдууд нь тасалбар болгох өдрийн байдлаар 108 зээл хуулийн шалгуурын бүх үзүүлэлтийг хангасан байна.

4.8. Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах тухай

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу багцыг шилжүүлэн авсан зээлийн хөрөнгө нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 9 дүгээр зүйл болон зээлийн багцад тавигдах шалгуур үзүүлэлтийг хангахгүй болсон эсхүл Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 2026/07 тоот тогтоолоор баталсан "Хөрөнгө итгэмжлэн удирдах журам"-д заасан дараах үндэслэл бий болсон тохиолдолд хөрөнгийн багцад өөрчлөлт оруулна.

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЭК ХХК
9020040947
7239689 .Ч. ХНТ10470

Хөрөнгийн багцад дараах байдлаар өөрчлөлт оруулна. Үүнд:

- Багцын хөрөнгийг солих;
- Багцын хөрөнгийг нэмэгдүүлэх;
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах.

Дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд тухайн хөрөнгийг шаардлага хангахгүй хөрөнгөд тооцож, солих замаар багцаас хасна. Үүнд:

ТАВАН БОГД КАПИТАЛ ХХК
ШТК 5469112 9021061377

2026 2
БҮРТГЭВ
СЗХ 2026 сар 11 өдөр БҮРТГЭВ

- Зээлдэгчийн хүсэлтээр тухайн зээлийн гэрээнд өөрчлөлт оруулсан нь үнэт цаас эзэмшигчдэд төлөх үнэт цаасны төлбөрийн нөхцөлд нөлөөлөхүйц байна гэж Үнэт цаас гаргагчаас үзсэн;
- Хөрөнгийн багцын шалгуур үзүүлэлттэй холбоотойгоор анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн Хөрөнгө худалдах худалдан авах гэрээнд заасан аль нэг мэдэгдэл, баталгаа зөрчигдсөн.
- Зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь 90-ээс дээш хоног хэтэрсэн;
- Зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь 30 хоногоос дээш хэтэрсэн бөгөөд цаашид зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болох нь үндэслэл бүхий бол.

Дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд хөрөнгийн багцад хөрөнгийг нэмэгдүүлнэ. Үүнд:

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15.3.1-д заасны дагуу Баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцаас орох орлого нь үнэт цаасны төлбөрийн үүргийг гүйцэтгэж хүрэхгүй болсон;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15.3.2-д заасны дагуу Үнэт цаас гаргагч нь нээлттэй гаргах нөхцөлийн дагуу нэмэлт үнэт цаас гаргахаар болсон;
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь багцын өгөөжийг нэмэгдүүлэх, төлбөрийн тасалдал үүсэхээс урьдчилсан сэргийлэх зорилгоор үнэт цаас эзэмшигчдэд төлөх үнэт цаасны төлбөрөөс бусад сул мөнгөн дүнгээр багц худалдан авах боломжтой гэж үзсэн, зээлийн багц худалдан авах талаар анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй харилцан тохиролцсон;
- Хууль болон гэрээнд заасан бусад.

Дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд Үнэт цаас гаргагч нь хөрөнгийн багцыг анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдана. Үүнд:

- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэхүү журамд заасны дагуу шаардлага хангахгүй хөрөнгийг бүхэлд нь солих хөрөнгийн жагсаалтыг ТЗК-д гарган өгөх боломжгүй, эсхүл гарган өгсөн жагсаалт нь шаардлага хангахгүй тохиолдолд солих боломжгүй хөрөнгийн багцын хэмжээгээр;
- Хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн 20 ба түүнээс дээш хувь нь 90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн тохиолдолд;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.11.5-д заасан нөхцөл байдал үүссэн бөгөөд талууд харилцан тохиролцсон тохиолдолд;

Хөрөнгийн багцыг нэмэгдүүлэхэд багцад ийнхүү нэмэгдсэн хөрөнгө нь баталгаат үнэт цаас гаргах өргөдөл, үнэт цаасны танилцуулгад тусгагдсантай адил онцлог, шинж чанартай байна.

ТЗК-ийн хөрөнгийн багц дахь хөрөнгөөс ХБҮЦ эзэмшигч этгээдээс өөр гуравдагч этгээд нэхэмжлэл гаргах эсхүл шаардах эрх хэрэгжүүлэхгүй.

4.9. Үнэт цаасыг хөрөнгө оруулагчдад олгохоос өмнө төлөгдөх төлбөр, зардлын мэдээлэл

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчийн ХЬҮЦ-ыг хөрөнгө оруулагчдад олгохоос өмнөх дараах төлбөрүүдийг Үнэт цаас гаргагчийн өмнөөс хариуцаж, төлөх бөгөөд Үнэт цаас гаргагчаас тус төлбөрүүдийг нэхэмжлэхгүй. Үүнд:

- Андеррайтерийн үйлчилгээний төлбөр,
- Зээлийн багц нь санхүүгийн шалгуур үзүүлэлт хангасан эсэх талаарх хөндлөнгийн аудитын тайлангийн үйлчилгээний төлбөр,

ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947
ТАВАН БОГД КАПИТАЛ ХХК

БҮРТГЭВ

СЗХ
БҮРТГЭВ

- Зээлийн багц нь хуулийн шалгуур үзүүлэлтэд нийцсэн эсэх талаарх хуулийн хөндлөнгийн дүн шинжилгээний тайлан гаргах үйлчилгээний төлбөр,
- Хэлцлийн зөвлөхийн үйлчилгээний төлбөр,
- Маркетингийн зардал,
- СЗХ болон УБҮЦБ-д бүртгүүлэхтэй холбоотой төлбөр, хураамжууд,
- ХБҮЦ гаргах болон арилжаалахтай холбоотой маркетингийн зардал.

4.10. Үнэт цаасны төлбөрийг төлөх төлбөрийн зохицуулалт

ТЗК нь Зээлийн эргэн төлөлтийн дансанд цугларсан мөнгийг хүлээн авах, ХБҮЦ-ны төлбөр төлөх зорилгоор Төлбөр цуглуулах дансыг банканд тусгайлан нээлгэж, төлбөр төлөх бэлэн байдлыг хангана. ХБҮЦ гаргах үйл ажиллагаа, төлбөр цуглуулах, хүлээн авах үйл ажиллагаанд зориулж оролцогч талууд дараах төрлийн данснуудыг нээлгэж, ашиглана.

Зээлийн эргэн төлөлтийн данс:

Үйлчилгээ үзүүлэгч нь Зээлийн эргэн төлөлтийг өөрийн харилцах данс буюу зээлийн эргэн төлөлтийн дансанд цуглуулах ба ТЗК-ийн хөрөнгийн багцад буй Зээлийн үндсэн болон хүүгийн төлөлтийг бусад хөрөнгөөс ангид бүртгэнэ. Зээлийн эргэн төлөлтийн дансыг зарцуулах эрхтэй этгээд нь үйлчилгээ үзүүлэгч (Очир Ундраа ОМЗ ББСБ ХХК) байна.

Гэхдээ зээлийн эргэн төлөлтийн данс болон түүний мөнгөн хөрөнгийг "Зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээ"-ээр Үнэт цаас гаргагч болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчид барьцаална. Үйлчилгээ үзүүлэгч нь зээлийн эргэн төлөлтийн дансанд тухай бүр орж ирсэн мөнгийг дараа сарын 5-ны өдрийн дотор холбогдох авлагыг суутган Төлбөр цуглуулах данс руу шилжүүлнэ.

Төлбөр цуглуулах данс:

ТЗК нь Төлбөр цуглуулах дансыг банканд тусгайлан нээлгэнэ. Төлбөр цуглуулах данс нь Үйлчилгээ үзүүлэгчийн нээсэн Зээлийн эргэн төлөлтийн дансанд цугларсан мөнгийг хүлээн авах, үнэт цаасны төлбөр төлөх зорилгоор ашиглах бөгөөд төлбөр хүлээн авах бэлэн байдлыг хангана. ТЗК болон Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь ТЗК-ийн нэрийн өмнөөс ТУЗ-өөс баталсан Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам болон төсвийн дагуу төлбөр цуглуулах данснаас зардал гаргах эрхтэй байна.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дэх данс:

ТЗК нь ХБҮЦ-ыг хадгалуулах, ХБҮЦ-ны төлбөрийн үүргийг гүйцэтгэх зорилгоор ҮЦТХТ дээр гэрээ байгуулж, данс нээлгүүлнэ. Тус үнэт цаасны данснаас зөвхөн ТЗК-ийн байгуулсан төлбөр цуглуулах данс руу зарлага гаргах боломжтой байна.

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь шаардлагатай тохиолдолд уг данс дахь мөнгөн үлдэгдлийг төлбөр цуглуулах данс руу татан, шаардлагатай зарцуулалтыг хийх эрхтэй байна.

ТЗК-ийн мөнгөн хөрөнгийг ашиглагдахгүй хугацаанд үр ашигтай байлгах үүднээс тодорхой хэмжээг СЗХ-ноос хүлээн зөвшөөрсөн дараах хөрөнгө оруулалтыг төгрөгөөр хийж болно. Үүнд:

1. Арилжааны банкны хадгаламжид байршуулах;
2. Монгол Улсын Засгийн газар, Монголбанкнаас гаргасан үнэт цаасыг худалдан авах;
3. Зохицуулагч байгууллагаас хориглоогүй аливаа хэлбэрээр хөрөнгө оруулах.

ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК

ТАВАН БОГД КАПИТАЛ ХХК

БҮРТГЭВ

СЗХ
БҮРТГЭВ

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь шаардлагатай тохиолдолд уг дансан дахь мөнгөн үлдэгдлийг төлбөр цуглуулах данс руу татан, шаардлагатай зарцуулалтыг хийх эрхтэй байна. Мөн тус үнэт цаасны данснаас зөвхөн ТЗК-ийн байгуулсан төлбөр цуглуулах данс руу зарлага гаргах боломжтой байна.

ТЗК-ийн үнэт цаасны хүүгийн болон үндсэн төлбөрийн төлөлтийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан төлбөрийн хуваарийн дагуу өөрийн брокерын үйл ажиллагаа эрхэлдэг компанид нээлгэсэн Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн дансанд шилжүүлнэ.

Хадгаламжийн данс:

Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Төлбөр цуглуулах данс дахь үндсэн болон хүүгийн төлбөрийн үлдэгдэл хэсгээр, мөнгөн хөрөнгийг ашиглагдахгүй хугацаанд үр ашигтай байлгах үүднээс тодорхой хэмжээг гэрээ болон хуулиар зөвшөөрөгдсөн хэлбэрээр байршуулж болно. Үүний тулд хадгаламжийн данс нээлгэн ашиглах бөгөөд энэ данснаас зөвхөн ТЗК-ийн байгуулсан төлбөр цуглуулах данс руу зарлага гаргах боломжтой байна. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь шаардлагатай тохиолдолд хадгаламжийг цуцлан, мөнгөн үлдэгдлийг төлбөр цуглуулах данс руу татан шаардлагатай зарцуулалтыг хийх эрхтэй байна.

ТЗК-ийн ТУЗ-өөс баталсан "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам"-д тусгасны дагуу Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь программаар зээлийн төлбөрийг хянах бөгөөд төлбөр цуглуулах данснаас доор дурдсан зарцуулалтыг хийх арга хэмжээ авч, Үнэт цаас эзэмшигчдэд төлөгдөх төлбөрийг зориулалт бусаар зарцуулахаас сэргийлнэ.

Төлбөр цуглуулах данснаас гарах гүйлгээ: Түүнчлэн ТЗК-ийн төлбөр цуглуулах данснаас зөвхөн журамд заасан дараах гүйлгээг гүйцэтгэнэ.

1. Үнэт цаас эзэмшигчдэд төлөх төлбөрийг ҮЦТХТ-ийн өөрийн данс руу шилжүүлэх
2. Үнэт цаасны хүүгийн орлогын татварыг төлөх
3. Хөрөнгийн багцад хөрөнгө солих, нэмэгдүүлэх гүйлгээ
4. Зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтад байршуулах
5. ТЗК-ийн ТУЗ-өөс баталсан төсвийн дагуу ТЗК-ийн үйл ажиллагаатай холбоотой ерөнхий удирдлагын зардал (Эдгээр зардлыг журмын 3.3 хэсэгт тусгайлан зааж өгсөн бөгөөд ТУЗ нь зардлын төсвийг баталж, Хөрөнгө итгэмжлэн удирдагчид мэдэгдэнэ. ТЗК нь журамд зааснаас бусад зардал гаргахгүй.)

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-өөс баталсан Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журамд зааснаар ХБҮЦ-ны болон ТЗК-аас гарах бусад зардлыг дараах дарааллын дагуу төлнө. Үүнд:

- ТЗК-ийн татварын төлбөр
- ХБҮЦ-ны хүүгийн орлогын татвар
- Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн төлбөр, үүргийн гүйцэтгэлийн хангуулахтай холбоотой зардал
- Үйлчилгээ үзүүлэгчийн шимтгэл, зардал
- Аудитын зэрэг бусад мэргэжлийн оролцогчид, үйлчилгээ үзүүлсэн этгээдийн үйлчилгээний төлбөр
- ТУЗ-ийн гишүүдийн цалин
- ХБҮЦ-ны хүүгийн төлбөр
- ХБҮЦ-ны үндсэн төлбөр
- Журамд заасан бусад зардал

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947
7239689 ХНТ10470

4.11. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг буцаан худалдан авах нөхцөл

Үнэт цаас гаргагч нь хөрөнгийн багцыг хуульд заасан дараах үндэслэлээр анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах тохиолдолд ХБҮЦ-ыг буцаан худалдан авна. Үүнд:

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 18.2.3-д заасны дагуу Хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн 20 ба түүнээс дээш хувь нь хугацаа хэтэрсэн хөрөнгөд тооцогдвол;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.11.5-д заасны дагуу Хөрөнгийн багцын үлдэгдлийн дүн түүний анхны үнийн 20 хувьд хүрсэн тохиолдолд анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагчтай тохиролцсон;

4.12. Үнэт цаасны төлбөр хугацаандаа төлөгдөхгүй нөхцөлд авах арга хэмжээ

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь багцын хөрөнгийг солих, багцын хөрөнгийг нэмэгдүүлэх, анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах зэргээр багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах боломжгүй тохиолдолд барьцаа хөрөнгөөр үүргийн гүйцэтгэл хангуулан ХБҮЦ-ны үндсэн болон хүүгийн төлбөр төлөх үүргийг хэрэгжүүлэх бөгөөд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбоотой Үйлчилгээ үзүүлэгчид шүүхэд нэхэмжлэл гаргахыг мэдэгдэж, хэрэгжилтэд хяналт тавина.

Хэрэв Үнэт цаас гаргагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны төлбөрийг төлөх чадваргүй болсон тохиолдолд барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэл хангуулах бөгөөд дараах алхмуудыг хэрэгжүүлнэ:

1. Барьцаалуулагч нь Зээлдэгчтэй байгуулсан Зээлийн болон Фидуцийн гэрээний дагуу фидуцийн зүйлээс зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах арга хэмжээ авах үүрэгтэй. Уг үүргийг ТЗК-тай байгуулсан Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээний хүрээнд Үйлчилгээ үзүүлэгч хэрэгжүүлнэ.

2. Хөрөнгө худалдах худалдан авах гэрээний 10-д заасан (Анхны үүрэг гүйцэтгүүлэгч буюу энэхүү гэрээний Барьцаалуулагч үүргээ гүйцэтгэхгүй байх) зөрчлийн улмаас ББСБ нь зээлийн төлбөрийг цуглуулж ТЗК-д шилжүүлэх үүргээ биелүүлж чадахгүй нөхцөл байдал үүссэн үед Барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах эрх ТЗК-д үүснэ.

3. Барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах эрх ТЗК-д шилжсэнээр тэрээр барьцааны зүйлийг өөрийн өмчлөлд үл маргах журмаар шилжүүлэн авч болно. Энэ тохиолдолд барьцааны зүйлээр үүргийн гүйцэтгэлийг хангуулах арга хэмжээг ТЗК-ийн нэрийн өмнөөс Хөрөнгө итгэмжлэн удирдагч хэрэгжүүлнэ. Барьцаалуулагч төлбөрийн чадваргүй болж, мэдэгдлийг хүлээн авах боломжгүй болсон нь түүнийг барьцааны үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

Үнэт цаас гаргагч нь Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй байгуулсан “Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ”-ний дагуу худалдан авах, 2026 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөр тасалбар болгосон нийт 44,006,588,238 төгрөгийн зээлийн багцаас өрөх мөнгөн хөрөнгөөр төлөх бөгөөд уг үнэт цаасыг гаргахтай холбоотойгоор гуравдагч этгээдээс баталгаа, батлан даалт гаргуулаагүй, мөн Очун Актив ХБҮЦ-ны тухайд эрх бүхий байгууллагаар санхүүжих чадавхын зэрэглэл тогтоолгоогүй болно.

4.13. Эрсдэлийн удирдлага

ХБҮЦ нь хэвийн төлөлттэй хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгөөр баталгаажсан бөгөөд энэ нь хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн эргэн төлөлт хугацаа

БҮРТГЭВ

СЗХ БҮРТГЭВ № 01

хэтрэхгүйгээр товлосон хугацаандаа орж ирэх, Үнэт цаасны хуваарьт төлбөрийг тогтоосон хугацаанд төлөх бололцоог бүрдүүлнэ.

ТЗК-ийн мөнгөн урсгалын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн эргэн төлөлт буюу ТЗК-д орох мөнгөн урсгал нь ХБҮЦ-ны төлбөр болох хүүгийн төлбөр болон үндсэн төлбөрийг гүйцэтгэхэд хангалттай түвшинд байна. Мөн ХБҮЦ-ны хүүгийн болон үндсэн төлбөр нь тэргүүн ээлжинд буюу Үнэт цаас гаргагчийн төлөх бусад төлбөрүүдээс хамгийн эхэнд төлөгдөхөөр зохицуулагдсан болно.

Хүснэгт 23: Үнэт цаасжуулах үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлүүд

Дотоод хүчин зүйлсээс шалтгаалсан эрсдэл		
Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцогч талуудтай холбоотой эрсдэл	▸ Оролцогч талууд гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхгүй байх ▸ Оролцогч талуудын үйл ажиллагаанд асуудал үүсэх	▸ Талуудтай байгуулах гэрээнд үүсч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хянах эрсдэлийг бууруулахтай холбоотой зохицуулалтыг тодорхой тусгах; ▸ Эрсдэлийг удирдах зорилгоор тайлан мэдээний хяналтыг тогтмол хэрэгжүүлэх; ▸ Эрсдэлийн удирдлагыг тогтмол хэрэгжүүлж, эрсдэлийн үнэлгээ арга хэмжээний талаар ТУЗ-д танилцуулж, шийдвэр гаргалтыг дэмжиж, шуурхай арга хэмжээг хэрэгжүүлэх ▸ Хөндлөнгийн аудитын хяналтыг хэрэгжүүлэх
Төлбөрийн чадварийн эрсдэл	▸ Хөрөнгийн зохисгүй удирдлага ▸ Төлбөрийн чадвар муудах, тасалдах, татан буугдах, дампуурах	▸ Зохицуулалтын хяналтын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн харьцааг ханган ажиллах, дотоод болон хөндлөнгийн хяналтыг тогтмол хэрэгжүүлэх ▸ Эрсдэлийн санг зохих журмын дагуу байгуулах
Гадаад хүчин зүйлсээс шалтгаалсан эрсдэл		
Хууль эрх зүй, зохицуулалтын эрсдэл	▸ Холбогдох хууль эрх зүйн орчин өөрчлөгдөх ▸ Зохицуулагч байгууллагын дүрэм, журамд өөрчлөлт орох	▸ ХБҮЦ гаргагч болон оролцогч талуудтай холбоотой хууль журам, зохицуулалтын орчинд өөрчлөлт орсон тохиолдолд үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн хурал хуралдаж, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд эрсдэлийн үнэлгээ, үүр нөлөөтэй холбоотой хөндлөнгийн байгууллага, хуулийн фирмийг хөлслөн ажиллуулах, зохицуулагч эрх бүхий байгууллагуудтай тогтмол мэдээлэл солилцох, шийдвэр гаргах замаар эрсдэлийг бууруулж ажиллана.

УЛААНБААТАР ХОТ ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК ХХК

ОЧУУЛАКЧИЙН ЭЭГ ТЗК ХХК 9026040947 7239689 ХНТ10470

БҮРТГЭВ

СЗХ 2020 .09. 11 БҮРТГЭВ

Зах зээлийн эрсдэл	▸ Салбарын болон санхүүгийн системийн хямрал	▸ Нэр хүндийн болон улс төрийн эрсдэлд өртөхөөс сэргийлэх, анхид байх ▸ Салбарын эрсдэлийн үнэлгээнд тогтмол шинжилгээ хийх, шийдвэр гаргалтад харгалзан үзэх
Давагдашгүй хүчин зүйлсээс шалтгаалсан эрслэл	▸ Байгалийн гамшиг, тааварлашгүй хүчин зүйлс ▸ Үймээн самуун, жагсаал цуглаан гэх мэт	▸ Давагдашгүй хүчин зүйлс бий болсон тухайгаа Үнэт цаас эзэмшигчдэд тухайн брокерын компаниар дамжуулан бичгээр мэдэгдэх, Үнэт цаас гаргагчийн болон Биржийн цахим хуудсаар мэдэгдэнэ. Тухайн мэдэгдэлд ямар байдлаар давагдашгүй хүчин зүйлс үүссэн, түүний хор уршгийг бууруулах талаар авсан, эсхүл авах гэж буй арга хэмжээ, давагдашгүй хүчин зүйлсийн улмаас үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон хугацааг тус тус тусгасан байна. ▸ Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Үнэт цаас эзэмшигчдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй байгаа нь үндсэн үүргээс чөлөөлөгдөх нөхцөл болохгүй бөгөөд үүргээ биелүүлэх хугацаа нь давагдашгүй хүчин зүйлсийн үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

Эх сурвалж: Үүсгэн байгуулагчийн мэдээлэл

Зээлийн багцыг үнэт цаасжуулж, хөрөнгө оруулалт татсан үед хөрөнгө оруулагч талд зээлийн багцаас үүдэлтэй эрсдэлүүд түлхүү тулгардаг. Эдгээр нь багцалсан зээлийн эргэн төлөлт хийгдэхгүй байх, үнэт цаасны хүү үндсэн төлбөрийн эргэн төлөлтөд хөрвөх чадварын зөрүү үүсэх, зээлдэгч зээлийг урьдчилж төлснөөр орлогын урсгал тогтворгүй болох зэрэг эрсдэлүүд байдаг. Иймд Үнэт цаас гаргагч нь тус эрсдэлийг бууруулах зорилгоор "Эрсдэл сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам"-ыг баталсан байна.

Тус журамд ТЗК-ийн ХБҮЦ гаргах, багц шилжүүлэн авах, багцын эргэн төлөлтийг хянах, үнэт цаасны төлбөрийг хөрөнгө оруулагч, үнэт цаас эзэмшигчдэд төлөхтэй холбоотой үйл ажиллагааны эрсдэлийг удирдах, түүнтэй холбогдох дотоод хяналтыг хэрэгжүүлэх, эрсдэл бууруулах, сонирхлын зөрчлийг илрүүлэх арга хэмжээ авахтай холбоотой холбогдох талуудын харилцааг зохицуулсан байна. Андеррайтерийн зүгээс энэхүү үнэт цаасны хүрээнд дараах эрсдэлүүд учирч болзошгүй гэж үзэж хэрхэн удирдах арга замын тодорхойлов. Үүнд:

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9028040847

Эрсдэлийн тодорхойлолт	Эрсдэлийн удирдлага
Зээлийн эрсдэл	
▸ Зээлийн багцын эрсдэлд зээлдэгч зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ зохих	▸ ТЗК нь Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах, дотоод хяналтын журамд зээлтэй холбоотой эрсдэлийг тодорхойлж, зээлтэй холбоотой эрсдэлийг удирдах аргыг тодорхойлсон

ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК ХХК

2026 № 1 2
БҮРТГЭВ
СЭХ
2026.06.11

ёсоор биелүүлээгүйн улмаас үүсэх эрсдэлийг ойлгоно. Үүнд зээлдэгч зээлийн хугацаа хэтрүүлэх, төлбөрийн чадваргүй болох, зээлдэгч эрх зүйн чадамжгүй болох, нас барах, сураггүй алга болсон нь шүүхийн шийдвэрээр тогтоогдох, зээлийн төлбөр гүйцэтгэх этгээд тодорхойгүй болох зэргийг ойлгоно.

- Хугацаанаас өмнө эргэн төлөгдөх эрсдэлд зээлдэгч зээлээ хугацаанаас нь өмнө эргэн төлснөөр хүлээгдэж байсан хүүгийн орлого буурах, хаагдах, хуваарь өөрчлөгдөх, тооцоолоогүй сул эх үүсвэр үүсэх, тооцоолоогүй эх үүсвэрт менежмент хийх шаардлага үүсэх зэргийг ойлгоно.

байна. Шаардлага хангаагүй зээлийг зээлийн багцаас хасах, шаардлага хангасан шинэ зээлээр солих, анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах зэрэг арга хэмжээ авна.

- Хугацаа хэтэрсэн зээл дээр үйлчилгээ үзүүлэгч тал, хөрөнгө итгэмжлэн удирдагч хяналт тавьж ажиллах ба үүнтэй холбоотой зохицуулалтыг Үйлчилгээ үзүүлэх гэрээнд тусгана.
- ТЗК нь зээл хугацаагаас өмнө эргэн төлөгдөх эрсдэл үүссэн тохиолдолд Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг болон ТЗК-ийн Хөрөнгө итгэмжлэн удирдах журамд заасны дагуу хөрөнгийн багцад хөрөнгө нэмэх байдлаар хариу үйлдэл үзүүлэх боломжтой.
- Зээлийн гэрээнд өөрчлөлт орсон тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагч болон Хөрөнгө итгэмжлэн удирдагчид мэдэгдэх бөгөөд тус өөрчлөлт нь шалгуур үзүүлэлтэд нийцэхгүй тохиолдолд зээлүүдийг зээлийн багцаас хасаж, шалгуур хангах зээлээр солих эсхүл буцаан худалдах нөхцөлтэй юм.

Хөрөнгийн багцтай холбоотой эрсдэл

- Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн эргэн төлөлтийн график нь үнэт цаасны төлбөрийн графикаас зөрүүтэй байх эрсдэл
- Хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгүүлэл өөрчлөлт оруулсантай холбоотой Хөрөнгийн багц чанаргүйдэх эрсдэл
- Тааварлаагүй хүчин зүйл, байгалийн гамшиг зэргээс үүдэн хөрөнгийн багцад байгаа зээлийн фидуциар барьцаалсан хөрөнгөд хохирол, эвдрэл учрах зэрэг эрсдэлийг ойлгоно.

- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үнэт цаас гаргагчтай байгуулсан “Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ”-нд тусгасны дагуу зээлийн багцын эргэн төлөлт болон үнэт цаасны эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллана. Шаардлагатай тохиолдолд Хөрөнгийн багц дахь зээлийг нэмэгдүүлэх, шаардлага хангаагүй зээлүүдийг солих, анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах арга хэмжээ авна.
- Зээлийн багцад хугацаа хэтрэлт үүссэн тохиолдолд багцыг солих, буцаах арга хэмжээнүүд авснаар зээлийн багцад хугацаа хэтэрсэн зээл үүсэх, ангилах, түүнчлэн эрсдэлийн сан үүсгэх шаардлага үүсэхгүй.
- Энэхүү ХБҮЦ-ны хувьд 44.0 тэрбум төгрөгийн дүн бүхий 1,919 зээлийг багцалж байгаа ба зээлийн багцад шинжилгээ гаргагч нь үүнээс 110 зээлийг түүвэрлэн шинжилгээ хийсэн байна. Компанийн ирүүлсэн шалгуур шалгуур үзүүлэлтүүдийг хангасан эсэхэд тохиролцсон горимуудыг гүйцэтгэхэд тус зээлүүд нь шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан байна.

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой эрсдэл

- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь анх зээлийн багцыг бүрдүүлэхдээ ТЗК-ийн Хөрөнгө итгэмжлэн удирдах
- Хөрөнгө итгэмжлэн удирдах журмын 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэгт заасан зээл шилжүүлсэн эрсдэл үүссэн тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс хөрөнгийн багцыг солихыг

ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК ХХК
ОЧУН АКТИВ НЭГ ТӨВ ХХК

БҮРТГЭВ

СЗХ
БҮРТГЭВ

журмын 2 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэгт заасан зээл буюу шаардлага хангаагүй зээл шилжүүлэх

- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь шаардлага хангаагүй зээлийг эргүүлэн авч, хөрөнгийн багцыг сольж, эсвэл нэмэх хангалттай зээлийн багцгүй байх, санал болгож буй зээлийн багц нь шаардлага хангахгүй байх
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь төлбөрийн чадваргүй болсон, дампуурсан, татан буугдах зэрэг эрсдэлийг ойлгоно.

шаардаж ТЗК-ийн Хөрөнгө итгэмжлэн удирдах журамд заасны дагуу эрсдэлийг удирдана. 2026 оны 1-р улирлын тайлангаар АҮГ буюу Очир Ундраа ОМЗ ББСБ-ийн нийт зээлийн багц 123.1 тэрбум төгрөг байна. Үнэт цаасжуулсан зээлийн багцыг хасаж тооцвол дунджаар 79.1 тэрбум төгрөгийн үнэт цаасжуулаагүй багц үлдэх ба үлдэгдэл багц нь үнэт цаасжуулсан хөрөнгийн багцаас 1.8 дахин их байгаа нь солих, сонгох зэрэг арга хэмжээг авахад хангалттай хүрэлцэхүйц нөөцтэй байгааг илэрхийлж байна.

- Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь сайн дурын үндсэн дээр эсхүл хуульд заасан үндэслэлээр татан буугдах тохиолдолд түүний ТЗК-д шилжүүлсэн Багцын хөрөнгийн үлдэгдлийг зохих журмын дагуу сонгогдсон өөр Үйлчилгээ үзүүлэгчид шилжүүлэх арга хэмжээ авна.
- ТЗК нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй холбоотой эрсдэлийг бууруулах зорилгоор “Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ”, “Фидуцийн барьцааны гэрээ”-нд холбогдох журам, гэрээнд тус бүр эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, мэдээлэл солилцох зохицуулалтыг тусгасан.
- ТЗК-ийн хөрөнгийн багц дахь хөрөнгөөс ХБҮЦ эзэмшигч этгээдээс өөр гуравдагч этгээд нэхэмжлэл гаргах эсхүл шаардах эрх хэрэгжүүлэхгүй. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс зээлдэгчид төлөх аливаа өр төлбөр, бусад нэмэлт үүрэг байхгүй, хөрөнгийн багцад байгаа зээлтэй холбоотой аливаа шүүхийн маргаан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгээгүй болохыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч баталгаа гаргасан ба ХБҮЦ-ны туршид уг баталгааг хангаж ажиллана.

Үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой эрсдэл

- Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийг бүрэн гүйцэд, гэрээгээр хүлээсэн хугацааны дагуу цуглуулан ТЗК-д шилжүүлэхгүй байх
- Үйлчилгээ үзүүлэгчийн тусгай зөвшөөрлийг хөрөөнөөс цуцлах, үйл ажиллагааг гүйцэтгэх чадамжгүй болох нь тогтоогдох
- Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийн чадваргүй, татан буугдсан, дампуурах эрсдэлийг ойлгоно.
- Үйлчилгээ үзүүлэгч нь зээлийн эргэн төлөлтийг өөрийн нэр дээрх харилцах данс буюу зээлийн эргэн төлөлтийн дансанд цуглуулах ба ТЗК-ийн хөрөнгийн багцад буй зээлүүдийн үндсэн болон хүүгийн төлөлтийг цуглуулан өөрийн бусад хөрөнгөөс ангид байлгана. ТЗК болон Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Үйлчилгээ үзүүлэгчтэй зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээ байгуулна. ХИУ нь Төлбөр цуглуулах дансны гүйлгээний хуулга авах, хянах эрхтэй.
- Үйлчилгээ үзүүлэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас ТЗК болон үнэт цаас эзэмшигчдэд хохирол учирсан бол уг хохирлыг үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн хөрөнгөөр төлж барагдуулна.
- Үйлчилгээ үзүүлэгч нь зээлийг төлүүлэхдээ ТЗК-тай байгуулсан гэрээний дагуу үйлчилгээ үзүүлэгч байгууллагын дотооддоо мөрдөгдөж буй Зээлийн

ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947
7239689 Л. ХНТ10470

2026 01 12 БҮРТГЭВ
СЗХ 2026 01 11 БҮРТГЭВ

үйл ажиллагааны журам, Зээл төлүүлэхтэй холбогдсон бусад журмыг дагаж мөрдөнө.

- Үйлчилгээ үзүүлэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлэхгүй, эсхүл Үйлчилгээ үзүүлэгч нь төлбөрийн чадваргүй болсон, татан буугдах, дампуурах эрсдэл үүссэн, төрийн зохицуулах байгууллагаас тусгай зөвшөөрлийг цуцалсан тохиолдолд ТЗК нь тусгаарласан зээлийн багцтай холбоотой авлага цуглуулах, төлбөр гүйцэтгэх үйл ажиллагааг өөр хэвийн үйл ажиллагаатай үйлчилгээ үзүүлэгчид шилжүүлэх, үйлчилгээ үзүүлэгчийг солих арга хэмжээ авна.
- ТЗК нь үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой эрсдэлийг бууруулах, үүссэн эрсдэлийг шийдвэрлэх зорилгоор холбогдох журам, гэрээнд эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, мэдээлэл солилцох зохицуулалтуудыг тусгасан байна.

Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай холбоотой эрсдэл

- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь хөрөнгийг гэрээнд зааснаас гадуур, Үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчид хохиролтойгоор зүй бусаар удирдах, ашиглах, журамд тусгаагүй хөрөнгөд байршуулах
- Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тусгай зөвшөөрлийг СЗХ-с цуцлах, үйл ажиллагаа доголдох
- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь татан буугдах, дампуурах зэрэг эрсдэлийг энд ойлгоно.

- Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь багцын удирдлагатай холбоотой тайлан мэдээллийг үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээний дагуу үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, холбогдох эрх бүхий байгууллагад тогтмол хүргэх бөгөөд хууль болон гэрээнд зааснаас гадуур, зүй бусаар удирдаж, ашигласан тохиолдолд ТЗК-ийн ТУЗ нь хөрөнгө итгэмжлэн удирдагчийг нэн даруй солих шийдвэр гаргах, эсхүл үйл ажиллагааг залруулах, хохирлыг барагдуулах тодорхой хугацаа өгөх эрхтэй. Мөн зүй бус хөрөнгийн удирдлагатай холбоотой аливаа хохирол учирсан тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь өөрийн хөрөнгөөр бүрэн төлж барагдуулах талаар гэрээнд тодорхой тусгаж баталгаажуулсан байна.
- Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тусгай зөвшөөрлийг төрийн зохицуулах байгууллагаас цуцлах, хөрөнгө итгэмжлэн удирдагч нь төлбөрийн чадваргүй болох, татан буугдах, дампуурах нөхцөл үүссэн тохиолдолд шаардлага хангах хөрөнгө итгэмжлэн удирдагчийг яаралтай шинээр сонгон ажиллуулна.
- ТЗК нь Хөрөнгө итгэмжлэн удирдагчтай холбоотой эрсдэлийг бууруулах, үүссэн эрсдэлийг шийдвэрлэх зорилгоор холбогдох журам, гэрээнд эрсдэл бууруулах, мэдээллийг цаг тухай бүр хүргэх, хянах, мэдээлэл солилцох зохицуулалтуудыг тусгасан байна.

Гадаад хүчин зүйлстэй холбоотой эрсдэл

- ХБҮЦ, ТЗК, оролцогч талуудад тавигдах шаардлагатай холбоотой хууль журам,
- ТЗК-ийн ТУЗ-ийн хурал хуралдаж, шаардлагатай гэж үзсэн тохиолдолд эрсдэлийн үнэлгээ, үр нөлөөтэй холбоотой хөндлөнгийн байгууллага

ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
ТАВАН БОГД КАПИТАЛ ТЗК ХХК

2026 06 12
БҮРТГЭВ
СЗХ
2026 .06.11
БҮРТГЭВ

зохицуулалт өөрчлөгдөх эрсдэлийг ойлгоно.

- Монгол улсын макро эдийн засгийн нөхцөл байдлаас үүдэн зээлдэгчдийн зээл авах эрэлт өөрчлөгдөх
- Хүүгийн түвшин өөрчлөгдсөнөөс үүдэн зээлдэгчдийн зээлийн ачаалал, дарамт нэмэгдэх, эсвэл зээлийг урьдчилж хаах хүсэл нэмэгдэх

хуулийн фирмийг хөлслөн ажиллуулах, зохицуулагч эрх бүхий байгууллагуудтай тогтмол мэдээлэл солилцох, шийдвэр гаргах замаар эрсдэлийг бууруулж ажиллана.

- Үнэт цаас гаргагчийн үнэт цаасны хүү болон зээлийн хөрөнгийн багцын хүүгийн хэмжээ тогтмол байх ба үнэт цаасны танилцуулга бэлтгэгдэх үед арилжаа банкнуудын хадгаламжийн хүүтэй харьцуулахад өндөр байгаа бөгөөд бусад нээлттэй өрийн хэрэгслийн хүүгийн хэмжээтэй өрсөлдөхүйц хэмжээнд байна. Хөрөнгө оруулагчдын хувьд хүүгийн төлбөрийг улирал бүр, үндсэн төлбөрийг хагас жил тутамд тэнцүү дүнгээр хүлээн авах ба эзэмших хугацааны туршид хүлээн авсан хүүгийн орлогыг дахин хөрөнгө оруулалт хийж хүүгийн түвшний эрсдэлийг бууруулах боломжтой байна.


Эргэн төлөлтийг сайжруулах

ТЗК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэгт заасны дагуу эргэн төлөлтийг сайжруулах дараах арга хэмжээнүүдийг авахаар тусгасан. Үнэт цаасны эргэн төлөлтийг сайжруулах бусад харилцааг гэрээ болон журмаар нарийвчлан зохицуулна.

- Багцын хөрөнгийг сайжруулах, солих.
- Багцын хөрөнгийг нэмэгдүүлэх.
- Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан худалдах.
- Багцын хөрөнгийн дүн болон бэлэн мөнгөний үлдэгдлийг ХБҮЦ-ны төлбөрийн төлөгдөөгүй дүнгээс багагүй байлгах.
- Хөрөнгийн багц дахь зээлийн төлбөрүүдийг Үйлчилгээ үзүүлэгчийн бусад хөрөнгөөс тусад нь ангид байлгах.
- Зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээг Үйлчилгээ үзүүлэгч, ТЗК, Хөрөнгө итгэмжлэн удирдагч нар байгуулах.
- ТЗК-ийн төлбөр гүйцэтгэх дансанд зарлагын хязгаарлалтууд хийгдэх ба Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, удирдлага, дотоод хяналтын журмын 3.3.6 дугаар зүйлийн 3.3.6.1 дэх хэсэгт заасны дагуу зохион байгуулах.
- ТЗК-ийн эргэн төлөлтийг сайжруулах арга хэмжээг ТЗК татан буугдах хүртэл хэрэгжүүлэх.
- ТЗК нь татан буугдах үед зээл, зээлийн эрсдэлийн сан нь Анхны үүрэг гүйцэтгэгчид шилжинэ.

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947
7239689 .Ъ. ХНТ10470

УЛААНБААТАР ХОТ
ТАВАН БОГД КАПИТАЛ ҮНЭТ ХХК


ҮНЭТ ЦААС
ГАРГАГЧИЙН
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН
ОРЧИН

2026 -06- 12
БҮРТГЭВ

СЗХ
2026 .06. 11. өдөр
БҮРТГЭВ

5. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

5.1. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн орчин

Монгол Улсын Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг гаргах, арилжихтай холбогдсон нийтлэг харилцааг энэ хуулиар, нарийвчилсан харилцааг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль тогтоомжийн дагуу зохицуулна" гэж заасны дагуу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, түүнд хяналт тавих, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийг 2010 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр баталж, 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр тогтоосон байдаг.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай, Компанийн тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

Үнэт цаас гаргагч нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотой үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахаас гадна дараах хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна. Үүнд:

- Иргэний хууль
- Компанийн тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль;
- Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хууль;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль;
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль;
- Компанийн засаглалын кодекс;
- СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам;
- СЗХ-ны Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийж бүртгэх тухай журам;
- СЗХ-ны Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам;
- СЗХ-ны Зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагчаас зар сурталчилгаа явуулах журам;
- СЗХ-ны Үнэт цаасны зах зээлд дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам;
- УБҮЦБ-ийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны бүртгэлийн журам;
- Холбогдох эрх бүхий байгууллагын тогтоосон бусад дүрэм, журам болон бусад хууль тогтоомж.

Зохицуулагч байгууллагаас гаргасан дүрэм журмууд

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам
- Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам
- Үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээллийн жагсаалт, түүнийг мэдээлэх журам
- Үнэт цаасанд нэгдсэн дугаар олгох журам

ТАВАН БОГД КАПИТАЛ ҮНЭТ ЦААС

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТӨК ХХК

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу Хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргагч нь тусгай зориулалтын компани байх ба тус хуульд тусгай зориулалтын компанийн үүсгэн байгуулагчид тавигдах

шаардлага, дүрэмд тусгагдах асуудал, хориглох болон зөвшөөрөх үйл ажиллагаа, тэдгээрийг хэрэгжүүлэх субъектийн талаар тусгайлан зохицуулсан байна. Тухайлбал, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуульд заасны дагуу тусгай зориулалтын компанид хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажилтан авч ажиллуулахыг хориглодог бөгөөд хувьцаа эзэмшигчид нь Хорооны зөвшөөрөлгүйгээр үнэт цаас гаргагчийн хувьцааг бусдад худалдах, шилжүүлэхгүй байх, Хорооны зөвшөөрөлгүйгээр компанийн дүрэмд өөрчлөлт оруулахгүй байх зэрэг зохицуулалтуудыг тусгасан байдаг. Түүнчлэн тус хуулиар хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч болон оролцогч этгээдүүдэд тавигдах шаардлага, баталгаат болон барьцаат үнэт цаас гаргах оролцогчдын хоорондын эрх зүйн харилцаа, эрх үүрэг, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах асуудлуудыг тусгайлан зохицуулсан байдаг.

Мөн Хорооны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-аар хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэгчид тавигдах шаардлага, ТЗК-н удирдлага, зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн эрх хэмжээ, ХБҮЦ гаргах тусгай зөвшөөрөл олгох, хүсэлтийг хянах, шийдвэрлэх, барьцаат болон баталгаат үнэт цаас гаргахад тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичиг, үнэт цаасны танилцуулгад тусгах мэдээлэл, түүний агуулга, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагч, хөрөнгийн багцын бүртгэлийг хянагч, аудит, хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдэд тавигдах шаардлага, бүрэн эрх, үүргийг тодорхойлж, ТЗК-н мэдээлэл хүргүүлэх тухай харилцааг зохицуулж байна. Журмын 3 дугаар зүйлд үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай холбоотойгоор түүний үүсгэн байгуулагчид тавигдах шаардлага, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд тавигдах шаардлага, төлөөлөн удирдах зөвлөлийн эрх хэмжээ, зарчим, үйл ажиллагааны тайлан мэдээ хүргүүлэх болон хөндлөнгийн аудит хийлгэх тухай нарийвчлан зохицуулсан байдаг.

УБҮЦБ-ийн "Бүртгэлийн журам"-аар ХБҮЦ-ийн биржид бүртгэх бэлтгэл ажил, ХБҮЦ бүртгүүлэх хүсэлт гаргах, ХБҮЦ-ны танилцуулгын агуулга, хэлбэр, ХБҮЦ-ийн бүртгэлийн шалгуур, шаардлага, ХБҮЦ гаргагч болон үнэт цаасанд тавигдах шалгуур, шаардлага, шалгуур, шаардлагаас чөлөөлөгдөх, хөнгөлөх үндэслэл, ХБҮЦ бүртгэх, бүртгэхээс татгалзах болон ХБҮЦ гаргагчийн бүртгэлтэй байх хугацаанд биелүүлэх үүргийг тодорхойлж, түүнтэй холбогдох харилцааг зохицуулж байна.

Үнэт цаас гаргагчийн татвар төлөх үүрэг болон хөрөнгө оруулагчийн хүүгийн орлогоос албан татвар суутган төлөхтэй холбоотой харилцааг Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль болон эрх бүхий этгээдээс баталсан холбогдох журам, зааврын дагуу зохицуулж байна.

5.2. Үнэт цаастай холбоотой журмууд

Монгол улсын хэмжээнд үнэт цаасны зах зээлийн үйл ажиллагаа, зах зээлд оролцогчдод хяналт тавих, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахтай холбоотой бүхий л харилцаа Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар зохицуулагддаг.

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомж нь Монгол улсын үндсэн хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрдэг болно. Үнэт цаас гаргах үйл ажиллагаа нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар зохицуулагдахаас гадна бусад зохицуулагч байгууллагууд буюу Санхүүгийн Зохицуулах Хороо, УБҮЦБ, болон Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төвийн холбогдох дүрэм, журмаар зохицуулагддаг.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулиар үнэт цаасыг гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор хөрөнгийн багцад тавигдах шаардлага, хөрөнгөөр

баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаанд зөвшөөрөл олгох, зохицуулах төрийн эрх бүхий байгууллага болон үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа явуулагч байгууллагын эрх хэмжээ, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэхтэй холбоотой үйл ажиллагааг тусгайлан зохицуулсан байдаг.

Хорооны "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-д үнэт цаас гаргах үйл ажиллагаатай холбоотойгоор хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэх, түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулдаг бөгөөд Хорооны "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 1.5 дахь хэсэгт "Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, хадгаламжийн бичиг гаргах болон бусад үүсмэл санхүүгийн хэрэгслийг бүртгэх харилцаа нь тус тусын үйл ажиллагааг тусгайлан зохицуулсан Хорооны журмаар зохицуулагдана." Гэж заасны дагуу ийнхүү тусгайлсан журмаар зохицуулагдаж байна.

Бусад баримт бичгүүд

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай холбоотой журмууд:

- Компанийн дүрэм
- ТУЗ-ийн үйл ажиллагааны журам
- Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам
- Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам
- Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам
- Хөрөнгө итгэмжлэн удирдах журам
- Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх тухай журам
- Тусгай зориулалтын компанийг татан буулгах журам

Үнэт цаасжуулах хэлцлийн оролцогч талуудтай байгуулсан гэрээнүүд:

- Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ
- Фидуцийн болон шаардах эрх барьцаалах гэрээ
- Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ
- Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ
- Зээлийн эргэн төлөлтийн барьцааны гэрээ

Үнэт цаасжуулах үйл ажиллагаанд оролцогчидтой байгуулсан гэрээнүүд:

- Андеррайтерийн үйлчилгээний гэрээ
- Харилцан тохиролцсон ажил үйлчилгээний гэрээ /Зээлийн шинжилгээ/
- Хуулийн хөндлөнгийн шинжээч, зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх гэрээ

Бусад гэрээ:

- Аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ
- Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ

5.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон хөрөнгийн багцтай холбоотой хууль эрх зүйн орчин

Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн үйл ажиллагаа болон үнэт цаас гаргах үйл ажиллагаанд гүйцэтгэх үүргийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулиар зохицуулж байна. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болох банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа нь Хорооны журам болон бусад холбогдох хууль, дүрэм журмаар зохицуулагддаг.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааг зохицуулахтай холдогдох дараах хууль, дүрэм журмууд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Үүнд:

2026 -Д- 2
БҮРТГЭВ
СЗХ
2026 оны 11 дэх
БҮРТГЭВ

- Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль
- Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль
- Иргэний хууль
- Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль
- Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль
- Улсын бүртгэлийн ерөнхий хууль
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль
- Зээлийн мэдээллийн тухай хууль
- Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам
- Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам
- Мэдээлэх үүрэгтэй этгээдээс цахимаар мэдээлэл илрүүлэх журам
- Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журам
- Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам
- Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам
- Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх журам
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журам
- Үл хөдлөх хөрөнгө барьцаалуулагчид мэдээлэл өгөх журам
- Банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагааг зохицуулах, түүнд хяналт тавих журам
- Гүйлгээнээс илэрсэн хуурамч мөнгөн тэмдэгтийг хүргүүлэх, бүртгэх, хадгалах, устгах журам
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам
- Бусад

УЛААНБААТАР ХОТ
ТАВАН БОГД КАПИТАЛ ТӨК ХХК
УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК

TAVAN BOGD CAPITAL

OCHUN FINANCE

2026 2
БУРТГЭВ

СЭХ
БУРТГЭВ

ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЭК ХХК
6026040947
7239689 С. ХНТ10470


2026 -06- 12
СЗХ
2026 .06. 11 өдөр
БҮРТГЭВ

6. ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА

6.1. Үнэт цаасны анхдагч зах зээлийн захиалга хүлээн авах заавар

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 12.1 болон 12.2-т зөвхөн СЗХ-ны нийтэд санал болгохыг хүлээн зөвшөөрсөн, мөн биржийн бүртгэлд бүртгэгдсэн үнэт цаасыг анхдагч зах зээлээр арилжихыг заасан байдаг.

Зураг 8: ХБҮЦ-ыг анхдагч зах зээлд санал болгох үйл явц



Анхдагч зах зээлийн арилжааны захиалга хүлээн авах: Үнэт цаас гаргагч нь анхдагч зах зээлийн захиалга авч эхлэхээс ажлын 3-с доошгүй хоногийн өмнө анхдагч зах зээлийн арилжааг эхлүүлэх мэдэгдлийг СЗХ-нд хүргүүлснээр анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг хүлээн авах болно.

Үнэт цаас худалдан авах сонирхолтой хөрөнгө оруулагч нь анхдагч зах зээлийн арилжаанд дараах зааврын дагуу оролцоно.

- Хөрөнгө оруулагч нь өөрийн Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн товд бүртгэлтэй дансанд мөнгө байршуулна.
- Хөрөнгө оруулагч нь гүйлгээний үнийн дүнгийн тодорхой хувиар тооцсон үйлчилгээний хөлс буюу шимтгэлийг ҮЦК-д төлөх ба үг шимтгэлд зохицуулагч байгууллагуудын болон үнэт цаасны компаниудын шимтгэлийн нийт дүн багтсан байна.
- Хөрөнгө оруулагч Монгол улсад байрладаг хувь хүн бол ХХОАТ-ын тухай хуулийн 16.1.4-т заасан орлого (хүүгийн орлого)-ын нийт дүнгээс тус хуулийн 21.5-т заасан 5 хувийн хэмжээгээр татвар суутгана.
- Хөрөнгө оруулагч Монгол улсад байрладаг хуулийн этгээд буюу ААН бол ААНОАТ-ын тухай хуулийн 18.6.3 т заасан (хүүгийн орлого) ын нийт дүнгээс тус хуулийн 20.2.5-т заасан 5 хувийн хэмжээгээр татвар суутгана.
- Гадаад улсын иргэн, хуулийн этгээд нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу татвар төлөх үүрэг хүлээх бөгөөд тухайн харьяаллын улстай давхар татварын гэрээ байгуулсан эсэх болон гэрээний нөхцөлийг судлан үзсэний үндсэн дээр хөрөнгө оруулахыг зөвлөж байна.
- Үнэт цаасыг анх удаа нийтэд санал болгох ажиллагаа амжилттай болсон тохиолдолд холбогдох журмын дагуу СЗХ-ны зөвшөөрлөөр үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлнэ. Ингэснээр үнэт цаасыг анхдагч зах

УЛААНБААТАР ХОТ
ТАВАН БОГД КАПИТАЛ ХХК
ШТК0128 5469 9021061377
УЛААНБААТАР ХОТ
ТЗК ХХК
9026040947
7239689 ХНТ10470

2026 -06- 12
БҮРТГЭВ

СЗХ
2026 .06. 11 өдөр
БҮРТГЭВ

зээлээс худалдан авсан хөрөнгө оруулагчид үнэт цаасыг бусдад худалдаалах эрхтэй болно.

- Үнэт цаасны эргэн төлөлтийн эх үүсвэр нь ТЗК-д шилжсэн 44.0 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй автомашин болон үл хөдлөх хөрөнгийн фидуци бүхий зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийн эргэн төлөлтөөс бүрдэнэ.

ХБҮЦ-ыг ангилалтай гаргахгүй бөгөөд тус баталгаат үнэт цаасыг хөтөлбөрийн буюу үе шаттайгаар санал болгон худалдахгүй.

6.2. Үнэт цаас худалдан авах, захиалга өгөх заавар

Хөрөнгө оруулагч нь Улаанбаатар үнэт цаасны биржид бүртгэлтэй үнэт цаасны компанид үнэт цаасны данс нээлгэж, өөрийн үнэт цаасны дансанд дараах зааврын дагуу үнэт цаас худалдан авах мөнгөн хөрөнгөө байршуулах ба үнэт цаасны компанид үнэт цаас худалдан авах захиалга өгнө. Үүнд:

1. Данс нээх: ҮЦК-д үнэт цаасны данс нээлгэнэ.
2. Дансаа цэнэглэх: ҮЦТХТ дээрх өөрийн нэр дээрх дансанд ХБҮЦ худалдан авах мөнгө байршуулна.
3. Захиалга өгөх: Өөрийн үйлчлүүдэг ҮЦК-д ХБҮЦ худалдан авах захиалга өгнө.
4. Үнэт цаасаа хүлээн авах: Анхдагч зах зээлийн арилжаа амжилттай хаагдаж, эрх бүхий байгууллага зөвшөөрснөөр хөрөнгө оруулагчийн нэр дээр ХБҮЦ шилжинэ.

ХБҮЦ худалдан авах мөнгө байршуулах заавар

Хүлээн авагчийн банк	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
Хүлээн авагчийн нэр	Нэр
Дансны дугаар	**** **** **** 12 орон бүхий үнэт цаасны дансны дугаар (Үйлчлүүлдэг ҮЦК-с авах)
Үнийн дүн	ХБҮЦ үнэ + Шимтгэл
Гүйлгээний утга	“Очун Актив Нэг ТЗК” ХХК-ийн ХБҮЦ-ны мөнгө, [Овог, нэр, регистрийн дугаар]

6.3. Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

Андеррайтер нь ХБҮЦ-ыг анхдагч зах зээлд санал болгож арилжаалсан тайланг захиалга авч дууссанаас хойш ажлын 3 өдрийн дотор арилжаа эрхлэх байгууллагын дүгнэлтийн хамт СЗХ-нд хүргүүлнэ. СЗХ нь уг тайланг хүлээн авч аливаа зөрчил гараагүй, амжилттай болсон гэж үзвэл хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрөл олгоно.

Тус зөвшөөрлийн дагуу үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагад өмчлөх эрхийн бүртгэл хийж, арилжаа эрхлэх байгууллага нь хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлнэ. ХБҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс үнэт цаасны хүү тооцогдож эхэлнэ.

Хоёрдогч зах зээл дээр үнэт цаас эзэмшигч нь бусдад чөлөөтэй худалдах, бусдаас худалдан авах эрхтэй байна.

6.4. Албан татварын тухай

Хөрөнгө оруулагч нь хувь хүн бол Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 16.1.4-т заасан хүүгийн орлогын нийт дүнгээс, 17.1.3-т заасан хувьцаа, үнэт цаас борлуулсны орлогоос худалдан авсан үнэ болон худалдан авахад төлсөн баримтаар

нотлогдох бусад зардлыг хассан дүнгээс тус хуулийн 21.5-д заасан 5.0 хувийн татвар төлнө.

Хөрөнгө оруулагч нь хуулийн этгээд бол Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.6.3-т заасан хүүгийн орлогын нийт дүнгээс, 18.3-т заасан хувьцаа, үнэт цаас борлуулсан, шилжүүлсэн үнээс худалдан авсан үнэ болон худалдан авахад төлсөн баримтаар нотлогдож байгаа шимтгэлийн дүнг хасаж, энэхүү дүнгээс тус хуулийн 20.2.5-д заасан 5.0 хувийн татвар төлнө.

6.5. Үнэт цаас эзэмшигчийн эрх


Үнэт цаас эзэмшигч нь дараах эрх, үүрэгтэй байна:

- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг УБҮЦБ-ийн арилжааны журмын дагуу худалдан авснаар үнэт цаасыг эзэмшилдээ шилжүүлэн авах, түүнийг шаардах эрхтэй;
- Эзэмшиж буй үнэт цаасыг чөлөөтэй арилжих, захиран зарцуулах;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хүү болон үндсэн төлбөрийг хуваарийн дагуу хүлээн авах, төлбөрийг хуваарийн дагуу төлөхийг үнэт цаас гаргагчаас шаардах;
- Үнэт цаас эзэмших эрхээ чөлөөтэй арилжаалах, захиран зарцуулах;
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас эзэмшиж буй хугацаанд Үнэт цаас гаргагчийн санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээллийг хүлээн авах, шаардах, танилцах;
- Үнэт цаас гаргагч нь үнэт цаасны танилцуулгад тусгасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол биелүүлэхийг шаардах;
- Үнэт цаасны танилцуулга болон холбогдох хууль тогтоомжид заасан үндэслэлээр хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг буцаан худалдах санал гаргах;
- Хууль тогтоомжид заасан бусад.

6.6. Үнэт цаас гаргагчийн үүрэг

Үнэт цаас гаргагч нь дараах эрх, үүрэгтэй байна:

- Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хүү болон үндсэн төлөлтийн график, схемийн дагуу төлбөрийг хуваарийн дагуу төлөлт хийж барагдуулах;
- Үнэт цаас гаргагч нь зохицуулах байгууллагуудын тогтоосон хүүгийн орлогын татварыг зохих хуулийн дагуу суутган үнэт цаас худалдан авагчид шилжүүлж, татварын төлбөрийг төсөвт төлөх;
- Үнэт цаасны танилцуулга болон хууль, журмыг зөрчиж Үнэт цаас эзэмшигчид учруулсан аливаа хохирлыг Үнэт цаас гаргагч нь үл маргах журмаар нөхөн барагдуулах;
- Үнэт цаас гаргагч нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой аливаа үйл явцын мэдээллийг ТЗК-н баталсан хууль журмын дагуу Үнэт цаас эзэмшигчдэд болон эрх бүхий байгууллагад мэдээлэх;
- Хууль тогтоомж, энэхүү үнэт цаасны танилцуулгад заасан үндэслэлээр хөрөнгийн багцыг анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагчтай тохиролцон буцаан худалдах;
- Бусад хууль тогтоомж, гэрээнд тусгагдсан эрх, үүргийг хүлээнэ.


ҮНЭТ ЦААС
ГАРГАХ ҮЙЛ
АЖИЛЛАГААНД
ОРОЛЦСОН
БАЙГУУЛЛАГУУД

2026 -06- 12
БҮРТГЭВ
СЗХ
2026 .06. 11 өдөр

7. ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД

7.1. Үндсэн андеррайтерийн компани

"Таван Богд Капитал ҮЦК" ХХК нь 2021 онд "Таван Богд Групп"-ийн хөрөнгө оруулалтаар үүсгэн байгуулагдсан ба 40 мэргэжилтнээс бүрдсэн багийн хүрээнд хөрөнгө оруулалтын зөвлөх, андеррайтинг, дилер болон брокерийн үйл ажиллагаа явуулж байна.

Ийнхүү 2021 оны 04 сараас үйл ажиллагаандаа томоохон өөрчлөлтийг хийж Санхүүгийн Зохицуулах Хорооноос Брокер, Дилер, Андеррайтер, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Мөнгөн хөрөнгийн номинал данс эзэмших, Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах худалдан авахад зуучлах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлүүдийг авч харилцагч, хөрөнгө оруулагчдад үнэт цаасны зах зээлийн өргөн хүрээнд үйлчилгээг үйлчилгээг үзүүлж байна.

TAVAN BOGD CAPITAL "Таван Богд Капитал ҮЦК" ХХК

Үйл ажиллагааны чиглэл	Брокер, Дилер, Андеррайтер, Хөрөнгө оруулалтын зөвлөх
Улсын бүртгэлд бүртгүүлсэн огноо	2011.04.15
Улсын бүртгэлийн дугаар	9011286006
Регистрийн дугаар	5469112
Хаяг	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай-16, Галлериа Улаанбаатар худалдааны төв 1 давхар
Утас	(+976) 7272 7282
Веб хуудас	www.tavanbogdcapital.com
Цахим хаяг	cr@tavanbogdcapital.com

"Таван Богд Капитал ҮЦК" ХХК нь IPO болон нээлттэй бонд гаргалтууд дээр үндсэн болон туслах андеррайтераар ажилласан ба нийт 213.5 тэрбум төгрөгийн нээлттэй үнэт цаасны санхүүжилт татсан туршлагатай. Мөн 2021 оны 12 дугаар сараас өнөөдрийг хүртэлх хугацаанд нийт 911.8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг биржийн бус зах зээлээс амжилттай татаад байна.

"Таван Богд Капитал ҮЦК" ХХК нь 2025 оны 12-р сарын 05-ны өдрийн 43/АҮ-25-021 тоот "Андеррайтерийн үйлчилгээний гэрээ"-г Үнэт цаас гаргагчтай байгуулсан. Энэхүү Андеррайтерийн гэрээнд Үнэт цаас гаргагчид УБҮЦБ с 40.0 тэрбум төгрөг хүртэлх хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаасыг олон нийтэд санал болгох, худалдах ажлыг удирдан зохион байгуулах, хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татан төвлөрүүлэхэд шаардлагатай магадлан шинжилгээ, тооцоолол, судалгаа, бэлтгэл ажлуудыг гүйцэтгэх, боломжит хөрөнгө оруулагчдад Үнэт цаасыг танилцуулах, санал болгох, арилжих үйлчилгээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн үзүүлэх зорилготой.

ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК ХХК
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК

2026 К 2
СЗХ
сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

7.2. Дэд андеррайтерийн компани

"Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК нь анх 2011 онд "Ти Ди Би Капитал" ХХК нэрээр үүсгэн байгуулагдаж, дотоодын болон олон улсын зах зээл, эдийн засгийн салбаруудын бие даасан онцлог болон тэдгээрийн хоорондын харилцан хамаарлын талаар мэдлэг, мэдээллийг хослуулан хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаагаа явуулж байна.

Андеррайтер нь Санхүүгийн зохицуулах хорооноос брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх, гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах, номинал данс эзэмших, уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд авсан байх бөгөөд эдгээр үйл ажиллагаагаа мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэн ажиллаж байна.

Тус компани нь харилцагчдын хэрэгцээ шаардлага, хүсэл зорилгыг эрхэмлэсэн, дэвшилтэт технологид суурилсан санхүүгийн цогц бүтээгдэхүүн үйлчилгээ, шийдлийг мэргэжлийн өндөр түвшинд түргэн шуурхай хүргэн үндэсний баялаг бүтээгчдийг дэмжиж, харилцагчдын найдвартай зөвлөх байхыг зорин ажиллаж байна. Мөн, харилцагчдадаа хөрөнгө оруулалтын банкны болон үнэт цаасны зуучлалын үйлчилгээг үзүүлж, хувьцаа, бонд зэрэг үнэт цаас, түүнд суурилсан санхүүгийн хэрэгслүүд, бүтэцжүүлсэн санхүүгийн хэрэгслийг нээлттэй болон хаалттай зах зээлд гаргах замаар санхүүжилт татах, үнэт цаас гаргах бэлтгэл ажилд зөвлөх, үнэт цаас гаргасны дараа нэмэлт үйлчилгээ үзүүлэх, компанийн хэлбэрийг өөрчлөх, компанийг өөрчлөн байгуулах, тухайн байгууллагын онцлогт тохирсон санхүүжилтийн хамгийн үр ашигтай хувилбарыг санал болгох, компанийн стратеги төлөвлөлтөд зөвлөх, бизнесийн үнэлгээ гаргах, гадаад дотоодын хөрөнгийн зах зээлийн арилжаанд оролцоход зуучлах, хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөх зэргээр харилцагчдынхаа санхүүгийн хэрэгцээг бүрэн хангах, мэргэжлийн зөвлөгөө, туслалцааг үзүүлдэг.

"Ти Ди Би Секьюритис" ҮЦК ХХК

Үйл ажиллагааны чиглэл	Брокер, Дилер, Андеррайтер, Хөрөнгө оруулалтын зөвлөх
Улсын бүртгэлд бүртгүүлсэн огноо	2008.08.15
Улсын бүртгэлийн дугаар	9011165033
Регистрийн дугаар	5251494
Хаяг	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө- 19, Худалдаа Хөгжлийн Банк төв оффис, 14 давхар
Утас	(+976) 7010 0261
Веб хуудас	www.tdbsecurities.mn
Цахим хаяг	info@tdbsecurities.mn

Тус компани нь үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн гадаад болон дотоодын зах зээлд нээлттэй болон хаалтай хүрээнд үнэт цаас гаргах нийт 4.8 тэрбум ам.долларын үнийн дүн бүхий төслүүд дээр ажилласан туршлагатай.

"Ти Ди Би Секьюритис" ҮЦК ХХК нь 2026 оны 04-р сарын 13-ны өдрийн 43/АУ-26-09 тоот "Хамтын ажиллагааны гэрээ"-г Үндсэн андеррайтертай байгуулсан. Энэхүү гэрээнд

УЛААНБААТАР ХОТ
ТАНАНБОГД КАПИТАЛ ҮЦК ХХК
ОЧУН АКТИВ ПЭЙ ХХК

2026 2
БҮРТГЭВ

СЗХ
2026 .06.11 өдөр
БҮРТГЭВ

Үнэт цаас гаргагчийн эрх бүхий этгээдийн шийдвэрт заасан нөхцөлөөр ХБҮЦ гаргах, Биржээр дамжуулан олон нийтэд санал болгох, худалдах ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Үндсэн андеррайтер болон Дэд андеррайтерийн хамтын ажиллагаа, эрх, үүрэг, хариуцлага, төлбөрийн нөхцөлийг зохицуулахаар хөрөнгө оруулагч нарт компанийг танилцуулах, санал болгох, санхүүжилт татаж өгөх үйлчилгээ үзүүлэхээр тусгасан байна.

УЛААНБААТАР ХОТ
ТАВАН БОГД КАПИТАЛ ХХК
ШТК0128 5469 9021061377

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947
7239689 ХНТ10470

2026 -ж. 1 2
БҮРТГЭВ
СЗХ
2026 сар 05 өдөр 13
ТЭВ

7.3. Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн тухай

"Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК нь 2005 оны 1 дүгээр сарын 27-нд үүсгэн байгуулагдаж, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 10 дугаар сарын 28 өдрийн 473 тоот тогтоолоор Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг ХБҮЦ-ны хөрөнгө итгэмжлэн удирдах чиглэлээр авсан.

"Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК

Үйл ажиллагааны чиглэл	Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа
Тусгай зөвшөөрлийн дугаар	ТЗ 316/18
Регистрийн дугаар	2870657
Гүйцэтгэх захирал	Ж.Онон
Хаяг	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Соёл амралтын хүрээлэн /14240/, Олимпын гудамж, 7/2 байр 803 тоот
Утас	+976 7012 2346
Цахим хаяг	info@uaf.mn

"Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК нь ТЗК-ийн санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, үнэт цаасны баталгаа болж буй хөрөнгийн эргэн төлөлтийг цуглуулж, үнэт цаасны хэлцэлтэй холбоотой төлбөрийг гүйцэтгэх, мөнгөн хөрөнгийг зөвшөөрөгдсөн хөрөнгө оруулалтад байршуулах, хөрөнгө оруулагч болон зохицуулагч байгууллагад тайлан мэдээ гаргах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах ажлыг гүйцэтгэнэ.

Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн удирдлагын багийн мэдээлэл

Гүйцэтгэх захирал	Ж.Онон	London School of Economics -г банк, санхүүгийн мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, бүтцийн санхүүжилт, компанийн засаглал, гадаад харилцааны чиглэлээр 18 жил ажилласан туршлагатай. Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны ерөнхий нарийн бичгийн даргын 2021 оны 11 дугаар сарын 11-ны өдрийн А-07 тоот тушаалаар Хөрөнгө оруулалтын чиглэлээр ажил үйлчилгээ явуулах эрх авсан.
Зөвлөх	Х.Маргад-Эрдэнэ	МУИС-ийг Бизнесийн удирдлагын бакалавр зэрэгтэй төгссөн. Багцын удирдлага, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, бүтцийн санхүүжилтийн чиглэлээр 16 жил ажиллаж байна. Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны ерөнхий нарийн бичгийн даргын 2020 оны 6 дугаар сарын 11-ны өдрийн 05 тоот тушаалаар Хөрөнгө оруулалтын чиглэлээр ажил үйлчилгээ явуулах эрх авсан.
Үйл ажиллагаа	Б.Буяннэмэх	МУИС-ийн эдийн засгийн бакалавр, бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй. Багцын удирдлага.

УЛААНБААТАР ХОТ
ТАВАН БОГД КАПИТАЛ ХХК
ТАВАН БОГД КАПИТАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ
ӨНӨӨ АКТИВ НЭГ ТЗК ХХК

хариуцсан захирал	зээлийн шинжилгээ, үнэт цаасны чиглэлээр 13 дахь жилдээ ажиллаж байна. Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны ерөнхий нарийн бичгийн даргын 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 10 тоот тушаалаар Хөрөнгө оруулалтын чиглэлээр ажил үйлчилгээ явуулах эрх авсан.

Компанийн гүйцэтгэх удирдлагын баг нь бүтэцжүүлсэн санхүүжилтийн чиглэлээр 10-18 жил ажилласан туршлагатай хамт олноос бүрддэг. Компани нь компанийн засаглалын олон улсын ISO 37000:2021 стандартыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажилдаг бөгөөд компанийн засаглал, санхүүгийн удирдлагаар мэргэшсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнтэй.

Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн эрх бүхий албан тушаалтан, хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааг хариуцан ажиллах мэргэжилтэн нь Хорооноос баталсан тохиромжтой этгээдийн журмын шаардлагыг хангасан, Гүйцэтгэх захирал, ХИУ үйл ажиллагааг хариуцан ажиллах мэргэжилтэн нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрх авсан, үйл ажиллагааг эрхлэхэд шаардлагатай хүний нөөцийн болон нягтлан бодох бүртгэл, тайлан тооцоо гаргах, программ, техник хангамжийн нөхцөлөөр хангагдсан болно.

4. Компанийн тухай хуулийн 84.1, 84.2 дахь хэсэгт заасны дагуу Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал, зөвлөх хариуцсан захирал, бизнес хөгжил хариуцсан захирал, санхүүгийн менежер, ерөнхий нягтлан бодогч, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад эрх бүхий албан тушаалтанд тооцох бөгөөд тэдгээр нь өөрийн хууль бус үйл ажиллагаанаас учирсан хохирлыг хариуцна.

Тав. Компанийн хөрөнгө

1. Компанийн өөрийн хөрөнгө буюу дүрмийн сан нь нийт 5,000,000,000 /таван тэрбум/ төгрөгийн үндэсний мөнгөн тэмдэгт /эсвэл валют/-ээс бүрдсэн хөрөнгөтэй байна. Энэхүү хөрөнгө нь нэг бүр нь 1,000,000 /нэг сая/ төгрөгийн үнэ бүхий 5000 /таван мянга/ ширхэг хувьцаанд хуваагдана.
2. Компанийн гаргасан хувьцааг дараах эзэмшигч эзэмшинэ. Үүнд:

Д/Д	Хувьцаа эзэмшигч	Эзэмших хувьцаа/ширхэг/	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Хувь хэмжээ
1.	Тардай овогтой Гантөмөр (РД: ЦГ66100716)	2,500	2,500,000,000	50%
2.	"Очир Үндраа Холдинг" ХХК (РД:6889972)	2,500	2,500,000,000	50%

3. Компани нь өөрийн хуримтлагдсан ашгийн хэмжээгээр дүрмийн сангаа нэмэгдүүлж болно.
4. Шаардлагатай нөхцөлд дүрмийн санд шинээр хөрөнгө оруулна.
5. Үйл ажиллагааны зарим чиглэлээр охин компани байгуулан дүрмийн сангаа тэр хэмжээгээр хорогдуулж болно.
6. Компанийн үүсгэн байгуулагч компанийн үйл ажиллагааны цэвэр ашгийг хуульд өөрөөр заагаагүй бол бүрэн захиран зарцуулна.

УЛААНБААТАР ХОТ
ТАВАН БОГД КАПИТАЛ ХХК
ЦТК0138 5400117 9021061377

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
7239691 ЦТ10470

УЛААНБААТАР ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ
ULAANBAATAR SECURITIES EXCHANGE
2026 -01- 2
БҮРТГЭВ

СЗХ
2026 оны 01 сар 11 өдөр
БҮРТГЭВ
№ 01

7. Компанийн хөрөнгийг гэр бүлийн гишүүдээс болон бусдад шилжүүлэх, өвлүүлэх харилцааг Монгол улсын энэ төрлийн хуулийн дагуу шийдвэрлэнэ. Гэхдээ энэхүү давуу эрхийг гэр бүлийн гишүүд эдэлнэ.
8. Компанийн өөрийн хөрөнгө буюу дүрмийн сан оруулсан хөрөнгийн бүртгэл жагсаалтыг улсын бүртгэлийн материалд тухай бүр оруулж байна.
9. Энэхүү хөрөнгөд тухайлбал үл хөдлөх хөрөнгийн хувьд үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээ, хөдлөх хөрөнгөд хөндлөнгийн байгууллага буюу хөрөнгийн үнэлгээний компанийн тайланг хавсаргаж баталгаажуулна.

Зургаа. Компанийн удирдлага түүний эрх хэмжээ

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг Компанийн тухай хуульд заасны дагуу хувьцаа эзэмшигчид хэрэгжүүлнэ. Хувьцаа эзэмшигчид нь Үүсгэн байгуулагч Тардай овогт Гантөмөр болон "Очир Ундраа Холдинг" ХХК байна.
2. Хувьцаа эзэмшигчид нь хууль ёсны эрхээс ТУЗ-ийн даргад шилжүүлэх тухай тогтоол гаргаж болно.
3. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийг хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр томилно.
4. Хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр томилсон Төлөөлөн удирдах зөвлөл компанийн гүйцэтгэх удирдлагыг солих, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтооно.
5. Компанийн хувьцаа эзэмшигчид нь компанид өөрчлөн байгуулах асуудлыг шийдвэрлэнэ.
6. Компанийг өөрчлөн байгуулсантай холбогдуулан хувьцаа эзэмшигчид нь Компанийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан эрхийг эдэлнэ.
7. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах этгээдүүд байна. Үүнд:
   - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн;
   - Гүйцэтгэх захирал;
   - Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн;
   - Санхүүгийн албаны дарга;
   - Ерөнхий нягтлан бодогч;
   - Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нар байна.

Долоо. Төлөөлөн удирдах зөвлөл

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл байна.
2. Төлөөлөн удирдах зөвлөл нь хууль тогтоомж, Компанийн дүрмээр болон Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарууллаас бусад Компанийн стратеги, бизнесийн чиглэлийг тогтоох, удирдлагыг чиглүүлж, гүйцэтгэлийг хянах асуудлаар шийдвэр гаргах эрх хэрэгжүүлэх компанийн засаглах дээд байгууллага юм.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо 5 байх ба нийт төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 1/3 нь хараат бус гишүүд байна.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа нэг жил байх ба төлөөлөн удирдах үйл ажиллагаа түүнтэй холбоотой харилцааг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.

Найм. Гүйцэтгэх удирдлага

1. Компанийн гүйцэтгэх удирдлага нь компанийн гүйцэтгэх захирал байна. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
2. Компанийн гүйцэтгэх захирал нь компанийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн үнэн зөвийг харицуцна.

Ес. Дотоод хяналт

1. Компани нь Дотоод хяналтын албатай байх ба алба нь Гүйцэтгэх захирлын шууд удирдлагад ажиллана.
2. Дотоод хяналтын алба нь компанийн Гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулсан "Дотоод хяналтын бодлого, журам"-тай байх ба нэмжийн үйл ажиллагаа түүнтэй холбоотой харилцааг дээрх журмаар зохицуулна.

УЛААНБААТАР ХОТ
ХААН БАНК КАПИТАЛ
КАПИТАЛ ТЦК ХХК
ШТК0128 5409112 9021061377

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947
7239689 ХХК

Арав. Компанийн санхүүгийн тайлан хяналт шалгалт

1. Компани нь санхүүгийн тайлангаа "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хууль, "Аудитын тухай" хуулийн дагуу баталгаажуулна, үүний үндсэн дээр татварын багц хуулийн заалтад нийцүүлсэн тогтоосон хугацаанд нь татварын тайлан гаргаж тооцоо хийнэ.
2. Санхүүгийн тайланд дараах бүрдэл хэсгүүдийг заавал оруулна.
   - Баланс
   - Орлого үр дүнгийн тайлан
   - Мөнгөн гүйлгээний тайлан
   - Хуримтлагдсан ашгын тайлан
   - Тайлангийн тайлбар, тодруулга, илтгэх хуудас,
3. Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг Гүйцэтгэх тайлан хариуцна. Компанийн орон тоонд хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа Ерөнхий нягтлан бодогч энэхүү хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.
4. Санхүү аж, ахуйн ажиллагаа, нягтлан бодох бүртгэл тайлан тэнцэл, татварын тооцооллын үнэн магадад хөндлөнгийн байгууллагаар шалгалт хийлгэж, ажил сайжруулна.
5. Хяналт, шалгалт лавлагаа, түүх архивын зорилгоор дараах даралт баримт бичгүүдийг хуульд заасан хугацаагаар хадгална.
   - Компанийн дүрэм түүнд орсон нэмэлт өөрчлөлтүүд
   - Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ
   - Компанийн дотоод бичиг баримт материалууд
   - Компанийн салбар төлөөлөгчийн газрын дүрэм гэрээнүүд
   - Нягтлан бодох бүртгэлд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох баримт бичгүүд
   - Компанийн ТУЗ-ийн дарга болон Гүйцэтгэх захирлын тушаал, шийдвэр, хурал зөвлөгөөний тэмдэглэл
   - Санхүү аж ахуйн үйл ажиллагааны анхан шатны болон дэлгэрэнгүй бүртгэл, нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг материалууд
   - Санхүүтийн болон үйл ажиллагааны тайлан тэнцэл түүнтэй холбогдох баримт материалууд

Арван нэг. Компанийг өөрчлөн байгуулах татан буулгах өр төлбөрийн барагдуулах

1. Компанийн өөрчлөн байгуулах тухай ойлголтод компанийг хуваах компанитай нийлэх, нэгдэх, тусгаарлах, өөрчлөх, асуудлууд хамаарагдана.
2. Компанийг өөрчлөн байгуулах тухай ойлголтод "Компанийн тухай"хуулийн 18.24 дүгээр зүйлийн заалтуудыг үндэслэн шийдвэрлэнэ.
3. Компани нь дараах үндэслэлээр татан буугдана.
   - Төлбөрийн чадваргүй болж шүүхийн шийдвэрээр дампуурсан
   - Үүсгэн байгуулагчийн шийдвэрээр цаашид үйл ажиллагаа явуулахгүй болсон
   - Хуульд заасан бусад үндэслэлээр
4. Компанийг татан буугдах шийдвэр гарсан байгууллагаас татан буулгах комиссыг томилон ажиллуулна.
5. Татан буугдах комисс томилсноор тухайн компанийн бүрэн эрх дуусгавар болж татан буугдах комисст шилжинэ.
6. Татан буулгах комисс нь "Компанийн тухай" хуулийн 26-29 дүгээр зүйлд заасны дагуу ажиллан эцэст нь улсын бүртгэлээс компанийг хасуулж ажлаа дуусгавар болгоно.
7. Татан буулгах комисс үүргээ гүйцэтгэх үедээ өөрийн бурууташ үйл ажиллагааны улмаас тухайн компанид ямар нэгэн хохирол учруулсан бол уул хохирлыг хуульд заасан журмын дагуу хариуцна.

Арван хоёр. Дүрэм хүчин төгөлдөр байх

1. Энэ дүрмийг монгол хэлээр 2 хувь үйлдэж , нэг хувийг нь УБЕГ-ын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт, нэг хувийг компани өөртөө хадгална.

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947
5239689 .Ч. ХНТ10470

2. Энэхүү дүрэм нь компани Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгэгдэж гэрчилгээнд тэмдэглэгээ хийсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

"ОЧИР-УНДРАА ББСБ" ХХК-ийн хувьцаа эзэмшигч:

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ Т.ГАНТӨМӨР

Б.БИЛИГ-ҮҮН

ОЧИР УНДРАА ХОЛДИНГ ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

УЛААНБААТАР ХОТ
ТАВАН БОГД КАПИТАЛ УЦК ХХК
ШТК0125 5469112 9021061377

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЭК ХХК
9026040947
7239689 Л. ХНТ10470

8.9. Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ

ОГНОО:
2026 оны 04 дүгээр сарын 21-ны өдөр

"ОЧУН АКТИВ НЭГ ТЗК" ХХК
("Үнэт цаас гаргагч")

болон

"ОЧИР УНДРАА ОМЗ ББСБ" ХХК
("Анхны үүрэг гүйцэтгүүлэгч")

ХӨРӨНГӨ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Дугаар: ОАН-2026-01

УЛААНБААТАР ХОТ

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947
9239689 ХНТ10470

Энэхүү Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-г дор дурдсан оролцогч талуудын хооронд Монгол Улсын Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журмын заасныг удирдлага болгон

(1) **"ОЧИР УНДРАА ОМЗ ББСБ" ХХК** Монгол Улс, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, Сөүлийн, 20/1 Сөүл плаза, 4 давхар, 401 тоот албан ёсны хаягт байрлах регистрийн **2734745** дугаартай (цаашид "Анхны үүрэг гүйцэтгүүлэгч" эсхүл "ББСБ" гэх), түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Г.Цогтгэрэл;

(2) **"ОЧИР АКТИВ НЭГ ТЗК" ХХК** Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, 5-р хороолол /14252/, Сөүлийн, 13а барилгын 12-р давхар албан ёсны хаягт байрлах регистрийн **7239689** дугаартай (цаашид "Үнэт цаас гаргагч", эсхүл "ТЗК" гэх), түүнийг төлөөлж Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Г.Цогтгэрэл.

Дараах нөхцөлийг харилцан тохиролцож байгуулав.

(1) Энэхүү Гэрээгээр Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Үнэт цаас гаргагчид энэхүү Гэрээнд заасан Шалгуур үзүүлэлтийг хангасан эзэлийн анлагын эрх, шаардах эрх, түүнд дагалдах эрхүүдийг худалдах, Үнэт цаас гаргагч нь хэлэлцэн тохиролцсон үнийг төлөх болон бусад холбогдох харилцааг зохицуулахад оршино.

(2) Үнэт цаас гаргагч нь Хэлцэл биелэх өдөр дор дурдсан Зээлийн хөрөнгө болон түүнд холбогдох эрх (хамтад нь **"Хөрөнгө"** гэх)-үүдийг багц болгон худалдан авч (цаашид **"Хөрөнгийн багц"** гэх), гэрээнд заасан үнийг төлөх. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийн багцыг энэхүү Гэрээнд заасан солих, хөрөнгийн багцыг гэрээнд заасан үндэслэлээр изэх нөхцөлтэйгөөр худалдахаар тохиролцов.

(3) Талууд Гэрээгээр хүлээсэн үүрэгээ үнэнч шударгаар биелүүлж, харилцан бие биесийн ашиг сонирхлыг хүндэтгэх, Гэрээгээр тохиролцсон анхны тохиролцоог туушгай хадгалах бөгөөд зээлийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас (цаашид "ХБҮЦ" гэх)-ны үргэлжлэх хугацаанд талууд Хөрөнгө оруулагч /Үнэт цаас эзэмшигч/-ийн эрх ашгийг нэн тэргүүнд тавьж идэвхтэй, шуурхай, бүтээлчээр хамтран ажиллана.

(4) Энэ Гэрээний хүчин төгөлдөр болон ХБҮЦ-ны үргэлжлэх хугацаанд хууль тогтоомж, энэхүү Гэрээ, бусад гэрээ, дүрэм, журамд заасан үндэслэлээр Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулж болно.

(5) Гэрээний хавсралтууд нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно (цаашид **"Гэрээний баримт бичиг"** гэх). Үүнд:

a. Гэрээний ерөнхий нөхцөл;
b. Гэрээний тусгай нөхцөл;
c. Гэрээний хавсралт №1 - Хөрөнгийн жагсаалт;
d. Гэрээний хавсралт №2 - Хөрөнгөд тавих ерөнхий шалгуур;
e. Гэрээний хавсралт №3 – Барьцааны гэрээнүүд, түүнд хамаарах Барьцааны зүйл;
f. Бусад шаардлагатай баримт бичиг.

(6) Энэ Гэрээ нь Хөрөнгийг худалдах, худалдан авахтай холбоотой талуудын эцсийн тохиролцоо болох тул урьд үйлдсэн энэ талаарх бусад хэлцлийг бүрэн орлоно.

(7) Гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлүүд зөрчилдвөл тусгай нөхцөлийг баримтална.

(8) Гэрээтэй холбоотой асуудлаар талууд албан бичгээр болон шуудан, мэйл, утсаар харилцана.

УЛААНБААТАР ХОТ
ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ОЧИР АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947
7239689 ХНТ10470

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧ:

"ОЧИР УНДРАА ОМЗ ББСБ" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Г.ЦОГТГЭРЭЛ

Итгэл үүсэг

ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ:

"ОЧУН АКТИВ НЭГ ТЗК" ХХК
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
Г.ЦОГТГЭРЭЛ

ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК

Гарын үсэг

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947
7239689 .'. ХНТ10470

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Нэр томьёо ба Тайлбар

Энэхүү Гэрээнд заасан дараах нэр томьёог том бүр доор дурдсан утгаар ойлгоно.

"Анхдагч зах зээлийн өргөдөл" гэж "Улаанбаатар үнэт цаасны биржээ" ХХК-ийн анхдагч зах зээлийн өргөдлийг;

"ХБҮЦ" гэж Үнэт цаас гаргагчийн өргөдлийг хүлээн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан үнэт цаасыг;

"Барьцааны гэрээнүүд" гэж Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн Зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Зээлдэгч нарын хооронд байгуулагдсан хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээ, фидуцийн гэрээг;

"Зээлийн баримт бичгүүд" гэж ББСБ-аас Зээлдэгчид зээл олгосон зээлийн гэрээ, зээлийн хувийн хэрэг, бусад баримт бичгүүдийг;

"Зээлийн данс бүртгэл" гэж Зээлдэгч тус бүрийн Зээлийн эргэн төлөлт, үлдэгдэл, хүү, нэмэгдүүлсэн хүүг тооцоолж, эргэн төлөлтийг хугацааны дарааллаар бүртгэсэн мэдээллийг;

"Зээлийн эргэн төлөлт" гэж Зээлдэгчийн сар тутамд зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу төлөх зээлийн үндсэн төлбөр, хүү, нэмэгдүүлсэн хүүг;

"Хугацаанаас өмнө эргэн төлөгдөх" гэж Зээлдэгч сар тутам төлөх зээлийн эргэн төлөлтийн хуваарь дахь төлөх дүнгээс илүү дүнгээр зээлийн үлдэгдлээс хасагдаж, эсхүл бүрэн төлөхийг;

"Үйлчилгээ" гэж Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 19 дүгээр зүйл заасны дагуу ББСБ нь ТЗК-тай байгуулсан Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээний хүрээнд хөрөнгөтэй холбоотой төлбөр цуглуулан шилжүүлэхтэй холбоотойгоор үзүүлж буй үйлчилгээг;

"Үнэт цаасны танилцуулга" гэж Үнэт цаас гаргагчаас ХБҮЦ-ыг олон нийтэд танилцуулж, өргөдлөлөх зорилгоор холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан танилцуулгыг;

"Хөрөнгө" гэж Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 3.1.1 дэх хэсэгт заасны дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн мөнгөн урсгал бий болгосон зээлийн хөрөнгө, түүнийг дагалдах олиныг эрхүүшийг;

"Хөрөнгийн багц" гэж энэхүү Гэрээний тусгай нөхцөлийн 1 дүгээр зүйлд заасан, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Үнэт цаас гаргагчид худалдсан Хөрөнгийг;

"Хөрөнгийн жагсаалт" гэж энэхүү Гэрээний хавсралт 1-д заасан, худалдаж байгаа хөрөнгийн жагсаалтыг;

"Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах" гэж хөрөнгийн багц дахь хөрөнгө нь Шалгуур үзүүлэлтийг хангаагүй, эсхүл гэрээнд заасан үндэслэл бий болсон тохиолдолд тухайн хөрөнгийг солих буюу шинээр хөрөнгө нэмж авах үйл ажиллагаа;

"Хэлцэл биелэх өдөр" гэж Үнэт цаас гаргагч гэрээний ерөнхий нөхцөлийн 3-д заасны дагуу ББСБ-д Хэлцэл биелэх үнийг төлж, Хөрөнгийн багцыг өөрт бүрэн шилжүүлэн авсан одрийг;

"Хэлцэл биелэх үнэ" гэж энэхүү Гэрээний тусгай нөхцөлийн 2.1 дэх хэсэгт заасан үнийг;

"Шаардлага хангахгүй хөрөнгө" гэж Шалгуур үзүүлэлтийг хангахгүй хөрөнгийг;

"Шалгуур үзүүлэлт" гэж Үнэт цаас гаргагчийн Төлөвлөн Удирдах Зөвлөлийн тогтоолоор батлагдсан, энэхүү Гэрээний хавсралт 2-д заасан, Хөрөнгөд тавих хуулийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлтийг тус тус ойлгоно.

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947
7239689 ,'. ХНТ10470

2. **Хөрөнгө худалдах үндсэн нөхцөл**

2.1. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 13.2-т зааснаар ТЗК нь Хөрөнгийг шилжүүлэн авснаар тухайн Хөрөнгөтэй холбоотой аливаа эрх, барьцаа, фидуци, баталгаа болон үүргийн гүйцэтгэлийг хангах бусад арга, санхүүгийн хэрэгсэл хөрөнгөтэй хамт шилжүүлсэнд тооцно.

2.2. Худалдах хөрөнгийн хэмжээг Хэлцэл биелэх өдрийн байдлаар Хөрөнгийн багц дахь Зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдлийн нийлбэр дүнгээр тооцох бөгөөд уг дүн нь гэрээний тусгай нөхцөлийн 2.1-д заасан Хэлцэл биелэх үнийн дүнтэй тэнцүү байна.

2.3. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчид Хөрөнгийг худалдан шилжүүлэх жагсаалт үйлдэн шилжүүлэх бөгөөд Хөрөнгийн жагсаалтыг энэхүү Гэрээний Хавсралт №1-ээр батална.

2.4. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийг солих, нэмж худалдах болон буцаан худалдан авч болох нөхцөлтэйгөөр худалдаж байгаа болно.

2.5. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.11, 14.3-т заасны дагуу Санхүүгийн Зохицуулах Хороо Хөрөнгийн багцыг бүртгэсэн өдөр уг багцад орсон Хөрөнгийг ТЗК-ийн өмчлөлд шилжсэнд тооцно.

2.6. Талууд Хөрөнгийн багцыг шилжүүлэхдээ Гэрээний тусгай нөхцөлийн 10 дугаар зүйлийн 10.1-д заасан актыг зурж хүлээлгэн өгч, авна.

2.7. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгө шилжсэнтэй холбоотойгоор тухайн зээлдэгчийн эрх зүйн байдлыг дордуулах, зээлийн эргэн төлөлтөд сөргөөр нөлөөлж болзошгүй аливаа үйлдэл, эс үйлдэхүйг хийхгүй байх үүрэгтэй ба Үйлчилгээ үзүүлэх гэрээгээр олгогдсон эрх хэмжээний хүрээнд зээлдэгчийн зээлтэй холбоотой зээл олгогчийн хувьд хэрэгжүүлэх бүхий л арга хэмжээ, үйлчилгээг зээлдэгчид үзүүлэх үүрэгтэй.

2.8. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Зээлийн данс бүртгэлийг хадгалж хөтлөх, үнэт цаас гаргагчтай тулган баталгаажуулах болон хөрөнгө солих, зээлийн баримт бичгийг үнэт цаас гаргагчид хүргүүлэх, хүлээн авах зэргээр Хөрөнгөтэй холбоотой ажиллагааг харицуан гүйцэтгэх, Үнэт цаас гаргагчтай харилцах эрх бүхий ажилтныг томилж,уг ажилтны мэдээллийг Үнэт цаас гаргагчид өгөх үүрэг хүлээнэ.

3. **Гэрээний үнэ**

3.1. Үнэт цаас гаргагч нь Хэлцэл биелэх өдөр уг гэрээний Тусгай нөхцөлийн 2.1-д заасан Хэлцэл биелэх үнийг төлнө.

3.2. Үнэт цаас гаргагч нь Анхдагч зах зээлийн арилжааны хугацаа дуусахад хөрөнгө оруулалтын хэмжээ Хэлцэл биелэх үнэд хүрсэн тохиолдолд Анхдагч зах зээлийн арилжаа дууссанаас хойш Хэлцэл биелэх өдөрт багтаан төлбөрийг энэхүү Гэрээний Тусгай нөхцөлийн 6.1-д заасан Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн төлбөр хүлээн авах дансанд шилжүүлнэ.

4. **Хэлцэл биелэх дунд хүрэхгүй байх тохиолдолд авах арга хэмжээ**

4.1. Үнэт цаас гаргагч нь Анхдагч зах зээлийн арилжааны хугацаанд Хөрөнгө оруулалтаас боогдсон дүн нь Хэлцэл биелэх дүнд хүрээгүй тохиолдолд хэлцлийг амжилттүй болсон гэж үзэх бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийг Үнэт цаас гаргагчид шилжүүлэхгүй.

4.2. Гэрээний 4.1-д заасан нөхцөл үүссэн тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Хөрөнгө оруулагчдаас цугларсан хөрөнгийг буцаан олгох ажиллагаа хийнэ.

4.3. Үнэт цаас гаргагч нь энэхүү Гэрээ болон бусад гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөнөөс бусад тохиолдолд Хөрөнгө оруулалт Хэлцэл биелэх дүнд хүрээгүйн улмаас Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид учирсан аливаа хохирлыг хариуцахгүй бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь ХБҮЦ гаргахтай холбогдуулан гаргасан аливаа зардлуудыг хариуцна.

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947
7299689 ХНТ10470

УЛААНБААТАР ХОТ
ГАЛАН БАТАЛГААЖУУЛАЛ
ЦЕНТРАЛ ДЕПОЗИТАРИЙ
КАПИТАЛ МАРКЕТ ХХК
ШТК0128 5469112 9021061377

5. **Зээлийн данс бүртгэл хөтлөх, баримт бичгийг хадгалах**

5.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийн багц дахь зээлийн данс бүртгэлийг өөрийн бусад зээлээс тусад нь данс бүртгэл үүсгэн хадгалах бөгөөд санхүүгийн тайлан тэнцлийг тусад нь хөтлөж холбогдох баримт бичгийг өөрийн оффис дээр хадгална. Үүнд:

5.1.1. Зээлдэгчээс гаргасан хүсэлт, захидал харилцаа;

5.1.2. Холбогдох бусад.

5.2. Үнэт цаас гаргагч болон түүнд хөрөнгө итгэмжлэн удирдах болон аудитын үйлчилгээ үзүүлэгч, мөн бусад эрх олгогдсон этгээд хэдийд ч Зээлийн болон хөрөнгийн багцын баримт бичгүүдэд бүхэлд нь болон хэсэгчлэн шалгалт хийх эрхтэй.

5.3. Үнэт цаас гаргагч нь дээрх шалгалтыг хийх зорилгоор Зээлийн баримт бичгүүдийг авах тухай ББСБ-д мэдэгдэнээс хойш ажлын 3 хоногт багтаан ТЗК-д хүргүүлэх эсхүл ажлын байран дээрээ ажлын цагаар томилогдсон ажилтныг ажиллах боломжоор хангах үүргийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч хүлээнэ.

5.4. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь тайланг хүлээн авч хянан баталгаажуулна.

6. **Барьцааны зүйл, барьцааны эрхийг хэрэгжүүлэх**

6.1. Энэхүү Гэрээний 2.5-д заасны дагуу Хөрөнгийн багц Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс ТЗК-д шилжсэнээр Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 13.2 дахь хэсэгт заасны дагуу Хөрөнгийн багц дахь зээлийн гэрээнүүдээс үүсэх бүхий л эрх (үүнд, шаардах эрх, барьцаа, фидуци, баталгаа, үүргийн гүйцэтгэлийг хангах аливаа бусад арга, санхүүгийн хэрэгсэл зэрэг орно) ТЗК-д шилжинэ.

6.2. Дээрх 6.1 дэх заалтын дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийн багцад хамаарах Барьцааны гэрээнүүд болон түүнтэй холбоотой шаардах эрхийг Үнэт цаас гаргагчид шилжүүлж байгаа бөгөөд Үнэт цаас гаргагч нь Барьцааны гэрээнүүдийн Барьцаалагч талын эдлэх бүхий л эрх (үүнд, шаардах эрх, одоо болон ирээдүйд үүсэх эд хөрөнгийн эрх, орлого, үр шим хүртэх зэрэг эрх орно)-ийг эдэлж, бусад үүрэг гүйцэтгүүлэгчээс тэргүүн эээлжид барьцааны зүйлээс шаардлагаа хангуулна. Үүнтэй холбоотойгоор Үнэт цаас гаргагчид дараах нэхцэлийн дагуу барьцааны эрх шилжинэ. Үүнд:

6.2.1. ***Барьцаагаар хангагдах шаардлага, түүний хэмжээ:*** Барьцаагаар хангагдах шаардлага нь Хөрөнгийн багцыг бүрдүүлж байгаа зээлийн үндсэн төлбөр, хүүгийн авлага, түүнд холбогдох эрхүүд, барьцааны зүйлийг худалдан борлуулахад гарсан зардал, улсын тэмдэгтийн хураамж, нөхөн төлүүлэхтэй холбоотой гарсан шүүхийн зардал, барьцааны зүйлийг арчлан хамгаалахад гарсан зардал уг эд хөрөнгөтэй холбоотойгоор төлсөн татвар хураамж, төлбөр болон зээлдүүлэгчид учирсан бусад хохирлын нийлбэрээр тодорхойлогдоно.

6.2.2. "***Барьцааны зүйл***" гэж энэ Гэрээний Хавсралт №3 ("Барьцааны гэрээнүүд, түүнд хамаарах Барьцааны зүйл")-д заасан хөрөнгүүд болон тэдгээрт хамаарах эрхийг;

6.2.3. ***Барьцаа хөрөнгийн жагсаалтад өөрчлөлт оруулах:*** Энэ Гэрээ болон Үнэт цаас гаргагчийн гаргасан журамд заасны дагуу Хөрөнгийн багцад өөрчлөлт орсон, солигдсон тохиолдолд барьцаа хөрөнгийн жагсаалтад өөрчлөлт оруулах замаар барьцааны зүйлд өөрчлөлт оруулна.

6.2.4. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэхүү Гэрээний хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд Барьцааны зүйлийг аливаа хэлбэрээр бусад этгээдийн өмчлөлд шилжүүлэхгүй байх, барьцаалахгүй байх, тийнхүү шилжүүлэхээр амлахгүй байх үүрэгтэй.

7. **Үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулах**

7.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчтай Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээг энэхүү Гэрээнд заасан Хэлцэл биелэх өдөр байгуулна.

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК ХХК

7.2. Үйлчилгээ үзүүлэх гэрээний дагуу ББСБ нь хөрөнгийн багц дахь зээлийн эргэн төлөлтийг Зээлдэгчээс цуглуулан үнэт цаас гаргагчид сар тутамд сарын тооцоогоор хувааръ өдөр шилжүүлэх, ТЗК нь үйлчилгээний төлбөр болон шимтгэлийг төлөх үүрэг хүлээнэ.

7.3. Энэхүү Гэрээгээр зохицуулаагүй үйлчилгээ үзүүлэгчтэй холбоотой харилцааг Үйлчилгээ үзүүлэх гэрээ болон ТЗК-ийн Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журамд заасныг баримтална.

8. Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах

8.1. Хөрөнгийн багцад дараах байдлаар өөрчлөлт оруулна. Үүнд:

8.1.1. Шилжүүлэн авсан хөрөнгө нь Шалгуур үзүүлэлтийг хангаж чадаагүй, эсхүл энэхүү Гэрээний тусгай нөхцөлийн 7 дугаар зүйлд заасан үндэслэл бий болсон тохиолдолд хөрөнгийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаах, Гэрээний тусгай нөхцөлийн 4 дүгээр зүйлд заасан шаардлага хангасан өөр хөрөнгөөр сольж өгөхийг шаардах эрхтэй.

8.1.2. Энэхүү Гэрээний тусгай нөхцөлийн 8 дугаар зүйлд заасан үндэслэл бий болсон тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс хөрөнгийг нэмэгдүүлэх.

8.2. Гэрээний ерөнхий нөхцөлийн 8.1-д заасны дагуу Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах тохиолдолд гэрээний Хавсралт №1-д заасан Хөрөнгийн жагсаалтад өөрчлөлт оруулах бөгөөд Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Багцын хөрөнгөд өөрчлөлт оруулах мэдэгдлийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид хүргүүлж, Анхны үүрэг гүйцэтгүүлэгч Хөрөнгийн багцыг солих буюу нэмж, энэхүү Гэрээний тусгай нөхцөлийн 10.3-т заасны дагуу Хөрөнгийн багц шилжүүлэх акт үйлдэж Талуудын эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж баталгаажуулснаар Хөрөнгийн жагсаалтад өөрчлөлт орсон гэж үзнэ.

8.3. Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулахтай холбоотой бусад харилцаанд ТЗК-ийн "Хөрөнгө итгэмжлэн удирдах журам"-аар тогтоосон зарчмыг баримтална.

9. Хөрөнгийн багцыг анхны үүрэг гүйцэтгүүлэгчид буцаан хүлээлгэх

9.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид Хөрөнгийг буцаан хүлээлгэхдээ энэхүү Гэрээний тусгай нөхцөлийн 9 дүгээр зүйлд заасан нөхцөл үүссэн тохиолдолд ТЗК-ийн "Хөрөнгө итгэмжлэн удирдах журам"-аар тогтоосон зарчмын дагуу буцаан хүлээлгэнэ.

9.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөрөнгийг буцаан хүлээлгэж авах чадваргүй байх тохиолдолд Үнэт цаас гаргагч нь уг Хөрөнгийг бусад гуравдагч этгээдэд худалдах эрхтэй. Үнэт цаас гаргагч нь гуравдагч этгээдэд Хөрөнгө худалдсантай холбоотойгоор үүсэж болох хохирлыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шаардах эрхтэй бөгөөд түүнд учирсан алдаа хохирлыг Үнэт цаас гаргагч хариуцахгүй болно.

10. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч зөрчил гаргах, түүнийг шийдвэрлэх

10.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх, Хөрөнгө оруулагчийн эрх ашигт сөргөөр нөлөөлөх үйлдэл, эс үйлдэхүй гаргасан тохиолдолд Гэрээний зөрчилд тооцно.

10.2. Гэрээний тусгай нөхцөлийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасан нөцтой зөрчил гаргасан нь ТЗК-ийн зүгээс Гэрээний ерөнхий нөхцөлийн 6.1 дэх хэсэгт заасан барьцааны эрхээ хэрэгжүүлэх үндэслэл болох бөгөөд хөрөнгийг гуравдагч этгээдэд худалдах эрхтэй болно.

10.3. Гэрээний Тусгай нөхцөлийн 13 дугаар зүйлийн 13.1-т заснаас бусад гэрээ зөрчсөн үйлдэл гаргасан бөгөөд Үнэт цаас гаргагчаас тогтоосон хугацаанд уг зөрчлийн арилгаагүй бол нөцтэйгөөр гэрээний үүргийг зөрчсөнтэй адилтган үзэж болно.

11. Маргаан шийдвэрлэх

11.1. Энэ гэрээ байгуулагдах үндсэн зорилго болон ХБҮЦ гаргах үйл ажиллагаатай

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947
7230689 ., ХНТ10470

холбоотойгоор Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчийн гэрээний үүргийн зөрчилтэй холбоотойгоос бусад тохиолдолд аливаа байдлаар Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх шүүх арбитрт болон төрийн байгууллагад гомдол нэхэмжлэл гаргах болон бусад арга хэмжээ авахгүй байх, төлбөр нэхэмжлэхгүй байх үүрэг хүлээнэ. Үнэт цаас гаргагчийн эсрэг татан буулгах, дампуурлын хэрэг эхлүүлэхгүй байх зэрэг байдлаар маргаан үүсгэхийг хориглоно.

11.2. Талууд хууль болон бусад дүрэм журмыг дагаж мөрдөөгүйгээс үүссэн хохирол, төлбөр цуглуулах үйлчилгээ, энэхүү гэрээтэй холбоотой гарсан аливаа маргааныг талууд эвлэрлийн аргаар шийдвэрлэнэ.

11.3. Хэрэв эвлэрлийн аргаар маргааныг шийдвэрлэж чадахгүй бол Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

12. Гэрээ хүчин төгөлдөр болох

12.1. Энэхүү Гэрээ нь Талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

12.2. Гэрээг дөрвөн хувь үйлдэх бөгөөд эдгээр нь хууль зүйн хувьд ижил хүчинтэй байна. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нэг хувь, Үнэт цаас гаргагч хоёр хувь, Хөрөнгө итгэмжлэн удирдагчид нэг хувийг тус тус хадгалуулна.

13. Гэрээний хугацаа

13.1. Энэхүү гэрээ нь байгуулагдсан үеэс эхлэн талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж дууссанаар болох хүртэл буюу Үнэт цаасны төлбөрийг хөрөнгө оруулагчдад төлж дууссан Үнэт цаас гаргагчийг татан буулгах хүртэл хүчин төгөлдөр байна.

13.2. ХБҮЦ-ны хугацаа дуусахаас өмнө Анхны үүрэг гүйцэтгүүлэгч ХБҮЦ-ыг бүцаан худалдан авсан тохиолдолд хугацаанаас өмнө гэрээг дуусгавар болгож болно.

13.3. ХБҮЦ-ны хугацаа нь хөрөнгө эзэмшигч эрилжаа эхлэсэн өдрөөс эхлэн 24 сар байна.

13.4. Энэхүү Гэрээний дагуу Хөрөнгийг үнэт цаас гаргагч худалдан авч Хөрөнгөд суурилсан ХБҮЦ гаргаж, олон нийтэд эрилжаалсан тохиолдолд аль нэг талын санаачилгаар гэрээг цуцлах эрхгүй байна.

14. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал

14.1. Талуудын урьдчилан таамаглах, даван туулах боломжгүй гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөлөөлөл (дайн, гал түймэр, үер, газар хөдлөлт, ажил хаяг, гоц халдварт өвчин, хорио цээр) нь гэрээний үүргийн биелэлтэд шууд нөлөөлсөн нотлогдсон бол Талууд энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүйн харицуцлагаас бүрэн болон хэсэгчлэн чөлөөлөгдөнө. Энэ үед гэрээний үүрэг биелүүлэх хугацаа нь давагдашгүй хүчин зүйлийн үргэжлэх хугацаагаар хойшлогдоно.

14.2. Энэхүү Гэрээний ерөнхий нөхцөлийн 14.1 дэх хэсэгт заасны дагуу ййшхүү харицуцлагаас чөлөөлөх үндэслэл нь МҮХАҮТ-аас олгосон гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, хүнд нөхцөл байдлын гэрчилгээ байна.

14.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдал үүссэн тохиолдолд талууд нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэж, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл тохиолдсон ба үүний улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тухайгаа нотлох үүрэг хүлээнэ.

14.4. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн талаар тухайн цаг үед нь нөгөө талдаа мэдэгдээгүй бол ирээдүйд уг нөхцөл байдлыг үндэслэл болгох эрхгүй.

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947
7239699 ҮХНТ10470

УЛААНБААТАР ХОТ
ХАВАН БОГД КАПИТАЛ ХХК

15. Бусад заалт

15.1. Энэхүү гэрээнд Монгол хэлийг ашиглана. Гэрээ түүнд холбогдох баримт бичиг, харилцах баримт бичиг нь энэ хэл дээр байна.

15.2. Энэхүү гэрээг ойлгох, тайлбарлах, хэрэглэхдээ Монгол Улсын хууль тогтоомжийг баримтална.

15.3. Талуудын аль нэг нь гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа нөгөө талдаа ажлын 10-аас доошгүй өдрийн өмнө мэдэгдэх бөгөөд нэмэлт, өөрчлөлтийг зөвхөн бичгээр оруулж талууд гарын үсэг зурж тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

15.4. Гэрээний нэмэлт, өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг бөгөөд гэрээний нэгэн адил үйлчилнэ.

15.5. Энэхүү Гэрээний ерөнхий нөхцөлийн 8.2-т заасны дагуу Гэрээний хавсралт №1-д оруулсан нэмэлт өөрчлөлтөд Гэрээний ерөнхий нөхцөлийн 15.3-д заасан журмыг баримтлахгүй байж болох бөгөөд энэ нь Гэрээний хавсралт №1-д оруулсан нэмэлт, өөрчлөлтийг хүчингүйд тооцох үндэслэл болохгүй.

15.6. Энэхүү Гэрээ нь Талуудын холбогдох эрх залгамжлагчид мөн адил үйлчилнэ.

15.7. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан "эрх хүлээн авагч" нь хөрөнгө болон хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахад шаардлагатай бүх арга хэмжээ авч, ТЗК-ийн нийт хөрөнгө, санхүүгийн тайлан, тэнцэл, баримт бичиг, албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг зэргийг хүлээн авч Үнэт цаас гаргагчийн эрх залгамжлагчаар тооцогдоно.

15.8. Хууль ёсны эрх залгамжлагчдаас бусад этгээдэд үүргийг шилжүүлэхийг хориглоно.

15.9. Гэрээний ерөнхий нөхцөлийн 15.7-д заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд энэхүү гэрээг хэрэгжүүлэхээр байгуулсан бусад гэрээнүүд хүчин төгөлдөр байна.

15.10. Талууд нь энэхүү Гэрээ байгуулагдсантай холбоотойгоор олж мэдсэн гэрээний тусгай нөхцөлийн 14.1-д заасан нууц мэдээ, мэдээлэл, баримт бичгийн нууцлалыг хадгалах ба хувийн болон бусад зорилгоор ашиглахгүй. Үнэт цаас гаргагч, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эрх ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх аливаа хэлбэрээр бусдад задруулахгүй, тараахгүй байх үүрэгтэй. Нууц мэдээллийг талууд гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 5 жилийн хугацаанд хадгална.

15.11. Талууд хууль тогтоомж төрийн эрх бүхий байгууллага шаардсанаас бусад нууц мэдээллийг бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр аливаа этгээдэд задруулах хэрэглэх эсхүл өөр бусад зорилгоор ашиглахыг хориглоно.

15.12. Гэрээний ерөнхий нөхцөлийн 15.10-15.11 заасныг зөрчиж, нууц мэдээллийг задруулсан тал нөгөө талдаа яаралтай мэдэгдэж, буруутай этгээд нь нууц мэдээллийг задруулснаас үүсэх аливаа хохирлыг бие даан хариуцна.

15.13. Холбогдох хуулийн дагуу энэхүү Гэрээний аливаа заалт хууль бус, хүчингүй, хэрэгжүүлэх боломжгүйд тооцогдвол:

(a) тус заалт нь бүрэн салгах боломжтой;

(b) тус хууль бус, хүчингүй болон хэрэгжих боломжгүй заалт нь өмнө энэхүү Гэрээний заалт байгаагүйд тооцогдох бол;

(c) гэрээний бусад заалтууд хүчинтэй хэвээр байх бөгөөд тус хүчингүй, хууль бус болон хэрэгжих боломжгүй заалт нь ямар нэг байдлаар Гэрээний бусад заалтад нөлөөлөхгүй.

15.14. Талуудын хооронд энэхүү Гэрээний зүйлтэй холбоотой асуудлаар өмнө нь хэлэлцэгдэж байсан хэлцэл, харилцан ойлголцлын санамж бичиг, урьдчилсан нөхцөлүүд, Гэрээ болон бусад хэлэлцээр (Бичгээр болон амаар хийгдсэн эсэхээс үл хамааран бүх харилцаа холбоог үүнд хамаарууллна) байгаа бол тэдгээрийг энэхүү Гэрээ бусад хэлэлцээрийн баримт бичгийн хамт орлох бөгөөд энэхүү Гэрээ нь (аливаа нэмэлт өөрчлөлт болон бусад Хэлэлцээрийн баримт бичгийн хамт) үүний дагуу зохицуулагдаж буй асуудлын хувьд талуудын хооронд хийгдсэн цорын ганц нэгдмэл гэрээнд тооцогдоно.

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947
7239689 ХНТ10470

УЛААНБААТАР ХОТ
ТӨРИЙН БОГД КАПИТАЛ УЦК ХХК

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. **Худалдах хөрөнгө, түүнд хамаарах эрхүүд**

   1.1. Хэлцэл биелэх өдрийн байдлаар Зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдэл нь энэхүү Гэрээний тусгай нөхцөлийн 2.1-д заасан үнийн дүнтэй тэнцэх хэмжээний Хөрөнгө болон түүнд холбогдох эрхүүдийг хамтад нь худалдана.

   1.2. Хөрөнгө болон түүнд холбогдох эрхүүд гэдэгт дор дурдсан эрхийг ойлгоно.

   1.2.1. Хөрөнгийн жагсаалтад тусгагдсан зээлийн хувьд зээлдүүлэгчийн авлагын болон бусад бүхий л эрхүүд;

   1.2.2. Зээлтэй холбоотойгоор болон гэрээний биелэлтийг хангах зорилгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эдлэх бүхий л эрхийг эдэлж, эрх бүхий байгууллага, гуравдагч этгээд, зээлдэгч болон хамтран зээлдэгч, холбоотой бусад этгээдэд холбогдуулан шаардлага гаргах эрх, шүүх, арбитрт хандан нэхэмжлэл гаргах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрх.

2. **Хэлцэл биелэх үнэ**

   2.1. Хэлцэл биелэх өдрийн байдлаар хэлцэл биелэх үнэ нь **40,000,000,000.00 (дөчин тэрбум)** төгрөг байна.

   2.2. Энэхүү дүн нь НӨАТ-гүй дүн байх бөгөөд Монгол Улсын Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.14-т заасны дагуу НӨАТ-аас чөлөөлөгдөнө.

3. **Хэлцэл биелэх өдөр**

   3.1. Талууд Анхдагч зах зээлийн арилжаа хийгдэж **40,000,000,000.00 (дөчин тэрбум)** төгрөг бүтэн түүнээс дээш дүнгээр хөрөнгө оруулалтыг татан төвлөрүүлсэн өдрийг хэлцэл биелэх өдрөөр тогтооно.

   3.2. Хэрэв Анхдагч зах зээлийн арилжааны хугацаа дуусахад Анхдагч зах зээлийн арилжаа **40,000,000,000.00 (дөчин тэрбум)** төгрөгт хүрээгүй тохиолдолд талууд уг хугацааг харилцан тохиролцож сунгаж болно.

4. **Хөрөнгөд тавигдах шаардлага**

   4.1. Хэлцэл биелэх өдрийн байдлаар Хөрөнгө нь Шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан байна.

   4.2. Хэлцэл биелэх өдрийн байдлаар энэхүү Гэрээний дагуу худалдах, худалдан авах Хөрөнгийн багц дахь Зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдлийн нийлбэр нь энэхүү Гэрээний тусгай нөхцөлийн 2.1-д заасан үнийн дүнтэй тэнцүү байна.

5. **Хөрөнгө шилжүүлэх**

   5.1. Хэлцэл биелэх өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан гэрээний хавсралт №1-д заасан жагсаалтын дагуу хөрөнгийн багцын бүртгэлийг Үнэт цаас гаргагчид бүрэн шилжүүлнэ.

   5.2. Зээлийн бүртгэлийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч болон Үнэт цаас гаргагч тус бүр хөтлөх бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь өөрийн бусад зээлээс салгаж тусад нь бүртгэлийг хөтөлнө.

6. **Гэрээний үнийг төлөх дансны мэдээлэл**

   6.1. Үнэт цаас гаргагч нь гэрээний төлбөрийг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн М банкны

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЭК ХХК
9026040947
7239689 ХИТ10470

9002734745 тоот "Очир Үндраа ОМЗ ББСБ" ХХК нэртэй данснад шилжүүлнэ.

7. **Хөрөнгө солих үндэслэл**

7.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд тухайн хөрөнгийг Шаардлага хангахгүй хөрөнгөд тооцож, Гэрээний туслай нөхцөлийн 4 дүгээр зүйлд заасан шаардлага хангасан өөр хөрөнгөөр солих замаар багцаас хасна. Үүнд:

7.1.1. Зээлдэгчийн хүсэлтээр тухайн зээлийн гэрээнд өөрчлөлт оруулсан нь үнэт цаас эзэмшигчдэд төлөх ХБҮЦ-ны төлбөрийн нөхцөлд нөлөөлөхүйц байна гэж ТЗК-иас үзсэн;

7.1.2. Багц дахь хөрөнгө нь энэхүү Гэрээний хавсралт №2-т заасан Шалгуур үзүүлэлтийг хангахгүй болсон;

7.1.3. Хөрөнгийн багцын шалгуур үзүүлэлттэй холбоотойгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн энэхүү Гэрээнд заасан аль нэг мэдэгдэл, баталгаа зөрчигдсөн;

7.1.4. Зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь 90-ээс дээш хоног хэтэрсэн, эсхүл Зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь 30 хоногоос дээш хэтэрсэн бөгөөд цаашид зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болох нь үндэслэл бүхий бол.

7.2. Хөрөнгийн багц солихтой холбоотой харилцаанд ТЗК-ийн ТУЗ-аас батлагдсан "Хөрөнгө интэмжлэн удирдах журам"-ыг баримтална.

8. **Хөрөнгө нэмж худалдан авах үндэслэл:**

8.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд багцын хөрөнгийг нэмэгдүүлнэ. Үүнд:

8.1.1. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 32.1-д заасан шаардлагыг хангахгүй буюу ХБҮЦ-ны хөрөнгийн багцаас орох орлого нь ХБҮЦ-ны төлбөрийн үүргийг гүйцэтгэж хүрэхгүй болсон;

8.1.2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 15.3.2-д заасны дагуу ТЗК нь нээлттэй гаргах нөхцөлийн дагуу нэмэлт ХБҮЦ гаргахаар болсон;

8.1.3. Хөрөнгө интэмжлэн удирдагч нь багцын өгөөжийг нэмэгдүүлэх, төлбөрийн тасалдал үүсэхээс урьдчилсан сэргийлэх зорилгоор хөрөнгө оруулагчдын ашиг сонирхолд нийцүүлэн үнэт цаас эзэмшигчдэд төлөх ХБҮЦ-ны төлбөрөөс бусад сул мөнгөн дүнгээр багц худалдан авах боломжтой гэж үзсэн, зээлийн багц худалдан авах талаар Анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй харилцан тохиролцсон;

8.1.4. Хууль буюу гэрээнд заасан бусад.

8.2. Хөрөнгийн багцыг нэмэгдүүлэх, нэмж худалдан авахтай холбоотой харилцаанд ТЗК-ийн ТУЗ-аас батлагдсан "Хөрөнгө интэмжлэн удирдах журам"-ыг баримтална.

9. **Хөрөнгийн багцыг бүхэлд нь худалдах нөхцөл:**

9.1. Анхны үүрэг гүйцэтгэгч нь дор дурдсан үндэслэл бий болсон тохиолдолд багцын хөрөнгийг бүхэлд нь худалдан авна. Үүнд:

9.1.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэхүү Гэрээнд заасны дагуу шаардлага хангахгүй хөрөнгийг бүхэлд нь солих хөрөнгийн жагсаалтыг ТЗК-д гарган өгөх боломжгүй, эсхүл гарган өгсөн жагсаалт нь шаардлага хангахгүй тохиолдолд солих боломжгүй хөрөнгийн багцын хэмжээгээр;

9.1.2. Хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн 20 ба түүнээс дээш хувь нь 90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн тохиолдолд;

9.1.3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.11.5-д заасан нөхцөл байдал үүссэн бөгөөд талууд харилцан тохиролцсон тохиолдолд.

10. **Хөрөнгийн багц шилжүүлэх акт**

10.1. Хэлцэл биелэх үнийг төлсөн өдөр ББСБ нь Зээлийн данс бүртгэлийг ТЗК-д шилжүүлж, Хөрөнгийн багцыг хүлээлгэн өгөх актыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Үнэт цаас гаргагч нар нь Хөрөнгө интэмжлэн удирдагч болон Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэгчийг оролцуулан үйлдэнэ.

11

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040
723968 10470

УЛААНБААТАР ХОТ
ГАЗАР БОГД КАПИТАЛ ҮЦК ХХК

10.2. Энэ Гэрээний ерөнхий нөхцөлийн 9 дүгээр зүйлд зааснаар Хөрөнгийн багцыг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид бүрдэн хуваалдах тохиолдолд Хөрөнгө итгэмжлэн удирдагч, Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэгч нар Хөрөнгийн багц хүлээлгэн өгөх актыг Үнэт цаас гаргагч, Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийг оролцуулан үйлдэнэ.

10.3. Энэ Гэрээний ерөнхий нөхцөлийн 8 дугаар зүйлд заасны дагуу Хөрөнгийн багцад өөрчлөлт оруулах тохиолдолд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Хөрөнгийн багц шилжүүлэх актыг үйлдэж, Хөрөнгийн багцыг шилжүүлэх бөгөөд энэ тухай Үнэт цаас гаргагч болон Үйлчилгээ үзүүлэгчид тус тус мэдэгдэнэ.

10.4. Энэ Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлд заасны дагуу Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үйлчилгээ үзүүлэгчийн үүргийг гүйцэтгэх гул тусгай нөхцөлийн 10.3-т зааснаар мэдэгдэхгүй байж болно.

11. Хөрөнгөтэй холбоотой баталгаа

11.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь хөрөнгөтэй холбоотой дараах баталгааг Үнэт цаас гаргагчид гаргаж байна. Үүнд:

11.1.1. Хөрөнгийн багц дахь хөрөнгө нэг бүр нь халшгүй биелэх өдрийн байдлаар хавсралтад заасан Шалгуур үзүүлэлтийг хангасан болно.

11.1.2. Энэ гэрээ болон түүнд хавсаргасан мэдээллүүд нь /гэрээ болон хавсралтад заасан хөрөнгө, тэдгээрийн шалгуур үзүүлэлтүүд, тэдгээртэй холбоотой баримт бичиг мэдээлэл/ үнэн зөв болно.

11.1.3. Хөрөнгө Үнэт цаас гаргагчид бүрэн шилжихэд ямар нэгэн хязгаарлалт байхгүй болно.

11.1.4. Хөрөнгийн багц дахь хөрөнгөтэй холбоотой Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс зээлдэгчид төлөх аливаа өр төлбөр, Зээлийн гэрээнд зааснаас бусад нэмэлт үүрэг байхгүй болно.

11.1.5. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Зээлдэгч, Зээлдэгчийн хамаарал бүхий этгээдтэй холбоотой аливаа маргаан, гомдол, нэхэмжлэл, дампуурлын хэрэг зэргийн талаар мэдэгдэл, мэдээлэл авагүй болно.

11.1.6. Хөрөнгийн багц дахь зээлтэй холбоотой аливаа шүүхийн маргаан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэгүй болно.

11.1.7. Хөрөнгөтэй холбоотой Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эрх хэрэгжих нөхцөл, эрхийн хүчин төгөлдөр байдал нь гэрээний хугацаанд бүрэн хангагдсан болно.

11.1.8. Зээлдэгч нь хөрөнгөтэй холбоотой аливаа үүргээ Хэлцэл биелэх өдөр хүртэл хэрэгжүүлж биелүүлсэн байх, үүргийн зөрчил бий болсон тохиолдолд уг зөрчлийг арилгасан, ийнхүү арилгасан зөрчлийг Хөрөнгө итгэмжлэн удирдагч болон аудитор шалгаж баталгаажуулах бүрэн боломжтой.

11.1.9. Хөрөнгийн багц дахь зээлийн баримт бичгүүд болон Зээлийн даяс бүртгэл нь зохих ёсоор бүртгэгдэн бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн эзэмшилд байгаа. Хэлцэл биелэх өдрийн байдлаар зээл бүрийн бичиг баримт, даяс бүртгэл бүрэн гүйцэд бөгөөд шинэчлэгдэж үнэт цаас гаргагчид шилжихэд бэлэн байгаа болно.

12. Үнэт цаас гаргагчид гаргасан баталгаа

12.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Үнэт цаас гаргагчид дараах баталгааг өөрийн үйл ажиллагаатай холбогдуулан гаргаж байна. Үүнд:

12.1.1. Энэхүү гэрээ болон ХБҮЦ гаргахтай холбоотой бусад холбогдох гэрээ хэлцэл түүний дотор үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулах эрх зүйн бүрэн чадамжтай бөгөөд здгээр гэрээ хэлцлийг байгуулснаар бусад гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээ болон эрх бүхий байгууллагын шийдвэр хууль тогтоомжийг зөрчөөгүй болно.

12.1.2. ББСБ нь энэ гэрээ болон бусад гэрээг байгуулах, гэрээний дагуу хөрөнгө шилжүүлэх, барьцаалах болон бусад үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүхий л баттэл ажлыг бүрэн хангаж, холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдсөн болно.

12.1.3. ТЗК-д хуваалдсан хөрөнгийн эрхийг Үнэт цаас гаргагчид шилжүүлэхэд ямар нэгэн зөрчилгүй бөгөөд тухайн эрх шилжүүлэлтийг бүртгүүлэх, дуусгавар болгоход

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК

аливаа хязгаарлалт байхгүй болно.

12.1.4. Хөрөнгийн багц дахь зээл бүртэй холбоотойгоор Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс зээлдэгч болон бусад этгээдэд төлөх ор төлбөр байхгүй бөгөөд сарын хураарьт төлбөртэй холбоотойгоор Зээлдэгчээс суутгал хийх эрх үүсэхгүй болно.

13. Гэрээний зөрчил

13.1. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн гаргасан дараах үйлдэл, эс үйлдэхүйг ноцтой зөрчил гэж үзнэ. Үүнд:

13.1.1. ББСБ-ын гаргасан аливаа баталгаа, мэдэгдэл, гэрээнд хавсаргасан аливаа баримт бичгүүд, түүнчлэн энэхүү гэрээ хэрэгжих явцад Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс үүрэг гүйцэтгүүлэгчид гаргаж өгсөн аливаа баталгаа, мэдэгдэл, тайлан мэдээлэл зөрөг нь худал, алдаатай байх;

13.1.2. ББСБ-аас энэ гэрээний хөрөнгө солих зохицуулалтын хүрээнд ТЗК-д сольж өгсөн өрлуулах хөрөнгө нь шаардлага хангахгүй хууль болон эрх бүхий байгууллага, Үнэт цаас гаргагчаас баталсан журамд нийцээгүй байх;

13.1.3. ББСБ нь энэ гэрээнд заасан хөрөнгө сольж өгөх болон бусдаан худалдан авах үүргээ биелүүлэхгүй байх;

13.1.4. ББСБ-ийн ТЗК-д худалдсанаас бусад зээлийн багц байхгүй болсон.

13.1.5. ББСБ төлбөрийн чадваргүй болсон, татан буулгах ажиллагаа хийгдэж эхэлсэн болон дампуурлын хэрэг үүсгэсэн;

13.2. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зөрчил нь энэхүү Гэрээний 13.1.1 - 13.1.5-д зааснаас бусад зөрчил байх тохиолдолд Үнэт цаас гаргагч нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид бичгээр мэдэгдэл өгч ажлын 5 хоногт багтаан зөрчлийг арилгахыг шаардах бөгөөд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь энэ хугацаанд багтаан уг зөрчлийг арилгах үүрэг хүлээнэ.

14. Нууц мэдээлэл

14.1. ХБҮЦ гаргах ажиллагаа болон Хөрөнгө шилжүүлэх үйл ажиллагаатай холбоотой аливаа мэдээлэл, хөрөнгийн багц болон түүний зээл, барьцаатай холбоотой зээлдэгч болон шаардлага гаргах эрхтэй гуравдагч этгээд, ТЗК, ББСБ-тай холбоотой аливаа мэдээлэл, Үнэт цаас гаргагчийн гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээ хэлцэл, техникийн болон тэдгээрээс авч буй үйлчилгээтэй холбоотой аливаа мэдээлэл, Санхүүгийн нөхцөл байдлын тухай аливаа мэдээлэл, санхүүгийн тайлан, зах зээлийн судалгаа, хуулийн этгээдийн бүртгэл болон үүсгэн байгуулах үндэслэл баримт бичиг, дүрэм журам, шийдвэр, бодлого, гэрээ хэлцэл эдгээрт заасан нөхцөл, мэдээлэл, тоон үзүүлэлт, зураг график зэргийг нууц мэдээлэлд тооцно.

14.2. Дээр дурдсан нууц мэдээлэл гэдэгт нийтэд ил болгосон, эсхүл ХБҮЦ гаргах ажиллагааны хүрээнд Үнэт цаасны танилцуулгад тусгаж олон нийтэд танилцуулагдах болон холбогдох хууль журмын дагуу тодорхой этгээдүүдэд танилцуулах мэдээлэл хамаарахгүй болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

АНХНЫ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГҮҮЛЭГЧ:	ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ:
"ОЧИР УНДРАА ОМЗ ББСБ" ХХК	"ОЧУН АКТИВ НЭГ ТЗК" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ	БОЛООЛОН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙНДӨРГӨ
Г.ЦОГТГЭРЭЛ	Г.ЦОГТГЭРЭЛ

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ТАВАН БОГД КАПИТАЛ ТЗК ХХК

8.10. Зээлийн багцын жагсаалт

Хавсралт хуудсын, хуудсын овог гарчиг хавсралт №1

	ДАНСНЫ ДУГААР	ВАЛЮТ	ОЛГОСОН ОГНОО	ДУУСАХ ОГНОО	ХАРИЛЦАГЧ	РД	АНСИЛАЛТ	ОЛГОСОН ДҮН	ҮЛДСЭН ЗЭЭЛ	БАРЬЦАА ХӨРӨНГИЙН НИЙТ ДҮН	БАРЬЦААД ТӨРӨЛ
1	11101301107005104	MNT	2024-08-01 00:00:00	2027-08-01 00:00:00	ГАНТӨГӨ ДАГСАМБҮҮ	АА84041115	1 - Хэвийн	11,000,000.00	6,983,511.77	180,000,000	ҮХХ
2	11101301107005951	MNT	2024-11-03 00:00:00	2027-12-03 00:00:00	ЭНХБАТАР БАЯДАА	ПН86103026	1 - Хэвийн	61,000,000.00	90,602,990.86	105,000,000	ҮХХ
3	11101301107006604	MNT	2024-12-24 00:00:00	2027-12-12 00:00:00	ЭНХТӨР ГАНБОЛД	ВЛ90068273	1 - Хэвийн	50,000,000.00	37,706,871.39	124,000,000	ҮХХ
4	11101301107006659	MNT	2025-04-22 00:00:00	2028-04-20 00:00:00	БАЯРМАА БАНГАА	НМ83080117	1 - Хэвийн	15,000,000.00	12,722,442.12	150,000,000	ҮХХ
5	11101301080000383	MNT	2020-05-26 00:00:00	2026-09-20 00:00:00	ГАНБААТАР ГЭНДЭН	ТВ70050910	1 - Хэвийн	300,000,000.00	74,139,319.06	321,200,000	ҮХХ
6	11101301080004475	MNT	2020-10-03 00:00:00	2026-10-03 00:00:00	СОЛОНГО ЧОЙЖИЛ	ЛЮ62062869	1 - Хэвийн	80,000,000.00	25,780,653.73	716,500,000	ҮХХ
7	11101301080004950	MNT	2024-02-09 00:00:00	2027-02-07 00:00:00	ЧИНГИС ОЛГОНЦЭЦЭГ	УУ89012055	1 - Хэвийн	75,000,000.00	37,166,295.06	107,500,000	ҮХХ
8	11101301080005537	MNT	2025-04-11 00:00:00	2028-04-10 00:00:00	ГАН-ЭРДЭНЭ ЗАЯА	ВЛ93033811	1 - Хэвийн	200,000,000.00	187,535,893.76	295,716,000	ҮХХ
9	11101301080005679	MNT	2025-07-08 00:00:00	2028-06-25 00:00:00	БАЯРМАГНАЙ ГӨРЭНТЭЭМАА	УС72101208	1 - Хэвийн	60,000,000.00	52,605,617.23	206,000,000	ҮХХ
10	11101301080005686	MNT	2025-07-25 00:00:00	2028-07-28 00:00:00	ТУМЕНБАЯР АЛЕКСАНДР	НЦ83053678	1 - Хэвийн	50,000,000.00	47,328,639.18	150,000,000	ҮХХ
11	11101301080006052	MNT	2025-09-04 00:00:00	2030-09-02 00:00:00	НЯМДАГВАР ЯНЖААТАР	УЦ96082575	1 - Хэвийн	150,000,000.00	145,998,997.24	275,000,000	ҮХХ
12	11101301080006617	MNT	2025-12-12 00:00:00	2026-12-09 00:00:00	ЦЭГЭЛДЭРЭЛ ДАШЗЭВЭГ	УВ86012628	1 - Хэвийн	5,000,000.00	4,695,212.26	100,000,000	ҮХХ
13	11101301080006653	MNT	2026-01-06 00:00:00	2027-12-25 00:00:00	ГАЙТАВ НЯМХАЛ	ЦД81081218	1 - Хэвийн	10,000,000.00	9,599,890.81	23,800,000	ҮХХ
14	11101301080006666	MNT	2026-01-28 00:00:00	2031-01-22 00:00:00	САЙНСАНАА АНХБАЯР	УЗ95051765	1 - Хэвийн	50,000,000.00	50,000,000.00	192,000,000	ҮХХ
15	11101301080006933	MNT	2024-01-11 00:00:00	2027-11-20 00:00:00	АЛТАНСАГАНА ОСНОТСЭНҮҮР	УЮ01271372	1 - Хэвийн	85,000,000.00	28,051,113.87	85,500,000	ҮХХ
16	11101301080006992	MNT	2024-10-14 00:00:00	2027-10-10 00:00:00	НЯМДОРИЙ УЛАМБАЯР	ИТ04339268	1 - Хэвийн	16,000,000.00	7,269,338.94	16,000,000	ҮХХ
17	11101301080007426	MNT	2025-01-16 00:00:00	2028-01-03 00:00:00	БАДАМЦЭЦЭГ ТӨМӨРДОРЖ	ЦВ79082860	1 - Хэвийн	15,000,000.00	11,490,596.26	46,000,000	ҮХХ
18	11101301080007440	MNT	2025-01-07 00:00:00	2028-02-06 00:00:00	ХҮРЭЛБАТЫН ЗАЛУУДАЛ	ЧЦ86080536	1 - Хэвийн	20,000,000.00	14,291,789.37	124,000,000	ҮХХ
19	11101301080007443	MNT	2025-01-17 00:00:00	2027-02-17 00:00:00	БАЯТАРЧУУ ПҮРЭЭЖ	ИМ81047611	1 - Хэвийн	18,000,000.00	12,262,589.99	56,000,000	ҮХХ
20	11101301080007461	MNT	2025-04-25 00:00:00	2028-04-25 00:00:00	АЛТАНОЛОГ БАТЖАРГАЛУУ	ЖЛ77082615	1 - Хэвийн	25,000,000.00	21,075,123.42	25,000,000	ҮХХ
21	11101301080007465	MNT	2025-04-30 00:00:00	2028-04-10 00:00:00	УУГАНБААТАР БАЯРБАДРАХ	НЦ67100512	1 - Хэвийн	15,000,000.00	12,214,572.45	43,500,000	ҮХХ
22	11101301080007468	MNT	2025-05-06 00:00:00	2028-04-20 00:00:00	ОЮУ ХАНГАРАЛ	УЗ68127709	1 - Хэвийн	25,000,000.00	19,810,752.42	26,000,000	ҮХХ
23	11101301080007857	MNT	2025-08-20 00:00:00	2028-08-10 00:00:00	БАТ-ЭРДЭНЭ-СҮРЭН	ПВ82110776	1 - Хэвийн	25,000,000.00	22,177,456.40	28,800,000	ҮХХ
24	11101301080007675	MNT	2025-10-15 00:00:00	2028-10-10 00:00:00	БАТЖИНГЭЦЭЦЭГ ЧЛАНГУУ	ЧЕ86071961	1 - Хэвийн	20,000,000.00	18,677,983.84	26,500,000	ҮХХ
25	11101301108000198	MNT	2025-05-01 00:00:00	2028-04-29 00:00:00	БАЯРАА ЛХАГВАСҮРЭН	ВЦ89093013	1 - Хэвийн	96,000,000.00	90,489,122.60	67,000,000	ҮХХ
26	11101301108000201	MNT	2025-05-15 00:00:00	2027-05-15 00:00:00	ЭМИНЖАРГАЛ БАТЖИГИТ	ЙЛ82010102	1 - Хэвийн	70,000,000.00	52,545,961.18	77,500,000	ҮХХ
27	11101301108000212	MNT	2025-08-29 00:00:00	2028-08-25 00:00:00	ЧОЙНЯМ ЛАНДАН	НВ96010135	1 - Хэвийн	25,000,000.00	22,992,179.56	35,000,000	ҮХХ
28	11101301108000214	MNT	2025-09-16 00:00:00	2029-08-25 00:00:00	БАРИАС ЦЭВЭГМАА	ИЖ73122637	1 - Хэвийн	30,000,000.00	28,084,192.86	31,000,000	ҮХХ
29	11101301108000220	MNT	2025-11-20 00:00:00	2026-11-19 00:00:00	БАСТАС ЮЛИЙ ЭНЕРЖИ	7005745	1 - Хэвийн	63,000,000.00	58,311,911.68	52,500,000	ҮХХ
30	11101301110003199	MNT	2023-01-23 00:00:00	2027-01-21 00:00:00	ДЭЛГЭРБАТ ӨҮРЭНТОГОО	ЦД86082365	1 - Хэвийн	27,500,000.00	10,608,429.78	33,500,000	Автомашин
31	11101301110003217	MNT	2023-01-27 00:00:00	2027-01-20 00:00:00	ГАНДОРИЖ УРАН	СЭ83020410	1 - Хэвийн	15,750,000.00	6,335,173.09	22,500,000	Автомашин
32	11101301110003256	MNT	2023-02-04 00:00:00	2027-02-04 00:00:00	НЯМРАГЧАА СҮМБЭРБАЗАР	ЕМ88092515	1 - Хэвийн	21,000,000.00	5,286,595.55	30,000,000	Автомашин
33	11101301110003274	MNT	2023-02-08 00:00:00	2027-02-08 00:00:00	БАЯРЦОГЗОЛ ӨНӨӨ	УИ98063037	1 - Хэвийн	22,000,000.00	9,228,915.09	31,500,000	Автомашин
Хуулийн хөндлөнгийн шинжилгээ хийхдээ сонгогдсон зээлийн дансны зээлийн хувийн хэрэг, түүнд агуулагдсан ББСБ-ын дотоод мэдээлэл, дүгнэлт, шийдвэр, бусад нотлох баримт, үйл баримтыг хуулийн 12 шалгуур үзүүлэлтүүд болон хуулийн хөндлөнгийн шинжилгээний хүрээнд шалгах 37 асуудал бүхий асуултуудын дагуу шалгах, үнэлэх замаар санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон Зээлийн данснуудын материалыг ББСБ-аас

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947
7239689 ХНТ10070

цахимаар хүлээн авч Хуулийн фирм нь оорийн байранд бичлэн гүйцэтгэсэн

1.3. Дүн шинжилгээ хийсэн арга зүй

Холбогдох хууль тогтоомж болон ББСБ-ын дотооддоо дагаж мөрдөх дүрэм журам, үнэт цаас гаргагчаас тогтоосон хуулийн 12 шалгуур үзүүлэлтийг үндэслэн хуулийн хэлтэсийн шинжилгээний хүрээнд шалгах асуудал, асуултуудыг боловсруулж бэлтгэсэн. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, СЗХ-ны 2022.06.22-ны өдрийн 360 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тустай зөвшөөрөл олгох журам"-ын хүрээнд сонгогдсон 108 зээлийг шалгасан болно. Дүн шинжилгээ хийж дуусгаад зөрчилтэй буюу анхаарах шаардлагатай гэж үзсэн зээлүүдийн жагсаалтыг ББСБ руу илгээж, эдгээртэй холбоотой тайлбар, нэмэлт баримтыг хүлээн авч, тухай бүр нь цахим шуудангаар харилцаж, утсаар холбогдож ажиллаа.

1.4. Тайлан гаргахад үндэслэл болгон ашигласан эх сурвалжийн жагсаалт

Сонгогдсон зээлүүдийн хувийн хэрэгт байгаа баримт материалууд болон ББСБ-аас ирүүлсэн тайлбар, баримтуудыг шалгаж энэхүү Тайланг гаргалаа.

Тайланг гаргахдаа дараах эрх зүйн эх сурвалжийг үндэслэл болголоо. Үүнд:

Хууль тогтоомж:

- Иргэний хууль (2002);
- Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль (2021),
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль (2018)
- Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль (2010);
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль (2010);
- Зээлийн мэдээллийн тухай хууль (2011);
- Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай (2015);
- Санхүүгийн зохицуулах хорооноос батлагдсан Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тустай зөвшөөрөл олгох журам (2022);
- Бусад холбогдох хууль тогтоомж.

1.5. Хангагдсанд тооцох нөхцөл

Энэхүү Тайланг боловсруулахдаа бид дараах нөхцөл хангагдсан гэж үзсэн болно. Үүнд:

1. Бидний судлан шинжилсэн бүх баримт бичгийн хуулбар, эсхүл маягтууд нь үнэн зөв, эх хувиас хуулбарласан, тэдгээр дээрх гэмдэгтийн хураамжийн төлбөр нь төлөгдсөн гэсэн гэмдэглэгээ болон бусад аливаа гэмдэглэгээ, гарын үсэг, тамга тэмдэг нь үнэн.
2. Бүх баримт бичгүүд нь тэдгээрийг үйлдсэн талуудын бүрэн эрхийн хүрээнд үйлдэгдсэн бөгөөд, одоо хүчин төгөлдөр байгаа, цаашид хүчин төгөлдөр хэвээр байх бөгөөд тухайн баримт бичгийн дагуу талуудын хүлээсэн үүрэг нь холбогдох хууль тогтоомжийн хүрээнд бүрэн хүчин төгөлдөр хэрэгжинэ.
3. Бидэнд өгсөн аливаа баримт бичгийн хуулбар нь тухайн баримт бичгийн эх хувьтайгаа нийцсэн бөгөөд тэдгээрийг бүрэн хуулбарласан, цаашид ямар нэгэн өөрчлөлт оруулгүйгээр хүчин төгөлдөр хэрэгжинэ.
4. Зээлийн хувийн хэрэгт авагдсан зээлийн гэрээ, барьцааны гэрээ, фидуцийн гэрээ, үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ нь Анхны үүрэг гүйцэтгүүлэгчид эх хувиар хадгалагдаж байгаа.
5. Тухайн баримт бичгүүд дээр шүүх, төрийн байгууллага болон бусад эрх бүхий байгууллагаас авах шаардлагатай зөвшөөрөл, батламжийг авсан, зохих шийдвэр гарсан, тэдгээр баримт бичгийг хүчин төгөлдөр болгоход шаардагдах аливаа бусад хэлцэл хийгдсэн, бусад баримт бичгүүд үйлдэгдсэн.
6. Зээлийн хувийн хэрэгт байгаа цахим үйлчилгээний нэгдсэн портал /e-mongolia.mn/-аас авсан лавлагаа, тодорхойлолтуудын нь үнэн зөв, хүчинтэй бөгөөд шаардлагатай зарим лавлагаа тодорхойлолтын төлбөр хураамж нь бүрэн төлөгдсөн.
7. ББСБ, түүний ажилтнуудаас аливаа хэлбэрээр хүлээн авсан аливаа мэдээлэл нь үнэн

УЛААНБААТАР ХОТ

ОЧУН АКТИВ НЭХ ТЭК ХХК

9026040947
7239689 Л. ХНТ10470934

зов, бодитой;

8. Зээлдэгчид зээл олгохын өмнө ББСБ нь барьцааны зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ, фидуцийн зүйл болох тээврийн хэрэгслийн гэрчилгээ, эсвэл гаалийн мэдүүлгийг авч танилцаж шалгасан.
9. Хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн үнийн дүнгийн нийлбэр нь үнэт цаасны төлбөрийн төлөгдөөгүй үнийн дүнгийн нийлбэрийн 110 хувиас багагүй байх шалгуур үзүүлэлт хангагдсан.
10. Хөрөнгийн багцад байгаа хөрөнгийн дундаж хүү үнэт цаасны хүүтэй тэнцүү буюу түүнээс их байх шалгуур үзүүлэлт хангагдсан.

Ажлын зохион байгуулалт, биелэлт:

Мэргэжилтний нэр	Хариуцсан ажил	Хугацаа	Биелэлт
М.Мөнхжаргал	Шинжилгээний багийг ахалсан. Холбогдох хууль тогтоомж, дүрэм журмуудыг судалж, эрх зүйн хэм хэмжээний түүвэр бэлтгэх	2026.02.03-09	Биелэгдсэн
М.Мөнхжаргал	Үйлчлүүлэгчээс тогтоосон хуулийн шалгуур үзүүлэлтийг хянаж, хөндлөнгийн шинжилгээний шалгах асуудал, асуултуудыг боловсруулж, шинжилгээний ажлын хүсэлт бэлдэх	2026.02.04-02.09	Биелэгдсэн
М.Мөнхжаргал	Зээлийн хөрөнгийн багцын нэгдсэн жагсаалт авч, санамсаргүй түүврийн аргаар зээлийн данснуудаас сонгох	2026.02.23-03.13	Биелэгдсэн
М.Мөнхжаргал Б.Эрдэнэмөнх Х.Билгүүн М.Ганзориг Б.Айдана Г.Долгөөн Б.Даваамягмар	Сонгогдсон зээлүүдийн материалуудад хуулийн хөндлөнгийн шинжилгээ хийх	2026.03.03-03.19	Биелэгдсэн
М.Мөнхжаргал Б.Айдана	Зөрчилтэй зээлүүдийг ББСБ-д мэдэгдэх, холбогдох тайлбар баримт хүлээн авах	2026.03.20-04.23	Биелэгдсэн
М.Мөнхжаргал Б.Айдана	Хуулийн хөндлөнгийн шинжилгээний тайлан боловсруулах, гаргах	2026.04.24-04.27	Биелэгдсэн

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НӨӨ ТЗК ХХК
9026040947
7239689 .Х. ХНТ 10479

2. ХУУЛИЙН ШАЛГУУР ХАНГАГДСАН ЭСЭХ ДҮГНЭЛТ

Шалгуур үзүүлэлт 1. Зээлийн гэрээ нь хуульд заасан шаардлагад нийцсэн, хүчин төгөлдөр, гэрээнд заасан үүрэг нь заавал биелэгдэх шинжтэй байх.

2.1 Иргэний хуулийн 451 дүгээр зүйлийн 451.2 дахь хэсэгт "Хуульд өөрөөр заагаагүй бол зээлийн гэрээг бичгээр хийнэ." гэж заасны дагуу зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээс зээлдэгчтэй байгуулсан зээл олгох гэрээ хэлцлүүд нь бичгээр байгуулагдсан байх шаардлагатай. Санамсаргүй түүврийн аргаар сонгосон 108 зээлийн хувийн хэрэгт байгаа зээлийн гэрээнүүд нь бүгд бичгээр байгуулагдсан байгаа тул Иргэний хуулийн 451.2-т заасан шаардлагад нийцсэн байна.

2.2 108 зээлийн хувьд зээлдэгч болон хамтран зээлдэгч нар нь өөрөө буюу хууль ёсны төлөөлүүлэгчээс олгосон итгэмжлэлийн дагуу төлөөлөгчөөр дамжуулан зээлийн гэрээнд гарын үсэг зурж, зээлдүүлэгчийн төлөөлөгч гарын үсэг зурж, хуулийн этгээдийн тэмдэг дарж, нотариатаар гэрчлүүлсэн байна.

2.3 Түүврээр шалгасан 108 зээлийн гэрээнүүд нь БЭБХЭМХМХШЗҮАтХ-ийн 20 дугаар зүйлд заасан шаардлагуудыг хангасан. Иргэний хуулийн 56 дугаар зүйлд заасан хүчин төгөлдөр бус байх нөхцөл байдалд хамаарахгүй байна. Иймд эдгээр дансны зээлийн гэрээнүүд хуульд заасан шаардлагад нийцсэн, хүчин төгөлдөр, гэрээнд заасан үүрэг нь заавал биелэгдэх шинжтэй байх шалгуурыг хангаж байна.

Шалгуур үзүүлэлт 2. Фидуцийн гэрээ нь хуульд заасан шаардлагад нийцсэн, хүчин төгөлдөр, гэрээнд заасан үүрэг нь заавал биелэгдэх шинжтэй байх.

2.4 Иргэний хуулийн 235 дугаар зүйлийн 235.5 дахь хэсэгт "Хуульд өөрөөр заагаагүй бол үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээг бичгээр хийнэ" гэж заасны дагуу фидуцийн гэрээг бичгээр байгуулах шаардлагатай. Санамсаргүй түүврийн аргаар сонгосон зээлүүдээс фидуци бүхий 90 зээл дээр Фудуцийн гэрээг бичгээр байгуулсан байгаа тул эдгээр фидуцийн гэрээнүүд нь Иргэний хуулийн 235.5-д заасан шаардлагад нийцсэн байна.

2.5 Фидуцийн гэрээнүүдэд хувьд үүрэг гүйцэтгүүлэгч болон үүрэг хүлээгч нар нь гарын үсэг зурж, хуулийн этгээдийн тэмдэг дарж, нотариатаар гэрчлүүлсэн байна. Иргэний хуулийн 56 дугаар зүйлд заасан хүчин төгөлдөр бус байх нөхцөл байдал эдгээр фидуцийн гэрээнүүдэд хамаарахгүй байна.

Иймд фидуцийн гэрээ нь хуульд заасан шаардлагад нийцсэн, хүчин төгөлдөр, гэрээнд заасан үүрэг нь заавал биелэгдэх шинжтэй байх шалгуурыг хангаж байна.

Шалгуур үзүүлэлт 3. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээ нь хуульд заасан шаардлагад нийцсэн, хүчин төгөлдөр, гэрээнд заасан үүрэг нь заавал биелэгдэх шинжтэй байх.

2.6 Иргэний хуулийн 156 дугаар зүйлийн 156.1 дэх хэсэгт "Барьцааны гэрээг бичгээр байгуулна." гэж заасны дагуу үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээг бичгээр байгуулах шаардлагатай. Санамсаргүй түүврийн аргаар сонгосон зээлүүдээс үл хөдлөх эд хөрөнгийн барьцаа бүхий 18 зээл дээр барьцааны гэрээг бичгээр байгуулсан байгаа тул эдгээр гэрээнүүд нь Иргэний хуулийн 156.1-д заасан шаардлагад нийцсэн байна.

2.7 Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээнүүдэд барьцаалагч болон барьцаалуулагч нар нь гарын үсэг зурж, хуулийн этгээдийн тэмдэг дарж, нотариатаар гэрчлүүлсэн байна. Иргэний хуулийн 56 дугаар зүйлд заасан хүчин төгөлдөр бус байх нөхцөл байдал эдгээр гэрээнүүдэд хамаарахгүй байна.

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947
7239689 ХНТ10470

Иймд үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээ нь хуульд заасан шаардлагад нийцсэн, хүчин төгөлдөр, гэрээнд заасан үүрэг нь заавал биелэгдэх шинжтэй байх шалгуурыг хангаж байна.

Шалгуур үзүүлэлт 4. Хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээ нь хуульд заасан шаардлагад нийцсэн, хүчин төгөлдөр, гэрээнд заасан үүрэг нь заавал биелэгдэх шинжтэй байх.

2.8. Иргэний хуулийн 156 дугаар зүйлийн 156.1 дэх хэсэгт "Барьцааны гэрээг бичгээр байгуулна." гэж заасны дагуу хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээг бичгээр байгуулах шаардлагатай. Санамсаргүй түүврийн аргаар сонгосон зээлүүдээс хөдлөх эд хөрөнгийн барьцаа бүхий 2 зээл дээр барьцааны гэрээг бичгээр байгуулсан байгаа тул эдгээр гэрээнүүд нь Иргэний хуулийн 156.1-д заасан шаардлагад нийцсэн байна.

2.9. Хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээнүүдэд барьцаалагч болон барьцаалуулагч нар нь гарын үсэг зурж, хуулийн этгээдийн тэмдэг дарсан байна. Иргэний хуулийн 56 дугаар зүйлд заасан хүчин төгөлдөр бус байх нөхцөл байдал эдгээр гэрээнүүдэд хамаарахгүй байна.

Иймд хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээ нь хуульд заасан шаардлагад нийцсэн, хүчин төгөлдөр, гэрээнд заасан үүрэг нь заавал биелэгдэх шинжтэй байх шалгуурыг хангаж байна.

Шалгуур үзүүлэлт 5. Зээлийн, фидуцийн, хөдлөх ба үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн дотоодоо мөрдөг холбогдох журмын дагуу байгуулсан байх, зээлийн хувийн хэрэг нээж, зохих ёсоор зээлийн хувийн хэргийн бүрдүүлбэрийг хангасан байх.

2.10. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн дотоодоо мөрдөг холбогдох журмын заалтуудыг хуулийн шаардлагын шалгах асуултууд болгон задалж анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс зээлийн, фидуцийн, хөдлөх ба үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээг ердийн практикт мөрдөг бүх дүрэм журмын дагуу байгуулсан эсэхийг зээлийн хувийн хэрэгт байгаа холбогдох баримт бичгүүдийн хүрээнд шалгалаа.

2.11. БЭБХЭМХМХШЗҮАтХ-ийн 19 дүгээр зүйлд зээл олгох үйл ажиллагаа ямар шат дараалалтай, ямар стандарт, журмын дагуу явуулахыг хуульчилсан байдаг ба анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зээл олгох үйл ажиллагаа нь зээлдэгчийн хүсэлтийн дагуу зээл олгох эсэх талаар судалгааг хийж, зээлийн хорооны шийдвэрээр зээлийг олгох эсэхээ шийдэж, зээлийг олгож байгаа нь хуулийн дээрх шаардлага болон холбогдох журам, стандартын дагуу олгосон байна.

2.12. Мөн БЭБХЭМХМХШЗҮАтХ-ийн 22 дугаар зүйлд зээлийн хувийн хэрэг нь 9 төрлийн бүрдүүлбэртэй байхаар хуульчилсан бөгөөд түүвэрлэгдэн сонгогдсон 108 зээлийн материалуудад зээлдэгчийн зээл хүссэн өргөдөл, зээлийн гэрээ, фидуцийн гэрээ, зээлдэгчийн орлогын мэдээлэл, ӨОХ-г нотолсон баримт, зээлийн олгох эсэхийг шийдвэрлэсэн зээлийн хорооны шийдвэр, зээлийн ашиглалтыг шалгасан баримт бүхэу автомашины тээврийн хэрэгслийг гэрчилгээний хуулбар, ЗМС-ын лавлагаа зэрэг дээрх хуулийн заалтад заасан бүрдүүлбэрүүдийг бүрэн хангасан байна.

Иймд сонгогдсон зээлүүд нь зээлийг холбогдох журмын дагуу үүсгэсэн байх бөгөөд зээлийн, фидуцийн, хөдлөх ба үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн дотоодоо мөрдөг холбогдох журмын дагуу байгуулсан байх, зээлийн хувийн хэрэг нээж, зохих ёсоор зээлийн хувийн хэргийн бүрдүүлбэрийг хангасан гэж дүгнэлээ.

11

УЛААНБААТАР ХОТ
ӨВӨРХАНГАЙ КАПИТАЛ
ӨВӨР БОГД КАПИТАЛ ҮЦК ХХК
ШТК0128 5469112 9021061377

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭХ ТЗК ХХК
9026040947 7239689 ХНТ10670

Шалгуур үзүүлэлт 6. Фидуцийн гэрээний дагуу автомашиныг анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлсэн байх, холбогдох бүртгэлийг хийлгэсэн байх, барьцаалсан хөдлөх эд хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг тэргүүн ээлжинд хангуулах боломжтой байх.

2.13. Фидуцийн гэрээний хувьд фидуцийн зүйл болох автомашиныг Зээлдүүлэгч өмчилж буй боловч автомашиныг Зээлдэгч бодитоор эзэмшиж ашиглаж байна. Энэ нь Монгол Улсын замын хөдөлгөөний дүрмийн 3.1, Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 8-д зааснаар механикжсан тээврийн хэрэгслийн жолооч нь тухайн тээврийн хэрэгслийн бүртгэлийн гэрчилгээтэй байх бя тээврийн хэрэгслийн гэрчилгээ холбогдох бусад баримт бичгийн хамт тээврийн хэрэгслийг жолоодох зохицуулалттай тул тээврийн хэрэгслийн гэрчилгээг эх хувиар нь хадгалах боломжгүй байдаг онцлогтой.

2.14. Зээлийн гэрээний харилцаа буюу түүнтэй холбоотойгоор үүсгэсэн фидуцийн харилцаа нь тухайн үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг ашиглахад Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ердийн практикт мөрддөг бүх дүрэм журмын дагуу үүссэн байна. Тухайлбал, фидуцийн зүйл болох тээврийн хэрэгслүүд нь үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжсэн байгаа нь үүргийн гүйцэтгэлийг фидуцийн зүйлээр хангуулах нөхцөлийг бүрдүүлж байна.

2.15. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн Зээлийн үйл ажиллагааны журмын 8.1.6.1-д зааснаар фидуцийн гэрээний дагуу фидуцийн зүйл болох автомашиныг анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлсэн эсэх, холбогдох бүртгэлийг хийлгэсэн эсэхийг шалгахад түүврээр сонгогдсон зээлүүдийн хувьд фидуцийн гэрээний дагуу автомашиныг анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлсэн байх, холбогдох бүртгэлийг хийлгэсэн байх, барьцаалсан хөдлөх эд хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг тэргүүн ээлжинд хангуулах боломжтой байх шалгуурыг хангаж байна.

Дүн шинжилгээнд хамрагдсан нийт 108 зээлийн хувьд холбогдох зээлийн гэрээний харилцаа буюу түүнтэй холбоотойгоор үүсгэсэн фидуци нь үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргаар баталгаажсан, үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргаар хамгаалагдаагүй аливаа бусад шаардлагаас давуу, зохих ёсоор үүсгэгдэж хүчин төгөлдөр болсон бөгөөд тухайн үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг үүсгэхэд болон хүчин төгөлдөр болгоход Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн ердийн практикт мөрддөг бүх дүрэм журмыг дагаж мөрдсөн гэж дүгнэж байна.

Шалгуур үзүүлэлт 7. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээг улсын бүртгэлд бүртгүүлсэн байх, барьцаалсан үл хөдлөх эд хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг тэргүүн ээлжинд хангуулах боломжтой байх.

2.16. Үүрэг гүйцэтгүүлэгчийн хууль ёсны шаардлага, эрх, ашиг сонирхлыг хангах үүднээс, зээлдэгч болон хамтран зээлдэгч нар зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор, зайлшгүй биелүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үүднээс зээлдэгчтэй байгуулах зээлийн гэрээнд үүргийн гүйцэтгэлийг хангах арга (барьцаа, фидуци, баталгаа, батлан даалт зэрэг)-ыг ашиглах нь Иргэний хуулийн 231 дугаар зүйлд заасантай нийцнэ. Түүнчлэн Иргэний хуулийн 153 дугаар зүйлийн 153.1 дэх хэсэгт заасны дагуу барьцаалагч буюу үүрэг гүйцэтгүүлэгч нь бусад үүрэг гүйцэтгүүлэгчдээс тэргүүн ээлжинд барьцааны зүйлийн үнээс шаардлагаа хангуулах эрхийг баталгаажуулсан байх шаардлагатай.

2.17. Түүврээр сонгогдсон 108 зээлээс үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан 18 зээлийн хувьд үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээг бичгээр байгуулж, гэрээнд талуудын нэр, оршин суугаа газар, барьцаагаар хангагдах шаардлага, шаардлагын хэмжээ,

ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЭК ХХК

барьцааны зүйл, түүний байгаа газар, харилцан тохиролцсон үнийг тус тус заасан байна. Улмаар уг гэрээг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлсэн байгаа нь Иргэний хуулийн 156.1, 156.2 166.1, ҮХЭХБтХ-ийн 12.1-д тус тус заасан шаардлагыг хангаж байна. Түүнчлэн зээлдэгч нартай байгуулсан Зээлийн гэрээний 7.2 дахь хэсэгт "Зээлийн гэрээний хугацаа дуусахад зээлдэгч зээл, хүүгийн төлбөрийг бүрэн төлөөгүй буюу энэхүү гэрээний 6.2, 6.3-д заасан үндэслэлээр хугацаанаас өмнө гэрээ цуцлагдсан тохиолдолд ББСБ энэ гэрээний салшгүй хэсэг болох Барьцааны гэрээ, Фидуцийн гэрээ болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээр хангуулна.", Барьцааны гэрээний 3.5 дахь хэсэгт "Барьцаагаар хангагдах шаардлага үүссэн тохиолдолд зээлийн гэрээний үүргийг хангуулахаар барьцааны зүйлийг эзэмших эрхийг барьцаалагчид шилжүүлэх, худалдан борлуулах ажиллагааг гэрээнд зааснаар хуульд нийцүүлэн гүйцэтгэхийг хүлээн зөвшөөрч байна." гэж тус тус заах байдлаар барьцаа хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хангуулах эрхийг баталгаажуулсан байна.

Иймд үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээг улсын бүртгэлд бүртгүүлсэн байх, барьцаалсан үл хөдлөх эд хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг тэргүүн зэрэгт хангуулах боломжтой байх шаардлагыг хангасан гэж дүгнэлээ.

Шаардлага үзүүлэлт 8. Фидуцийн зүйл, үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээний барьцаа хөрөнгө нь хуульд заасны дагуу төлбөр гаргуулж болохгүй эд хөрөнгө биш байх.

2.18. ХЭХБЭБХБтХ-ийн 7.2-д "Хуульд заасны дагуу төлбөр гаргуулж болохгүй хөдлөх эд хөрөнгө болон бусдын өмчлөлд шилжүүлж үл болох эрх барьцааны зүйл байж болохгүй." гэж заасан. Үүрэг гүйцэтгүүлэгчийн зээлдэгч, хамтран зээлдэгч нартай байгуулсан фидуцийн болон хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээ нь хуульд заасан шаардлагад нийцэж байгаа бөгөөд Фидуцийн зүйл, барьцаа хөрөнгө нь хуульд заасны дагуу төлбөр гаргуулж болохгүй эд хөрөнгө биш болох нь холбогдох гэрээнүүд болон хөдлөх эд хөрөнгийн жагсаалт, тээврийн хэрэгслийн гэрчилгээ зэрэг баримтуудаар нотлогдож байна.

2.19. Иргэний хуулийн 154.1-д зааснаар үл хөдлөх эд хөрөнгө нь барьцааны зүйл болох бөгөөд үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан 18 зээл нь бүгд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн үл хөдлөх эд хөрөнгүүд барьцаалсан байх тул хуульд заасны дагуу төлбөр гаргуулж болох эд хөрөнгө байна.

Иймд фидуцийн зүйл, үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээний барьцаа хөрөнгө нь хуульд заасны дагуу төлбөр гаргуулж болохгүй эд хөрөнгө биш байх шаардлагыг хангасан байна.

Шаардлага үзүүлэлт 9. Тасалбар болгох өдрийн байдлаар зээлийн гэрээ, фидуцийн гэрээ, хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээний үүрэг дуусгавар болоогүй, үүрэг гүйцэтгэгчийн хувьд аливаа сөрөг шаардлага гаргаагүй, эсхүл эдгээр гэрээг цуцлах хүсэл зоригийг илэрхийлээгүй байх

2.20. Түүврээр сонгосон 108 зээлийн данснуудын зээлийн гэрээ, фидуцийн гэрээ, хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээнд тусгасан үүрэг гэрээний хугацаанаас өмнө дуусгавар болох, үүрэг гүйцэтгэгчийн хувьд аливаа сөрөг шаардлага гаргах, эсхүл эдгээр гэрээг цуцлах хүсэл зоригийг илэрхийлсэн эсэх талаар шалгаж үзлээ.

2.21. Түүврээр сонгосон 108 зээлийн хувьд 7 зээл нь 2023 онд, 38 зээл нь 2024 онд, 52 нь 2025 онд, 11 зээл нь 2026 онд тус тус олгогдсон зээлүүд байсан. Зээлийн

УЛААНБААТАР ХОТ
ТҮВАН БОГД КАПИТАЛ ҮЦК ХХК
ШТН0120 5469112 9021061377

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ ХӨГ ТЗК ХХК
9026040047 7239689 ХНТ10470

материалуудыг 2026.03.03-ны өдрөөс эхлэн хүлээн авсны дараа зээл шалгах явцад нийт 15 зээлийн төлбөрийг зээлдэгч нар нь бүрэн төлж зээлийг хаасан тухай ББСБ-аас бидэнд мэдэгдсэн. Иймхүү эдгээр 15 зээлийн хувьд зээлийн гэрээ, фидуцийн гэрээ, хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээний үүрэг бүгд дуусгавар болсон байна. Харин үлдсэн 93 зээлийн гэрээний хугацааны хувьд 2026 оны 9-12 сард 7 зээлийн хугацаа дуусахаар байна. Бусад 86 зээлийн гэрээний хугацаа нь 2027-2032 онд дуусахаар байна.

2.22. Мөн хуулийн фирмд анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс ирүүлсэн баталгаагаар багцад орсон нийт зээлүүд нь өмнө нь ХБҮЦ-ны өөр багцад орж байгаагүй, барьцаалагдаагүй, худалдагдаагүй гэдгээ мэдэгдсэн болно.

2.23. Хуулийн фирмийн зүгээс санамсаргүй түүврийн аргаар сонгосон 108 зээлийг судалж дууссаны дараа, ББСБ-аас 15 зээл бүрэн төлөгдөж хаагдсан талаар тайлбар баталгаа ирүүлсэн. БЭБХЭМХМХШЗҮАтХ-ийн 25.1 дэх хэсэгт "Зээлдэгч зээлийн гэрээгээр тохиролцсон хугацаанаас өмнө хэдийд ч зээлийн гэрээний үүргээ бүхэлд нь болон хэсэгчлэн гүйцэтгэж болно." гэж заасны дагуу зээлдэгч нь зээлийн гэрээний төлбөрийг урьдчилан төлөх эрхтэй болохыг дурдах нь зүйтэй.

Иймд түүврийн аргаар сонгогдсон 108 зээлээс 93 зээл нь тасалбар болгох өдрийн байдлаар зээлийн гэрээ, фидуцийн гэрээ, хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээний үүрэг дуусгавар болоогүй, үүрэг гүйцэтгэгчийн хувьд аливаа сөрөг шаардлага гаргаагүй, эсхүл эдгээр гэрээг цуцлах хүсэл зориг илэрхийлээгүй байх шалгуурыг хангасан гэж дүгнэлээ.

Шалгуур үзүүлэлт 10. Зээлдэгч нь эрх зүйн бүрэн чадамжтай байх

2.24. Монгол Улсын Иргэний хуулийн 15.1 дэх хэсэгт "Иргэний эрх зүйн бүрэн чадамж буюу иргэн өөрийн үйлдлээр өөртөө эрх олж авах, үүрэг бий болгох чадвар насанд хүрснээр буюу 18 наснаас бий болно." гэж заасны дагуу зээлдэгч болон хамтран зээлдэгч нар нь 18 насанд хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай болох нь зээлийн хувийн хэрэгт авагдсан зээлийн гэрээ, зээл хүсэгчийн анкет, зээлдэгчийн иргэний үнэмлэхийн лавлагаа зэрэг баримт бичгүүдээр нотлогдож байна.

2.25. Иргэний хуулийн 26.1-д "Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсч, хуульд заасан журмын дагуу татан буугдаж, улсын бүртгэлээс хасагдсанаар дуусгавар болно." гэж, ХЭУБтХ-ийн 5.1-д "Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар нь улсын бүртгэлд бүртгүүлснээр үүснэ." гэж тус тус заасны дагуу зээлдэгч хуулийн этгээд болох 3 хязгаарлагдмал хариуцлагатай компани нь улсын бүртгэлд бүртгэгдсэн болох нь эдгээр компаниудын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, улсын бүртгэлд бүртгэгдсэн дүрэм зэрэг баримтаар нотлогдож байна.

Иймд түүврийн аргаар сонгогдсон 108 зээлийн зээлдэгч нар нь эрх зүйн бүрэн чадамжтай байх шалгуурыг хангасан гэж дүгнэлээ.

Шалгуур үзүүлэлт 11. Хөрөнгийн багцад байгаа хөрөнгө нь үнэт цаас гаргагчийн эзэмшилд шилжих боломжтой бөгөөд эрхийн доголдолгүй байх

2.26. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зээлдэгч нартай байгуулсан зээлийн гэрээнүүдийн 5.1.12 заалтаар "Энэхүү гэрээний шаардах эрхийг гуравдагч этгээдэд шилжүүлэх, эрх шилжүүлсэнтэй холбоотойгоор Зээлдэгч, хамтран зээлдэгч, хамтран үүрэг гүйцэтгэгчийн холбогдох мэдээлэл, баримтыг гуравдагч талд шилжүүлэн өгөх" гэж зааж өгсөн байх бөгөөд энэ нь Иргэний хуулийн 123 дугаар зүйлтэй нийцэж байна.

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ ТЭЗ ТЗК ХХК
9026040947
7239689...1 ХНТ10470

2.27. Гүүврээр сонгосон 108 зээлээс 90 зээлийн хувьд Иргэний хуулийн 231.1.6 дахь заалтад заасан фидуцийн гэрээг байгуулсан байх бөгөөд зээлийн хөрөнгө болох автомашинуудын автотээврийн хэрэгслийн гэрчилгээнүүл нь анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн нэр дээр улсын бүртгэлд бүртгэгдсэн байна. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/222 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Авто тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам"-ын 4.1, 4.3-т зааснаар анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн хүсэлт зөвшөөрөлтэйгөөр бусдын өмчлөлд шилжих зохицуулалттай тул зээлийн хөрөнгө нь хууль зүйн хувьд анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн бүрэн өмчлөлд байна гэж үзлээ.

2.28. Харин үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан 18 зээлийн хувьд барьцааны гэрээг улсын бүртгэлд бүртгэж, үл хөдлөх эд хөрөнгүүд дээр анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн барьцааны эрх үүссэн байх тул хөрөнгийн багцад байгаа эдгээр хөрөнгийг үнэт цаас гаргагчийн эзэмшилд шилжих боломжтой бөгөөд эрхийн доголдолгүй хөрөнгө гэж үзнэ. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 14.4-д "Хөрөнгө нь үл хөдлөх эд хөрөнгийн барьцаатай бол баталгаат үнэт цаасны хөрөнгийн багцыг бүртгэсэн тухай Хороонд шийдвэрийг үндэслэн эрхийн улсын бүртгэлийн байгууллага улсын бүртгэлд барьцааны тухай тусгай тэмдэглэл хийнэ" гэж заасныг үндэслэн ХБҮЦ-ыг СЗХ-нд бүртгүүлсний дараа улсын бүртгэлд барьцааны тухай тусгай тэмдэглэл хийлгэхийг үнэт цаас гаргагчид анхааруулж байна.

Иймд хөрөнгийн багцад байгаа хөрөнгө нь үнэт цаас гаргагчийн эзэмшилд шилжих боломжтой бөгөөд эрхийн доголдолгүй байх шалгуурыг хангасан гэж дүгнэлээ.

Шалгуур үзүүлэлт 12. Зээлийн гэрээнд зааснаар зээлдэгчийн бичгээр гаргасан хүсэлтийн дагуу зээлийг зээлдэгч эсвэл хамтран зээлдэгчийн дансанд шилжүүлсэн байх, автомашины лизингийн зээлийн хувьд зээлдэгчийн худалдагч талын данс руу шилжүүлэхийг зөвшөөрсөн хүсэлтийг үндэслэн автомашин худалдагч тал руу худалдах, худалдан авах гэрээнд тусгагдсан банкны данс руу шилжүүлсэн байх

2.29. Гүүврээр сонгосон 108 зээлийг шалгахад зээлийн гэрээнд заасан зээлдэгчийн данс аль эсвэл автомашины лизингийн зээлийн хувьд зээлдэгчийн худалдагч талын данс руу шилжүүлэхийг зөвшөөрсөн хүсэлтийг үндэслэн автомашин худалдагч талын худалдах, худалдан авах гэрээнд тусгагдсан банкны данс руу зээлийг шилжүүлсэн баримт зээлийн хувийн хэрэгт бүрэн авагдсан байх шалгасан бүх зээл нь уг шалгуурыг хангасан гэж дүгнэлээ.

График 3. Санамсаргүй түүврийн аргаар сонгосон нийт зээлийн данснуудын хуулийн шаардлага үзүүлэлт хангасан байдал



УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026041094
7239689

3. НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

- Санамсаргүй түүврийн аргаар сонгосон 108 зээлд хуулийн хөндлөнгийн шинжилгээ хийхэд 108 зээл нь хуулийн шаардлагын бүх үзүүлэлтийг хангасан, үүнээс 15 зээл нь бүрэн төлөгдөж хаагдсан байна. Эдгээр зээлийн данснуудын мэдээллийг Хавсралт №1-ээс үзнэ үү.
- Хуулийн шинжилгээ хийх явцад зээлийн данс түүх бүр дээр илрүүлсэн зөрчил, алдааг тухай бүр нь ББСБ-д мэдэгдэж, алдааг засуулсан болно
- БЭБХЭМХМХШЗУАтХ-ийн 19.14 дэх хэсэгт "Зээлдэгч хуулийн этгээд нь олгосон зээлийг өөрийн санхүүгийн тайланд тусгаж, энэ талаарх мэдээллийг зээлүүлэгчид өгөх үүрэгтэй. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу эрх зүйн байдал нь тодорхойлогдсон этгээд хуулиар санхүүгийн тайлан гаргах үүрэг хүлээсэн бол түүнд энэ хэсэг нэгэн адил хамаарна." гэж заасны дагуу цаашид хуулийн этгээдэд олгосон зээлийг тухайн хуулийн этгээд өөрийн санхүүгийн тайланд тусгаж, энэ тухай зээлдүүлэгчид эргэж мэдээлэл ирүүлж байх тухай анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн зээлийн үйл ажиллагааны журамд нэмэлт өөрчлөлт оруулж, үүнийхээ дагуу зээлийг санхүүгийн тайланд тусгасан баримт мэдээллийг зээлийн хувийн хэрэгт хавсаргаж байхыг үүгээр зөвлөж байна.
- Фидуцийн гэрээний дагуу автомашины анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлсэн байх шаардлагатай тул ББСБ-ын өмчлөлд шилжүүлсэн автомашины тээврийн хэрэгслийн шинэ гэрчилгээг зээлийн хувийн хэрэгт заавал хавсаргаж байхыг зөвлөж байна.
- БЭБХЭМХМХШЗУАтХ-ийн 19.3, 19.8, 20.2.4, 22.5-д зүй зүйд заасныар зээлийн гэрээнд зээлийн зориулалтыг тодорхой бичиж тусгах шаардлагатай тул ББСБ-аас байгуулж буй зээлийн гэрээнд зээлийн зориулалтыг тодорхой тусгаж оруулах шаардлагатай. Ингэхдээ зориулалт нь "БУСАД" гэх мэтчилэн тодорхой бус байдлаар бичихгүйгээр зориулалтыг тодорхой ойлгомжтой байдлаар бичиж тусгаж байхыг ББСБ-д зөвлөж байна.

ХУУЛИЙН ХӨНДЛӨНГИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:

Өмгөөллийн "Эм Жэй Эл Атторнейс" ХХН-ийг төлөөлж
Удирдах партнер, Гүйцэтгэх захирал М МӨНХЖАРГАЛ

УЛААНБААТАР ХОТ
ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947
7239889 ХНТ10470

ХАВСРАЛТ

Хавсралт №1. ХУУЛИЙН ХӨНДЛӨНГИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН "ОЧИР УНДРАА ОМЗ ББСБ" ХХК-ИЙН ЗЭЭЛИЙН ДАНСНУУД

№	Зээлийн дансны дугаар	Шалгуур хангасан эсэх
1	1110130111005837	тийм
2	1110130111006097	тийм
3	1110130198000001	тийм
4	1110130111005302	тийм
5	1110130108000673	тийм
6	1110130198000003	тийм
7	1110130147001140	тийм
8	1110130108000425	тийм
9	1110130111004870	тийм
10	1110130111006120	тийм
11	1110130150000130	тийм
12	1110130131000340	тийм
13	1110130197000000	тийм
14	1110130109000400	тийм
15	1110130112001370	тийм
16	1110130111005490	тийм
17	1110130113000230	тийм
18	1110130147001290	тийм
19	1110130148000030	тийм
20	1110130150000170	тийм
21	1110130146000000	тийм
22	1110130147001210	тийм
23	1110130110000230	тийм
24	1110130111004410	тийм
25	1110130111004920	тийм
26	1110130111006128	тийм
27	1110130112001289	тийм
28	1110130147001275	тийм
29	1110130111005264	тийм
30	1110130111003254	тийм
31	1110130111005826	тийм
32	1110130111006121	тийм
33	1110130112001288	тийм
34	1110130147000724	тийм
35	1110130147000818	тийм
36	1110130147001105	тийм
37	1110130148000005	тийм
38	1110130189000016	тийм
39	1110130147000965	тийм
40	1110130147000997	тийм
41	1110130147001226	тийм
42	1110130148000006	тийм
43	1110130150000009	тийм
44	1110130151000009	тийм
45	1110130107000664	тийм
46	1110130110000194	тийм
47	1110130108000661	тийм
48	1110130111005915	тийм
49	1110130111006130	тийм
50	1110130112001277	тийм
51	1110130147000459	тийм
52	1110130193000005	тийм

17

УЛААНБААТАР ХОТ

ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК

53	11101301070000656	ТИЙМ
54	11101301080000665	ТИЙМ
55	11101301470000945	ТИЙМ
56	11101301110005151	ТИЙМ
57	11101301310000308	ТИЙМ
58	11101301110004327	ТИЙМ
59	11101301110005312	ТИЙМ
60	11101301110005584	ТИЙМ
61	11101301110005650	ТИЙМ
62	11101301110005787	ТИЙМ
63	11101301110005972	ТИЙМ
64	11101301110006080	ТИЙМ
65	11101301120001408	ТИЙМ
66	11101301110003943	ТИЙМ
67	11101301110004504	ТИЙМ
68	11101301110004991	ТИЙМ
69	11101301110005332	ТИЙМ
70	11101301110006060	ТИЙМ
71	11101301110006204	ТИЙМ
72	11101301470000771	ТИЙМ
73	11101301470001208	ТИЙМ
74	11101301470001293	ТИЙМ
75	11101301500000170	ТИЙМ
76	11101301510000642	ТИЙМ
77	11101301110005877	ТИЙМ
78	11101301110006052	ТИЙМ
79	11101301470000794	ТИЙМ
80	11101301470001214	ТИЙМ
81	11101301500000026	ТИЙМ
82	11101301510000625	ТИЙМ
83	11101301120001230	ТИЙМ
84	11101301970000002	ТИЙМ
85	11101301080000440	ТИЙМ
86	11101301110005958	ТИЙМ
87	11101301090000434	ТИЙМ
88	11101301110004615	ТИЙМ
89	11101301110004816	ТИЙМ
90	11101301110005481	ТИЙМ
91	11101301110005828	ТИЙМ
92	11101301110005322	ТИЙМ
93	11101301120001409	ТИЙМ
94	11101301080000668	ТИЙМ
95	11101301110006210	ТИЙМ
96	11101301130000197	ТИЙМ
97	11101301080000424	ТИЙМ
98	11101301130000240	ТИЙМ
99	11101301110004110	ТИЙМ
100	11101301110004440	ТИЙМ
101	11101301470000630	ТИЙМ
102	11101301470000460	ТИЙМ
103	11101301090000330	ТИЙМ
104	11101301110003210	ТИЙМ
105	11101301110003280	ТИЙМ
106	11101301110005110	ТИЙМ
107	11101301070000510	ТИЙМ
108	11101301130000190	ТИЙМ

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЭК ХХК

Хавсралт №2. "ХӨРӨНГИЙН БАГЦАД ТАВИГДАХ ХУУЛИЙН ШАЛГУУР"

1. Зээлийн гэрээ нь хуульд заасан шаардлагад нийцсэн, хүчин төгөлдөр, гэрээнд заасан үүрэг нь заавал биелэгдэх шинжтэй байх;
2. Фидуцийн гэрээ нь хуульд заасан шаардлагад нийцсэн, хүчин төгөлдөр, гэрээнд заасан үүрэг нь заавал биелэгдэх шинжтэй байх,
3. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээ нь хуульд заасан шаардлагад нийцсэн, хүчин төгөлдөр, гэрээнд заасан үүрэг нь заавал биелэгдэх шинжтэй байх;
4. Хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээ нь хуульд заасан шаардлагад нийцсэн, хүчин төгөлдөр, гэрээнд заасан үүрэг нь заавал биелэгдэх шинжтэй байх;
5. Зээлийн, фидуцийн, ходлох ба үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээг Анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн дотоодоо мөрдлөг холбогдох журмын дагуу байгуулсан байх, зээлийн хувийн хэрэг нээж, зохих ёсоор зээлийн хувийн хэргийн бүрдүүлбэрийг хангасан байх
6. Фидуцийн гэрээний дагуу автомашины анхны үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлсэн байх, холбогдох бүртгэлийг хийлгэсэн байх, барьцаалсан хөдлөх эд хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг тэргүүн ээлжинд хангуулах боломжтой байх;
7. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээг улсын бүртгэлд бүртгүүлсэн байх, барьцаалсан үл хөдлөх эд хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг тэргүүн ээлжинд хангуулах боломжтой байх;
8. Фидуцийн зүйл, үл хөдлөх болон ходлох эд хөрөнгийн барьцааны гэрээний барьцаа хөрөнгө нь хуульд заасны дагуу төлбөр гаргуулж болохгүй эд хөрөнгө биш байх;
9. Тасалбар болгох өдрийн байдлаар зээлийн гэрээ, фидуцийн гэрээ, хөдлөх болон үл ходлөх эд хөрөнгийн барьцааны гэрээний үүрэг дуусгавар болоогүй, үүрэг гүйцэтгэгчийн хувьд аливаа сөрөг шаардлага гаргаагүй, эсхүл эдгээр гэрээг цуцлах хүсэл зориг илэрхийлээгүй байх;
10. Зээлдэгч нь эрх зүйн бүрэн чадамжтай байх;
11. Хөрөнгийн багцад байгаа хөрөнгө нь үнэт цаас гаргагчийн эзэмшилд шилжих боломжтой бөгөөд эрхийн доголдолгүй байх,
12. Зээлийн гэрээнд зааснаар зээлдэгчийн бичгээр гаргасан хүсэлтийн дагуу зээлийг зээлдэгч эсвэл хамтран зээлдэгчийн дансанд шилжүүлсэн байх, автомашины лизингийн зээлийн хувьд зээлдэгчийн худалдагч талын данс руу шилжүүлэхийг зөвшөөрсөн хүсэлтийг үндэслэн автомашин худалдагч тал руу худалдах, худалдан авах гэрээнд тусгагдсан банкны данс руу шилжүүлсэн байх.

ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК

Хавсралт №3. "ХУУЛИЙН ХӨНДЛӨНГИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ШАЛГАХ АСУУДАЛ, АСУУЛТУУД"

А. Зээл олгох процесс ажиллагаа, зээлийн хувийн хэргийн шалгуур, олгосон зээлд хяналт тавих дотоодын журмын хэрэгжилт:

1) Зээлийн хувийн хэргийн бүрдүүлбэр шалгах хуудсыг бөглөж гарын үсэг зурсан эсэх
2) Зээлийн сангал шийдвэрлэлтийн хуудсыг үйлдэж, гарын үсэг зурсан эсэх
3) Зээлдэгчийн зээлийн мэдээллийн сангийн лавлагааг авсан эсэх /ЗМС-гийн лавлагааны хүчинтэй хугацаа 3 хоног байх ба зээлийн хүсэлт гаргасан өдөр лавлагад хүчинтэй байна/
4) Зээлдэгч иргэний зээл хүссэн өргөдөл, зээл хүсэгчийн анкет байгаа эсэх, гарын үсэг зурсан эсэх
5) Зээл хүсэгч хуулийн этгээд нь зээл авах хүсэлт, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг бичгээр гаргаж, гарын үсэг зурж тэмдэг дарсан эсэх (хувьцаа эзэмшигчдийн нэрийг дурдсэс тулгах. ТУЗ-ийн тогтоолтой бол дурмийг шалгах)
6) Зээл хүсэгчийн мэдээллийг ашиглах зөвшөөрлийн хуудас дээр мэдээллийн эзнээр гарын үсэг зурууласан эсэх
7) Зээлдэгчийн иргэний үнэмлэхийн лавлагаа, оршин суугаа хаягийн лавлагаа, шүүхийн шийдвэрээр буслад өр төлбөртэй эсэх лавлагааг тус тус авсан эсэх. Зээлдэгч хуулийн этгээдийн хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа, шүүхийн шийдвэрээр буслад өр төлбөртэй эсэх лавлагаа тус тус авсан эсэх
8) Бизнесийн үйл ажиллагаатай зээлийн хувьд зээл хүсэгчийн үйл ажиллагаатай танилцсан хуудас үйлдэж гарын үсэг зурсан эсэх
9) 100 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй зээлийн хувьд Эрсдлийн дүгнэлт, Хуулийн дүгнэлт гарсан эсэх
10) Зээлдэгчийн орлогыг нотлох баримт байгаа эсэх (НДШ төлөлтийн лавлагаа, QR кодтой банкны дансны хуулга, эсвэл банкны теллерийн тамгатай банкны дансны хуулга, эсвэл интернэт банкнаас хэвлэсэн бол хуулга дээр зээлийн мэргэжилтэн гарын үсэг зурсан байх гэх мэт)
11) Зээлдэгч хуулийн этгээд нь олгосон зээлийг өөрийн санхүүгийн тайланд тусгаж, энэ талаарх мэдээллийг зээлдүүлэгчид өгөх эсэх
12) Зээл олгохтой холбоотой баримт бичгүүдийн бүрдэл бүрэн хангагдсан зээлийн хувийн хэрэгтэй эсэх
13) 2025 оны 4 сараас өмнө олгосон бизнесийн зээлийн хувьд зээлдэгчийн үйл ажиллагаа явуулж буй салбарын нөхцөл байдал, санхүүгийн нөхцөл байдал, төлбөрийн чадварыг үзүүлэлтийг жилд нэг удаа хянаж баталгаажуулсан эсэх
14) Зээлийн гэрээний хугацаа нь 12 сараас дээш, 50 сая төгрөгөөс дээш дүнгээр 2025 оны 9 сараас өмнө бизнесийн зээл авсан зээлдэгчийн үйл ажиллагаанд эхний 6 сард нэг удаа, дараагийн жилд 1 удаа газар дээрх хяналт хийсэн эсэх, зээл хүсэгчийн үйл ажиллагаатай танилцсан хуудас үйлдсэн эсэх
15) 2025 оны 9 сараас өмнө олгосон бизнесийн зээлийн хувьд зээлийн үлдэгдэл 100-300 сая төгрөг хүртэл бол жилд нэг удаа, 300 сая төгрөгөөс дээш үлдэгдэлтэй бол хагас жилд нэг удаа санхүүгийн тайлангийн хяналт хийсэн эсэх

Б. Зээлийн гэрээтэй холбоотой шалгуур:

16) Зээлийн гэрээ нь Иргэнний хуулийн 451, 452, 453 дугаар зүйл, БЭБХЭМХМХШЗҮАтХ-ийн 20 дугаар зүйлд заасан шаардлагад нийцсэн эсэх, гэрээнд заасан үүрэг нь заавал биелэгдэх шинжтэй эсэх
17) Зээлийн гэрээ хүчин төгөлдөр эсэх, гэрээнд талууд буюу тэдгээрийн эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж тэмдэг дарсан эсэх, нотариатаар гэрчлүүлсэн эсэх, бусад этгээд төлөөлж гарын үсэг зурсан бол итгэмжлэл хуулийн шаардлага хангасан эсэх
18) Зээлийн гэрээнд зээлийн дүн, зориулалт, хугацаа, хүү, шимтгэл, эргэн төлөлтийн хуваарь тусгагдсан эсэх
19) Зээлдэгч иргэн 18 насанд хүрсэн эсэх

ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК

20) Зээлдэгч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ хүчинтэй эсэх, үйл ажиллагаа явуулах хугацаа болон түстэй эвлэлөөртийн хугацаа дууссан эсэх, зээл хүсэх үед үүсгэн байгуулагдаад 6 ба түүнээс дээш сар болсон байсан эсэх
21) Зээлийн хувийн хэрэг нь БЭБХЭМХТТЗҮАтХ-ийн 22 дугаар зүйлд заасан шаардлага хангаж байгаа эсэх
22) Зээлийн гэрээний шаардах эрхийг гуравдагч этгээдэд шилжүүлэх боломжтой байх
23) Зээлийн гэрээний үүрэг дуусгавар болоогүй, үүрэг гүйцэтгэгчийн хувьд аливаа өөрөг шаардлага гаргаагүй, эсүл эдгээр гэрээг цуцлах хүсэл зориг илэрхийлээгүй байх
24) Зээлийг зээлийн гэрээнд заасан хэмжээгээр зээлдэгчийн зээлийн дансанд шилжүүлсэн, эсүл зээлдэгч зээлийн дансаас зээлээ ашигласан эсэх /Зээлийн гэрээнд заасанаар зээлдэгчийн бичгээр гаргасан хүсэлтийн дагуу зээлийг зээлдэгч эсвэл хамтран зээлдэгчийн дансанд шилжүүлсэн эсэх, автомашины лизингийн зээлийн хувьд зээлдэгчийн худалдагч талын данс руу шилжүүлэхийг зөвшөөрсөн хүсэлтийг үндэслэн автомашин худалдагч тал руу худалдах, худалдан авах гэрээнд тусгагдсан банкны данс руу шилжүүлсэн эсэх/

Б. Фидуцийн зүйл, фидуцын гэрээ, барьцааны зүйл, барьцааны гэрээтэй холбоотой шаардлага:

25) Фидуцийн гэрээ нь Иргэний хуулийн 235 дугаар зүйлд нийцсэн эсэх, гэрээнд заасан үүрэг нь заавал биелэгдэх шинжтэй эсэх
26) Фидуцийн гэрээ хүчин төгөлдөр эсэх, үүрэг хүлээгч, үүрэг гүйцэтгүүлэгч нар гарын үсэг зурж тэмдэг дарсан эсэх, нотариатаар гэрчлүүлсэн эсэх, бусад этгээд төлөөлж гарын үсэг зурсан бол итгэмжлэл хуулийн шаардлага хангасан эсэх
27) Фидуцийн гэрээний дагуу фидуцийн зүйл болох автомашиныг анхны үүрэг гүйцэтгүүлэгч буюу зээлдүүлэгчийн өмчлөлд шилжүүлсэн эсэх, холбогдох бүртгэлийг хийлгэсэн эсэх
28) Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээ нь Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 11, 12 дугаар зүйлд заасан шаардлагад нийцсэн хүчин төгөлдөр эсэх, талууд гарын үсэг зурж тэмдэг дарсан эсэх, гэрээнд заасан үүрэг нь заавал биелэгдэх шинжтэй эсэх
29) Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээнд барьцаа хөрөнгийн нэр, эрхиулалт, байршил, улсын бүртгэлийн дугаар, гэрчилгээний дугаар, огноо, барьцаа хөрөнгийн харилцсан төхиролцсон үнэ, барьцаа хөрөнгийн давлагааны дугаар тусгагдсан эсэх
30) Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээг улсын бүртгэл бүртгүүлсэн эсэх, барьцаалсан үл хөдлөх эд хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг тэргүүн ээлжинд хангуулах боломжтой эсэх
31) Хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээ нь ХЭХБЭБХБтХ-ийн 10 дугаар зүйлд заасан шаардлагад нийцсэн хүчин төгөлдөр эсэх, талууд гарын үсэг зурж тэмдэг дарсан эсэх, гэрээнд заасан үүрэг нь заавал биелэгдэх шинжтэй эсэх
32) Хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээнд барьцаа хөрөнгийн нэр, тоо хэмжээ, баталгаат засварын хүчинтэй хугацаа, харилцан тохиролцсон үнэ тусгагдсан эсэх.
33) Хөдлөх эд хөрөнгийн барьцаат баталгаажуулсан эсэх /Барьцааны гэрээг улсын бүртгэлд бүртгүүлсэн эсэх эсвэл барьцаа зүйлийг барьцаалагчийн эзэмшилд шилжүүлсэн эсэх/, барьцаалсан хөдлөх эд хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг тэргүүн ээлжинд хангуулах боломжтой эсэх
34) Фидуцийн зүйл, барьцаалсан үл хөдлөх эд хөрөнгө буюу хөдлөх эд хөрөнгө нь хуульд заасны дагуу төлбөр гаргуулж болох эд хөрөнгө мөн эсэх, бист байдлын догдолдолгүй, шаардах эрхийн зөрчилгүй байх
35) Фидуцийн гэрээ, хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны гэрээний үүрэг дуусгавар болоогүй, үүрэг гүйцэтгэгчийн хувьд аливаа өөрөг шаардлага гаргаагүй, эсүл эдгээр гэрээг цуцлах хүсэл зориг илэрхийлээгүй байх
36) Барьцаа хөрөнгийн давлагаа авсан эсэх
37) Фидуцийн зүйл болох автомашин, барьцааны зүйл болох үл хөдлөх эд хөрөнгө, хөдлөх эд хөрөнгөтэй бичлэн танилцсан эсэх

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ ПЭГ ТЗК ХХК

8.18. Хуулийн дүгнэлт

MJL
ATTORNEYS

"ОЧУН АКТИВ НЭГ ТЗК" ХХК-ААС ГАРГАЖ БУЙ ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН БАТАЛГААТ ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНЫ ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ

Хэнд зориулж:	"ОЧУН АКТИВ НЭГ ТЗК" ХХК-д
Хаяг:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, 5-р хороолол /14252/, сөүлийн гудамж, 13а барилгын 12-р давхар
Утас/Факс:	(976) 99101389
Хаанаас:	Өмгөөллийн "Эм Жэй Эл Атторнейс" ХХН
Хаяг:	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Самбуугийн гудамж 13/02, Глобал Бизнес Центр, 503 тоот
Утас/Факс:	(976) 7012-9665

2026 он

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947
7239689 ХИТ10470

АГУУЛГА

НЭГ. ЕРӨНХИЙ ХЭСЭГ 2

1.1. Дүгнэлт гаргасан хуулийн фирм 2
1.2. Дүгнэлт гаргахад ашигласан эрх зүйн эх сурвалж 2
1.3. Шинжлэн судалсан баримт бичиг, материалын жагсаалт 3
1.4. Дүгнэлтийн хүрээ, хязгаарлалт 5
1.5. Товчилсон үгийн тайлбар 5

ХОЁР. ДҮГНЭЛТИЙН ХЭСЭГ 6

2.1. ТЗК-ийг үүсгэн байгуулах ажиллагаа болон түүнийг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн байдалд нь хууль тогтоомжид нийцсэн эсэх, гэрчилгээ, тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр эсэх. 6
А. ТЗК-ийн тухайд 6
Б. ТЗК-ийн үүсгэн байгуулагчийн тухайд 6
2.2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн эсэх 7
А. Үнэт цаас гаргах тухай шийдвэр, үйл ажиллагаа 7
Б. Үнэт цаасны танилцуулга 8
2.3. ТЗК-ийн дүрэм, үндсэн үйл ажиллагаанд ашиглагдах журмууд нь хууль тогтоомжид нийцсэн эсэх 11
А. ТЗК-ийн дүрэм, үндсэн үйл ажиллагаанд ашиглагдах журмууд 11
Б. Бусад тогтоол, шийдвэрүүд 12
2.4. Баталгаат үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээд бүрэн ажиллагаатай гүйцэтгүүлэгч, хадгалагчтай байгуулсан хөрөнгө шилжүүлэх, хадгалах, хадгалдан авах, үйлчилгээ үзүүлэх, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ, хэлцэл нь хууль тогтоомжид нийцсэн эсэх, хууль зүйн бодит хэлцлийн шаардлагыг хангаж буй эсэх 13
А. Хөрөнгө хадгалах, хадгалдан авах гэрээ 13
Б. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ 13
Г. Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ 14
Д. Үнэт цаасжуулалтын бусад гэрээ 15
2.5. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч нь хөрөнгө итгэмжлэн удирдагч, бусад оролцогчидтой ашиг сонирхлын зөрчилгүй эсэх 15
2.6. Хөрөнгийн багц дахь хөрөнгийн төрөл бүрээс хамааруулан санамсаргүй түүврийн аргаар сонгох замаар үнэт цаас гаргагчаас тогтоосон хууль зүйн шалгуур үзүүлэлт хангаж буй эсэх 16
2.7. Багцын хөрөнгөөс үүрэгийн гүйцэтгэлийг хангуулахтай холбогдох гэрээ, хэлцэл нь хууль тогтоомжид нийцсэн эсэх, гэрээ, хэлцэлд үүрэгийн гүйцэтгэлийн зүйлтэй холбоотой аливаа шаардах эрхийг шилжүүлэхгүй болон хэрэгжүүлэхгүй байхыг үүрэг болгосон, эсхүл шилжүүлэхийг хориглосон, хязгаарласан нөхцөл тустасан эсэх 16

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ ХӨГ
ТЗК ХХК
9026040947
7239689 ХНТ10470

УЛААНБААТАР ХОТ
ТӨВАН БОГД
КАПИТАЛ ҮЦК ХХК

MJL
ATTORNEYS

Чингэлтэй дүүрэг, 4-р хороо Самбуугийн
гудамж 13/02 Глобал Бизнес Центр, 503 тоот
Улаанбаатар хот, Монгол Улс
Утас: +(976) 7012-9665
И-мэйл: info@mjlattorneys.mn
Вэб: www.mjlattorneys.mn

Огноо: 2026.5.05

№: 26/29

"ОЧУН АКТИВ НЭГ ТЗК" ХХК-д

"ОЧУН АКТИВ НЭГ ТЗК" ХХК-ААС ГАРГАЖ БУЙ ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН БАТАЛГААТ ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААНЫ ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ

НЭГ. ЕРӨНХИЙ ХЭСЭГ

1.1. Дүгнэлт гаргасан хуулийн фирм

Өмгөөллийн "Эм Жэй Эл Атторнейс" ХХН ("Өмгөөллийн нөхөрлөл") нь дотоод болон гадаадын хуулийн этгээд, хувь хүнд бизнесийн аливаа асуудлаар хууль зүйн зөвлөгөө, үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлдэг өмгөөллийн нөхөрлөл бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хорооны 2015 оны 12 сарын 17-ны өдрийн 429 дүгээр тогтоолоор үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээр бүртгүүлсэн.

Энэхүү хууль зүйн дүгнэлтийг "Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК-тай 2026 оны 02 сарын 03-ны өдөр байгуулсан MJL-25359-C1 тоот "Хуулийн хөндлөнгийн шинжилгээ, хуулийн зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх гэрээ"-ний дагуу "Очун актив нэг ТЗК" ХХК ("Компани")-аас Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны хүрээнд Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 360 дугаар тогтоолоор батлагдсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам"-ын 10.4 дэх хэсэгт заасан 7 багц агуулгын хүрээнд гаргаж байна.

Өмгөөллийн нөхөрлөл нь үнэт цаас гаргагч, түүнийг үүсгэн байгуулагч, хөрөнгө итгэмжлэн удирдагч, андеррайтер болон санхүүгийн хөндлөнгийн шинжилгээ хийх компани болон тэдгээрийн эрх бүхий албан тушаалтнуудтай харилцан хамааралгүй, сонирхлын зөрчилгүй бөгөөд хөндлөнгийн этгээд мөн болно.

1.2. Дүгнэлт гаргахад ашигласан эрх зүйн эх сурвалж

1) Иргэний хууль;

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК

2) Компанийн тухай хууль;
3) Үнэт цаасны зах зээлийн тухай хууль;
4) Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль;
5) Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль;
6) Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль;
7) Санхүүгийн зохицуулах хорооны 2022.06.22-ны өдрийн 360 дугаар тогтоолоор батлагдсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам";
8) Хууль зүйн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 2013.07.25-ны өдрийн А/167/203 дугаар тушаалын хавералтаар батлагдсан "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөрөнгийн багцыг тусгай тэмдэглэл хийж бүртгэх тухай журам".

1.3. Шинжлэн судалсан баримт бичиг, материалын жагсаалт

Дараах баримт бичиг, материалыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шинжлэн судалж, энэхүү хууль зүйн дүгнэлтийг гаргалаа. Үүнд:

1) 2026.04.28-ны өдрийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны танилцуулга,
2) "Очун Актив Нэг ТЗК" ХХК-ийн дүрэм, гэрчилгээ;
3) "Очир Ундраа Холдинг" ХХК-ийн дүрэм, гэрчилгээ;
4) "Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК-ийн дүрэм, гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн гэрчилгээ;
5) "Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчийн 2025 оны 12-р сарын 18-ны өдрийн "Компани үүсгэн байгуулах тухай" 2025/98 дугаар шийдвэр;
6) "Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчийн 2025 оны 12-р сарын 18-ны өдрийн 2025/99 дугаар "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай" шийдвэр,
7) "Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчийн 2026 оны 3-р сарын 19-ний өдрийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай" 2026/10 тоот шийдвэр;
8) "Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчийн 2026 оны 3-р сарын 19-ний өдрийн "Тусгай зориулалттай компанийн зөвшөөрөл авах тухай" 2026/11 тоот шийдвэр;
9) "Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 10-р сарын 31-ний өдрийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай" 25/42 дугаар шийдвэр;
10) Санхүүгийн зохицуулах хорооны 2026 оны 03 сарын 26-ны өдрийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай" 84 дүгээр тогтоол;
11) "Очун Актив Нэг ТЗК" ХХК-ийн 2026.03.26-ны өдрийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, хавералтууд;
12) "Очун Актив Нэг" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 01-р сарын 29-ний өдрийн 26/04 дүгээр "Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих тухай журмыг батлах тухай" тогтоол;
13) "Очун Актив Нэг" ХХК-ийн "Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих тухай журам"

14) "Очун Актив Нэг" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 01-р сарын 29-ний өдрийн 26/05 дугаар "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журмыг батлах тухай" тогтоол;

15) "Очун Актив Нэг" ХХК-ийн "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам";

16) "Очун Актив Нэг" ХХК-ийн "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам";

17) "Очун Актив Нэг ТЗК" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 4-р сарын 20-ний өдрийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотой оролцогч талууд сонгох, холбогдох гэрээ болон журмыг батлах тухай" 2026/07 дугаар тогтоол;

18) "Очун Актив Нэг ТЗК" ХХК-ийн "Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам";

19) "Очун Актив Нэг ТЗК" ХХК-ийн "Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам";

20) "Очун Актив Нэг ТЗК" ХХК-ийн "Тусгай зориулалтын компанийг татан буулгах журам";

21) "Очун Актив Нэг ТЗК" ХХК-ийн "Үнэт цаасны төлбөр цуглуулах, төлбөр төлөх журам";

22) "Очун Актив Нэг ТЗК" ХХК-ийн "Хөрөнгө итгэмжлэн удирдах журам";

23) "Очин Актив нэг" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 01-р сарын 29-ний өдрийн 26/01 дүгээр "Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг томилох тухай" тогтоол;

24) "Очин Актив нэг" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 01-р сарын 29-ний өдрийн 26/02 дугаар "Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад нэр дэвшүүлэх тухай" тогтоол;

25) "Очин Актив нэг" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 01-р сарын 29-ний өдрийн 26/03 дугаар "Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох тухай" тогтоол;

26) "Очун Актив Нэг ТЗК" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 4-р сарын 20-ний өдрийн "Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийг батлах тухай" 2026/08 дугаар тогтоол;

27) "Очун Актив Нэг ТЗК" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 4-р сарын 20-ний өдрийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай" 2026/09 дугаар тогтоол;

28) "Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК ба "Очун Актив Нэг ТЗК" ХХК-ийн хооронд 2026.04.21-ний өдөр байгуулсан ОАН-2026-01 тоот "Хөрөнгө худалдах худалдан авах гэрээ";

29) "Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК ба "Очун Актив Нэг ТЗК" ХХК-ийн хооронд 2026.04.21-ний өдөр байгуулсан ОАН-2026-05 тоот "Фидуцийн барьцааны гэрээ";

30) "Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК ба "Очун Актив Нэг ТЗК" ХХК-ийн хооронд 2026.04.21-ний өдөр байгуулсан ОАН-2026-06 тоот "Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ";

31) "Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК, "Очун Актив Нэг ТЗК" ХХК болон "Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК-ийн хооронд байгуулсан ОАН-2026-04 тоот "Зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээ";

32) "Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК, "Очун Актив Нэг ТЗК" ХХК болон "Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК-ийн хооронд байгуулсан ОАН-2026-02 тоот "Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ";

УЛААНБААТАР ХОТ
ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947
7239689 .Х. ХНТ10470

33) Очун Актив Нэг ТЗК" ХХК болон "Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК-ийн хооронд байгуулсан ОАН-2026-03 тоот "Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ";

34) "Очун Актив Нэг ТЗК" ХХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн мэдээлэл, баримт бичиг

1.4. Дүгнэлтийн хүрээ, хязгаарлалт

1. Өмгөөллийн нөхөрлөл нь Компаниас ирүүлсэн баримт бичиг, материал, тэдгээрт агуулагдсан мэдээллийн хүрээнд энэхүү дүгнэлтийг гаргаж байгаа бөгөөд тэдгээр баримт бичгүүд нь үнэн зөв, хүчин төгөлдөр ба баримт бичгүүдэд зурагдсан гарын үсэг, дарагдсан тамга тэмдэг нь үнэн зөв, жинхэнэ бөгөөд эрх бүхий этгээдүүд үйлдсэн гэж үзсэн болно.
2. Энэхүү дүгнэлтийг зөвхөн хууль зүйн асуудлаар гаргаж байгаа ба аливаа тоон мэдээлэл, санхүүгийн тооцооллыг хамаарахгүй бөгөөд тэдгээрийн үнэн зөв байдлыг тогтоохгүй болно.
3. Энэхүү дүгнэлт гарсан өдрөөс хойш дүгнэлтэд ашигласан баримт бичиг, тэдгээрт агуулагдсан мэдээлэлд аливаа өөрчлөлт орсон бол үүнийг өмгөөллийн нөхөрлөл хариуцахгүй.
4. Хууль зүйн дүгнэлтийг зөвхөн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгүүлэх зорилгоор хийсэн ба Компани нь өөр бусад зорилгоор ашиглах, хэсэгчлэн эсхүл бүхэлд нь нийтэд дэлгэх, түгээх болон дүгнэлтэд өмгөөллийн нөхөрлөлийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөлт засвар оруулахыг хориглоно.
5. Компанийн зүгээс ач холбогдол бүхий баримт, мэдээллийг нуусан, орхигдуулсан, дүгнэлт гаргах явцад танилцуулаагүй, буруу, дутуу танилцуулсан нөхцөлд үүсэх асуудлаар өмгөөллийн нөхөрлөл хариуцлага хүлээхгүй болно.
6. Энэхүү дүгнэлт нь 2-т дурдсан Монгол Улсын хүчин төгөлдөр хууль тогтоомж, эрх зүйн актын хүрээнд хязгаарлагдаж байгаа болно.
7. Хөндлөнгийн хуулийн фирмийн хувьд мэдэх боломжгүй, үйлчлүүлэгчээс мэдэгдээгүй үлдээсэн бусад мэдээ, мэдээлэл байвал тийнхүү олж мэдээгүйгээс үүдэн гарах аливаа асуудалд хуулийн фирм хариуцлага хүлээхгүй.

1.5. Товчилсон үгийн тайлбар

СЗХ – Санхүүгийн зохицуулах хороо

ТЗК – Тусгай зориулалтын компани

ТУЗ – Төлөөлөн удирдах зөвлөл

ХИУ – Хөрөнгө итгэмжлэн удирдагч

ХБҮЦ – Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

ХБҮЦтХ – Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль

ХБҮЦГБТЗОЖ – Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох журам

ХЭУБ – Хуулийн этгээдийн улсын бүртгэл

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947
7239689 ..\. ХНТ10470

УЛААНБААТАР ХОТ
ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК ХХК

ХОЁР. ДҮГНЭЛТИЙН ХЭСЭГ

2.1. ТЗК-ийг үүсгэн байгуулах ажиллагаа болон түүнийг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн байдал нь хууль тогтоомжид нийцсэн эсэх, гэрчилгээ, тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр эсэх.

А. ТЗК-ийн тухайд

"Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2025 оны 12-р сарын 18-ны өдрийн "Компани үүсгэн байгуулах тухай" 2025/98 дугаар шийдвэрээр "Очун актив нэг" ХХК /Регистрийн дугаар: 7239689/-ийг үүсгэн байгуулж, 2026.01.23-ны өдөр ХЭУБ-д бүртгүүлсэн байна. Санхүүгийн зохицуулах Хорооны 2026 оны 3 сарын 26-ний өдрийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай" 84 дүгээр тогтоолоор тус компанид Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, ТЗ 315/84 дугаартай тусгай зөвшөөрлийн гэрчилгээ олгосон байх бөгөөд "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах" чиглэлийн үйл ажиллагааг хугацаагүй эрхлэн явуулахаар шийдвэр, дүрэмдээ тусгаж, ТЗК болж, компанийн дүрмийн шинэчилсэн хувилбарыг 2026 оны 4-р сарын 09-ний өдөр баталж, 2026 оны 4-р сарын 14-ны өдөр ХЭУБ-д бүртгүүлж, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлтийн тэмдэглэл хийлгэсэн байна. Тус компанийн Гүйцэтгэх захирлаар Ганбаатар овогтой Цогтгэрэлийг томилж, 2026 оны 01-р сарын 23-ны өдөр ХЭУБ-д бүртгүүлсэн байна. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 1,000,000 төгрөг байгаа ба нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 1,000 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэж, нийт хувьцааг "Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК бүхэлд нь эзэмшиж байна. Компанийн албан ёсны бүртгэлтэй хаяг нь Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, 5-р хороолол, Сөүлийн гудамж, 13-А барилгын 12 давхар байна.

Иргэний хуулийн 26.1-д "Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсч, хуульд заасан журмын дагуу татан буугдаж, улсын бүртгэлээс хасагдсанаар дуусгавар болно." гэж, ХЭУБтХ-ийн 5.1-д "Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар нь улсын бүртгэлд бүртгүүлснээр үүснэ." гэж тус тус заасны дагуу "Очун актив нэг ТЗК" ХХК-ийг ХЭУБ-д бүртгүүлсэн, гэрчилгээ хүчинтэй бөгөөд бүртгэл нь хүчин төгөлдөр байгаа тул ТЗК нь хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвартай байна. "Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2025 оны 12-р сарын 18-ны өдрийн "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох тухай" 2025/99 дүгээр шийдвэрээр "Очун актив нэг" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр Баярраа овогтой Баасандорж, Гэндэндаржаа овогтой Баянтуяа, ердийн гишүүнээр Ганбаатар овогтой Цогтгэрэл нарыг тус тус томилсон. Мөн "Очун актив нэг" ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 01 сарын 29-ний өдрийн "Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг томилох тухай" 26/01 тогтоолоор тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Ганбаатар овогтой Цогтгэрэлийг томилсон байна.

ТЗК-ийн дүрэм нь нийт 8 зүйлтэй байгаа уг дүрэм нь Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйл, ХБҮЦтХ-ийн 12 дугаар зүйлийн 12.9 дэх хэсэг, ХБҮЦГБТЗОЖ-ийн холбогдох зохицуулалттай нийцэж байна.

Б. ТЗК-ийн үүсгэн байгуулагчийн тухайд

"Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК /Регистрийн дугаар: 2734745/-ийн [illegible] компанийн хувьцаа эзэмшигч байгуулагчийн 2002.12.26-ны өдрийн 01 тоот шийдвэрээр анх үүсгэн байгуулж, 2007.11.13-

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947
7239689 ХНТ10470

ны өдөр ХЭУБ-д бүртгүүлсэн бүртгэлийн гэрчилгээг ирүүлсэн байна. Тус компани нь зээлийн үйл ажиллагаа эрхлэх, факторингийн үйлчилгээ үзүүлэх, гадаад валютын арилжааны,иттэлцлийн үйлчилгээ эрхлэх, цахим төлбөр тооцоо, мөнгөн гүйвуулга хийх, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх гэсэн 5 чиглэлийн үндсэн үйл ажиллагааг хугацаагүй эрхлэн явуулахаар дүрмэндээ тусгасан байгаа ба компанийн дүрмийг мөн ХЭУБ-д бүртгүүлсэн байна. Тус компанийн Гүйцэтгэх захирлаар Ганбаатар овогтой Цогтгэрэлийг томилж, 2018.03.28-ны өдөр ХЭУБ-д бүртгүүлсэн байна. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 5,000,000,000 (таван тэрбум) төгрөг байгаа ба нэг бүр нь 1,000,000 (нэг сая) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 5,000 (таван мянган) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэж, нийт хувьцааны 50%-ийг "Очир Ундраа Холдинг" ХХК, үлдсэн 50%-ийг Монгол улсын иргэн Тардай овогтой Гантөмөр эзэмшиж байна. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн нэгдсэн мэдээллээс харахад "Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК-ийн эцсийн өмчлөгчөөр Монгол улсын иргэн Тардай овогтой Гантөмөрийг 2024.04.15-ны өдөр бүртгэгдсэн байна.[1] Компанийн албан ёсны бүртгэлтэй хаяг нь Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, 5-р хороолол, Сөүлийн гудамж, 13А барилгын, 12 давхар байна.

Иргэний хуулийн 26.1-д "Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсч, хуульд заасан журмын дагуу татан буугдаж, улсын бүртгэлээс хасагдсанаар дуусгавар болно." гэж, ХЭУБтХ-ийн 5.1-д "Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар нь улсын бүртгэлд бүртгүүлснээр үүснэ." гэж тус тус заасны дагуу "Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК-ийг ХЭУБ-д бүртгүүлсэн, гэрчилгээ хүчинтэй бөгөөд бүртгэл нь хүчин төгөлдөр байгаа тул ТЗК-ийг үүсгэн байгуулагч нь хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвартай байна. Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 03-р сарын 13-ны өдрийн 639 дүгээр тогтоолоор тус компанид Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, ТЗ 101/128 дугаартай тусгай зөвшөөрлийн гэрчилгээ олгосон байх бөгөөд тус хорооны 2021 оны 07-р сарын 07-ны өдрийн 281 дүгээр тогтоолоор тус компанид Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх зөвшөөрөл олгож, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад тэмдэглэл үйлдсэн байна. Иймд тус компани нь ХБҮЦтХ-ийн 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэг болон ХБҮЦГБТЗОЖ-ийн холбогдох зохицуулалтын шаардлагыг хангасан ТЗК байгуулах эрхтэй компани байна. Тус компанийн дүрэм нь нийт 12 зүйлтэй байгаа ба дүрэм нь Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйл, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 10.1, ХБҮЦГБТЗОЖ-ийн холбогдох зохицуулалтад нийцэж байна.

Иймд ТЗК нь хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж бүртгэгдсэн, ТЗК-ийн үүсгэн байгуулагч нь хуульд заасан шаардлага хангасан, ТЗК-ийг үүсгэн байгуулах ажиллагаа болон түүнийг хуулийн этгээдийн бүртгэлд бүртгүүлсэн байдал нь хууль тогтоомжид нийцсэн, гэрчилгээ, тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр гэж дүгнэж байна.

2.2. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн эсэх

А. Үнэт цаас гаргах тухай шийдвэр, үйл ажиллагаа

"Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 10-р сарын 31-ний өдрийн 25/42 дугаар "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай" тогтоол, "Очун

[1] https://opendata.burtgel.gov.mn/desinfo/b0N1aHO0aHNYbjg2ZVJKSGhWZ2/pUT09Ojpjdjf02xx[illegible]pl7TkPV

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947
7239689 ᐧ.ᐧ ХНТ10476

ТАВАН БОГД КАПИТАЛ УЦК ХХК

Актив нэг" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчийн 2026 оны 3-р сарын 19-ны өдрийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай" 2026/10 дугаар тогтоол, "Очун актив нэг ТЗК" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 4-р сарын 20-ны өдрийн 2026/09 дүгээр "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай" тогтоолоор 40,000,000,000 (дөчин тэрбум) төгрөгийн нийт үнийн дүн бүхий нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 400,000 ширхэг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг Улаанбаатар үнэт цаасны бирж дээр нийтэд санал болгон гаргахаар тогтоосон байна. Эдгээр тогтоол, шийдвэрүүд нь Компанийн тухай хуулийн 76.1.5, 76.1.18 дахь заалт, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 7 дугаар зүйлтэй тус тус нийцэж байна.

"Очун Актив нэг ТЗК" ХХК нь тусгай зориулалтын компанийн статустайгаар хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахаар холбогдох зөвшөөрлийг авахаар явуулж байгаа үйл ажиллагаа нь ХБҮЦтХ-ийн 5.1, 11.1-д заасантай нийцэж байна. Үнэт цаас гаргагчаас гарган өгсөн мэдээллээр "Очун Актив Нэг ТЗК" ХХК-тай холбоотой дампуурлын хэрэг үүсгэх хүсэлт, нэхэмжлэл гараагүй, татан буулгах ажиллагаа явагдаагүй, эрх хүлээн авагч томилох тухай эрх бүхий байгууллагын шийдвэр гараагүй байгаа тул ХБҮЦтХ-ийн 5.4-т заасан нөхцөл байдал үүсээгүй байна. "Очун Актив Нэг ТЗК" ХХК нь зээлийн хөрөнгийн багцыг бүрдүүлж, хөрөнгийн жагсаалт гаргаж, үнэт цаасны танилцуулгаа бэлтгэж, хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ болон холбогдох бусад бичиг баримтын хамт бүрдүүлсэн байгаа ба эдгээртэй холбоотой явуулсан үйл ажиллагаа, үнэт цаас гаргахтай холбоотой шийдвэрүүд нь хууль нийцсэн, ХБҮЦтХ болон ХБҮЦГБТЗОЖ-ын хүрээнд байна.

Б. Үнэт цаасны танилцуулга

"Очун Актив Нэг ТЗК" ХХК-ийн Үнэт цаасны танилцуулгын "Үнэт цаасны товч танилцуулга" гэсэн хэсэгт Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны ерөнхий нөхцөлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Үнэт цаас гаргагч	"Очун Актив Нэг ТЗК" ХХК
Анхны үүрэг гүйцэтгүүлэгч	"Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК
Үнэт цаасны төрөл	Зээлийн багцын хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас
Үнэт цаасны нэгжийн нэрлэсэн үнэ	100,000 (Нэг зуун мянган) төгрөг
Үнэт цаасны тоо ширхэг	400,000 ширхэг хүртэл
Үнэт цаасны нийт үнийн дүн	40,000,000,000 (дөчин тэрбум) төгрөг
Үнэт цаасны хугацаа	24 сар
Үнэт цаасны хүү	19.5 % /жилийн/
Үнэт цаасны хүү төлөлт	Улирал тутам
Үнэт цаасны үндсэн төлбөрийн төлөлт	Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн өдрөөс хойш хагас жил тутам тэнцүү дүнгээр буюу 6 дахь сард 25%, 12 дахь сард 25%, 18 дахь сард 25%,

	24 дэх сард 25%.
Үнэт цаасны төлбөр төлөгдөх эх үүсвэр	Хөрөнгийн багц дахь зээлийн үндсэн төлбөр болон хүүний орлого
Үнэт цаасны хүүд ногдох татвар	Хүүний орлогын 5%
Үнэт цаасны хадгалалт	"Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК
Анхдагч зах зээлийн захиалга	Андеррайтер төвтэй

Үнэт цаасны танилцуулгын "Үнэт цаасны төвч танилцуулга" гэсэн хэсэгт зааснаар зээлийн хөрөнгийн багц нь дараах байдлатай байна. Үүнд:

Арилжаа эрхлэх байгууллага	Улаанбаатар Үнэт Цаасны Бирж
Арилжааны хэлбэр	Нээлттэй зах зээлд
Зээлийн багцын үнийн дүн	44,006,588,238
Зээлийн тоо	1,919 зээл
Зээлдэгчдийн тоо	1,885 зээлдэгч
Барьцаа	Барьцаат зээлийн багц, хэвлийн эргэн төлөлтийн данс
Зээлийн чанар	100% хэвийн
Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт	Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс зээлийн багц худалдан авахад зарцуулна. Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь зээлийн багц худалдсанаас хүлээн авах мөнгийг зээлийн багцыг нэмэгдүүлэхэд зарцуулна.

Үнэт цаасны танилцуулгын "Үнэт цаасны төвч танилцуулга" гэсэн хэсэгт зааснаар Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд дараах талууд оролцож байна. Үүнд:

Анхны үүрэг гүйцэтгүүлэгч / Үүсгэн байгуулагч	"Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК
Үндсэн андеррайтер	"Таван Богд Капитал ҮЦК" ХХК
Дэд андеррайтер	"Ти Ди Би Секьюритис ҮЦК" ХХК
Зээлийн шинжилгээ гаргагч	"Си Пи Ти Эй Аудит" ХХК

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК

Хуулийн фирм	"Өмгөөллийн Эм Жэй Эл Атторнейс" ХХН
Хөрөнгө итгэмжлэн удирдагч	"Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК

Үнэт цаасны танилцуулгад үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээ буюу автомашины фидуци болон үл хөдлөх эд хөрөнгийн барьцаа байхаар тодорхойлсон нь Иргэний хууль болон Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд тус тус нийцэж байна. Мөн үнэт цаасыг нээлттэй хүрээнд гаргаж байгаа нь ХБҮЦтХ-ийн 7.2 дахь заалтад харшлахгүй.

Үнэт цаасны танилцуулгад ТЗК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн талаарх мэдээллийг оруулсан ба "Очун Актив Нэг ТЗК" ХХК-ийн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд дараах 3 гишүүнийг сонгосон байна. Үүнд:

Д/Д	Овог нэр	Албан тушаал
1	Ганбаатар овогтой Цогтгэрэл	Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн
2	Баяраа овогтой Баасандорж	Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн
3	Гэндэндаржаа овогтой Баянгуяа	Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн дээрх бүрэлдэхүүн болон нийт гишүүдийн 2/3 нь хараат бус гишүүн байгаа эсэх нь Компанийн тухай хуулийн 77.1, ХБҮЦтХ-ийн 12.8 дахь хэсэг, ХБҮЦГБТЗОЖ-ийн 3.2 дахь хэсэгтэй тус тус нийцэж байна.

Үнэт цаасны танилцуулгад үнэт цаас гаргах харилцаанд оролцогчдын онооссон нэр, хуулийн этгээдийн бүртгэлд бүртгүүлсэн огноо, гэрээгээр хүлээсэн үүрэг, компанийн удирдлага, бүтэн зохион байгуулалт, үйл ажиллагаа, өмнө ХБҮЦ гаргах ажиллагаанд оролцож байсан туршлага, "Очун Актив Нэг ТЗК" ХХК-ийн товч танилцуулга, ТУЗ-ийн дарга, гишүүдийн мэдээлэл, хөрөнгийн багцыг шилжүүлэн авсан гэрээ, хөрөнгийн багцыг бүрдүүлэх зорилгоор анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс шилжүүлж байгаа зээлийн хөрөнгийн хувьд хангавал зохих хуулийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлтүүд, хөрөнгийн багцын шинж чанар, харьцаа, үзүүлэлт, шилжүүлэн авч буй хөрөнгийн дүн, хүүгийн түвшин, хувь хэмжээ, эргэн төлөгдөх хугацаа, мөнгөн урсгалын тооцоолол, хугацаа, барьцаа хөрөнгийн мэдээлэл, хөрөнгийн багцын чанарын үзүүлэлт, хөрөнгийн багцад байгаа хөрөнгүүд эргэн төлөгдөх баталгаа алдагдаж, багцын мөнгөн урсгалд эрсдэл учирсан тохиолдолд анхны үүрэг гүйцэтгүүлэгч багцад бүртгэгдсэн эрсдэлтэй зээлийг буцаан худалдан авахтай холбоотой эрх, үүрэг, хариуцлага болон солих нөхцөлийн талаар, үнэт цаастай холбоотойгоор үүсэж болзошгүй эрсдэлийн төрлүүд, эрсдэлийн удирдлагын цогц арга хэмжээний төлөвлөгөө, үнэт цаас гаргагч нь үнэт цаасаа эргүүлэн худалдаж авахыг шаардах, байгуулсан гэрээг цуцлах нөхцөл, үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөр төлөлтөд гуравдагч этгээдээс баталгаа, батлан даалт гаргаагүй талаар, үнэт цаасны нэрлэсэн үнэ, тоо ширхэг, анхдагч зах зээлд санал болгох, худалдах арга, хэлбэр, үнэт цаасыг худалдан авагч хөрөнгө оруулагчид ногдох татварын мэдээлэл, үнэт цаас гаргах ажиллагаанд хөндлөнгийн үйлчилгээ үзүүлсэн Хороонд бүртгэлтэй хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдийн гаргасан дүгнэлт, үнэт цаас гаргах ажиллагаанд аудитын үйлчилгээ үзүүлсэн Хороонд бүртгэлтэй аудитын гаргасан дүгнэлт, үнэт цаасны төлбөрийг хөрөнгө оруулагчид олгохоос өмнө төлөгдөх бусад төлбөр,

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040941
7239689 ХНТ10470

зардлын талаар, үнэт цаас гаргах ажиллагаанд оролцож буй холбоотой этгээдүүд хоорондоо нэгдмэл сонирхолтой болон холбоотой этгээд эсэх, бизнесийн холбоо харилцаатай эсэх талаар мэдээллүүдийг тусгасан байгаа нь ХБҮЦГБТЗОЖ-ын 5.7-д заасантай нийцэж байна.

Хөрөнгө итгэмжлэн удирдагчаар томилогдсон "Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК нь 2005 оны 1 дүгээр сарын 27-нд үүсгэн байгуулагдаж, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 10 дугаар сарын 28 өдрийн 473 тоот тогтоолоор "Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл"-ийг авсан байгаа нь ХБҮЦтХ-ийн 20.1, ХБҮЦГБТЗОЖ-ын 8.1-д заасан шаардлагыг хангаж байна.

Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан үнэт цаас гаргагчийн оноосон нэр, оршин байгаа газрын шуудангийн болон холбоо барих хаяг, эрхэлж байгаа үйл ажиллагаа, эзэмшиж байгаа хувьцаа, тусгай зөвшөөрөл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, бүртгэсэн огноо, үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн мэдээлэл, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүдийн мэдээлэл, үнэт цаасаар баталгаажсан хөрөнгийн талаарх мэдээллүүд нь үнэн зөв, хүчин төгөлдөр тусгагдсан гэж дүгнэв.

Дээр дурдсан хууль зүйн ач холбогдолтой мэдээллээс бусад санхүү эдийн засгийн ерөнхий мэдээлэл, үзүүлэлтүүд, үнэт цаас гаргагчийн талаарх олон нийтэд илэрхий тодорхой үйл баримтууд, санхүүгийн тайланд тусгагдсан баталгаажуулах боломжгүй тоон үзүүлэлтүүд, санхүүгийн мэдээлэл, хөндлөнгийн байгууллагуудын хийсэн дүн шинжилгээ, санхүүгийн тооцоолол, Компанийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэл, эрсдэлийн таамаг, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө зэрэг мэдээлэлд өмгөөллийн нөхөрлөлийн зүгээс хууль зүйн дүн шинжилгээ хийх боломжгүй болно.

Иймд ХБҮЦ гаргах тухай шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн, үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь хууль зүйн хувьд үнэн зөв, хүчин төгөлдөр гэж дүгнэж байна.

2.3. ТЗК-ийн дүрэм, үндсэн үйл ажиллагаанд ашиглагдах журмууд нь хууль тогтоомжид нийцсэн эсэх

А. ТЗК-ийн дүрэм, үндсэн үйл ажиллагаанд ашиглагдах журмууд

"Очун актив нэг ТЗК" ХХК-ийн дүрмийн 2.1-д Компани нь ХБҮЦтХ-д заасан тусгай зориулалтын компани байна, 8.2.3-т зааснаар компани нь баталгаат үнэт цаас бүрэн төлөгдөж дууссан тохиолдолд татан буугдах тухай зохицуулалтыг дүрэмд тусгасан байгаа тул ТЗК-ийн дүрэм нь Компанийн тухай хуулийн 16.2 дахь хэсэг, ХБҮЦтХ-ийн 12.9 дэх хэсэгтэй тус тус нийцэж байна.

"Очун Актив Нэг" ХХК-ийн "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам", "Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох, солих тухай журам", "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам", "Үнэт цаас эзэмшигчдэд мэдээлэл хүргүүлэх журам", "Эрсдэл, сонирхлын зөрчлийг илрүүлэх, үнэлэх, удирдах дотоод хяналтын журам", "Тусгай зориулалтын компанийг татан буулгах журам", "Үнэт цаасны төлбөрийг шилжүүлэх, төлөөр төлөх журам", Хөрөнгө итгэмжлэн удирдах журам" болон эдгээр журмуудыг баталсан ТЗК-ийн ТУЗ-ийн тогтоолууд нь Компанийн тухай хууль, ХБҮЦтХ, Мөнгө угаах болон

ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК ХХК

ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК

- терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, ХБҮЦГБТЗОЖ-ын 4.1, 5.6 болон ТЗК-ийн дүрэмтэй нийцсэн, хүчин төгөлдөр эрх зүйн актууд байна.

Б. Бусад тогтоол, шийдвэрүүд

"Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2025 оны 12-р сарын 18-ны өдрийн "Компани үүсгэн байгуулах тухай" 2025/98 дугаар шийдвэр, "Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 10-р сарын 31-ний өдрийн 25/42 дугаар "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай" тогтоол, "Очун Актив нэг" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчийн 2026 оны 3-р сарын 19-ны өдрийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай" 2026/10 дугаар тогтоол, "Очун актив нэг ТЗК" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 4-р сарын 20-ны өдрийн 2026/09 дүгээр "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай" тогтоол, "Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчийн 2026 оны 3-р сарын 19-ний өдрийн "Тусгай зориулалттай компанийн зөвшөөрөл авах тухай" 2026/11 тоот шийдвэр, "Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 10-р сарын 31-ний өдрийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай" 25/42 дугаар шийдвэр; "Очун Актив Нэг ТЗК" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 4-р сарын 20- ний өдрийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахтай холбоотой оролцогч талууд сонгох, холбогдох гэрээ болон журмыг батлах тухай" 2026/07 дугаар тогтоол, "Очин Актив нэг" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 01-р сарын 29-ний өдрийн 26/01 дүгээр "Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг томилох тухай" тогтоол; "Очин Актив нэг" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 01-р сарын 29-ний өдрийн 26/02 дугаар "Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад нэр дэвшүүлэх тухай" тогтоол, "Очин Актив нэг" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 01-р сарын 29-ний өдрийн 26/03 дугаар "Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох тухай" тогтоол; "Очун Актив Нэг ТЗК" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 4-р сарын 20- ний өдрийн "Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийг батлах тухай" 2026/08 дугаар тогтоол, "Очун Актив Нэг ТЗК" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 4-р сарын 20- ний өдрийн "Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тухай" 2026/09 дугаар тогтоол нь Компанийн тухай хууль, ХБҮЦтХ, "Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК ба "Очун Актив Нэг ТЗК" ХХК-ийн дүрэмд нийцсэн хүчин төгөлдөр шийдвэрүүд байна. Дээрх шийдвэр, тогтоолуудаар ТЗК байгуулах, ХБҮЦ гаргах, ТУЗ-ийн гишүүдийг томилох, хөрөнгө итгэмжлэн удирдагч, хөндлөнгийн аудитор, хууль санхүүгийн хөндлөнгийн шинжээч, хэлцэл эрхлэн гүйцэтгэгчийг томилох, үйл ажиллагааны зөвшөөрөл олгох, үйл ажиллагаандаа мөрдөх дүрэм журам болон үнэтцаасжуулалтын гэрээ хэлцлийг баталсан байгаа нь ХБҮЦтХ болон ХБҮЦГБТЗОЖ-ын 5.2, 3.4.5, 8.2-т заасантай тус тус нийцэж байна.

Иймд ТЗК-ийн дүрэм, үндсэн үйл ажиллагаанд ашиглагдах журмууд нь хууль тогтоомжид нийцсэн гэж дүгнэж байна.

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947
7239689 .Т. ХНТ10470

УЛААНБААТАР ХОТ
ХААН БОГД КАПИТАЛ ҮЦК ХХК
ШТК0128 5459912 9021061377

2.4. Баталгаат үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч этгээд буюу анхны үүрэг гүйцэтгүүлэгч, худалдагчтай байгуулсан хөрөнгө шилжүүлэх, худалдах, худалдан авах, үйлчилгээ үзүүлэх, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ, хэлцэл нь хуульд нийцсэн эсэх, хууль зүйн бодит хэлцлийн шаардлагыг хангаж буй эсэх

А. Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ

а. "Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК ба "Очун Актив Нэг ТЗК" ХХК-ийн хооронд 2026.04.21-ний өдөр байгуулсан ОАН-2026-01 тоот "Хөрөнгө худалдах худалдан авах гэрээ"-гээр Анхны үүрэг гүйцэтгүүлэгч нь Хөдлөх эд хөрөнгө /автомашин ба бусад/ болон үл хөдлөх эд хөрөнгө /орон сууц ба бусад/ барьцаалсан зээлийн хөрөнгө түүний авлагын шаардах эрх, холбогдох барьцаа, баталгаа болон үүргийн гүйцэтгэлийг хангах бусад арга хэрэгсэл болон түүний дагалдах эрхүүдийг Худалдан авагч буюу үнэт цаас гаргагчид гэрээний дагуу шилжүүлэх, Худалдан авагч нь хөрөнгийг шилжүүлэн авч, энэхүү гэрээнд заасны дагуу худалдан авалтын харьцуулалтыг төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулсан байна. Энэ нь Иргэний хуулийн 243.1 дэх хэсэгтэй нийцэж байна.

б. Гэрээний ерөнхий нөхцлийн 2.1, гэрээний тусгай нөхцлийн 1.1, 1.2-т заасанаар гэрээний зүйл нь Зээлийн хөрөнгө буюу Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс Худалдан авагчид худалдсан буюу шилжүүлсэн Зээлийн гэрээ, үндсэн зээл, зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүүгийн үүргийн гүйцэтгэлийг хангуулах арга, барьцаа, фидуци, батлан даалт, баталгаа, даатгал, эдгээр гэрээний шаардах эрхийг хамаарч байна. Энэ нь ХБҮЦтХ-ийн 3.1.1-д *"хөрөнгө" гэж зээл, түүнээс болон санхүүгийн түрээсийн гэрээ, орлого бичгээс үүсэх шаардах эрх, зээлийн карт олгогчийн авлага зэрэг мөнгөн урсгал бий болгох боломжтой санхүүгийн хэрэгслийг ойлгоно."* гэж заасантай нийцэж байна.

в. "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ"-ний ерөнхий нөхцлийн 2.1, 6.1, 6.2, тусгай нөхцлийн 1.1, 1.2 дахь заалтад зээл, шаардах эрх, зээлийн барьцаатай холбоотой бүхий л шаардлага, эрх зэрэг хөрөнгийн багцтай холбоотой бүх зүйлийг шилжүүлэхээр заасан нь үүргийн агуулгад харшлахааргүй байгаа тул Иргэний хуулийн 260.1 дэх хэсэг болон ХБҮЦтХ-ийн 13.1, 13.2 дахь хэсэгтэй тус тус нийцэж байна.

г. "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ" нь ерөнхий нөхцөл 15 зүйл, тусгай нөхцөл 14, нийт 29 зүйлтэй байгаа бөгөөд зүйл тус бүрийн хэсэг, заалтын зохицуулалт нь хуульд нийцэж байгаа ба гуравдагч этгээдийн эрх ашгийг зөрчөөгүй, хэрэгжих боломжтой байна. Иймд анхны үүрэг гүйцэтгүүлэгч ба үнэт цаас гаргагч нарын хооронд байгуулагдах "Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ" нь хууль зүйн бодит хэлцлийн шаардлагыг хангасан, хуульд нийцсэн байна.

Б. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ

а. "Очун Актив Нэг ТЗК" ХХК болон "Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК-ийн хооронд байгуулсан ОАН-2026-03 тоот "Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс ТЗК-ийн худалдан авсан нэгдсэн хөрөнгийн багц, зээлийн хөрөнгө болон мөнгөн хөрөнгийг түүний нэрийн өмнөөс "Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК итгэмжлэн удирдахтай холбоотой харилцааг зохицуулсан байна. Улмаар гэрээг үнэт цаасны танилцуулгад хавсаргасан байгаа нь ХБҮЦтХ-ийн 20.5-д заасантай нийцэж байна.

б. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд хөрөнгийн багц дахь зээлийн хөрөнгийн [illegible] гаргагчийн эрх ашгийг нийцүүлэн эзэмших, удирдах, хяналт тавих буюу үнэт цаас эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн Хороноос тогтоосон бусад арга хэмжээг

хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгэх, Зээлийн хөрөнгө нь үнэт цаас гаргагчаас тогтоосон шалгуур үзүүлэлтийг хангахаргүй болсон, холбогдох журамд заасан үндэслэл бий болсон тохиолдолд энэ талаар ТЗК-д мэдэгдэх, ТЗК-ийн ТУЗ-ийн шийдвэрийн дагуу багцад өөрчлөлт оруулах арга хэмжээ авах зэрэг эрхийг тусгасан байгаа нь ХБҮЦтХ-ийн 20.1, 20.2 болон ХБҮЦГБТЗОЖ-ын 8.2 дахь заалттай тус тус нийцэж байна.

в. Гэрээний ерөнхий нөхцлийн 3.1-3.11 болон бусад заалтуудад Хөрөнгө итгэмжлэн удирдагчид олгогдсон эрх хэмжээг нэг бүрчлэн заасан байгаа нь ХБҮЦГБТЗОЖ-ын 8.2 дахь хэсэгт Хөрөнгө итгэмжлэн удирдагчийн эрх хэмжээг хөрөнгө итгэмжлэн удирдагч болон ТЗК-ийн хооронд байгуулсан ХИУ гэрээгээр тогтооно гэж заасантай нийцсэн байна.

Иймд үнэт цаас гаргагч ба хөрөнгө итгэмжлэн удирдагч нарын хооронд байгуулсан "Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ" нь хууль зүйн бодит хэлцлийн шаардлагыг хангасан, хууль нийцсэн байна.

В. Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ

"Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК ба "Очун Актив Нэг ТЗК" ХХК-ийн хооронд 2026.04.21-ний өдөр байгуулсан ОАН-2026-06 тоот "Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ"-гээр үнэт цаас гаргагчийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах захиргааны үйлчилгээ үзүүлэх, ТЗК нь ажлын хөлс төлөх харилцааг зохицуулсан байна. Уг гэрээ нь ХБҮЦтХ-ийн 12.11.4 дэх заалтад "ТЗК нь хорооноос баталсан журам болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны танилцуулгад заасны дагуу хөрөнгө худалдаж буюу шилжүүлэх авах, баталгаат үнэт цаас гаргах, хөрөнгийг өмчлөх, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг нийцүүлэн хөрөнгийг удирдах эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай үйлчилгээ үзүүлэх болон бусад гэрээ байгуулах эрхтэй" гэж заасантай нийцэж байна. Уг гэрээний 2.1-д захиргааны үйлчилгээ үзүүлэгч нь ТЗК-ийн мөнгөн хөрөнгөөс шаардлагатай мөнгөн гүйлгээг хийж гүйцэтгэхэд ХИУ-ид хяналт тавих, шаардлагатай тохиолдолд хамтран ажиллах; ТЗК-ийн Нягтлан бодох бүртгэлийн хөтлөлтийг ХИУ-аар хянуулан холбогдох стандарт, журам, зааврын дагуу хийх, санхүү, татвар, нийгмийн даатгал болон холбогдох бүх тайлан мэдээг хуульд заасан хугацаанд тайлагнах; Үнэт цаас эзэмшигчийн нэрээр хүүгийн орлогын албан татварыг тайлагнах; ТЗК-ийн жилийн үйл ажиллагааны тайлангийн аудитад бэлтгэх, талуудаас баримт бичиг цуглуулж, хөндлөнгийн аудитад хүлээлгэн өгөх, бүцаан авах, хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хүлээн авч ТУЗ болон ХИУ-д хүргүүлэх; ХБҮЦ-ны багц дахь зээлийн хөрөнгийн буюу хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн барьцааны бүртгэлийг хуульд тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагад бүртгүүлэх, бүртгэлд өөрчлөлт оруулах, дуусгавар болгох ажлыг зохион байгуулах, ТЗК-ийн хагас жилийн болон жилийн үйл ажиллагааны тайлангийн мэдээллийг нэгтгэж, ХИУ-д хүргүүлэх зэрэг бүртгэл тайлагнал болон бусад үйлчилгээтэй холбоотой нийт 15 төрлийн үйлчилгээг үзүүлэхээр заасан байгаа нь Монгол улсын Иргэний хууль болон ХБҮЦтХ-ийн 19.1, 19.2, 19.8 дахь хэсэгт заасантай нийцэж байна.

Г. Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ

"Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК, "Очун Актив Нэг ТЗК" ХХК болон "Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК-ийн хооронд байгуулсан ОАН-2026-02 тоот "Төлбөр цуглуулах үйлчилгээ үзүүлэх гэрээ"-гээр Үйлчилгээ үзүүлэгч нь Үнэт цаас гаргагчаас гаргах ХБҮЦ-ны төлбөрийг цаг хугацаанд нь цуглуулан, шилжүүлэх, бүртгэлийг хөтлөх, тайлагнах, Зээлийн эрсдэлийг удирдах журмын дагуу зээлийн хяналт тавьж, зээл төлүүлэх ажиллагаа явуулах болон

Хөрөнгө итгэмжлэн удирдагчаас уг үйл ажиллагаанд хяналт тавих. Үнэт цаас гаргагч нь үйлчилгээний төлбөрийг төлөхтэй холбоотой харилцааг зохицуулсан байна. Энэхүү гэрээ нь Монгол улсын Иргэний хууль болон ХБҮЦтХ-ийн 19.1, 19.3, 19.8 дахь хэсэгт заасантай нийцэж байна.

Д. Үнэт цаасжуулалтын бусад гэрээ

Үнэт цаасжуулах хэлцлийн хүрээнд байгуулах дараах гэрээ хэлцлүүд байна:

a. Фидуцийн барьцааны гэрээ;
b. Зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээ.

Дээрх гэрээнүүд нь Иргэний хуулийн 123 дугаар зүйл, 235 дугаар зүйл, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, ХБҮЦтХ-ийн 12.13, 20.5, 19.3 дахь хэсэг болон ХБҮЦГБТЗОЖ-тай нийцэж байна. "Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК нь хөрөнгө итгэмжлэн удирдагчаар ажиллах харилцааг гэрээгээр зохицуулсан байгаа нь ХБҮЦтХ-ийн 17.1, 20.3-д заасантай нийцэж байна. Иймд ХБҮЦ гаргах ажиллагаанд оролцогч этгээд буюу анхны үүрэг гүйцэтгүүлэгчтэй байгуулсан хөрөнгө шилжүүлэх, худалдах, худалдан авах, үйлчилгээ үзүүлэх, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ, хэлцлүүд нь хуульд нийцсэн эсэх, хууль зүйн бодит хэлцлийн шаардлагыг хангасан гэж дүгнэж байна.

2.5. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч нь хөрөнгө итгэмжлэн удирдагч, бусад оролцогчидтой ашиг сонирхлын зөрчилтэй эсэх

Хөрөнгө итгэмжлэн удирдагч "Юү Эй Эф Ассет Менежмент" ХХК, хөндлөнгийн аудит буюу зээлийн шинжилгээ гаргагч "Си Пи Ти Эй Аудит" ХХК, хуулийн хөндлөнгийн шинжээч "Өмгөөллийн Эм Жэй Эл Атторнейс" ХХН, андеррайтерийн үйлчилгээ үзүүлэгч "Юү эй эф ассет менежмент" ХХК, "Таванбогд Капитал УЦК" ХХК болон "Ти Ди Би Секьюритис УЦК" ХХК нар нь үнэт цаас гаргагч "Очун Актив Нэг ТЗК" ХХК болон үүсгэн байгуулагч "Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК нартай аливаа байдлаар нэгдмэл сонирхолгүй, ашиг сонирхлын зөрчилгүй, энэхүү дүгнэлтэд дурдсанаас өөр бизнесийн холбоогүй байна. Мөн эдгээр оролцогчид тус бүр нь нэгдмэл сонирхолгүй, ашиг сонирхлын зөрчилгүй бичгээр баталгаажуулж баталгаа үйлдсэн байна.

Харин Компанийн тухай хуулийн 99.1.8 дахь заалтын дагуу үйлчилгээ үзүүлэгч "Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК нь үнэт цаас гаргагчтай нэгдмэл сонирхолтой этгээд болж байгаа ч үүнийг ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэх үндэсгүй байна. Учир нь ХБҮЦтХ-ийн 19.8-д "Анхны үүрэг гүйцэтгүүлэгч, үүсгэн байгуулагч, худалдагч нь үйлчилгээ үзүүлэгчийн үүргийг гүйцэтгэж болно." гэж заасны дагуу "Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК нь өөрийн үүсгэн байгуулсан "Очун Актив Нэг ТЗК" ХХК-ийн үйлчилгээ үзүүлэгчээр ажиллах боломжтой. Мөн түүнчлэн "Очун Актив Нэг ТЗК" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 4-р сарын 20- ний өдрийн "Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийг батлах тухай" 2026/08 дугаар тогтоолоор Үнэт цаас гаргагчид "сонирхлын зөрчилтэй хэлцэл" болон "их хэмжээний хэлцэл" байгуулах зөвшөөрөл олгосон байна.

Иймд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагч нь хөрөнгө итгэмжлэн удирдагч, бусад оролцогчидтой ашиг сонирхлын зөрчилгүй гэж дүгнэлээ.

ТАВАН БОГД КАПИТАЛ УЦК ХХК

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК

2.6. Хөрөнгийн багц дахь хөрөнгийн төрөл бүрээс хамааруулан санамсаргүй түүврийн аргаар сонгох замаар үнэт цаас гаргагчаас тогтоосон хууль зүйн шалгуур үзүүлэлт хангаж буй эсэх

ХБҮЦ-ны хөрөнгийн багцыг бүрдүүлж буй 1919 зээлээс итгэлцлийн түвшин 95%, хүлээгдэж буй алдааны дээд хязгаар 9% байхаар тооцоолж санамсаргүй түүврийн аргаар 108 зээл сонгож шинжлэн судалсан. Ингэхдээ нийт 13 төрлийн зээлийн бүтээгдэхүүний төрөл тус бүрээс сонгож, Улаанбаатар хот, хөдөө орон нутгийг хамруулж зээлийн түүврийг сонгосон. Үнэт цаас гаргагчаас баталсан хуулийн 12 шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн нийт 37 төрлийн дэд шалгуур асуултуудын хүрээнд хуулийн шинжилгээг хийж гүйцэтгэсэн. Хуулийн шинжилгээ хийх явцад зээлийн данс тус бүр дээр илрүүлсэн зөрчил, алдааг тухай бүр нь ББСБ-д мэдэгдэж, алдааг засуулж ажилласан. Ингээд санамсаргүй түүврийн аргаар сонгосон 108 зээл нь хуулийн шалгуурын бүх үзүүлэлтийг хангасан байсан болно. Эдгээр зээлээс 15 зээл нь бүрэн төлөгдөж хаагдсан байсан. Иймд хөрөнгийн багц дахь хөрөнгийн төрөл бүрээс хамааруулан санамсаргүй түүврийн аргаар сонгосон зээлийн дансууд нь үнэт цаас гаргагчаас тогтоосон хууль зүйн шалгуур үзүүлэлт хангасан гэж дүгнэв. *(Хавсралт №1: ХӨРӨНГӨӨР БАТАЛГААЖСАН ҮНЭТ ЦААСНЫ ХЭЛЦЛИЙН ХҮРЭЭНД СОНГОГДСОН ЗЭЭЛИЙН ДАНСНУУД НЬ ХУУЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД НИЙЦСЭН ЭСЭХ ТАЛААРХ ХУУЛИЙН ХӨНДЛӨНГИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН-г 2026.04.27-ны өдөр "Очун Актив Нэг ТЗК" ХХК-д хүргүүлсэн ба уг тайлантай танилцана уу.)*

2.7. Багцын хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбогдох гэрээ, хэлцэл нь хууль тогтоомжид нийцсэн эсэх, гэрээ, хэлцэлд үүргийн гүйцэтгэлийн зүйлтэй холбоотой аливаа шаардах эрхийг шилжүүлэхгүй болон хэрэгжүүлэхгүй байхыг үүрэг болгосон, эсхүл шилжүүлэхийг хориглосон, хязгаарласан нөхцөл тусгасан эсэх

Баталгаат үнэт цаас гаргах гол урьдчилсан нөхцөл бол уг үнэт цаасыг баталгаажуулж буй хөрөнгө байдаг. "Очун Актив Нэг ТЗК" ХХК-ийн гаргаж буй энэхүү үнэт цаасны хөрөнгө нь автомашин барьцаалсан зээл, хөдлөх ба үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан зээл, фидуци, барьцааны гэрээ, эдгээр гэрээнээс үүсэх шаардах эрх байгаа нь ХБҮЦтХ-ийн 3.1.1-д заасантай нийцэж байна. Анхны үүрэг гүйцэтгүүлэгчээс зээлдэгч нартай байгуулсан зээлийн гэрээ нь Иргэний хуулийн 451.1, барьцаалуулагч нартай байгуулсан барьцааны гэрээ нь Иргэний хуулийн 156.1, 235.5-д заасантай тус тус нийцэж байна. "Очир Ундраа ОМЗ ББСБ" ХХК-аас зээлдэгч нартай байгуулсан зээлийн гэрээний 5.1.12-т ББСБ нь "Энэхүү гэрээний шаардах эрхийг гуравдагч этгээдэд шилжүүлэх, ..." эрхтэй гэж заасан байгаа тул Зээлдэгч буюу барьцаалуулагч нь гэрээний эрх, шаардах эрхийг ХБҮЦ гаргах зорилгоор ТЗК-д шилжүүлэхийг зөвшөөрсөн, зээлдүүлэгч буюу барьцаалагч нь уг шаардах эрхийг бусдад шилжүүлэх эрхтэй байгаа тул уг зээлийн гэрээ, барьцааны гэрээ, фидуцийн гэрээ нь Иргэний хуулийн 123 дугаар зүйлтэй нийцэж байна.

Иймд багцын хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбогдох гэрээ, хэлцэл нь хууль тогтоомжид нийцсэн байх бөгөөд зээлийн болон барьцааны гэрээнд үүргийн гүйцэтгэлийн зүйлтэй холбоотой аливаа шаардах эрхийг шилжүүлэхгүй болон хэрэгжүүлэхгүй байхыг үүрэг болгосон, шилжүүлэхийг хориглосон буюу хязгаарласан нөхцөл тусгагдаагүй байна.

УЛААНБААТАР ХОТ
ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК ХХК
ШТК0128 5469112 8021061377

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947
7239689 ХНТ18470

Хууль зүйн дүгнэлт гаргасан:

Өмгөөллийн "Эм Жэй Эл Атторнейс" ХХН-ийг төлөөлж
Удирдах Партнер & Захирал, өмгөөлөгч М.Мөнхжаргал

УПАА НБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947
7239689 ХНТ10470

УПАА НБААТАР ХОТ
ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК ХХК
ШТК0128 5469112 9021061377

8.19. Үндсэн андеррайтерийн улсын бүртгэлийн гэрчилгээ

МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000238888

2011.04.15 — /Бүртгэсэн он,сар,өдөр/
9011286006 — /Хувийн хэргийн дугаар/
5469112 — /Регистрийн дугаар/

Таван богд капитал ҮЦК — Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр/

Дүрэм
/Үүсгэн байгуулах баримт бичиг/

Шийдвэр — 01 — 2011.04.11
/шийдвэрийн нэр/ /дугаар/ /он, сар, өдөр/

66120 Брокерын үйл ажиллагаа эрхлэх /2011.06.30-/
/Код/ /Үйл ажиллагааны чиглэл/

Хугацаагүй — 3 — 1,330,000.00
/хугацаа/ /хувьцааны тоо/ /хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр/

Улаанбаатар, Сүхбаатар, 8-р хороо, Их эзэн Чингис хаанч нэрэмжит талбай - 16, Галлериа Улаанбаатар төвийн 1 давхарт, Утас1: 72727282, Утас2: , Факс:
/хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР
/Бүртгэсэн байгуулагын нэр/
УЛСЫН БҮРТГЭГЧ О.ӨНЗИЙБАТ
/тэмдэг/ /гарын үсэг/

Гэрчилгээ дахин олгосон 2021 он 09 сар 16 өдөр

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947
7239689 ... ХНТ16...

УЛААНБААТАР ХОТ
ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК ХХК

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичиг оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Гочоо овогтой Менхэрдэнэ-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2021.06.29	Г.Санжаа
2	Дахин гэрчилгээ олгов.	2021.09.16	О.Эрдэнэбат
3	66300 Үнэт цаасны дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв. 64190 Менген хөрөнгийн орлого,зарлагын номинал данс эзэмших /-/ үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2021.10.18	Г.Санжаа
4	32110 Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах,худалдан авахад зуучлах үйл ажиллагаа /-/ үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2021.11.02	Н.Энхцэцэг
5	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 800000 мян.төг-р нэмэгдэж нийт 2130000 мян.төг болсон өөрчлөлтийг бүртгэв.	2022.07.26	Ч.Мөнхтуяа

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ заавартай бол хүчингүй.

000238888

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947
7239689 .Ч. ХНТ10470

УЛААНБААТАР ХОТ
ХАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК ХХК
ШТК0128 5469112 9021061377

8.20. Үндсэн андеррайтерийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээ

МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар ТЗ 301/84

2011 оны 06 сарын 30 өдөр

Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 06 сарын 30 өдрийн 207 дугаар тогтоолоор

"ТАВАН БОГД КАПИТАЛ УЦК" ХХК -д

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ЗОХИЦУУЛАЛТТАЙ

үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА Д.БАЯРСАЙХАН

"Тамга"

Энэхүү гэрчилгээ нь хавсралтын хамт хүчинтэй

ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК

9026040947
7239689 .'. ХНТ10470

ТАВАН БОГД КАПИТАЛ УЦК ХХК

(Энэхүү хавсралт нь тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хамт хүчинтэй)

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

ТЗ 301/84 ТООТ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ

"Тэмдэг"

Тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдэд зориулсан тэмдэглэлүүд

НЭГ. Хуулийн этгээдийн оноосон нэр: **"ТАВАН БОГД КАПИТАЛ УЦК" ХХК**

ХОЁР. Хуулийн этгээдийн ангилал: **ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД ЗОХИЦУУЛАЛТТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

ГУРАВ. Үйл ажиллагааны төрөл,хэлбэрийн тэмдэглэл:

Д/д	Үйл ажиллагааны төрөл, хэлбэр	Олгосон огноо	Олгосон шийдвэрийн дугаар	Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, сунгасан хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар
1.	Брокер	2011.06.30	№207тогтоол	
2.	Дилер	2011.06.30	№207 тогтоол	2019.08.28 №250 тогтоол
1.	Дилер	2021.10.13	№433 тогтоол	
2.	Хөрөнгө оруулалтын зөвлөх	2021.10.13	№433 тогтоол	
3.	Андеррайтер	2021.10.13	№433 тогтоол	
1.	Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах,худалдан авахад зуучлах	2021.10.28	№476 тогтоол	
2.	Монгол хөрөнгийн орлого, зарлагын шимтгэл даңс эзэмших	2021.10.28	№476 тогтоол	

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ
ТЗК ХХК
9026040947
7239689 .т. ХНТ10470

УЛААНБААТАР ХОТ
ТАВАН БОГД КАПИТАЛ УЦК ХХК
ШТК0126 5469912 5021061377

"Зэт Жи Би ҮЦК" ХХК -ийн онооосон нэрийг "Таван Богд Капитал ҮЦК" ХХК болгон өөрчлөхийг зөвш
2021.06.28 №158 тушаал

ДӨРӨВ. Хуулийн этгээдийн хаяг, хаягийн өөрчлөлтийн тэмдэглэл:

Д/д	Хаяг	Утас	Тэмдэглэл хийсэн огноо, тэмдэг
1.	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 4-р хороо, Түшиг оффис төвийн байр, 408 тоот.		
2.	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,8-р хороо, Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай-16, Галлерия-Улаанбаатар худалдаа үйлчилгээний төв, 1 давхарт	72727282	2021.08.02 №5/2629 албан тоот

ТАВ. Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийн тэмдэглэл:

Д/д	Хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн, хорогдуулсан хэмжээ	Зөвшөөрөл олгосон огноо	Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ
1.		2011.06.30	№207	51,000,000
2.	50,000,000 /нэмэгдүүлсэн/	2021.05.28	№136	101,000,000
3.	1,229,000,000 /нэмэгдүүлсэн/	2021.09.14	№239	1,330,000,000
4.	800,000,000 /нэмэгдүүлсэн/	2022.06.30	№353	2,130,000,000

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947
7239689 ХНТ10

УЛААНБААТАР ХОТ
ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК ХХК
ШТК00128 5469112 9021061377

ЭОВ.

ЗУРГАА. Хувьцаа эзэмшигчийн талаар:

Д/д	Овог нэр /Хуулийн этгээдийн нэр/	Регистрийн дугаар	Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн	Хувь	Зөвшөөрөл олгосон огноо	Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар, тэмдэг
1.	Г.Болормаа	ХГ69102564	51,000,000	100%	2011.06.30	№207 тогтоол
2.	Г.Болормаа	ХГ69102564	101,000,000	100%	2021.05.28	№136 тушаал
1.	Ж.Барсболд	СЮ76100216	101,000,000	100%	2021.06.28	№158 тушаал
1.	Ж.Барсболд	СЮ76100216	66,500,000	5%	2021.09.14	№239 тушаал
2.	"Таванбогд трейд" ХХК	2543303	1,130,500,000	85%	2021.09.14	№239 тушаал
3.	Г.Мөнх-Эрдэнэ	УМ90082417	133,000,000	10%	2021.09.14	№239 тушаал
1.	"Таванбогд трейд" ХХК `	2543303	1,810,500,000	85%	2022.06.30	№353 тушаал
2.	Г.Мөнх-Эрдэнэ	УМ90082417	213,000,000	10%	2022.06.30	№353 тушаал
3.	Ж.Барсболд	СЮ76100216	106,500,000	5%	2022.06.30	№353 тушаал

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947
7239689 .Х. ХНТ10

УЛААНБААТАР ХОТ
ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК ХХК
ШТК0128 5469112 9021061377

ДОЛОО. Хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрын тэмдэглэл:

Д/д	Нэр, дугаар	Хаяг, хаягийн өөрчлөлт	Зөвшөөрөл олгосон огноо	Зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар	Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон огноо, шийдвэрийн дугаар

УЛААНБААТАР ХОТ
ОЧУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
9026040947
7239689 Л. ХНТ10470

УЛААНБААТАР ХОТ
ТАВАН БОГД КАПИТАЛ УЦК ХХК
ШТК0128 5469112 9021061377

8.21. Дэд андеррайтерийн улсын бүртгэлийн гэрчилгээ

МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
000250403

2008.08 15 / Бүртгэсэн он,сар өдөр /

9011165033 / Хуулийн хэрэгийн дугаар /

5251494 / Регистрийн дугаар /

Ти Ди Би секьюритис ҮЦК / Хуулийн этгээдийн нэр, харьцуулсан хэлбэр /

Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Дүрэм / Үүсэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр / шийдвэр гаргасан нэр /

01 / дугаар /

2008.08.16 / он, сар, өдөр /

66120	Брокер, андеррайтер, дилер, хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ /-/
66190	Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа, номинал данс эзэмшик

/ Код / / Үйл ажиллагааны чиглэл /

Хүчингүй / хүчингүй / 2 / өөрчлөлтийн тоо / 9,500,000.00 / хөрөнгийн хэмжээ, мөнгөн дүнгээр /

Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, энхтайвны өргөн чөлөө, худалдаа, хөгжлийн банкны төв байр, Утас1: 311914, Утас2: , Факс: 311944 / хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР
/ Бүртгэсэн бөгөөд гэрчилгээ олгосон нэр /

УЛСЫН БҮРТГЭГЧ (гарын үсэг) У.МАНДАХТУЯА

Гэрчилгээ дахин олгосон 2022 он 02 сар 09 өдөр

УПАА[illegible] ХОТ
ОНУН АКТИВ НЭГ ТЗК ХХК
902604094
7239689 ... ХНТ10470...

УЛААНБААТАР ХОТ
ТАВАН БОГД КАПИТАЛ ҮЦК ХХК
ШТК0128 5469112 9021061377
